



Хэн Компанийг Чиглүүлж Байна вэ?

Компанийн засаглалын талаарх сурвалжлах удирдамж



ICFJ
International Center
for Journalists
Advancing Quality Journalism Worldwide



Global
Corporate
Governance
Forum

IFC
International
Finance
Corporation
World Bank Group

© Зохиогчийн эрх 2012 он. Бүх эрх хамгаалагдсан.

Олон Улсын Санхүүгийн Корпораци
2121 Пеннисилваны өргөн чөлөө, NW.
Вашингтон DC 20433

Энэхүү хэвлэлд тусгасан мэдээлэл, тайлбар болон дүгнэлтийг Олон Улсын Санхүүгийн Корпораци, түүний харъяат байгууллагууд, Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд, эсвэл ОУСК-ийн төлөөлж буй улс оронд ямар нэг байдлаар хамаатуулж авч үзэх ёсгүй. Олон улсын санхүүгийн корпораци нь энэхүү хэвлэлд тусгасан мэдээний үнэн зөв байдалд баталгаа гаргахгүй бөгөөд мэдээг ашигласантай холбоотой аливаа үр дүнд үүрэг хариуцлага хүлээхгүй болно.

Энэхүү ажлын материалыг зохиогчийн эрхээр хамгаалсан. Тус ажлыг бүхэлд нь, эсвэл хэсэгчлэн хувилж тараавал холбогдох хууль тогтоомжийг зөрчсөн хэрэг болно. Олон улсын санхүүгийн корпораци нь энэхүү ажлыг тарааж дамжуулахыг дэмжиж байгаа бөгөөд сонирхсон хэрэглэгчдэд үүнийг ашиглаж өөр бүтээл гаргах, дахин дамжуулж тараах, эсвэл дахин худалдах ямар ч эрхгүйгээр хувийн, бизнесийн бус хэрэгцээнд зориулж хуулбарлах эрхийг үүгээр зөвшөөрч байна. Өөр аливаа зорилгоор хуулбарлах, эсвэл ашиглах тохиолдолд Олон улсын санхүүгийн корпорациас тусгай бичгэн зөвшөөрөл авах шаардлагатай. Тус бүтээлийг дахин хэвлэх, эсвэл гэрэл зураг байдлаар хуулбарлах зөвшөөрөл авахын тулд бүрэн мэдээлэл бүхий хүсэлтээ доорх хаягаар илгээнэ үү.

Олон улсын санхүүгийн корпораци
Дэлхийн Банкны Зөвшөөрөл олгох хэсэг
Хэвлэлийн газар
Вашингтон DC 20433
1818 Н гудамж, NW

Дагалдах эрх зэрэг эрхүүд болон тусгай зөвшөөрлийн талаарх бүх асуултаа доорх хаягаар явуулах ёстой.

Олон улсын санхүүгийн корпораци
Дэлхийн Банкны Зөвшөөрөл олгох хэсэг
Хэвлэлийн газар
Вашингтон DC 20433
1818 Н гудамж, NW

Факс: (202) 522-2422

Хэн Компанийг Чиглүүлж Байна вэ?

Компанийн засаглалын талаарх сурвалжлах удирдамж

Олон улсын Сэтгүүлчдийн төв
Компанийн засаглалын олон улсын форум
Олон улсын санхүүгийн корпораци

Өнөөдөр мэргэжлийн байдлаар сурвалжлахын тулд бизнесийн сэтгүүлчид орчин үеийн компаниуд хэрхэн үйл ажиллагаа явуулдаг, амжилтанд хүрэхэд шаардлагатай нөхцөл болон тэдгээрт тулгардаг бэрхшээл, асуудлуудын талаар өргөн цар хүрээний ойлголттой байх хэрэгтэй. Ялангуяа компанийн сайн засаглалын практикийн ач холбогдлыг ойлгодог, үнэлдэг сэтгүүлчид бусдын хүндэтгэлийг олж авч, өөрсдийн мэдээлж байгаа компаниудтайгаа итгэлцэл бүхий ажлын харилцаа холбоог тогтооно.

2007 онд Хэвлэл мэдээллийн сургалтын хөтөлбөрийг эхлүүлсэнээс хойш Олон улсын корпорацийн засаглалын форум нь Зүүн, Өмнөд болон Төв Ази, Латин Америк, Африк, Ойрхи Дорнодод сэтгүүлчдэд зориулсан төрөл бүрийн сургалтын хөтөлбөр, семинар зохион байгуулсаар ирсэн бөгөөд ингэхдээ ихэнх тохиолдолд Томсон Ройтерс Сан, Agence France-Presse-тай хамтран ажилласан байна.

Ийм сургалт, арга хэмжээний үеэр бид компанийн засаглалын талаар шаардлагатай мэдлэггүй атлаа энэ талаар сурвалжилж байгаа бизнесийн сэтгүүлчдийн олон жишээтэй тулгарсан. Форумын зүгээс хэвлэл мэдээллийнхэнтэй хамтран ажиллах нь компанийн засаглалтай холбоотой асуудлуудын талаарх ойлголтыг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээний нэг чухал хэсэг бөгөөд шинээр гарч ирж буй зах зээл, хөгжиж буй улс орнуудад компанийн засаглалын зөв практикийг хөгжүүлнэ. Энэ арга хэмжээний хувьд Дэлхийн банк группын гишүүн болох Олон улсын санхүүгийн корпорацитай хамтран ажиллаж байна.

Манай хөтөлбөрийн зорилго бол компанийн засаглалын талаарх мэдээллийг бизнесийн ертөнц, олон нийтэд түгээн тараахад сэтгүүлчдэд онцгой үр чадварыг эзэмшүүлэх, өөрөөр хэлбэл зөвхөн хувь нийлүүлэгчид төдийгүй нийгэмд ихээхэн нөлөө үзүүлж болох компанийн үйл ажиллагааны талаар уншигчдад ойлгуулах сэтгүүлчдийн үр чадварын асуудал энд хамааралтай. Судалгаа шинжилгээ хийж, ойлголттой болсоноороо сэтгүүлчид нь компанийг хангалтгүй удирдаж байхад юу тохиолддог талаар мэдээлж болно. Түүнчлэн сэтгүүлчид нь шилдэг практикийг баримталж мөрдөж байгаа компаниуд

зөвхөн сайн гүйцэтгэл үзүүлээд зогсохгүй мөн хүнд хэцүү эдийн засгийн нөхцөлд хэрхэн уян хатан байгааг харуулж болно.

Мөн илүү их судалгаа, мэдлэгтэй байдлаар бизнесийн үйл ажиллагааны талаар сурвалжлах нь бусдын мэдээнээс ялгарч, сайн бэлтгэж бодож төлөвлөсөн, оновчтой мэдээ мэдээллийг хайж байгаа илүү мэдлэг мэдээлэлтэй бизнес эрхлэгчдийг татна.

“Хэрвээ та компаниудын талаар мэдээлж байхдаа компанийн засаглалын талаар орхигдуулвал та уншигчдад мэдээний нэг хэсгийг л зөвхөн өгч байна гэсэн үг” гэж (Перугийн) Компаний оролцогчид (Stakeholders) сэтгүүлийн Christina Sevillano del Aguila зөвлөж хэлсэн байдаг. “Хөрөнгө оруулагчдын хувьд ч мөн ялгаагүй, тэдэнд буруу явдлаа залруулахын тулд компаниуд юу хийдэг талаарх хараат бус мэдээлэл хэрэгтэйгээс гадна ийм мэдээг үзэгчдийн сонирхолтой нийцүүлж ойлгоход хялбар байдлаар бичих ёстой”.

Энэхүү Удирдамжийг бэлтгэхэд Олон улсын Сэтгүүлчдийн төв(ОУСТ)-тэй хамтран ажилласан нь олон улсын, ялангуяа хүндрэл бэрхшээлтэй тулгарсан зах зээлүүд дээр ажиллаж байгаа сэтгүүлчдэд өргөн цар хүрээний туршлага болсон. Форумын зүгээс компанийн засаглалтай холбоотой туршлага, үр чадварыг өгөх бол харин ОУСТ нь мэдээг юу сонирхолтой болгодог, компанийн засаглалын гол гол элементүүдийн талаар бизнесийн сэтгүүлчдийн суралцаж мэдэх ёстой шаардлагуудтай тус Удирдамжийг тохирсон байгаа эсэхийг баталгаажуулдаг. Эдгээр үйл ажиллагаа нь сэтгүүлчдэд юу шаардлагатай болох талаар ойлголт өгөөд зогсохгүй мөн сургалтын хөтөлбөрөөр дамжуулж үүнийг хэрхэн түгээх ёстой талаар заана. ОУСТ нь энэхүү Удирдамжид дурдсанаас ч илүү өргөн цар хүрээний нөөц, туршлагатай болно.

Энэхүү Удирдамж нь бизнесийн сэтгүүлчдэд сургалт явуулахтай холбоотой Форумын болон ОУСТ-ийн туршлага, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн компанийн засаглалын чадамж бэхжүүлэх хэрэгсэл, мэдлэг олгох материал дээр тулгуурласан байдаг. Энэ нь компанийн засаглалын талаарх чухал

сэдвүүдийг хөндөж, бидний өөрсдийн ажиглалт болон түршлагатай сэтгүүлчдийн хувь нэмэр дээр үндэслэсэн эрэн сурвалжлах сэтгүүлзүйн жишээ, кейс судлалыг авч үзнэ.

Тус Удирдамж нь компанийн засаглалын тодорхой эх сурвалж болох зорилгогүй бөгөөд харин шинээр гарч ирж буй болон хөгжиж буй зах зээлд ажиллаж байгаа бизнесийн сурвалжлагч нарт маш хэрэгцээтэй чухал зарчмуудыг тодорхойлно. “Удирдамжийн тухай” гэсэн хэсэг нь Удирдамжийн зорилго, хэрэглээ болон үүрэг функцийг тайлбарлана.

Форумын бүхий л бүтээл, ажлын кейсийг гаргахад олон хүн, байгууллагуудтай өргөн цар хүрээнд хамтран ажиллаж тус Удирдамжийг гаргасан. Энэхүү удирдамжийг гаргахад оруулсан хувь нэмрийг нь “Талархал” хэсэгт тусгайлан талархаж сайшаан бичсэн болно.

*Олон Улсын Компанийн
Засаглалын Форумын тэргүүн*
Philip Armstrong



Манай хөтөлбөрийн зорилго бол компанийн засаглалын талаарх мэдээллийг бизнесийн ертөнц, олон нийтэд түгээн тараахад сэтгүүлчдэд онцгой үр чадварыг эзэмшүүлэх, өөрөөр хэлбэл зөвхөн хувь нийлүүлэгчид төдийгүй нийгэмд ихээхэн нөлөө үзүүлж болох компанийн үйл ажиллагааны талаар уншигчдад ойлгуулах сэтгүүлчдийн үр чадварын асуудал энд хамааралтай.

Хэн нь компанийг чиглүүлдэг вэ? Компанийн засаглалын талаар сурвалжлах удирдамжийг олон улсын мэргэжилтнүүдийн идэвхитэй оролцоо, хичээл зүтгэлийн ачаар гаргасан болно.

Олон улсын Компанийн засаглалын форум нь хэвлэл мэдээллийнхэнд зориулсан тус Удирдамжид хувь нэмрээ оруулсаны төлөө гол зохиогч **Margie Freaney** болон Олон улсын сэтгүүлчдийн төв, Форумын Хувийн хэвшлийн зөвлөх группын дор (цагаан толгойн дэс дарааллаар) нэр дурдсан дараах мэргэжилтнүүд, шүүмжлэгчид, гишүүдэд гүнээ баярлаж талархсанаа тусгайлан илэрхийлье.

Amira El Saeed Agag, Үйл ажиллагаа хариуцсан ажилтан
ОУСК-ийн зөвлөх үйлчилгээ, ЕГИПЕТ, МИНА

Simone Azevedo, Зохиогч Редактор,
Capital Alberto,
БРАЗИЛ

Tamal Bandyopadhyay, Дэд гүйцэтгэх захирал,
Mint,
ЭНЭТХЭГ

Vanessa Bauza, Харилцаа холбооны ажилтан,
ОУСК-ийн Байгаль орчин, нийгэм болон засаглалын хэлтэс, АНУ

Mahwesh Bilal Khan, Үйл ажиллагааны гишүүн ажилтан, ОУСК-ийн Ойрхи Дорнод болон Хойд Америкийн зөвлөх үйлчилгээ, ПАКИСТАН

Caroline Bright, Олон улсын бүтээгдэхүүн хариуцсан тэргүүн, Компанийн засаглал,
ОУСК-ийн Тогтвортой бизнесийн үйл ажиллагааны зөвлөх, АНУ

Johanna Carrillo, Хөтөлбөрийн тэргүүн захирал, Олон улсын Сэтгүүлчдийн төв, АНУ

Corina Cepoi, Захирал.
Мэргэжлийн сэтгүүлзүйн Chrisinau сургууль,
МОЛДОВА

Eric Chinje, Стратеги, харилцаа холбоо хариуцсан захирал, Mo Ibrahim сан,
ИХ БРИТАНИ

Juan Carlos Fernandez, Үйл ажиллагаа хариуцсан ахлах ажилтан, ОУСК-ийн Тогтвортой бизнесийн үйл

ажиллагааны зөвлөх – Зүүн Ази болон Номхон далай,
ВЬЕТНАМ

Craig Hammer, Хэвлэл мэдээлэл, засаглалын мэргэжилтэн, Дэлхийн банк институт, АНУ

Robert Holloway, Захирал,
gence France Press (AFP) сан, ФРАНЦ

Isimkah Ibuakah, Хуулийн зөвлөх, Нигерийн Компанийн засаглалын банкны хөтөлбөр – ОУСК-ийн Тогтвортой бизнесийн үйл ажиллагааны зөвлөх, Дэд Сахарын Африк, НИГЕРИ

Sonja Matanovic, Харилцаа холбооны захирал,
Олон улсын сэтгүүлчдийн төв,
АНУ

Edmond Mjekiqi, Стратегийн шинжээч
ОУСК-ийн Байгаль орчин, нийгэм болон засаглалын хэлтэс, АНУ

Peter Montagnon, Хөрөнгө оруулалтын ахлах зөвлөх,
Санхүүгийн мэдээллийн зөвлөл,
ЛОНДОН

Sharon Moshavi, Дэд Ерөнхийлөгч, Шинэ санаачлага,
Олон улсын сэтгүүлчдийн төв,
АНУ

Anne Molyneux
CS International,
АВСТРАЛИ/ИХ БРИТАНИ

Kiril Nejkov, Үйл ажиллагааны ажилтан, Компанийн засаглал, ОУСК – Европ болон Төв Азийн зөвлөх үйлчилгээ, МАКЕДОН

Adesinaola Odugbemi

Гадаад албаны хэлтэс,
Дэлхийн банк,
АНУ

John Plender, Тэргүүлэх зохиогч,

The Financial Times,
ЛОНДОН

Marjorie Pavia, Тэргүүлэх зохиогч,

The Financial Times,
ЛОНДОН

Loty Salazar, Мэдлэгийн менежментийн ажилтан,
ОУСК-ийн Тогтвортой бизнесийн үйл ажиллагааны
зөвлөх, АНУ

James D. Spellman

Strategic Communications XXX,
АНУ

Eugene Spiro, Төслийн ахлах ажилтан. ОУСК-ийн

Олон улсын компанийн засаглалын форум,
АНУ

Alexey Volynets, Мэдлэгийн менежментийн
гишүүн ажилтан, ОУСК-ийн Олон улсын компанийн
засаглалын форум, АНУ

Designer: Wendy Kelly,

WLK Design Group Инк,
АНУ

Энэхүү Удирдамжийг бизнес болон санхүүгийн салбарын талаар сурвалжлах зарим туршлагыг хэдийнээ эзэмшсэн сурвалжлагчид, редакторуудад зориулсан болно.

Удирдамжийн зорилго нь компанийг хэрхэн удирдан чиглүүлж байгаа, компанийн хувьцаа эзэмшигчид, компаний бусад оролцогчид (компаний шийдвэр, бодлого, үйл ажиллагаанас хамааралтай буюу тэдгээрт нөлөөлөх оролцогчид, тухайлбал, компаний зээлдүүлэгч, хувьцаа эзэмшигч, захирал, ажилтан, төрийн байгууллага, нийлүүлэгч, ажил гүйцэтгэгч, хэрэглэгч зэрэг) ноцтой үр нөлөө үзүүлж болох үйл явдлуудыг тодорхойлж мэдээгээ бичихэд туслах явдал юм.

Хэвлэл мэдээллийн манаачийн үүрэг, төлөөлөн удирдах зөвлөл нь хэрхэн ажилладаг, юу нь сайн засаглалыг бий болгодог, ямар санхүүгийн мэдээ гаргадаг, хувьцаа эзэмшигчдийн үүрэг юу болох, компанийн дотоод ажлуудын мэдээллийн чанартай зүйлсийг хэрхэн мөрдөж шалгах, ашиглах талаарх сэдвүүдийг хамарсан болно.

Сэтгүүлчид нь компанийг хууль, дүрэм журмуудыг зөрчиж байгаа эсэхийг харуулсан “улаан туг” буюу анхааруулах дохиог хэрхэн таних талаар сурна. Мэдээг сурвалжлах, бичих талаарх зөвлөмжүүдийн хүрээнд мэдээг ойлгомжтой, тэнцвэртэй, шударга болон итгэл үнэмшилтэй байдлаар боловсруулахад сурвалжлагчдыг удирдан чиглүүлнэ.

Тус Удирдамжийн гурван нийтлэг шинж чанар нь сурвалжлагчид мэдээлж буй сэдэв, сүрсан мэдлэгээ “итгэлтэй”-гээр ашиглахад тусалдаг.

Сурвалжлагчийн тэмдэглэлийн дэвтэр:

Бизнесийн гарамгай, шилдэг сэтгүүлчдийн зөвлөгөө

Мэдээний хэрэгслийн хайрцаг: Мэдээний санааг хэрхэн, хаанаас олж авах

Та юу мэдэх вэ? Удирдамжийн хичээл, сургалтуудыг ашиглах

Бүлэг бүр нь мэдээлж сурвалжилж буй компаниудын талаар гарч болзошгүй мэдээг олж таних, гол гол факт баримтуудыг ухаж судлах, дүгнэлтээ

тайлбарлах, ойлгомжтой бөгөөд сайн мэдээ бичихэд шаардлагатай мэдлэг, ур чадварыг эзэмшихэд сурвалжлагч нарт тусална.

- Компанийн засаглал гэж юу болох, энэ нь мэдээнд хэрхэн нөлөөлж болох. (1 дүгээр бүлэг, Сайн засаглал гэж юу болох, яагаад сэтгүүлчид үүнийг анхаарах ёстой вэ?)
- Бусад сурвалжлагчдын мэдээлж чаддаггүй компанийн төлөөлөн удирдах зөвлөл болон хороодын зүгээс мэдээг бичиж, агуулгыг нь гаргахад тэдгээрийн гүйцэтгэх үүргийг хэрхэн ойлгох. (2 дугаар бүлэг, бүх чухал төлөөлөн удирдах зөвлөл)
- Хувьцаат компаниудад хувьцаа эзэмшигч нь зөвхөн хувь нийлүүлэгч байгаад зогсохгүй мөн мэдээний санааны гайхалтай эх сурвалж болж байдаг. (3 дугаар бүлэг, Хувьцаа эзэмшигчдийн талаарх бүх зүйл)
- Компаниуд ямар бүтэц зохион байгуулалттай байдгийг ойлгосноор ТУЗ болон удирдлага хэрхэн харилцан ажилладаг, яагаад гэр бүлийн эзэмшлийн болон төрийн эзэмшлийн компаниуд үргэлж хувьцаа эзэмшигчид, төрийн дээд эрх ашгийн төлөө ажиллах боломжгүй байдаг талаар сэтгүүлчийг олж мэдэхэд тусална. (4 дүгээр бүлэг, гэр бүлийн болон төрийн эзэмшлийн компаниудын эргэн тойронд)
- Хууль эрхзүйн дагуух мэдэгдлүүд нь хаанаас юуг харж, харж байгаа зүйлээ хэрхэн тайлбарлахаа мэддэг сурвалжлагчдад онцгой мэдээ бичих арвиан эх сурвалж болно. (5 дугаар бүлэг, Шугамыг дагах: Дүрэм журмууд болон мэдээлэх зарчим)
- Санхүүгийн тайлангууд болон жилийн тайлангууд, ялангуяа чухал хэсгүүдийг нь олж уншдаг болсоноор ихэвчлэн сэтгүүлзүйн шуугиан тарьсан мэдээ гаргахад тус болно. (6 дугаар бүлэг, Тоон үзүүлэлтийн цаадах мэдээг олж харах)
- Мэдээгээ боловсруулах нь компаниуд хариуцсан сурвалжлагчдын гол хийх зүйл юм. Иймээс компанийн гүйцэтгэх удирдлагууд болон олон нийттэй харилцах албаны захирлуудаас ирж буй


дарамт, шахалтан дор ажилладаг. (7 дугаар бүлэг, Зөвлөмжийг бичих, мэдээлэх)

Бүлэг бүрийн төгсгөлд эх сурвалжийн талаарх хэсэг байгаа бөгөөд үүнд бүлгийн сэдэвтэй холбоотой үндсэн эх сурвалжуудыг жагсаан бичсэн. Удирдамжийн төгсгөлд Сонгосон эх сурвалжууд гэсэн хэсэг байх бөгөөд энэ нь компанийн засаглалын талаарх хэрэгцээтэй вэбсайт, зөвлөмжүүдийг өгнө. Толь бичиг нь компаниуд болон корпорацийн

засаглалын сэдвүүдийг хамарч хэрэглэгдсэн нэр томъёог тодорхойлж бичдэг.

Санамжууд: Бүх тоо нь ам.доллараар байна.
“Компани”, “корпораци” болон “аж ахуйн нэгж” гэдэг нэр томъёонууд нь бизнесийн нэгж, байгууллагын илэрхийлж, хоорондоо ялгаатай байдлаар хэрэглэгддэг.

АГУУЛГА



9 БҮЛЭГ 1

Сайн засаглал гэж юу болох, яагаад сэтгүүлчид үүнийг авч үзэх ёстой вэ?

БҮЛЭГ 2

19 Төлөөлөн удирдах зөвлөлийн талаарх бүхий л чухал зүйлс

БҮЛЭГ 3

29 Хувьцаа эзэмшигчдийн талаарх бүхий л зүйл

БҮЛЭГ 4

39 Гэр бүлийн болон төрийн өмчит байгууллагуудын эргэн тойронд

БҮЛЭГ 5

49 Шугамыг дагах: Дүрэм журмууд болон мэдээлэх зарчим

БҮЛЭГ 6

59 Тоон үзүүлэлтийн цаадах мэдээг олж харах

БҮЛЭГ 7

67 Зөвлөмжийг бичих, мэдээлэх

СОНГОСОН ЭХ СУРВАЛЖУУД

77

ТАЙЛБАР ТОЛЬ

82

Сайн засаглал гэж юу болох, яагаад сэтгүүлчид үүнийг анхаарч үзэх ёстой вэ?

“Компанийн засаглал муу байвал компаниудыг мөхөөж, захирлуудыг нь шоронд оруулж, олон улсын нягтлан бодох бүртгэлийн фирмийг дампууруулж, компаниуд болон засгийн газруудад аюул авчирна”

— *The Economist* (Төлөөлөн удирдах зөвлөлийн чухал зүүлэлтүүд)

Сайн сэтгүүлчид нь хамгийн мэдээлэлгүй хэвлэлийн мэдээгээр ч сайн мэдээ бичиж чадна. “Компанийн засаглал” гэдэг нэр томъёо дангаараа нь анхааруулгын дохиог дэлдэхгүй ч дараах үгс нь анхааруулах үүргээ гүйцэтгэнэ: *Луйвар, хулгай, гарз хохирол, мэдлэг чадваргүй байдал, давхар хэлцэл, гэр бүл-хамаатансах үзэл, эрх мэдлээ хэтрүүлэх, шамшигдуулах, ашиг сонирхлын зөрчил, бусдад давуу эрх олгох, авилгал хээл хахууль*

Дээрх нэр томъёо нь сэтгүүлчдийг энэ тухай олон нийтэд хүргэх сэдлийг төрүүлдэг бөгөөд учир нь эдгээр үгс сайн сэтгүүлзүйн үндэслэл болох онцгой бөгөөд шинэлэг мэдээг бичих боломж олгоно.

Гэвч компанийн засаглалын мэдээ нь зөвхөн гэмт хэргийн тухай биш юм. Тухайлбал хүний амьжиргааг сайжруулах шинэ бараа бүтээгдэхүүн, ажил үйлчилгээг дэлхий дахинд өгч их хувь заяаг бий болгосон эрэгтэй, эмэгтэй хүн, онцгой авъяастай удирдагчид, аугаа санаа сэдэл, баатар болон зөн билэгтний талаар байж болно.

Үндсэндээ засаглал гэдэг нь компани, эсвэл төрийн өмчит байгууллагуудыг чиглүүлэх хэрэгсэл болно. Дэлхийн олон улс оронд тогтоож хэрэглэж байгаа удирдамж, стандарт болон шилдэг арга практик нь сайн засаглалыг юу бүрдүүлдэг болохыг тодорхойлдог бөгөөд энэ талаар ойлголт сайтай бизнесийн сэтгүүлчид нь сайн болон муу засаглалын хоорондох ялгааг хурдан сурч мэдэж болно. Аль ч тохиолдолд энэ нь сайн мэдээ болох боломжтой.

Энэхүү Удирдамжаас та сайн, муу засаглалыг юу

бүрдүүлдэг, “улаан туг”-ийг хэрхэн тодорхойлдог, компанийн удирдагчид юу хийж байгаа талаарх мэдээллийг хаанаас олж авдаг болохыг сурч мэднэ. Мөн та олон улсын сурвалжлагчдын бичсэн мэдээ, уншигч болон үзэгчдэд ойлгомжтой, сайн мэдээ бичих арга техникийн талаар олж мэднэ.

Компанийн засаглал нь компанийг хянах, чиглүүлэхэд шаардлагатай дүрэм журам, зохион байгуулалтыг тогтоодог ба мөн түүнчлэн компаний үйл ажиллагаа, түүний гүйцэтгэлийн төлөө төлөөлөн удирдах зөвлөлөөс хувьцаа эзэмшигчдийн өмнө хүлээсэн үүрэг, түүн дотор менежментийг чиглүүлж, хянах журмыг тодорхойлдог.

Компанийн засаглалын тухай мэдээ нь ерөнхийдөө хүмүүсийн тухай юм. Өөрөөр хэлбэл, компанийн бодлогуудыг өөрчлөх хүсэлтэй хувьцаа эзэмшигчид, компанийн стратеги болон бодлогыг тогтоох үүрэг бүхий захирлуудын хоорондох тэмцэлдээн, өөр өөр санаа бүхий менежерүүдийн тухай юм. Ийм мэдээнд ил тод бөгөөд хариуцлагатай байдал чухал үүрэг гүйцэтгэдэг бөгөөд зохицуулагчид, хөрөнгийн биржүүд, хувьцаа эзэмшигчид, компанийн бусад оролцогчийн үйл ажиллагаа энд хамааралтай. Сэтгүүлчид нь хууль журам зөрчсөн томоохон зүйлсийн талаар онцолж ил тод байдалд чухал үүрэг гүйцэтгэнэ. Ил тод байдалгүйгээр үндсэн систем нь ч сайн ажиллаж чадахгүй.

“Компанийн засаглал гэдэг нь байгууллагын бүхэлд нь хамарч гэрэлтсэн нарны тухай асуудал юм” гэж Пакистан дахь Kashf Microfinance Bank ХХК-ийн гүйцэтгэх захирал Roshaneh Zafar хэлсэн байдаг.



Компанийн засаглалын товч тодорхойлж хэлвэл “Бизнесийн зан төлөвийг сайжруулах нь:

Яагаад бидэнд компанийн засаглал хэрэгтэй” гэжээ. (Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (ЭЗХАХБ): <http://bit.ly/J11k9R>

Олон сэтгүүлчид компанийн засаглалын талаар ойлгож мэдэлгүйгээр энэ талаар хэдийнээ сурвалжилж мэдээлсэн байдаг. Удирдлагын өөрчлөлт, эсвэл компанийн шинэ худалдан авалтын талаарх мэдээ нь энэ талаарх үгсийг дурдаагүй ч компанийн засаглалын талаар болно.

Сэтгүүлчдийн зүгээс мэдээнд голчлон анхаарах ёстой зүйлс нь компанийн стратеги, хяналт болон ил тод байдлыг ухаж мэдэх явдал юм. Сайн компанийн засаглал нь судалгаагаар баримтжуулсан илүү өргөн цар хүрээний нөлөөтэй байна. Учир нь:

- Хөрөнгө оруулалтыг хөхүүлэн дэмждэг,
- Хөрөнгө оруулагчийн хүлээлт, сонирхлыг сайжруулдаг, улмаар энэ нь компанийн хөрөнгө татан төвлөрүүлэх, эсвэл зээлийн өртгийг бууруулдаг,
- Компаниудын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлдэг,
- Эдийн засгийн хямралд тэсч үлдэхэд компанийг илүү сайн бэлтгэх,
- Авилгал, хээл хахуулийг бууруулах,
- Хувьцаа эзэмшигчдэд шударгаар харьцах,
- Нийгэмд ихээхэн нөлөө үзүүлдэг томоохон бизнесийг тэнцвэржүүлж, хяналт шалгалтын нэг хэсгийг бүрдүүлэх.

Компанийн өсөлт нь ялангуяа гадны санхүүжилтаас хамгийн их хамааралтай салбар, чиглэлүүдэд хүчтэй илэрдэг болохыг судалгаагаар харуулжээ. Мөн компанийн засаглалын чанар нь эдийн засгийн шоконд байх үед компанийн зан төлөвт нөлөөлж



Сайн засаглалын үзүүлэх нөлөөллийн талаар “10 дугаар хэсэг: Компанийн засаглал болон хөгжил”-аас харна уу <http://bit.ly/M2shli>

болно. Сайн засаглалтай компаниудын хувьцааны үнэ нь хямралын үед хэлбэлзэл багатай байдаг.

Сайн компанийн засаглал нь гэр бүлийн болон гэр бүл зонхилсон удирдлагатай компаниудад энэ төрлийн ихэнхи компаниудыг сөнөхөд хүргэдэг өв залгамжлахын төлөөх тэмцэлийг амжилттай даван туулахад туслах боломжтой гэж Хонгконгийн Хятад судлалын их сургуулийн Эдийн засаг, санхүүгийн институтын профессор, захирал Joseph Fan хэлжээ. (<http://bit.ly/M2txF7>).

Сэтгүүлчид хэрхэн манаач болох вэ

Хувьцаа эзэмшигчдийг ихээхэн алдагдалд хүргэх, эдийн засагт нөлөөлж болох үйл явдлыг илчлэх, үнэн дүр царайг нь ил гаргаж байгаа ажиллагаа нь хэвлэл мэдээллийн байгууллага манаачийн үүргээ гүйцэтгэж байгаа нэг хэлбэр юм. Компаниудын удирдлагын чадварт анхаарал хандуулах, захирлууд болон удирдлага нь зөв шийдвэр гаргаж байгаа эсэхийг тодруулах, тэдгээрийн үйл ажиллагаа нь компанийн өмнө хүлээсэн үүрэг хариуцлагатай хэрхэн холбогдож байгааг эсэхийг нягтлах нь сэтгүүлчийн ажил юм.

Эдгээр асуулт нь эрс тэс ялгаатай үзэгч, уншигчдад мэдээ байдлаар хүрч үйлчилж болно. Үүнд харилцагчид, хөрөнгө оруулагчид, татвар төлөгчид, бизнесийн удирдлагууд, захирлууд, зохицуулагчид, бодлого тогтоогчид болон хэрэглэгчид орно.

Компанийн урт хугацааны ашиг сонирхол болон хувьцаа эзэмшигчдийн туйлын ашиг сонирхлын төлөө захирлууд ажиллаж байгаа эсэхийг сурвалжлагчид таньж мэдэж сурсанаар өөрсдийн мэдээлж байгаа компаниудын талаар илүү нарийн судалж мэдээлэх анхны алхам болно. Хүлээн зөвшөөрөгдсөн практикуудыг дагаж мөрдөөгүй захирлууд, менежерүүдээс яагаад ийм үйлдэл гаргасныг нь асуух ёстой. (Төлөөлөн удирдах зөвлөл нь хэрхэн стратегийг чиглүүлдэг, хувьцаа эзэмшигчийн ашиг сонирхлыг хамгаалдаг, төлөөлөн удирдах зөвлөл болон менежмент нь хэрхэн харилцан ажилладаг талаар илүү нарийвчилсан мэдээлэл авахыг хүсвэл 2 дугаар бүлгийг үз).

Сайн засаглалыг тодорхойлох, таних

Гэхдээ сайн засаглалыг юу бий болгодог вэ? Эдүгээр засаглалын зорилгуудад хүрэхэд захирлууд болон менежерүүдийн дагаж мөрдөх ёстой зарчмуудыг тодорхойлж бичсэн хууль, удирдамжуудтай 70 гаруй улс орон байна. Ингэхдээ



Компанийн урт хугацааны ашиг сонирхол болон хувьцаа эзэмшигчдийн туйлын ашиг сонирхлын төлөө захирлууд ажиллаж байгаа эсэхийг сурвалжлагчид таньж мэдэж сурсанаар өөрсдийн мэдээлж байгаа компаниудын талаар илүү нарийн судалж мэдээлэх анхны алхам болно.

заавал дагаж мөрдөх хуулийн хэлбэрээр бус ихэвчлэн сайн дураар дагаж мөрдөхийг уриалсан хэлбэртэй байдаг. Эдгээр хууль тогтоомжид “шилдэг арга практик”-ийг тодорхойлсон байдаг бөгөөд сайн засаглалыг дэмжих тусгай бодлого, дүрэм журмуудыг тодорхойлох зорилготой.

Ийм хууль тогтоомжуудын зөвлөмжөөс нилээд зөрчсөн компаниуд нь тусгай хяналт шалгалтанд орох бөгөөд сайтар эрэн сурвалжилсан мэдээг гаргаж болно. Ийм зөрчлийг онцолж мэдээлэх нь компаниуд хууль бусаар ажиллаж байгаа эсэхийг хэвлэл мэдээллийн зүгээс анхаарч байгаа арга замуудын нэг билээ.



Өөрийн улс орны засаглалын тухай хууль тогтоомжуудыг бусад улс орнуудтай харьцуул.
<http://bit.ly/lrtlHR>

Жишээлбэл: ихэнх хууль тогтоомжуудад төлөөлөн удирдах зөвлөлийг хэд хэдэн хараат бус гишүүдтэй байхыг шаарддаг. “Хараат бус” гэдэг нь компанийн удирдлагатай, эсвэл компанитай холбогдолтой бусад хүмүүстэй бодитой харилцаа холбоогүй этгээдийг үндсэндээ хэлнэ. Ашиг сонирхлын зөрчилгүй гэсэн утгаараа ийм гишүүн нь компани болон түүний хувьцаа эзэмшигчдийн үр ашгийн төлөө шийдвэр гаргах боломжтой байна.

Дээд шатны менежерүүдийн төрөл төрөгсөд, эсвэл найз нөхөдөөс бүрдсэн Төлөөлөн удирдах зөвлөл нь хувьцаа эзэмшигчдийн ашиг сонирхлын төлөө

тэнцвэртэй, хяналттай байдлаар үйлдэл гаргах нь эргэлзээтэй байдаг.

Олон оронд байгаа нийтлэг нэг зүйл бол компаниуд нь өөрийн ноёрхолоо тогтоосон нэг гэр бүлийн гишүүдээс бүрдсэн хувьцаа эзэмшигчидтэй байдаг явдал юм. Энэ нь ялангуяа шинээр хөгжиж буй зах зээлүүдэд түгээмэл үзэгдэл юм. Мэдээж гэр бүлийн гишүүд нь төлөөлөн удирдах зөвлөл, менежментэд давамгайлж ордог ба тусгай хувьцааны тусламжтайгаар бусад хувьцаа эзэмшигчдийн санал өгөх эрхийг хянах замаар нөлөөллөө хэрэгжүүлдэг. Энэ нь компанийн хувьцааны бага хувийг эзэмшигч байгаа гэр бүлийн хувьд ч боломжтой байдаг.

Түүнчлэн шинээр хөгжиж буй зах зээлд нийтлэг байдаг тохиолдол нь төлөөлөн удирдах зөвлөл болон менежментийг төрөөс бүрдүүлсэн төрийн хяналттай, эсвэл төрийн эзэмшилтэй байгууллагууд байдаг. Энэ нь хувьцаа эзэмшигчдийн үр ашгийн төлөө биш харин улс төрийн шалтгааны улмаас шийдвэр гаргахад хүргэдэг.

Засаглалын асуудлууд нь гол мэдээг бүрдүүлнэ

Гэр бүлийн эзэмшлийн компаниуд нь эдийн засгийн сайн сайхан байдлыг хангах үндэс суурь байдаг. Тухайлбал, АНУ-ын Форд Мотор, Энэтхэгийн Тата групп болон Туркийн Сабанчи Холдинг компанийг дурдаж болно. Гэхдээ бас гэр бүлийн эзэмшилтэй компаниуд нь компанийн засаглалтай холбоотой ноцтой зөрчилтэй ч байх боломжтой.

Жишээлбэл, Энэтхэгийн Сатям Компьютер Системс ХХК-ийн гэр бүлийн гишүүд гэр бүлийн эзэмшлийн

бусад хоёр компанийн хөрөнгийг шилжүүлж авахаар оролдож байсан.

Энэтхэгийн Times-д мэдээлсэнээр, “Сатямын хэрэг 2009 оны 1 дүгээр сарын 7-ны өдөр гарсан. Тус компанийг үндэслэн байгуулагч B.Ramalinga Raju хэд хэдэн жилийн турш бүртгэл тооцоог гүйвүүлж зөрчил гаргажээ.” Тус луйврыг илчилж төлөөлөн удирдах зөвлөлд бичсэн захидалд Raju онцлохдоо “сүүлийн жилүүдэд компанийн бүртгэл, тооцоонд тусгасан болон үйл ажиллагааны бодит ашгийн хоорондох ахиуц зөрүү нь өсөн нэмэгдэх төлөвтэй байгаа. Энэ нь улмаар удирдан хянах боломжгүй хувь хэмжээнд хүрсэн...” гэжээ. Тэрээр цааш нь тодорхойлж бичихдээ “яг л бар унасантай адил, идэж завшилгүйгээр хэрхэн ажиллаж байсныг огт мэдэх арга алга” гэсэн байна.

Хожим нь Сатям компанийн хөрөнгийг хувьцаа эзэмшигчдээс буруутай этгээдүүдын үр ашгийн төлөө гүйвүүлсаны төлөө торгууль оногдуулах, ийм зүй бус хэргээс хамгаалах, эсвэл хувьцаа эзэмшигчдийг хамгаалсан хэд хэдэн хууль тогтоомжийг зөрчсөн болох нь тодорхойлогдсон.



Сатямын хэргийн талаар илүү мэдээлэл авахыг хүсвэл

<http://reut.rs/lcj4hL>

<http://scr.bi/IA3vm7>

<http://bit.ly/HEcrLX>

Эрсдлийг таамаглах

Компанийн засаглалын хууль тогтоомжуудад тодорхойлсон нэг шилдэг практикт компанид тулгарч болзошгүй эрсдлийг урьдчилан таамаглах, эрсдлийг бууруулах ажлыг зохион байгуулах үр чадварыг компаний удирдлагаас шаардсан байдаг. Компаниуд нь ашгийг олох хэмжээнд эрсдэл хүлээдэг. Төлөөлөн удирдах зөвлөл нь бизнесийн бүх эрсдлийг тодорхойлж, үнэлж, мэдээлж, эрсдлийг бууруулах арга хэмжээг авч байгаа эсэхийг баталгаажуулах үүрэгтэй.

Эрсдлийг удирдан зохион байгуулах үүрэг хариуцлага нь олон нийтийн эрүүл мэндийн асуудлыг цочроосон Фукушимагийн Дай-Чи цөмийн станцыг сүйрүүлсэн 2012 оны Японы газар хөдлөл, цунамигийн дараа гарсан гол асуудалтай урган гарч ирсэн.

Японы эрчим хүчний хувьцаат компани болох Tokyo Electric Power Company Инк(TEPCO)-ийн захирлууд өмнө нь тодорхойлчихсон байсан эрсдлүүдэд хангалттай хэмжээнд бэлтгэж чадаагүй болох талаар яагаад сэтгүүлчид, шүүмжлэгчид асуусан вэ? Яагаад тус компанид хараат бус төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд, эсвэл эрсдлийн удирдлагын хороо байгаагүй вэ? Эдгээр эрсдлийг арилгах алхмууд, эрсдлүүдийг тодорхойлох зохих ёсны бодлогууд байгаагүй вэ, яагаад ийм цөмийн гамшиг болсон вэ?

“TEPCO цунами болно гэдгийг урьдчилж таамаглаж чадаагүй, гэхдээ ийм явдал гарахад бэлэн байх ёстой байсан” гэж шинжээч, судлаач Nathaniel Parish Flannert бичсэн. Түүний онцлон тэмдэглэсэнээр цөмийн байгууламж нь дунд зэргийн хэмжээний цунамид ч эвдрэх аюултай байсан гэж гадны мэргэжилтнүүд анхааруулж байжээ.

Гэхдээ эдгээр шүүмжлэл, асуудлууд нь ихэвчлэн үйл явдал, фактын дараа гарч ирсэн.

Компаниуд засаглалын сайн зарчим, арга практикийг хэрхэн дагаж мөрдөж байгаа эсэхийг сэтгүүлчид шүүж тунгаахад туслах, компанийг үнэлэхэд туслах арга хэрэгслүүдийн нэг бол компанийн засаглалын үзүүлэлтүүд юм. Олон улс оронд эдгээр үзүүлэлтийг жил бүр гаргадаг тул мэдээ бэлтгэх санаа болдог.

Тухайлбал, Дэлхийн банкны нэг хэсэг болох Олон улсын санхүүгийн корпораци (ОУСК) нь 2011 оны Вьетнамын компанийн засаглалын үнэлгээний үзүүлэлтийг гаргасан бөгөөд үүнд хувьцаа эзэмшигчдийн эрх, ашгийг хамгаалах системийг сайжруулахыг шаардсан байдаг. Ингэхдээ Ханой болон Хо Чи Минх хотын хөрөнгийн биржүүд дээр бүртгэлтэй 100 томоохон компаниудын засаглалын арга барилуудыг судалж авсан үзсэн байна.

Хууль тогтоомжууд, компанийн засаглалын үнэлгээний үзүүлэлтүүд нь тухайн улс оронд



Энэ талаарх мэдээг үзэхийг хүсвэл:

<http://bit.ly/HEcwiH>

Энэ талаарх холбоосыг үзэхийг хүсвэл:

<http://bit.ly/I73s2j>



Facebook, LinkedIn зэрэг нийтийн сүлжээний сайтууд нь онцгой мэдээлэл, ялангуяа ажилтнуудын нүдээр харсан зүйлсийн талаар мэдээлэл өгч болно. Өөр нэг ач холбогдолтой хэрэгсэл бол компанийн шүүмжлэгч нарын бичсэн блогууд байж болно.

компаниуд нь нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн шилдэг арга практикуудыг дагаж мөрдөж байгаа эсэхийг тодорхойлоход сэтгүүлчдэд шалгах хуудас болно.

(Энэхүү бүлгийн мэдээний санааг илэрхийлсэн хэрэгслийн хайрцаг нь хууль тогтоомжууд болон компанийн засаглалын үнэлгээний үзүүлэлтүүд дээр тулгуурласан болно.)

Муу засаглалын үр нөлөөлөл

Компани нь засаглалын гол зарчмуудыг дагаж мөрдөөгүй, ёсзүйн болон нягтлан бодох бүртгэлийн зарчмуудыг зөрчсөн, эрсдлийн менежмент, хяналтыг буруу хэрэгжүүлсэн, төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэр гаргалт үр дүнгүй болсон тохиолдолд холбогдох үр нөлөө нь ноцтой байж болно.

Хувьцааны үнэ нь хүчтэй унаж, хувьцаа эзэмшигчдэд сөрөг нөлөө үзүүлж, зарим тохиолдолд тухайн компанийн үйл ажиллагаа явуулж байгаа салбарт ч сөрөг нөлөө үзүүлж болно. Тухайн компани нь ажлын байрны цомхотгол хийх хүртэл арга хэмжээ авахад хүрч, улмаар тухайн бүс нутагт бусад хор хохиролтой үр нөлөөг үзүүлж болно.

Зарим ноцтой тохиолдолд засгийн газраас тусламж авахад хүрч, татвар төлөгчдөөр зардлыг нь төлүүлэхэд хүргэж болно. 2011 онд Bank of Moscow засгийн газраас тусламж авсан бөгөөд зээлийн өртөг нь 14 тэрбум ам.доллар буюу Оросын дотоодын нийт бүтээгдэхүүний 1 хувьтай тэнцэх үзүүлэлт болсон.

Мэдээнүүд нь ихэвчлэн хувийн бизнесийн сонирхолтой онцлог зүйлсээр дүүрэн байдаг. Улс орны хамгийн том корпорациудыг удирддаг маш нууцлаг бөгөөд хүчирхэг бизнес гэр бүлүүд, төрийн сайд асануудын талаар сэтгүүлчид олж мэдэж бичих хэрэгтэй болно. Ийм мэдээг бичихэд тухайн бизнесийг залгамжилж авах удам угсааны асуудал маш чухалд тооцогддог.

Энэтхэг улсын хамгийн том олон салбарт үйл ажиллагаа явуулдаг Тата Группын захирал 75 настай Ратан Татаг залгамжлах этгээдийн талаар тус улсын болон олон улсын хэвлэл мэдээллээр онцлон ярьж, шуугианд дэгдсэн. Залгамж халааны асуудал нь зөвхөн тухайн компанид нөлөө үзүүлээд зогсохгүй мөн тухайн улсын эдийн засагт их хэмжээний нөлөө үзүүлнэ. Тата Группын 100 охин, хараат компани нь л гэхэд олон улсын эдийн засаг, ажлын байрны гол хөдөлгөгч хүч болж байдаг.

2011 оны 11 дүгээр сард энэ талаар шийдвэр гарахад Тата группын хамгийн том хувьцаа эзэмшигчийн хүү Cyrus Mistry шинэ удирдагч болж, түүний давуу болон сул талуудын талаар олон шуугиан тарьсан мэдээ гарсан.

Компанийн засаглалын мэдээ нь бүхэлдээ далд өрсөлдөөн тэмцээний талаар ч байж болно. Тухайлбал, Энэтхэгийн улсын Reliance компанийн төлөө ах дүүс Амбани нар тэмцэлдэж, компанийн бизнесийг хэрхэн хуваах талаарх маргаан нь улс орны эдийн засагт бүхэлд нь аюул тарьсан.



See an example of a story about the Ambani brothers at:
<http://tgr.ph/I73Ail>

Юу асуух, хаанаас олж хайх талаар мэдэж байх

Ах дүүс Амбанигийн хэрэг шиг мэдээг сурвалжлахын тулд сэтгүүлчид компанийг өөрчлөх дохионуудыг хэрхэн таних, ямар асуулт асуухаа мэдэж байх

ёстой. Үүнд мэдээж тухайн компаниудын захирал, удирдлага нар хэрхэн ажиллаж байгаа, мөн компанийн сайн засаглалын талаар гүн гүнзгий мэдлэг, ойлголттой байх шаардлагатай.

Хөрөнгийн бирж дээр бүртгэлтгүй компаниуд, ялангуяа гэр бүлийн эзэмшлийн компаниудын хувьд ихэвчлэн маш нууцлаг байдаг бол төрийн өмчит олон компаниуд найдвартай мэдээг гаргадаггүй, мэдээллийн найдвартай эх сурвалж биш байх жишээтэй. Ийм нууцлаг байгууллагуудын талаар мэдээ бичихэд сурвалжлагчид нь компанийн дотроос болон гаднаас эх сурвалж мэдээлэл олж мэдээг бэлтгэх хэрэгтэй болдог.



Энэ талаарх мэдээний жишээг харахыг хүсвэл:
<http://bit.ly/IA4ymd>

Компаний ажилчид, бэлтгэн нийлүүлэгчид, өрсөлдөгчид, албан ёсны борлуулагч нар нь ихэвчлэн тухайн компанийг харах бас нэг өнцөг байдгийг санах хэрэгтэй. Facebook, LinkedIn зэрэг нийтийн сүлжээний сайтууд нь онцгой мэдээлэл, ялангуяа ажилтнуудын нүдээр харсан зүйлсийн талаар мэдээлэл өгч болно. Өөр нэг ач холбогдолтой хэрэгсэл бол компанийн шүүмжлэгч нарын бичсэн блогууд байж болно. Аль ч тохиолдолд сэтгүүлчид нь албан бус бүх мэдээг шалгаж баталгаажуулах ёстой бөгөөд мөн зарим ажилчид, блог бичигчдэд байж болох мэдээ, бас өширхсөн үйлдлийн талаар ойлгож мэдэж байх ёстой.

Компанийн удирдах түвшний менежмент нь ярилцлага өгөхөөс татгалзсан байж болох ч компанийн санхүүгийн тайлангууд болон бусад баримт бичгүүд, зохицуулах байгууллагын тайлангуудыг уншиж, шинжлэх талаарх мэдлэг нь мэдээг бичих үндэслэл болно.

Wall Street сэтгүүлийн сурвалжлагч Jonathan Weil нь Enron Корпорацийн талаарх АНУ-ын Үнэт цаас, арилжааны газрын мэдээг шалгаж, нягтлан бодох бүртгэл болон үүсмэл хэрэгслүүлийн мэргэжилтнүүдтэй зөвшилцөж, үүсмэл хэрэгслүүдийн нягтлан бодох бүртгэлийг нарийвчлан судлахад хоёр сар зарцуулсан байна. Улмаар тэрээр 2000 оны 9 дүгээр сард дээрх компанийн мэдээлсэн ашиг орлогын үзүүлэлт зөрчилтэй болох талаар мэдээлжээ.

Эхэндээ түүний нийтлэлд ихээхэн ач холбогдол

өгсөнгүй. Гэхдээ эцэст нь хэвлэл мэдээллийн зарим шинжээчид тус компанийн нягтлан бодох бүртгэлийн зарчмууд асуудалтай болох талаар эхний шинж тэмдгүүдийг дурдаж, Weil-ийн мэдээг онцолж эхэллээ. Энэ нь компанийн хувьд тэсрэлт болж, дээд түвшний гүйцэтгэх удирдлагуудыг нь гэмт хэрэгт дуудаж, АНУ-ын түүхэнд байгаагүй компанийн хамгийн том гэмт хэрэг болж мэдэхээр байсан юм.

Үл итгэх үзэл, шургуу хөдөлмөр, сайн эх сурвалж

Сэтгүүлчид Enron компанийн талаар таагүй мэдээг нийтлэхээс өмнө тус компанийн луйврын үйл ажиллагааны талаар хэд хэдэн жилийн турш яригдаж байсан тухай Michael J. Borden санхүүгийн сэтгүүлчдийн үүрэг оролцоог судалж бичихдээ онцолсон байдаг.

Enron компанийн талаар сэтгүүлчдийн мэдээлсэн зүйлсийн талаар тэрээр онцлохдоо “энэ бол үл итгэх үзэл, шургуу хөдөлмөр, нягтлан бодох бүртгэлийн тайлангуудыг шинжлэх ур чадвар болон шинжээчид, бусад мэргэжилтнүүдийн хамтын ажиллагаа” гэсэн байна. Нарийн нягт мэдээ бэлтгэх талаарх нөгү-хаутай байснаар сурвалжлагч нь нийгэм, эдийн засагт өөрчлөлт, шинэчлэлд авчиргах хууль эрхзүй болон зохицуулалтын хариу арга хэмжээг бий болгоход хурдасгуур буюу катализаторын үүрэг гүйцэтгэж болох юм.

Сэтгүүлчид нягтлан бодох бүртгэлийн ахисан шатны зэрэг авахын тулд их дээд сургуульд суралцаж, ийм мэдлэг чадварыг хэрхэн олж авах вэ?

Зарим тохиолдолд асуудлыг гадны мэргэжилтэн тодруулж өгдөг бөгөөд энэ нь бүхий л шатанд сайн эх сурвалжтай болох шаардлагатайг харуулж байна.

Тухайлбал, Оросын эрчим хүчний Газпром компанийн талаар гадны нэр хүндтэй хэвлэл мэдээллээр дамжуулж нэгэн хэджи сангийн менежер хэд хэдэн сэтгүүлчдэд анхааруулсан. Өөрөөр хэлбэл Газпром компани найз нөхөд, төрөл төрөгсдийн удирдаж хянадаг байгууллагуудад хөрөнгөө шилжүүлж байгааг мэдээлсэн байна. Эцэст нь компанийн гүйцэтгэх удирдлага огцорч, Газпром компани бусад өөрчлөлт шинэчлэлтийг хийсэн байдаг.

Эдрээтэй байдлыг ойлгомжтой болгох

МЭДЭЭНИЙ ХЭРЭГСЛИЙН ХАЙРЦАГ

Мэдээний санаа: Таны мэдээлж байгаа компаниуд улс орны хэмжээнд тогтоосон сайн засаглалын талаарх хууль тогтоомжуудыг хэрхэн дагаж мөрдөж байна вэ? Мэдээ болж мэдэх компанийн засаглалын талаарх хууль журмуудад аливаа өөрчлөлт байна уу?

Түүнчлэн өөрийн улс орныг хөрш зэргэлдээ улс орнуудтай харьцуулахад компаниуд нь сайн засаглалын арга аргуудыг хэрхэн дагаж мөрдөж байгаа эсэхийг нягтлаж мэдээ бичиж болно. Ил тод байдал болон нээлттэй байдал гэсэн зөвхөн нэг асуудлыг энд авч үзэхэд болно. Доорх асуудлуудад компанийг харьцуулж судал. Үүнд:

- Хөндлөнгийн аудитортой байна уу? Хөндлөнгийн аудитор нь тухайн улсдаа, эсвэл олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн аудитын компани эсэх? Ашиг сонирхлын ямарваа зөрчилтэй байна уу?

Торонтогийн их сургуулийн санхүү, бизнесийн эдийн засгийн профессор, Александр Дик мэдээ компаниудад хэрхэн нөлөөлж байгааг судалсан бөгөөд тэрээр хэлэхдээ: “Засаглалын талаарх мэдээлэлтэй холбоотой бэрхшээлтэй асуудал гэвэл хир ээдрээ зангилаатай байгаа талаар юм. Хэрвээ ийм ээдрээ зангираагүй бол хувьцаа эзэмшигчид ямар нэгэн зүйл хийж боломжтой байна... Компанийн үйл ажиллагаанд оролцож байгаа талуудын хувьд болж байгаа зүйлсийг нуух, төөрөгдөлд оруулах гэсэн оролдлого байдаг” гэжээ.

Ийм л учраас бизнесийн сэтгүүлчдийн хувьд уншигч, үзэгчдэд таатай байдлаар баримтуудыг мэдээлэх, нарийн төвөгтэй нягтлан бодох бүртгэлийн манёврын

- Захирлууд нь компанийн хувьцааг худалдах, худалдан авахдаа энэ талаар мэдээлдэг үү? Ингэхдээ энэ нь цаг хугацаандаа байдаг уу?
- Тухайн компани нь захирлуудын танилцуулга, туршлага ур чадвар болон төлөөлөн удирдах зөвлөлийн бусад харилцаа холбооны талаар хир их мэдээлэл өгдөг вэ? Энэ мэдээнд нь ашиг сонирхлын аливаа зөрчил байдаг уу? Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд нь хараат бус байна уу?
- Компанийн удирдлага болон захирлуудын цалин хөлсний талаар хир өргөн цар хүрээнд мэдээлж байна вэ? Энэ нь компанийн бусад аргуудтай нийцэж байна уу?
- Хараат бус захирлуудад цалин хөлс олгодог уу? Хэрвээ үгүй бол тэдгээрийг төлөөлөн удирдах зөвлөлд ажиллуулахын тулд хэрхэн сэдэлжүүлдэг вэ?
- Компаниуд нь өөрсдийн стратеги болон таамаглаж байгаа эрсдлүүдийн талаар яаж мэдээлдэг вэ?

Энэ сэдвийн талаарх жишээг харахыг хүсвэл:
<http://bit.ly/ljIFaY>

талаар бичихдээ мэргэжлийн үг хэллэгээс зайлсхийх нь маш чухал байдаг. Нэр томъёог тодорхойлж тайлбарлаж, мэргэжлийн үг хэллэгээс зайлсхийж, ойлгомжтой байдлаар мэдээ бичих нь уншигч үзэгчдийг татахад тусална. Учир нь уншигч, үзэгчид дэндүү мэргэжлийн, гүн гүнзгий мэдээг хайхрахгүй байж болно.

Мэдээний эхэнд явах

Сүүлийн хорь гаруй жилийн турш авилгал хээл хахуулийн талаарх мэдээ зонхилох болжээ. Гэхдээ ихэнх тохиолдолд компани үр нөлөөнд автсаны дараа үйл явдлыг дагаж мөрдөх загвараар ажиллаж байсан.

Тухайлбал, Сатямагийн мэдээнд дээр ч дээрх байдал



Засаглалын талаарх мэдээлэлтэй холбоотой бэрхшээлтэй асуудал гэвэл хир ээдрээ зангидраатай байгаа талаар юм. Хэрвээ ийм ээдрээ зангираагүй бол хувьцаа эзэмшигчид ямар нэгэн зүйл хийж боломжтой байна...”

— Торонтогийн их сургуулийн санхүү, бизнесийн эдийн засгийн профессор, Александр Дик

ажиглагдсан. Нягтлан бодох бүртгэлийн мэдээллээ олон нийтэд буруу мэдээлсэнээс болж компанийг сүйрэлд хүргэсэн бөгөөд тухайн үйл явдал болсоны дараа л холбогдох мэдээ нь гарч байсан.

PricewaterhouseCoopers хэмээх хөндлөнгийн аудитор Сатямын буруу санхүүгийн тайлан тэнцлүүдийг хэд хэдэн жилийн турш баталгаажуулсаар ирсэн.

Хожим хойно нь сэтгүүлчид болон бусад шүүмжлэгчид нар Сатямын аудиторууд үнэхээр хараат бус мэргэжилтнүүд байсан эсэх талаар эрэн сурвалжилж, хэдэн сая бэлэн мөнгө алга болсон байхад аудиторууд яагаад анхааруулж мэдээлээгүй талаар асуулт тавьж байсан.

Ийм хэрэг болохоос өмнө ердөө нэг жилийн дотор Сатям компани Компанийн Засаглалын Дэлхийн Зөвлөлөөс компанийн засаглалын үлгэр жишээ Golden Peacock шагналыг авч байсан байх жишээтэй. Дараа нь тус Зөвлөл шагналаа буцааж, компанийг материаллаг мэдээ баримт өгөөгүй гэж гомдол гаргаж байсан.

Харин Business Week-ийн сурвалжлагч Beverly

Behan бичихдээ Сатямын төлөөлөн удирдах зөвлөл сайн компанийн засаглалын практикаар даажигнаж байгаа нь тодорхой гэж бичсэн байдаг. Сэтгүүлчид санхүүгийн үр чадвар дутмаг төлөөлөн удирдах зөвлөлийн бүтэц бүрэлдэхүүн нь хараат бус гишүүдтэй байсан ч компаний удирдлагаас хараат бус байж чадаагүй, (үүнээс болж сайн компанийн засаглалтайд тооцогдсон) болохыг эрэн сурвалжилж мэдэж болох байсан.

Сатямын хэрэг дээр төвлөрч авч үзэхэд гайхалтай бизнесийн шагнал болон жил бүрийн тайлангууд ч компаниудыг хууль ёсоор, ёсзүйтэй ажиллаж байгаа эсэх баталгаа болохгүй нь харагдаж байна.

Хамгийн их дуулиан дагуулсан бизнесийн авилгалын тухай хэргүүдийн нэг бол Хорватад болсон үйл явдал болж байна. Подравка хэмээх хүнсний чиглэлийн алдартай компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд болон менежерүүд нь 2009 оноос хойш гурван жилийн турш будлиан тарьж, компанийн мөнгийг өөр компанид хөрөнгө оруулан хувьцааг нь худалдаж авах замаар өөр компанийг худалдаж авахын тулд хууль бус үйлдэл гаргаж, тодорхой гишүүд үгсэн



СУРВАЛЖЛАГЧИЙН ТЭМДЭГЛЭЛИЙН ДЭВТЭР

“Хэрвээ та санхүүгийн тайлангуудыг хэрхэн унших талаар мэдлэгтэй байсан бол компанийг удирдаж байгаа этгээдүүд, эсвэл тэдгээрийг хамгаалсан зохицуулах байгууллагуудын албан ёсны мэдээнд найдаж, тэдгээрт тулгуурлан мэдээгээ бэлтгэдэг бусад сурвалжлагчаас ялгарахад тус болно”

— Jonathan Weil, Enron-ийн мэдээг хамгийн их бичсэн Wall Street-ийн сурвалжлагч асан, одоо Блүүмбергийн мэдээний редактор болсон.

Эх сурвалж: Аудитын сурвалжлага, Ryan Chittum, Columbia Journalism Review.

Эрэн сурвалжлах сэтгүүлзүй бол өөр хэрэг. Үүнд сурвалжлагчийн санаачлага, сэтгэн бодох чадвар шаардлагатай бөгөөд өөрөөр хэлбэл судлагдаагүй газар нутгийг судалж, шинэ нээлт хийж, холбоо хамааралтай ажиллана гэсэн үг...



хуйвалдаж байжээ.

Хэвлэл мэдээллийн ертөнцөд Хорватын дээр дурдсан компанийн шүүх хэрэг нь хамгийн том хэргүүдийн нэгэнд тооцогдож байсан бөгөөд компанийн хуучин гүйцэтгэх удирдлагууд, бизнесийн түншүүд нь хамгийн багадаа 54 сая еврог завшсан хэрэгт унаад зогсохгүй тухайн хэрэг улам даамжирч тус улсын дэд ерөнхий сайдыг хүртэл огцроход хүргэсэн байна. Түүнийг ч энэ хэрэгт холбоотой гэж үзсэн.

Подравка компанийн удирдлага, хяналтын зөвлөл нь өөрчлөгдөж солигдсон боловч 2012 оны 3 дугаар сард ч дээр дурдсан хэрэг анхаарал татсан хэвээр байлаа.

Хэрэг болсоны дараа учир шалтгааныг нь задлан шинжилж байсаны оронд ийм явдал болохоос өмнө компанийн үйл ажиллагааны талаар бичих нь тайлбарлах сэтгүүлзүй (зарим тохиолдолд “археологийн” сэтгүүлзүй ч гэдэг) болон эрэн сурвалжлах сэтгүүлзүйн хоорондох ялгааг харуулж байна. Тайлбарлах сэтгүүлзүй нь тухайн үйл явдал хэрхэн яагаад гарав гэдгийг авч үздэг. Ийм төрлийн сэтгүүлзүй нь үнэ цэнэтэй, тайлбарласан байж болно. Ийм мэдээг ихэвчлэн зохицуулах байгууллага, эсвэл шүүхийн үйл ажиллагааны үр дүнгийн дараа бичдэг.

Харин эрэн сурвалжлах сэтгүүлзүйн хувьд ялгаатай. Үүнд сурвалжлагчийн санаачлага, сэтгэн бодох чадвар шаардлагатай бөгөөд өөрөөр хэлбэл судлагдаагүй газар нутгийг судалж, шинэ нээлт хийж, холбоо хамааралтай ажиллана гэсэн үг...хэн нэгний өмнө нь аялж байсан газраар дахин явахгүй.

Бизнесийн сэтгүүлчид компаниудын дотоод үйл ажиллагааны талаар мэдээлэхдээ улам гарамгай болж, илүү гүн гүнзгий эрэл хайгуул хийснээр аливаа хэрэг гарахаас нь өмнө зүй бус үйл ажиллагааны талаар олж мэдээлэх боломжтой болно (эрэн сурвалжлах сэтгүүлзүйн сургалт, мэдээлэл болон дэмжлэг үзүүлдэг байгууллагуудын вэбсайтуудыг 7 дугаар бүлгээс үзнэүү).



ТА ЮУ МЭДЭХ ВЭ?

Шуурхай асуулт, хариулт

1. Төлөөлөн удирдах зөвлөл яагаад хараат бус гишүүдтэй байх ёстой вэ?

- A. Шаардлагатай тохиолдолд захирлууд болгон ажиллуулах боломжтой
- B. Ашиг сонирхлын зөрчилгүй шийдвэр гаргах боломжтой
- C. Компанийн хувь эзэмшлийн томоохон хэсгийг эзэмшдэггүй.

2. Компанийн эрсдлийн удирдлагын үндсэн үүрэг хариуцлагыг хэн хүлээх вэ?

- A. Гүйцэтгэх удирдлага
- B. Төлөөлөн удирдах зөвлөл
- C. Хувьцаа эзэмшигчид

3. Компанийн засаглалын үнэлгээний үзүүлэлтүүд нь дараах талаараа ач тустай болно

- A. Компаниуд нь компанийн засаглалын сайн арга барилыг дагаж мөрдөж байгаа эсэхийг тодорхойлдог,
- B. Компанийн хувьцаа өсөх төлөвтэй болохыг тооцоолж таамагладаг,
- C. Захирлууд өөр хэд хэдэн төлөөлөн удирдах зөвлөлд ажиллаж байгаа эсэхийг олж мэддэг.

Харуулт: 1. B, 2. B, 3. A

ЭХ СУРВАЛЖУУД БҮЛЭГ 1

Редакторын тэмдэглэл: 1 дүгээр бүлгийг бэлтгэхэд зориулж доорх эх сурвалжуудыг авч үзсэн болно. Ихэнхи вэбсайтууд нь олон нийтэд нээлттэй мэдээллээ байрлуулсан байдаг. Харин Wall Street сэтгүүл, Financial Times зэрэг тодорхой эх сурвалжуудын мэдээг үзэхийн тулд нэвтрэх эрх захиалах шаардлагатай. New York Times нь уншигч, үзэгч бүрт зориулж сар бүрд хязгаарлагдмал тооны архивласан материал өгдөг.

НИЙТЛЭЛ, БҮТЭЭЛҮҮД

Beverly Behan, “Энэтхэгийн Сатямын засаглалын асуудлууд”, Bloomberg BusinessWeek, 2009 оны 1 дүгээр сарын 16-ний өдөр
<http://buswk.co/НМу6Ро>

Catherine Belton, Neil Buckley, “Оросын банкууд: Барьцаа хөрөнгийн гэмтэл”, “Financial Times”, 2011 оны 9 дүгээр сарын 22-ны өдөр <http://on.ft.com/INw0Pe>

Michael J. Borden, “Компанийн засаглал дахь санхүүгийн сэтгүүлзүйн үүрэг оролцоо”, судалгааны ажил, Cleveland State их сургууль, Cleveland-Marshall хуулийн сургууль, 2006 оны 10 дугаар сар
<http://bit.ly/ltvWXd>

Ryan Chittum, “Audit Interview: Jonathan Weil”, Columbia Journalism Review, 2008 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр
<http://bit.ly/ltw6OL>

Nathaniel Parish Flannery, “TEPCO корпорацийн менежментийн асуудал Японы 15 тэрбум ам.долларын цацраг идэвхитэй бодисыг алдагдахад нөлөөлсөн үү?” Forbes, 2011 оны 5 дугаар сарын 27-ны өдөр
<http://onforb.es/HEdjA5>

James Fontanella-Khan, “Тата группын өв залгамжлал ноцтой ажил болов”, Financial Times, 2011 оны 11 дүгээр сарын 24-ний өдөр
<http://on.ft.com/HB3716>

Joe Leahy, “Тата групп өв залгамжлагчаа хайж байна”, Financial Times, 2011 оны 9 дүгээр сарын 5-ны өдөр

<http://on.ft.com/HDG9AZ>

Dean Nelson, “Reliance-ийн ах дүүс Амбаничуудын хоорондох өрсөлдөөн Энэтхэгийн эдийн засаг заналхийлэв”, Telegraph, 2009 оны 8 дугаар сарын 27-ны өдөр
<http://tgr.ph/173Ail>

Melissa Preddy, “Компанийн засаглалын мэдээг илэрхийлэх гүйцэтгэх удирдлагуудын хөдөлгөөнийг мөрдөх нь” Donald W. Reynolds Бизнесийн сэтгүүлзүйн үндэсний төв, Business-journalism.org,” 2011 оны 1 дүгээр сарын 21-ний өдөр
<http://bit.ly/IGmvTM>

Scott Sherman, “Enron, Хөндөөгүй мэдээг үл мэдээлэх нь”, Columbia Journalism Review, 2002 оны 3, 4 дүгээр сар,

Manoj Shivanna, “Сатямын хэрэг: Компанийн засаглалын сүйрэл”, кейс судлал, Monash их сургууль, 2010 он
<http://bit.ly/174BHa>

“Муу мэдээний талаарх сайн мэдээ: Компанийн засаглалын төлөөх ичгүүр сонжворгүй төлбөр”, 2007 он, Knowledge@Wharton, 2007 он
<http://bit.ly/IGn8Nh>

“Өмнөд Солонгосын Самсунгийн ерөнхийлөгч авилгалын хэргээр огцров”, 2008 оны 4 дүгээр сарын 4-ний өдөр <http://bit.ly/174R8T>

“Lee өршөөл авсаны дараа захирлын албан тушаалдаа эргэж оров”, Financial Times, 2010 оны 3 дугаар сарын 24-ний өдөр
<http://on.ft.com/IGnfZf>

НОМ ЗОХИОЛ, СУДАЛГАА

Anya Schiffrin, редактор, “Муу мэдээ (Америкийн бизнесийн хэвлэл мэдээллийнхэн зуун жилийн мэдээг хэрхэн алдсан талаар)”, New Press, Нью-Йорк, 2011 он.

Rebecca Smith, John R. Emshwiller, “24 өдөр (Wall Street-ийн хоёр сурвалжлагч Corporate America-д итгэх итгэлийг үгүй хийсэн хуурмаг явдлыг хэрхэн мэдээлж чадаагүй вэ),” HarperBusiness, 2004 он.

Bob Tricker, “Төлөөлөн удирдах зөвлөлийн захирлуудад зориулсан үндсэн зарчмууд”, эдийн засагчийн Profile Books ХХК-тай хамтарсан бүтээл, Bloomberg Press, АНУ, Канад, 2009 он.

*“Японд анхаарлаа хандуулах нь: Яагаад эрсдлийн менежмент асуудалтай болов”, GMI Blog, 2011 оны 6 дугаар сарын 28-ны өдөр.
<http://bit.ly/HETsIE>*

*“Бизнесийн зан төлвийг сайжруулах нь: Яагаад бидэнд компанийн засаглал хэрэгтэй вэ”, (Компанийн засаглалын талаарх ЭЗХАХБ-ын 2004 оны засварласан хувийг хянаж баталсаны дараах илтгэл), Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага
<http://bit.ly/J11k9R>*

*Олон улсын компанийн засаглалын тухай хууль тогтоомжуудыг нэгтгэсэн вэбсайт
<http://bit.ly/lttIHR>*

Төлөөлөн удирдах зөвлөлийн талаарх бүхий л чухал зүйлс

Компани дотор хамгийн дээд эрх барих байгууллага бол төлөөлөн удирдах зөвлөл юм. Тус зөвлөл нь мэдээний гол эх сурвалжууд болж байдаг.

Гэхдээ асуудал урган гарсан үед л зөвхөн сэтгүүлчдийн үйлдэл эхэлдэг юм шиг санагдсан. Тухайлбал, тухайн компани нь нягтлан бодох бүртгэлийн хэрэгт орооцолдсон, эсвэл компанийн гүйцэтгэх удирдлага нь огцрохоор болсон зэрэг үйл явдлын дараа сэтгүүлчид онцолж ярьдаг.

Компанийн үйл ажиллагааг бүдүүвчилж тэмдэглэхэд төлөөлөн удирдах зөвлөлийн гүйцэтгэх онцгой эрх мэдэл, үүрэг хариуцлага нь ямагт анхаарал татсан, үнэ цэнэтэй зүйл болж байдаг.

Өргөн цар хүрээнд хэлвэл төлөөлөн удирдах зөвлөлийн үүрэг хариуцлага нь компанийн ашиг сонирхол болон хувьцаа эзэмшигчдийн хөрөнгийг хамгаалах, тэдгээрийн хөрөнгө оруулалтын өгөөжийг баталгаажуулах явдал байдаг. Стратегийн бүх шийдвэр гаргалт нь ТУЗ-н санаачилгаар эхэлж эсвэл, аль нэг өөр этгээд санаачилсан ч гэсэн төлөөлөн удирдах зөвлөлөөр эцсийн байдлаар батлуулах ёстой. Нэн ялангуяа ТУЗ нь дээд түвшний гүйцэтгэх удирдлагуудыг хөлслөн авч, халж, компанийн гүйцэтгэлийг хянаж, санхүүгийн тайлангуудыг баталж, гүйцэтгэх удирдлагын цалин хөлс болон урамшууллыг шийдвэрлэж, болзошгүй эрсдлийг үнэлж төлөвлөж, компанийн нэгтгэл болон худалдан авалтын үйл ажиллагааг батлах зэрэг бусад үндсэн шийдвэр гаргалтуудыг хийдэг.

Мөн түүнчлэн ТУЗ нь тухайн компаний ёс зүйтэй, хуулийн дагуу, хариуцлагатай ажиллаж байгаа гэдгийг харуулах нүүр царай нь болж байдаг.



Төлөөлөн удирдах зөвлөлийн үүрэг хариуцлагуудтай холбоотой жагсаалтыг үзэхийн тулд ЭЗХАХБ-ын Компанийн засаглалын талаарх зарчмууд буюу “Төлөөлөн удирдах зөвлөлийн үүрэг хариуцлагууд”-ыг үз. Хуудас 24. <http://bit.ly/HARlwY>

Төлөөлөн удирдах зөвлөлийн төрлүүд болон захирлууд

Нэг, эсвэл хэд хэдэн этгээдэд эрх мэдэл хийгээд мэдээллийг төвлөрүүлэхээс урьдчилан сэргийлэхийн тулд төлөөлөн удирдах зөвлөл нь гүйцэтгэх ба гүйцэтгэх бус гишүүд, зарим нь хараат бус гишүүд (тодорхойлолтыг үз)-ийн тоог тэнцвэржүүлэхийг хичээдэг. Төлөөлөн удирдах зөвлөлд байх ёстой хараат бус гишүүдийн тооны талаар мэргэжилтнүүд харилцан адилгүй байр суурьтай байдаг боловч нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн тоо нь гуравны нэгээс тал хувь хүртэл байдаг.

Төлөөлөн удирдах зөвлөлийн талаар мэдээлж байгаа сэтгүүлчдийн хувьд захирлууд, төлөөлөн удирдах зөвлөлийг тодорхойлоход ашиглагддаг тодорхойлолтуудыг ойлгох хэрэгтэй байна.

Түүнчлэн ТУЗ-н гүйцэтгэх гишүүн нь тухайн компаний гүйцэтгэх захирал эсвэл санхүүгийн захирал зэрэг компанийн гүйцэтгэх удирдлагад давхар ажиллаж байдаг. Харин гүйцэтгэх бус гишүүн гэдэг нь компаний удирдлагын нэг хэсэг биш бөгөөд компаний талаар гадны байр суурь болон онцгой ур чадварын хувьд үнэ цэнэтэйд тооцогддог.

Засаглалын мэргэжилтнүүдийн үзэж байгаагаар “гүйцэтгэх бус” захирлууд нь “гүйцэтгэх” захирлуудыг байлцуулалгүйгээр тогтмол нууцлаг байдлаар хуралдаж уулзах ёстой.

Олон улс оронд төлөөлөн удирдах зөвлөл нь хараат бус гишүүдийн тодорхой хэмжээний тоо, харьцаа үзүүлэлтийг хангасан байх ёстой байдаг.


Хараат бус захирал

“Хараат бус” гэдэг үгийн тодорхойлолт нь харилцан адилгүй байдаг. Гэхдээ ихэвчлэн аливаа этгээдийг санхүү, гэр бүлийн болон ажлын хувьд харилцан хамааралгүй, эсвэл компани, түүний захирлууд хийгээд ажилчидтай бусад чухал харилцаа холбоогүй байхыг шаарддаг.

Бусад шалгуур үзүүлэлтүүдэд:

- Саяхны ажилтан биш байх,
- Ойрын хугацаанд компанитай томоохон бизнесийн харилцаа холбоогүй байх,
- Захирлаар ажилласны хөлс, хувьцааны опшин, тодорхой хороонд ажилласантай холбоотой хөлс, тэтгэвэрээс бусад байдлаар компаниас цалин хөлс ойрын үед, эсвэл одоогийн байдлаар аваагүй байх,
- Компанийн зөвлөхүүд, захирлууд болон удирдах түвшний ажилчидтай гэр бүлийн ойр дотно харилцаа холбоогүй байх,
- ТУЗ-н бусад гишүүдтэй ямар нэг чухал харилцаа холбоогүй, тэдгээрийн ажилладаг компанид нь давхар ТУЗ-н гишүүнээр ажилладаггүй, тэдгээрт компанитай нь ямар нь холбоогүй байх
- Томоохон хувьцаа эзэмшигч биш байх,
- Төлөөлөн удирдах зөвлөлд удаан хугацаагаар ажиллаагүй байх

Эх сурвалж: Дэлхийн банк групп, Олон улсын санхүүгийн корпораци, Олон улсын компанийн засаглалын форум, “Төлөөлөн удирдах зөвлөлийн компанийн засаглалтай холбоотой манлайлах үр чадварын сургалтын материалаас”



Төлөөлөн удирдах зөвлөл нь нэг, эсвэл хоёр түвшинт загвартай байж болно. Үүнд:

- *Нэг түвшинт* буюу нэг төрлийн төлөөлөн удирдах зөвлөл нь гүйцэтгэх захирал, менежментийн баг, эсвэл гүйцэтгэх хорооны өдөр тутмын бизнесийн үйл ажиллагааг төлөөлөх бөгөөд гүйцэтгэх болон гүйцэтгэх бус гишүүдийн аль алинаас бүрддэг. Энэ бүтэц зохион байгуулалт нь Америкийн Нэгдсэн Улс, Их Британи, Тусгаар тогтносон хамтын улс орнууд зэрэг нийтлэг хууль тогтоомжийн уламжлалтай улс орнуудад хамгийн ихээр тааралддаг.
- *Хоёр түвшинт* буюу хоёр төрлийн, хосолсон төлөөлөн удирдах зөвлөл нь хяналтын болон менежментийн зөвлөл гэсэн хоёр тусдаа хэсэгт хуваагддаг. Хяналтын зөвлөл нь өдөр тутмын үйл ажиллагааг гүйцэтгэдэг менежментийн зөвлөлийг хянадаг. Энэхүү бүтэц зохион байгуулалт нь ихэвчлэн Герман зэрэг иргэний хуулийн уламжлалтай улс орнууд, түүнчлэн Зүүн Европын олон улс орнууд, Францын зарим компаниудад түгээмэл ажиглагддаг.

Сэтгүүлчдэд өгөх зөвлөмж: Хоёр түвшинт системд хоёр зөвлөлийн хооронд хагарал тэмцэл байдаг уу? Эдгээр зөрчил нь компанийн сайн гүйцэтгэл үзүүлэх боломж бололцоог судалж шинэ шинэ мэдээг бичихэд тусалж болно.

Төлөөлөн удирдах зөвлөл, удирдлага нь тус тусдаа үүрэг хариуцлагатай

Төлөөлөн удирдах зөвлөлийн үүрэг хариуцлагууд нь удирдлагын түвшнээс ялгаатай байдаг. Компанийн талаар үр дүнтэй мэдээлэхийн тулд сэтгүүлчид нь удирдлагын түвшинд эрх мэдлийг хэрхэн хуваалцах талаар тооцон үзэж, гүйцэтгэх удирдлагуудын дундах өөрчлөлтийг нягт нарийн судалж харах ёстой. Төлөөлөн удирдах зөвлөл болон удирдлагын хоорондох харилцаа холбоо нь мөн чухал ач холбогдолтой байна.

Удирдлагын баг нь компанийн өдөр тутмын үйл ажиллагааг чиглүүлж, бизнесийн стратегия тодорхойлдог гүйцэтгэх удирдлагаар эхэлнэ. Түүнчлэн удирдлагын багт үйл ажиллагаа хариуцсан захирал, санхүүгийн захирал болон мэдээллийн захирал орохоос гадна тухайн салбараас шалтгаалж удирдлагын түвшний бусад албан тушаалууд орсон байна.



Байгууллага доторх үүрэг хариуцлага бүрийг тодорхойлохын тулд хөрөнгө оруулагчдын ашиг сонирхлын сэдвээр тайлбар бүхий нийтлэл бичдэг санхүүгийн олон салбарын мэргэжилтнүүдийг авч ажиллуулж, нэг талыг баримтлаагүй хөрөнгө оруулалтын эх сурвалж болсон Investopedia-ын “Байгууллагын бүтцийн үндсэн зарчим”-ыг үз.
<http://bit.ly/HG44Qj>

Компанийн өв залгамжлагч гарах, тодрох, албан тушаал өөрчлөгдөх зэрэг дотоод өөрчлөлт болон эрх мэдлийн төлөөх тэмцэлдээн нь компанийн удирдлагын шатлал болон ирээдүйн чиг хандлагын өөрчлөлтийг тодорхойлдог. Захирал нь огцрох, томилогдох зэрэг төлөөлөн удирдах зөвлөлийн өөрчлөлт нь мөн томоохон өөрчлөлтийн дохио болж мэднэ. Ийм л учраас сэтгүүлчид дээрх өөрчлөлт, хөдөлгөөнд чухал анхаарал тавих ёстой бөгөөд үргэлж ийм мэдээг эрэлхийлж байх шаардлагатай. Өөрөөр хэлбэл компанийн хэвлэлийн мэдээнд албан

тушаалын өөрчлөлтийн бодит шалтгааныг тодорхой гаргаагүй байж болох учир улам гүнзгийрүүлж судалж мэдээлэх ёстой гэсэн үг.

Төлөөлөн удирдах зөвлөл нь удирдлага болон хараат бус хэд хэдэн захирлуудтай нягт харилцаа холбоотой байх үед асуудал урган гарах магадлалтай байдаг гэж компанийн засаглалын зөвлөхүүд үздэг. Үүнээс зарим тохиолдолд гүйцэтгэх захирлын нөлөөнд хэт автаж, төлөөлөн удирдах зөвлөл нь удирдлагын үйл ажиллагаа болон санал төлөвлөгөөг тэр чигээр нь батлах буюу хамаагүй тамга дарж болно. 2011 онд J.P. Morgan-ийн Depostiroy Receipts компаний хийсэн судалгаагаар Латин Америкт ийм асуудал ноцтой байсан бөгөөд төлөөлөн удирдах зөвлөл нь хараат бус байдлын хувьд хангалтгүй түвшинд байжээ.

“...Төвлөрсөн удирдлагын түвшин нь эрсдлийн хэмжээг нэмэгдүүлж болно” гэж GovernaceMetrics Internataional (GMI)-ийн талаарх J.P.Morgan-ий судалгаанд судлаач, шинжээч Nathaniel Parish Flanery онцлон бичсэн байдаг. Тус судалгаанд үндэсний баялгийн сангууд, институционал хөрөнгө оруулагчид болон бусад харилцагчдыг багтаасан олон улсын 20,000 гаруй компаниас мэдээ цуглуулж шинжилгээ хийсэн.

Тус судалгаанд дурдсан компаниуд дотроос тэрбумтан Карлос Слимийн эзэмшлийн Мексик дэх компаниуд ч байсан. Тэрээр өөрийн Grupo Carso SAB-аар дамжуулж теле харилцаа холбооны компаниуд болон Мексикийн бусад компаниудын төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гүйцэтгэх захирлын ажил гүйцэтгэдэг. Түүний энэхүү том эзэнт гүрэн нь банк, утсан харилцаа холбоо, замын барилга, зоогийн газар зэрэг салбаруудад үйл ажиллагаа явуулдаг 200 гаруй компаниудыг удирддаг болохыг сонинд дурдсан байдаг.



Слим болон түүний хувь эзэмшлийн талаарх илүү дэлгэрэнгүй мэдээллийг авахыг хүсвэл: <http://tgr.ph/KEooiO>

Болзошгүй зөрчил

Сэтгүүлчид нь хувьцаа эзэмшигчдийн болон төлөөлөн удирдах зөвлөлийн ашиг сонирхлын хоорондох болзошгүй зөрчлийг тодорхойлоход хэрэглэгддэг “төлөөллийн ацан шалаа” гэсэн нэр томъёотой таарч болох юм. Менежментийн нөлөөнд автсан

төлөөлөн удирдах зөвлөл нь компанийн хувьцаа эзэмшигчдийн урт хугацааны ашиг сонирхолын оронд богино хугацааны ашиг хонжоо хайж болох талтай юм. Хувьцаа эзэмшигчид нь эрсдлийг таамаглах хүсэлгүй байж болох бөгөөд удирдлага нь компанийн өрсөлдөх чадвар болон өсөлтийг бууруулахын тулд ийм нөхцөл байдлыг бий болгож болно.

Хувьцаа эзэмшигчдийн туйлын ашиг сонирхлыг төлөөлөн удирдах зөвлөл төлөөлдөг, харин удирдлага нь эдгээр ашиг сонирхолтой нийцүүлж ажиллах ёстой гэдгийг баталгаажуулж, стратегийн хувьд ийнхүү сэтгэж үндсэн үүрэг хариуцлагаа биелүүлэх нь захирлуудын ажил юм (доорх хүснэгтийг үз).

Төлөөлөн удирдах зөвлөлийн бүтэц бүрэлдэхүүн, үр ашигт байдлыг шалгах

Төлөөлөн удирдах зөвлөлийн бүтэц бүрэлдэхүүн нь GMI зэрэг засаглал сайтай байгууллагуудын зорилтот талбаруудын нэг юм.

GMI-ийн нэг хэсэг болох Corporate Library-аар төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус байдал, үр ашгийг үнэлэхэд хөрөнгө оруулагчдад туслах шалгах хуудсыг боловсруулсан байдаг. Үүнд:

- *Төлөөлөн удирдах зөвлөлийн хэмжээ.* Тогтсон тоо гэж байхгүй, гэхдээ төлөөлөн удирдах зөвлөлийн дундаж хэмжээ нь 9-10 гишүүн юм. Дэндүү олон гишүүнтэй төлөөлөн удирдах зөвлөл нь нүсэр байх бол харин дэндүү бага гишүүнтэй бол ажлын ачааллыг даах чадвар муутай байж болно.
- *ТУЗ-н хараат бус гишүүдийн тоо:* Нийт гишүүдийн дийлэнх олонхи байх нь зохимжтой гэж олон ажиглагчид үздэг.
- *Гүйцэтгэх удирдлага, аудит, цалин урамшууллын болон нэр дэвшүүлэх хороодын оролцоо:* Цалин урамшууллын болон аудитын хороод нь хараат бус захирлуудаас бүрдсэн байх ёстой. Аудитын хорооны дарга нь мэргэшсэн, эсвэл бүртгэлтэй нягтлан бодогч мэргэжилтэй байх ёстой гэж зарим ажиглагчид үздэг ч энэ асуудлаар дахиад л нэгдсэн нэг ойлголт, хэлцэл байдаггүй.
- *Хязгаарлагдмал удирдлага.* Ерөнхийдөө төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн нь гурваас илүү төлөөлөн удирдах зөвлөлд ажиллах ёсгүй бөгөөд ТУЗ нь ашиг сонирхлын

зөрчилгүй байх ёстой.

- *Мэдэгдэл:* Компаниуд нь ашиг сонирхлын зөрчил үүсгэж болох гүйцэтгэх удирдлагууд, захирлууд болон бусад холбогдох талуудтай хийсэн хэлцлээ зарлаж мэдэгдэх ёстой.



Төлөөлөн удирдах зөвлөлийн үүрэг хариуцлагууд болон шалгарсан арга практикийг харахыг хүсвэл: <http://bit.ly/HDB765>

Захирлууд нь компанид хангалттай хэмжээний хувь эзэмших ёстой гэсэн нийтлэг ойлголт байдаг бөгөөд энэ нь хууль ёсны эрх ашгийг илэрхийлнэ. Нөгөө талаар байгууллагын засаглалын зөвлөхүүд нь ийм их хэмжээний хувь эзэмшилтэй захирлуудын эсрэг болгоомжтой ханддаг бөгөөд учир нь ийм эрх олгосноор захирлууд богино хугацааны ашгийн төлөө нягтлан бодох бүртгэлийн манёвр ашиглаж хувьцааны үнийг өсгөх хүсэлтэй байж болно гэж үздэг байна.

Захирлуудыг төлөөлөн удирдах зөвлөлд байх хугацаанд нь хангалттай хэмжээний төлбөр өгч, туршлага болон мэдлэг чадварыг нь үнэлж хөлс шагнал олгох ёстой.

“Хараат бус захирлууд” гэж компанитай ямар ч холбоо хамааралгүй гадны этгээдүүд бөгөөд компанийн засаглалын мэргэжилтнүүдийн үзэж байгаагаар хараат бус байдлаа хадгалж үлдэхийн тулд 5 хувиас бага хувь эзэмших ёстой ажээ. Энэ хувь нь улс орон бүрээс хамаарч харилцан адилгүй байдаг. Энэтхэг улсын Компанийн тухай шинэ хуулийн төсөл 2012 онд батлагдах бөгөөд үүнд гадны захирлууд нь хамгийн ихдээ 2 хувийн хувьцаа эзэмших ёстой гэж заасан байдаг.

Хувьцаа эзэмшигчид нь ихэвчлэн жил бүрийн хурал дээр төлөөлөн удирдах зөвлөлийн санал болгосны дагуу захирлуудыг сонгодог. Ази тивд бол төлөөлөн удирдах зөвлөлийн захирлуудыг нэр заах, сонгож эрхтэй хяналтын хувьцаа эзэмшигч байх нь нийтлэг байдаг.

Мөн ийм хувь эзэмшлийн хязгаар, хугацаа нь улс орон төдийгүй компаниасаа хамаарч харилцан адилгүй байдаг ч төлөөлөн удирдах зөвлөлийн хугацаа нь ерөнхийдөө нэгээс гурван жил байдаг.

Удирдах, чиглүүлэх хоёрын үндсэн ялгаа

	ЗАХИРЛУУД	МЕНЕЖЕРҮҮД
Шийдвэр гаргалт	Байгууллагын ирээдүйг тодорхойлох, хөрөнгө болон нэр хүндийг нь хамгаалах шаардлагатай. Түүнчлэн өөрсдийн шийдвэр гаргалтыг компаний бусад оролцогчдийн эрх ашиг болон хууль эрхзүйн орчинтой хэрхэн зөв уялдуулах вэ гэдгийг анхаарах учиртай	Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрүүд бодон бодлогуудыг хэрэгжүүлэхэд илүү анхаарал хандуулдаг
Үүрэг хариуцлагууд	Компанийн урт хугацааны хөгжлийн төлөө туйлын үүрэг хариуцлага хүлээдэг. Ерөнхийдөө захирлууд нь компанийн төлөө үүрэг хариуцлагаа биелүүлэх, итгэмжлэлийн үүрэг хариуцлагаа биелүүлэхдээ зохих ёсны анхаарал тавьж, ур чадвараа ашиглах үүргийг хуулиар оноосон байдаг. Хэрвээ үүрэг хариуцлагаа зөрчсөн буюу зохиох ёсоор гүйцэтгээгүй бол биечлэн хариуцлага хүлээж болно. Зарим тохиолдолд компанийн үйлдлийн өмнөөс хариуцлага хүлээж ч болно.	Ихэвчлэн захирлын түвшний үүрэг хариуцлагуудтай холбогддоггүй
Хувьцаа эзэмшигчийн харилцаа холбоо	Хувьцаа эзэмшигчид нь захирлуудыг албан тушаалаас нь чөлөөлж болно. Түүнчлэн компанийн захирлууд нь хувьцаа эзэмшигчдийн өмнөөс хариуцлагатай ажиллана.	Захирлууд, удирдлагын зүгээс ихэвчлэн халж, томилж байдаг. Ховор тохиолдолд хариуцлага хүлээх хууль эрхзүйн шаардлагатай тулгарч болно.
Манлайлал	Байгууллагыг дээд түвшинд зөв манлайлж, чиглүүлнэ	Өдөр тутмын манлайлах үүрэг нь гүйцэтгэх захиралд хамааралтай бөгөөд менежерүүд нь захирлуудын өмнөөс ажиллана
Ёсзүй, үнэ цэнэ	Компанийн үнэ цэнэ болон ёсзүйн байдлыг тодорхойлоход гол үүрэг гүйцэтгэнэ	Төлөөлөн удирдах зөвлөлөөс зааварчилгаа авч, ёсзүйг хэрэгжүүлэх ёстой
Компанийн удирдлага, захиргаа	Компанийн захиргааны ажлуудыг хариуцна	Компанийн захиргаатай холбоотой үүрэг хариуцлагуудын заримыг удирдлагад/менежерүүдэд шилжүүлж болох боловч эцсийн хариуцлагыг захирлууд хүлээнэ.
Хуулийн заалтууд	Олон улс оронд компани нь хуулийн заалтуудыг дагаж мөрдөж чадаагүй бол захирлуудад оногдуулж болох торгуулийн тухай хатуу чанга үүрэг хариуцлага хүлээлгэх олон хуулийн заалтууд байдаг.	Эдгээр хуулийн заалт нь ихэвчлэн менежерүүдэд нөлөө үзүүлдэггүй.

Эх сурвалж: Chris Pierce, "Сайн захирал", Лондон: Kogan Page, 2003 он



СУРВАЛЖЛАГЧИЙН ТЭМДЭГЛЭЛ

Аудит болон зөвлөх үйлчилгээний компаниудын судалгаа, тайлангууд нь мэдээний санааг өгч болно.

LiveMint-ийн Moulishree Srisvastava хэмээх онлайн бизнесийн хэвлэл мэдээллийн компани нь Grant Thornton India-ийн нэг хамтрагчийн чадвар мэдлэгийг ашиглаж Энэтхэгийн гэр бүлийн бизнесүүдэд тулгарч байгаа компанийн засаглалтай холбоотой бэрхшээлтэй асуудлын талаарх мэдээг бэлтгэж, мухардалд орсон байдлуудыг бичсэн

байна.

Үүнд дараах асуудлууд багтсан байна:

- Хараат бус захиралуудын хэрэгцээг өндөрөөр үнэлэх,
- Хөрөнгийн зах зээл дээр биш хаалттай хүрээнд тодорхой компаний хувьцааг худалдан авах замаар хийдэг хөрөнгө оруулалтыг нээлттэй болгох
- Луйврын эсрэг тэмцэх, эрсдлийг удирдах

Мэдээг уншихыг хүсвэл: <http://bit.ly/HARyV>

Төлөөлөн удирдах зөвлөлийн олон талын чадварыг шалгах

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд нь компанийн хэрэгцаа шаардлагад нийцсэн ур чадвар, туршлагатай байх ёстой. Түүнчлэн шаардлагатай тохиолдолд гүйцэтгэх удирдлага, ТУЗ-ийн даргын гаргасан шийдвэрийг эсэргүүцэх, үзэл бодлоо хамгаалах үндэслэлийг дэвшүүлэх хангалттай хэмжээний чадвартай байх ёстой. Ийм чадварын тусламжтайгаар зарим тохиолдолд Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд нь сэтгүүлчдэд компанийн дотоод үйл ажиллагаанд юу асуудал болоод байгаа талаар мэдээлж, сайн мэдээ гаргах боломжийг бий болгодог.

Сүүлийн жилүүдэд засаглалын зөвлөхүүд болон хувьцаа эзэмшигчдийг дэмжигчид Төлөөлөн удирдах зөвлөлд эмэгтэйчүүдийн тоог илүү нэмж төрөлжүүлэх талаар бичиж байгаа бөгөөд зарим улс оронд энэ талаар шаардаж хуульчлан баталсан ч байдаг.

Зөвлөхүүдийн үзэж байгаагаар бол хүйсийн ялгаатай байдал нь төлөөлөн удирдах зөвлөлийн ур чадвар, чадамж, туршлага болон үзэл санааг илүү олон талтай болгоно. Тэдгээрийн хэлж байгаа эдгээр давуу тал нь тэнцвэртэй шийдвэр гаргалтанд хүргэж, санхүүгийн менежментийг илүү үр дүнтэй хянаж, хувьцаа эзэмшигчдэд ажлаа тайлагнах явдлыг сайжруулж, эрсдлийн удирдлагыг хянамгай болгодог.

2012 оны GMI-ийн тайланд “өмнөх жилийн судалгаанаас харахад төлөөлөн удирдах зөвлөлд эмэгтэйчүүдийн оролцох оролцоо эрчимтэй нэмэгдсэн байна” гэжээ. 43 улс оронд 4,300 компанийн дунд явуулсан судалгаанаас харахад

МЭДЭЭНИЙ ХЭРЭГСЛИЙН ХАЙРЦАГ

Мэдээний санаа: Таны мэдээлж байгаа компаниудын төлөөлөн удирдах зөвлөлийн хороодын үүрэг хариуцлага, бүтэц зохион байгуулалтыг шалгаж үзнэ үү.

- Төлөөлөн удирдах зөвлөл нь засаглалын зөвлөхийн (холбогдох хуулиар зөвлөсөн) зөвлөж, санал болгосон бүхий л хороодыг байгуулсан байна уу?
- Хороодын гишүүд нь ямар төрлийн ур чадвар, мэдлэгтэй байна вэ?
- Хороодын гишүүдэд онцгой ур чадвар байна уу? (Тухайлбал, аудитын хорооны гишүүдэд?)
- Хороодын гишүүд нь хараат бус байна уу? (энэ бүлэг дэх тодорхойлолтыг үзнэ үү.)



Төлөөлөн удирдах зөвлөлийн хүйсийн ялгаатай байдлын талаар илүү дэлгэрүүлж уншихыг хүсвэл: Эрэгтэй захирлуудтай хийсэн ярилцлага: <http://bit.ly/LEphFk>

төлөөлөн удирдах зөвлөлийн нийт суудлын тооны 10.5 хувийг эмэгтэйчүүд эзэлж байгаа нь өмнөх жилээс 10 хувь өссөн үзүүлэлт болж байна. Эмэгтэйчүүдгүй төлөөлөн удирдах зөвлөлийн хувь нь 40 хувиас бага зэрэг доош унасан байна. Мөн судалгаанд дэлхийд 10 ТУЗ-н гишүүний судал тутмын нэг суудлыг эмэгтэй гишүүн эзэлж байна гэжээ.

Төлөөлөн удирдах зөвлөлийн хороодыг шинжилж үзэх нь

Төлөөлөн удирдах зөвлөл нь төлөөлөн удирдах зөвлөлийн тодорхой ажил үүргийг гүйцэтгүүлэх, техникийн асуудлуудад нарийвчилсан судалгаа шинжилгээ хийлгэх, өөрийн батлах, шийдвэрлэх ёстой асуудлуудаар мэргэжлийн зөвлөмжийг авах зорилгоор хороодыг байгуулдаг. Тус зөвлөл нь хороодод хариуцуулж өгсөн асуудлын эцсийн хариуцлагыг хүлээдэг. Хороод нь захирлуудыг тодорхой салбар чиглэлийн, ялангуяа хорооны гишүүдэд өөрийн мэргэшсэн салбар чиглэлээрээ илүү ажиллах, судлах боломжийг олгодог. Хороод нь төлөөлөн удирдах зөвлөлд ажлаа тайлагнах ба мөн гүйцэтгэх удирдлагын санал төлөвлөгөөг судалж, энэ асуудал нь төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрлэх асуудал мөн эсэх, мөн бол тухайн асуудалд хорооны байр суурь, дүгнэлтээ гаргаж зөвлөлийн хурлаар оруулдаг тул тухайн асуудлууд нь голдуу стратегийн асуудлууд байдаг.

Төлөөлөн удирдах зөвлөлөөс олон хороодыг байгуулж болох бөгөөд байгуулах үндсэн хороод нь:

- **Аудитын хороо** — Компаний хөндлөнгийн болон дотоод аудиторыг сонгож, ажлыг нь хянадаг.
- **Цалин урамшууллын хороо** — Компанийн зүгээс дээд түвшний удирдлагад хир их бэлэн мөнгө, хувьцаа болон бусад шагнал урамшууллыг өгөх ёстойг зөвлөдөг.
- **Нэр дэвшүүлэх хороо** — Төлөөлөн

удирдах зөвлөлийн гишүүнд тохирох этгээд хайх, үнэлэх, судлах, сонгон шалгаруулах, Хувьцаа эзэмшигчдийн хуралд нэрийг нь дэвшүүлж оруулдаг.

- **Компанийн засаглал** — Компаний бодлогуудыг хянаж, шаардлагатай бол өөрчлөлт шинэчлэлийг санал болгодог. Түүнчлэн төлөөлөн удирдах зөвлөл нь Гүйцэтгэх удирдлагын хороог байгуулж болох бөгөөд тус хороо нь төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын чөлөөт цагаар ТУЗ-ийн эрх мэдлийг хэрэгжүүлдэг. Мөн болзошгүй эрсдлүүдийг урьдчилан таамаглаж, төлөвлөхийн тулд Эрсдлийн хороог байгуулж болно.

Санхүүгийн салбарт төлөөлөн удирдах зөвлөл нь тодорхой хороодыг байгуулж, тэдгээрийн бүтэц бүрэлдэхүүн, үйл ажиллагаа, ялангуяа эрсдлийн менежментийг үндэслэлтэй тайлбарлах явдал банкны хууль тогтоомж, дүрэм журмуудад нийтлэг ажиглагдах болжээ. Түүнчлэн компаниуд ёсзүйн, хямралын менежмент, байгаль орчны бодлого, хөдөлмөрийн асуудал, технологи зэрэг асуудлуудаар байнгын, эсвэл түр хороодыг байгуулан ажиллуулж болно.

Онцгой тохиолдолд ашиг сонирхлын болзошгүй зөрчил, эсвэл худалдан авалтыг шалгахын тулд хороо байгуулж болно. Ингэхэд төлөөлөн удирдах зөвлөлийн ашиг сонирхлын зөрчилгүй гишүүдийн санал бодол чухалд тооцогдоно.

Компанийн засаглалын хамгийн шилдэг арга барил, заавар журмын дагуу бол тодорхой хороод, ялангуяа аудит, нэр дэвшүүлэх, цалин урамшуулал болон компанийн засаглалын хороод нь үндсэндээ хараат бус захирлуудаас бүрдэх ёстой.

Эдгээр хороодын бүтэц бүрэлдэхүүнийг хянаж үзэхэд улаан түг буюу анхаарал татсан асуудал гарч ирж болно. Тухайлбал:

- ТУЗ-ийн дарга нь бүх шийдвэр гаргалтыг нягт нямбай хянаж байна уу?
- Ашиг сонирхлын зөрчил байна уу? (Тухайлбал, Аудитын хорооны захирлууд нь аудитортой бизнесийн тусгай харилцаа холбоотой юу? Мөн гол гол хувьцаа эзэмшигчидтэй онцгой харилцаа холбоотой юу?)
- Төлөөлөн удирдах зөвлөлийн туршлага хангалттай юу? (Аудитын хороонд санхүүгийн болон нягтлан бодох бүртгэлийн ур чадвартай гишүүд орсон байна уу?)



For other red flags on board committees, see: <http://bit.ly/HGJADD>

Улаан тугуудыг тодорхойлж сурах

Компани нь цохилтонд орвол төлөөлөн удирдах зөвлөл нь анхаарлын төвд орж, эргэж харахад ямар асуудалтай байсан талаар ихэвчлэн тодруулж авч үздэг. Энэтхэг улсын Сатям Компьютер системс компанийн Төлөөлөн удирдах зөвлөл нь гэр бүлийн гишүүд буюу танилуудаас бүрдсэн байдаг бөгөөд компанийн удирдлагуудтай, эсвэл тухайн салбартаа түршлага багатай, санхүүгийн үр чадваргүй этгээдүүдтэй ажил хэргийн болон хувийн ойр дотно харилцаа холбоотой байжээ.

Гэхдээ хэрэг мандаж гарсаны дараа л тухайн асуудлыг хүмүүс олж мэддэг гэвч сэтгүүлчид үүнийг анхааралтай мэдээлж асуудлуудыг урьдчилан харах боломжтой. Өөрөөр хэлбэл захирлууд, гүйцэтгэх удирдлагууд болон хяналтыг тогтоосон хувьцаа эзэмшигчдийн түршлага, үр чадвар, харилцан хамаарал, гол гол үзүүлэлтүүдийг нарийвчлан судалж үзнэ. Захирлуудын зөвлөлийн нэгдмэл сонирхолтой этгээдүүдийг шалгах хэрэгтэй. ТУЗ-ийн гишүүдээс өөр компаний зөвлөлд ажиллаж байгаа эсэх, ийнхүү давхар ажиллаж байгаа компани болон түүний төлөлөн удирдах зөвлөлийн бусад гишүүдтэй нөлөө бүхий харилцаатай эсэхийг судална.

Ингэж ухаж судалсанаараа гадаргуу хөрсөн доорх таамаглаж байгаагүй, чухал харилцаа холбоог нээж илрүүлэх боломжтой.

“Хараат бус захирлууд нь ихэвчлэн компанийн удирдагаас хараат бус байж болох ч эдгээр захирал нь бусад ТУЗ-ийн гишүүд, эсвэл томоохон хувьцаа эзэмшигчидтэй чухал харилцаа холбоотой байх нь олонтаа” гэж Дубай хотын Компанийн засаглалын Hawkanah институтийн ахлах эдийн засагч, гүйцэтгэх удирдлага Dr. Nasser Saidi хэлсэн байна.

Хараат бус захирлууд нь ТУЗ-аас огцроход энэ талаар сэтгүүлчид болон хөрөнгө оруулагчид онцлон тэмдэглэж, мэдээлдэг. Ийм ажлаас гарах тохиолдол байнга гараад байдаггүй бөгөөд компанид гүн гүнзгий асуудал байгааг зааж болно. “Гэр бүлийн”, эсвэл “хувийн” шалтгааны улмаас огцорсон гэх тохиолдолдлын талаар сэтгүүлчид улам нарийвчлан судалж үзэх нь бараг байнга байх ёстой зүйл юм.

2007 оны 9 дүгээр сард Хятадад байрлалтай Auto-

mated Touchstone Machine (ATM) компанийн хоёр хараат бус захирал огцорсон бөгөөд компанийн хамгийн сүүлийн санхүүгийн тайлангуудыг цаашид баталгаажуулж чадахгүй гэдгээ мэдэгдсэн байна. Эдгээр хоёр гишүүний нэг нь Сингапурын хөрөнгийн биржид бүртгэлтэй тус компанийн аудитын хорооны гишүүн, нөгөө нь тус хорооны дарга байсан тул дээрх огцорсон асуудал илүү чухал нөлөө үзүүлсэн байна.

2008 онд хөрөнгийн биржээс тус компанийг хасах хүртэл ATM-д ийм огцрох үзэгдэл энгийн явдал болсон байна.

Мөн Сингапурын хөрөнгийн биржэд бүртгэлтэй China Aviation Oil компанийн захирал ч ийм дохиог өгч ажлаасаа гарчээ. Тэрээр 2 жил ажилласныхаа дараа 2008 онд ажлаасаа огцорсон бөгөөд ТУЗ нь шилдэг арга практикийг уландаа гишгэж байгаа тул хараат бус захирлын үүргээ биелүүлэх боломжгүй болсон гэж мэдэгдсэн. Тэрээр олон нийтэд мэдээлсэн захидалдаа ТУЗ-ийн бусад тодорхой гишүүд нь хараат бус болохыг илчилсэн байна.

ТУЗ-ийн дарга болон гүйцэтгэх захирал: тусдаа асуудал уу, эсвэл нэг ойлголт уу?

ТУЗ-ийн дарга болон гүйцэтгэх захирлын үүрэг хариуцлага нь тусдаа байх ёстой эсэх талаарх асуудал нь өөр нэг анхаарал татсан асуудал болж байна.

Үүрэг хариуцлагыг хуваах нь зохистой гэж үздэг мэргэжилтнүүдийнхээр бол хараат бус ТУЗ-ийн дарга нь ТУЗ-ийг тэргүүлж хувьцаа эзэмшигчдийнн ашиг сонирхлыг илүү сайн хамгаалж чадах бол харин гүйцэтгэх захирал нь ашиг сонирхлын олон зөрчлийг арилгаж бизнесийг удирдан явуулдаг.

Гэхдээ зарим нь ийм үүрэг хариуцлагын хуваарилалт нь олон компаниудад туйлын сайн сонголт болохгүй гэж үзэж, дээрх санааг үгүйсгэдэг. Тэдний үзэж байгаагаар эрх мэдлийн төлөөх тэмцэлдээн байхгүй гэсэн утгаараа нэг захиралтай байх нь илүү дээр ажээ.

Ихэнх том компаниуд үүрэг хариуцлагыг тусгаарлаж байхад мөн ихэнх шинэ хууль тогтоомжууд болон компанийн засаглалын дүрэм журмуудад ч үүнийг баталгаажуулсан байдаг. Гэхдээ л үүрэг хариуцлагын тусгаарлал нь нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн арга барилаас хол байна.

Мексикийн Grupo Televisa S.A компанид ТУЗ-ийн дарга болон гүйцэтгэх захирлын үүргийг нэгтгэж

хослуулсан нь GMI-ийн шүүмжлэлийн бай болсон байна. Сэтгүүлчид энэхүү зүй бус зүйлийн талаар мэдээлж сурвалжлахаас ч өмнө тухайн явдал нь сайн засаглалын зарчмуудыг зөрчсөн талаар байнга давтан ярьж байлаа.

GMI-ийн зүгээс Grupo Televisa-ийг шүүмжилсэн нь:

- Өөрийн эцгээсээ компанийг өв залгамжлан авсан Televisa-ийн ТУЗ-ийн дарга бөгөөд гүйцэтгэх захирал Azcarrage Jean нь хараат бус даргыг томилоогүй,
- 20 гишүүнтэй төлөөлөн удирдах зөвлөлийн ердөө таван гишүүн нь бүрэн хэмжээнд хараат бус байсан, хэд хэдэн гишүүн нь Televisa-тай бизнес хийдэг компаниудын төлөөлөн удирдах зөвлөлд ажилладаг байсан,
- Гүйцэтгэх бус гишүүдийн аль нь ч телевизэд ажиллаж байсан хангалттай хэмжээний түршлагагүй байсан,
- ТУЗ-ийн хараат бус байдалд зөвлөлийн захирал хоорондын харилцаа холбоо, мөн Televisa болон захирлуудын хоорондох бизнесийн харилцаа холбоо “ноцтой нөлөөлж” байсан.

Сэтгүүлчдийн зүгээс өөрсдийн мэдээлж байгаа компаниудын төлөөлөн удирдах зөвлөлийн талаар асууж болох асуултуудад:

- Захирлууд нь ТУЗ-д хир удаан хугацаагаар ажиллаж байна вэ?
- Нэг захирлын ажиллах хугацаа хэд вэ?
- Захирлууд хэдэн ТУЗ-д ажилладаг вэ? Тэд тухайн ажиллаж байгаа компанитайгаа бусад бизнесийн харилцаатай юу?
- Тэдний хэн нэг нь өөр компанийн ТУЗ-д ажилладаг уу? Тэд нар ямар хэмжээний цалин хөлс авдаг вэ?
- Захирлууд компанид хичнээн хувьцаа эзэмшдэг вэ?
- Аль нэг захирал нь ойрын үед хувьцаагаа зарсан уу? Ийм үзэгдэл өмнө нь байсан уу?
- Захирал бүрийн ирцийн үзүүлэлт ямар вэ?

Түүнчлэн GMI нь Televisa-ийг хараат бус ТУЗ-ийн хороодгүй мөн аудит, цалин урамшуулал, компанийн засаглалын хороодыг тус тусад нь томилж чадаагүй гэж шүүмжилжээ.

Цалин хөлсний асуудлаар сонор сэрэмжтэй байх

ТУЗ-ийн хараат бус байдал нь цалин хөлсний тал дээр чухал байж болно. Энэ нь сүүлийн хорь гаруй жилийн турш хөгжилтэй орнуудын зах зээлд хамгийн чухал асуудал болж байсан.

Бусад улс орнуудтай харьцуулахад АНУ-д цалин хөлстэй холбоотой шуугиан тарьсан хэргүүд хамгийн их гарч байлаа. Гэхдээ 2008 онд Economist-д онцлон тэмдэглэхдээ Америк маягийн дээд түвшний гүйцэтгэх захирлуудын цалин урамшуулалын систем нь Европын олон компаниудад нийтлэг байсан бөгөөд энэ үеэс хойш зөвхөн дээрх хандлага улам илт тодохой болжээ.

Биржид бүртгэлтэй компаниуд нь ихэвчлэн итгэмжлэлийн тайлан мэдэгдлүүд дээрээ цалин хөлсний асуудлыг ил тод зарладаг. Компанийн жил бүрийн хувь нийлүүлэгчдийн хурал болохоос өмнө саналын хуудсыг хувьцаа эзэмшигчдэд илгээдэг. Энэ хурлаар зөвхөн дээд түвшний удирдлагуудын жил бүрийн цалин хөлсний талаар мэдээлээд зогсохгүй мөн урамшуулал, тэтгэмж, хувьцааны опшин, тэтгэвэрт гаралт, эсвэл үүрэгт ажлыг дуусгавар болоход төлөх төлбөрийн талаар авч хэлэлцдэг.

Шинээр гарч ирж буй зах зээл дээрх олон хөрөнгийн биржүүдийн хувьд гүйцэтгэх удирдлагын цалин хөлсний талаар мэдээлэх шаардлага, дүрэм журам байдаггүй. Тухайлбал, санхүүгийн зах зээлийн нэгдмэл байдлын талаарх CFA институтын төвийн нэг судалгаанд Ази тивийн улс орнуудад цалин хөлсний талаар мэдээлэх тогтолцоо байхгүй, олон улсын шилдэг арга барилаас хоцорсон байгаа тул хөрөнгө оруулагчдыг хамгаалах талаар сайжруулсан арга хэмжээ авч ажиллах шаардлагатай байна гэжээ.

“Ази тивийн одоогийн байдал нь хувьцаа эзэмшигчдийн байгууллагын санхүүгийн асуудлын талаар олж мэдэх эрхийг хязгаарлаж байна, улмаар энэ нь бизнесийн үйл ажиллагаа явуулахад итгэл хүлээлгэсэн этгээдүүдийн үүрэг хариуцлага. Мөн ийм байдал нь хувь хүний хариуцлагатай байдлыг үнэлэхэд сохор болгож байна” гэж дээрх судалгаанд дурдсан байна.

Шинээр гарч ирж буй зах зээлүүдийн хувьд бол гүйцэтгэх бус захирлуудын цалин хөлс хангалтгүй байх, эсвэл цалин хөлсгүй ажиллах явдал байдаг нь илүү их анхаарал татах асуудал болж байна. Зарим компаниуд ТУЗ-ийн гүйцэтгэх бус захирлууддаа хувь нийлүүлэгчийн хурлаар бага хэмжээний төлбөр төлдөг, бүтэн жилийн хөдөлмөрийн хөлсийг үнэлдэггүй. Гүйцэтгэх бус захирлуудад ийнхүү цалин хөлс хангалттай хэмжээнд олгож чадахгүй байгаа учраас эдгээр захирлуудыг хувийн орлогоо нэмэгдүүлэхийн тулд хэд хэдэн ТУЗ-ийн албан тушаалд ажиллах сонирхолтой болгож болно. Энэ нь компанийн төлөөх сэтгэл, сонирхлыг бууруулаад зогсохгүй мөн хариуцлагатай байдлыг алдагдуулж болзошгүй юм.

Чухал асуудлуудыг тодорхойлоход тайлан, судалгаануудыг ашиглах

CFA буюу Мэргэшсэн санхүүгийн шинжээчийн судалгаа зэрэг тайлангууд нь компанийн засаглалын талаарх байнга мэдээлэхийг хүссэн сэтгүүлчдийн хувьд “алтны орд” болно. Түүнчлэн судалгааны ажлууд, санал асуулга болон блогууд нь компанийн засаглалын талаарх муу арга барил, эсвэл болзошгүй зөрчлийг тодорхойлон бичсэн байдаг ч компаниудын талаар мэдээлдэг шилдэг сурвалжлагчдын мэдээний дэргэд ач холбогдол багатай юм. Ёс суртахуун, ил тод, хараат бус байдал, хариуцлага, үүрэг болон шударга байдал зэргээр компаниудыг авч үзэж, үнэлгээ өгдөг.

Тухайлбал, CFA-ийн мэдээллийн ил тод байдалтай холбоотой судалгаанд дурдсанаар сэтгүүлчид нь өөрсдийн мэдээлж байгаа томоохон компаниудын мэдэгдэл, зарлалыг шалгаж үзэж, тийнхүү олон нийтэд мэдээллийг хүргэхдээ шалгарсан хамгийн сайн арга барилыг дагаж мөрдөж байгаа эсэхийг нарийвчлан авч үзэх ёстой. Мөн тухайн бүс нутаг, эсвэл салбар дахь бусад компаниудтай харьцуулалт хийж болно.

Түүнчлэн мэдээ хайж байгаа сэтгүүлчдийн хувьд тухайн бүс нутгийн жилийн судалгаа, компанийн засаглалын үнэлгээний үзүүлэлтүүд нь ач холбогдолтой юм. Хараат бус брокер, хөрөнгө оруулалтын групп болох CLSA Asia Pacific Markets нь Азийн Компанийн засаглалын холбоотой хамтарч Ази тивийн 11 улс орны 580 хувьцаат компаниудыг хамруулсан компанийн засаглалын жилийн судалгааг гаргадаг.



ТА ЮУ МЭДЭХ ВЭ?

Шуурхай асуулт, хариулт

1. Гүйцэтгэх болон гүйцэтгэх бус захирлын хоорондох ялгаа юу вэ?

- A. Гүйцэтгэх захирал нь ТУЗ-ийн хороог тэргүүлдэг бол гүйцэтгэх бус захирал нь тус хороог удирддаггүй.
- B. Гүйцэтгэх захирал нь менежментийн нэг гишүүн бол гүйцэтгэх бус захирал нь гишүүн бус болно.
- C. Ялгаа байхгүй.

2. Захирал нь хараат бус байдлаа хадгалахад ямар хүчин зүйлс сөрөг нөлөө үзүүлдэг вэ?

- A. Компанийн менежментийн гишүүн байх
- B. Компанийн үйл ажиллагаа явуулж байгаа салбарын мэргэжилтэн
- C. Өөр компанид захирлын үүрэг хашиж байх

3. Дараах хороодоос аль нэг нь төлөөлөн удирдах зөвлөлд хамгийн нийтлэг байдаг. Харин бусад нь сонголтот хэлбэрээр байдаг. Аль нь хамгийн их нийтлэг хороо вэ?

- A. Нэгтгэл, худалдан авалтын хороо
- B. Аудитын хороо
- C. Ёс зүйн хороо

Хариултууд: 1. B, 2. A, 3. B

ЭХ СУРВАЛЖУУД БҮЛЭГ 2

Редакторын тэмдэглэл: 2 дугаар бүлгийг бэлтгэхэд зориулж доорх эх сурвалжуудыг авч үзсэн болно. Ямар ч хүн ихэнх вэбсайтууд руу нь орох боломжтой. Wall Street сэтгүүл, Financial Times зэрэг тодорхой эх сурвалжуудын мэдээг үзэхийн тулд нэвтрэх эрх захиалах шаардлагатай. New York Times нь уншигч, үзэгч бүрт зориулж сар бүрд хязгаарлагдмал тооны архивласан материал өгдөг.

НИЙТЛЭЛ, БҮТЭЭЛҮҮД

Annalisa Barrett, судалгааны ахлах мэргэжилтэн, “Төлөөлөн удирдах зөвлөлд байгаа хүмүүст ирдэг бүх зүйлс”, Байгууллагын өөрчлөлт шинэчлэлтийн ирээдүй, Corporate Library, 2009.
<http://bit.ly/HGJADd>

Nathaniel Parish Flannery, GMI-ийн судлаач шинжээч, “Telenovela: Мексик улсын Televisa-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хариуцлагатай байдлын цаашдын асуудлууд”, Forbes, 2011 оны 6 дугаар сарын 9-ний өдөр
<http://onforb.es/IOMgNe>

Nathaniel Parish Flannery, Governance Metrics International (GMI)-ийн судлаач шинжээч, “Шинэ судалгаагаар Латин Америкийн компанийн засаглалын одоогийн тулгамдсан асуудлуудыг онцолсон”, 2011 оны 9 дүгээр сарын 27-ны өдөр
<http://bit.ly/J7LCtC>

Kalpana Rashiwala, “АТМ-ийн хараат бус захирлуудын огцролт”, Business Times (Сингапур), 2007 оны 9 дүгээр сарын 17-ны өдөр
<http://bit.ly/IlMhcz>

Aude Lagorce, “Европ тивд шуугиан дэгдээсэн гүйцэтгэх удирдлагын цалин хөлсний асуудал”, MarketWatch, 2009 оны 5 дугаар сарын 14-ний өдөр.
<http://on.mktw.net/IS6LeO>

Ric Marshall, ахлах шинжээч, “Захирлуудын асуудал: Хувьцаа эзэмшигчийн санаа зовоосон асуудлуудыг онцлох нь”, Company Library, 2010 он

Michelle Quah, “Ази тив гүйцэтгэх удирдлагын цалин хөлсний талаар мэдээлэх системээ сайжруулах шаардлагатай байна”, Business Times (Сингапур), 2008 оны 3 дугаар сарын 3-ны өдөр.
<http://bit.ly/lv2nDM>

Moulisree Srivastava, “Гэр бүлийн бизнес засаглалын асуудалтай тулгарав”, LiveMint, 2011 оны 9 дүгээр сарын 21-ний өдөр.
<http://bit.ly/HP6I3M>

Pavan Kumar Vijaya, “Компанийн тухай шинэ хуулийн төсөлд ёсзүйн асуудлын өндөр түвшинд авч үзнэ”, DNA India, 2011 оны 12 дугаар сарын 30-ны өдөр
<http://bit.ly/I9jdFN>

“Байгууллагын бүтэц зохион байгуулалтын үндэс суурь”, Investopedia
<http://bit.ly/HG44Qj>

“Европ дахь гүйцэтгэх захирлын төлбөр: Анхаарал татсан асуудал”, Economist, 2008 оны 6 дугаар сарын 12-ны өдөр
<http://econ.st/HGNnR5>

“Дэлхийн хамгийн том нээлттэй хувьцаат компаниудын 40 гаруй хувь нь төлөөлөн удирдах зөвлөлдөө ямар ч эмэгтэй гишүүнгүй болохыг судалгаагаар тогтоожээ”, Corporate Library, 2011 оны 3 дугаар сарын 14-ний өдөр.
<http://bit.ly/KD5CI6>

НОМ, СУДАЛГАА

“ТУЗ-ийн цоорхойг нөхөх нь”, *Study Group on Corporate Boards blue ribbon panel*, Колумбийн Бизнесийн их сургууль, Delaware-ийн их сургуулийн Компанийн засаглалын John L. Weinberg-ийн төв, 2011 он.
<http://bit.ly/JyJ9OM>

Төлөөлөн удирдах зөвлөлийн үүрэг хариуцлага, шилдэг арга барил зэрэг Компанийн засаглалын баримт бичгүүд, Корпорацийн захирлуудын форум
<http://bit.ly/HDB765>

Corporate Governance Watch 2010, жилийн судалгаа, CLSA Asia Pacific Markets and Asian Cor-

porate Governance Association (ACGA).
<http://bit.ly/IESikf>

Гүйцэтгэх бус захирлуудын хараат бус байдал (Ази тивийн бодит хараат бус байдлыг олох нь), CFA институтийн Санхүүгийн зах зээлийн нэгдмэл байдлын төлөөх Ази-Номхон далайн орнуудын оффис, 2010 он. <http://scr.bi/HRt9Vo>

“Төлөөлөн удирдах зөвлөл дэх эмэгтэйчүүд: Эрэгтэй захирлуудтай хийсэн харилцан яриа”, Олон улсын Компанийн засаглалын форум, 2011 он.

<http://bit.ly/LEphFk>

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ТАЛААРХ БҮХ ЗҮЙЛС

Олон хувьцаа эзэмшигчид компаниуд юу хийж байгаа, төлөөлөн удирдах зөвлөл нь хариуцлагатайгаар ажлаа гүйцэтгэж байна уу, хөрөнгө оруулалтыг болгоомжтойгоор удирдан зохицуулж, зарцуулж байгаа эсэхийг мөрдөн шалгаж, мэдээлэхэд сэтгүүлчдэд итгэж найдаж байдаг.

Гэхдээ сүүлийн жилүүдэд хувьцаа эзэмшигчид нь өөрсдөө илүү их дуу хоолойгоо илэрхийлж, олон төрлийн асуудалд илүү идэвхитэй байр сууринаас оролцож байгаа. Янз бүрийн улс орнуудын зохицуулах байгууллагууд нь хувьцаа эзэмшигчдэд ТУЗ-н гишүүнд нэр дэвшүүлэх эрхийг олгож тэдний нөлөөг улам бататгасан.

2008 онд АНУ-ын ипотекийн зээлийн зах зээл нуран унаж, дэлхийн санхүүгийн зах зээлийн хямралыг даатгах болсон нь захирлууд хувьцаа эзэмшигчдийн өмнө үүрэг хариуцлагаа биелүүлж байгаа эсэх талаар илүү нарийн авч үзэхэд хүргэжээ. Үүнтэй зэрэгцэн хуул шүүхээр маргалдах явдал нэмэгдэж, хэвлэлийнхний мэдээллийн үрсгал ч дагаж ихэслээ.

Хувьцаа эзэмшигчдийн эсэргүүцэл нь дан ганц идэвхитэн, эсвэл институционал хөрөнгө оруулагчид(даатгалын компани, тэтгэврийн сан болон компаниудын хувьцааг их хэмжээгээр худалдаж авдаг хөрөнгө оруулалтын итгэлцлийн сангууд)-ын үйлдлээс хамааралгүйгээр улам эрчимтэй болж мөн түүнчлэн гэр бүлийн эзэмшлийн компаниуд ч мөн ийм эсэргүүцэлтэй тулгарлаа.

Macau casino-ийн эзэн Stanley Ho өөрийн эзэнт гүрнийг удирдан хянахын тулд гэр бүлийн дотоод зөрчил тэмцэлтэй тулгарсан байна. Эцэст нь компанийн өв залгамжлагчдын хоорондох маргааныг шийдвэрлэхийн тулд өөрийн ихэнх хувьцаанаасаа татгалзахад хүрчээ.

Но-ийн гэр бүлийн энэхүү хэрэг гэр бүлийн гишүүдийн хоорондох маргаан шийдвэрлэх хууль журманд ч тусгалаа олжээ. Сэтгүүлчид бие биеэсээ өрсөн, урьд

өмнө нь хөндөгдөж байгаагүй хамгийн сүүлийн үеийн мэдээг олж авахын тулд тэмцэлдэж байв. Иргэний нэхэмжлэл, шүүхийн үйл ажиллагаа нь ихэвчлэн сэтгүүлчдэд хувьцаа эзэмшигчийн үйлдлийг мэдэх боломжоор хангадаг ч үүнээс гадна институционал хөрөнгө оруулагчид, зохицуулах байгууллагууд, шинжээчид, ТУЗ-ийн гишүүд болон компанийн дотоод мэдээлэл эзэмшигчдийн дундах харилцаа холбоо, мэдээлэл нь мөн мэдээний сайн эх сурвалж болдог.

Хувьцаа эзэмшигчид өөрсдийн санал шүүмжлэлийг анхаарлын төвд авчрахын тулд хэвлэл мэдээлэлд байнга мэдээ өгдөг байна. Заримдаа цорын ганц хувьцаа эзэмшигч ч аюулын хонхыг дэлдэж, компани юу хийж байгаа талаар шалгах сонирхлыг сурвалжлагчдад өгдөг.

Нэг жишээ дурдаж болж байна. Лондонгийн хөрөнгийн биржэд бүртгэлтэй Bumi plc-тэй хамтарсан Индонезийн нүүрсний компани болох PT Bumi Resources –ийн зээлийн үйл ажиллагааны талаар нэг хувьцаа эзэмшигч нь асуудал тарьсан байна. Nat Rothschild хэмээх хувьцаа эзэмшигч нь тус компанийн 11 хувийг эзэмшдэг банкны өв залгамжлагч этгээд бөгөөд компанийн зүгээс өндөр хүүтэй зээлээр дахин санхүүжилт татан төвлөрүүлэх гэж гэж байхад нь харьяа компаниудад зээл өгөхийг шаардаж дайрчээ.

Тэрээр өөрийн гомдлын талаар нарийвчлан бичиж компанийн захирлуудад захидал бичсэн бөгөөд захидлын нэг хувийг Financial Times-ийн сурвалжлагчдад өгсөн байна.



Энэ ганц хувьцаа эзэмшигч том компанийн эсрэг зогссон талаар Financial Times хэрхэн мэдээ

бичсэнийг харахыг хүсвэл:
<http://on.ft.com/IF2PvR>

Хувьцаа эзэмшигч нь компани ямар асуудалтай тулгарч болох талаарх сэтгүүлчдэд мэдээлж туслах боломжтой юм. Сурвалжлагчид нь компанийн “ашиг хүртэгч эзэд”-ийг шалгах ёстой. Эдгээр эздийн хувьцаа нь хамтын сан, эсвэл хөрөнгө оруулалтын итгэлцлийн сан зэрэг өөр этгээдийн нэр дээр байсан ч ийм хувь эзэмшлээсээ ашиг, өгөөж хүртэж байдаг. Шинээр гарч ирж буй болон хөгжиж буй зах зээлд үнэт цаасны зах зээл нь ихэвчлэн хөгжлийн эхэн үед шатандаа байдаг бөгөөд хувь эзэмшил нь компанийн эздийг шалгаж мөрдөхөд хэцүү болгосон бүртгэлийн дүрэм журмуудтай байж болно.

Зарим хувьцаа эзэмшигчид үйл ажиллагааг зогсоодог

2011 онд Rupert Murdoch-ийн News корпорацийн ёсзүй болон ТУЗ-ийн үүрэг хариуцлагын талаар анхаарал татсан асуудлыг татсан утасны дуут шууданг хакердсаны дараа институционал хөрөнгө оруулагчид тус компанийг шүүмжилсэн.

АНУ-ын хамгийн том нийтийн тэтгэврийн сан болох California Public Employees Retirement System (Calpers) нь Rupert Murdoch болон хүү James, Lachlan нарыг News корпорацийн төлөөлөн удирдах зөвлөлд дахин сонгох саналыг эрх эзэмшиж байсан. Өөрөөр хэлбэл бусад институционал хөрөнгө оруулагчдыг ийм үйлдэл гаргах сэдэл үүсгэж чадна. 2012 оны 3 дугаар сарын эхээр хувьцаа эзэмшигчдийн дарамтан дор Murdoch-ийн хүү James-ийг News International-ийн гүйцэтгэх захирлын албан тушаалаас нь огцруулсан.

Олон ч сэтгүүлчид 2011 оны 10 дугаар сард болох компанийн жил бүрийн ээлжит хурлын талаар олон долоо хоног онцолж ярьсан. Их хэмжээний хувьтай хувьцаа эзэмшигчид ч өөрсдийн зорилгодоо хүрэх боломж багатай байлаа. News корпораци нь хоёр зэрэглэлийн хувьцаатай бөгөөд Murdoch-ийн гэр бүлийн В хувьцаа нь саналын эрхийн 40 хувийг эзэлдэг бол үлдсэн 60 хувь нь ямар ч саналын эрхгүй байлаа.

“Ийм нөхцөл байдлын улмаас бага зэрэглэлийн хувьцаа эзэмшигчид нь өөртөө эрсдлийг хүлээж, чадваргүй, эсвэл бүтэлгүй менежерүүдийг ч зайлуулах боломжгүй болгодог” гэж сэтгүүлч Dan Gillmor Guardian (Их Британи)-д бичсэн байна.

Шинээр хөгжиж буй зах зээлийн хувьцаа эзэмшигчид ч үүнтэй төстэй бэрхшээлтэй асуудлуудтай тулгардаг. Өөрөөр хэлбэл өөрсдийн

ашиг сонирхлыг хамгаалах нь үндсэн санаа зовоосон асуудал болж байдаг.

2004 онд Оросын засгийн газраас Yukos Oil компанийн үйл ажиллагааг үр дүнтэйгээр зогсооход цөөнх хувьцаа эзэмшигчид нь хохирч үлдсэн. Компанийн эзэн ба үүсгэн байгуулагч Михайль Ходорковскийг Сибирийн шоронд хорих ял оноосон. Шүүх үйл ажиллагаа болон ял оноолт нь улс төрийн сэдэлтэй байсан эсэх талаар маргаан байдаг.

Yukos-ийн хөрөнгө оруулагчдын дийлэнх нь гадаад бөгөөд компанид хөрөнгө оруулсан 100 хүртэлх тэрбум ам.долларыг нөхөн төлүүлэх оролдлого хийж, хуулийн янз бүрийн манёвр ашиглахыг хичээж байв. Гэхдээ олон улсын шүүх үйл ажиллагаанд зарим жижиг хувьцаа эзэмшигчид ялалт байгуулсан тохиолдол байдаг ч ерөнхийдөө ийнхүү амжилттай ялах нь ховор байдаг.

Бага хувьцаа эзэмшигчийн түүхийг харх

Зарим тохиолдолд цөөнхийн хөрөнгө оруулагчидтай зүй бусаар харьцвал хуулийн үйлдэл хийхэд хүргэж болдог. Тухайлбал Мексикийн TV Azteca-тай холбоотой хэргийг дурдаж болно. Тус компанийн ТУЗ-ийн дарга бөгөөд гүйцэтгэх захирал Ricardo Salinas Pliego хувьцаа эзэмшигчдэд мэдэгдэлгүйгээр нээлттэй хувьцаат TV Azteca-аар дамжуулж өөрийн шинэ компанид хөрөнгө оруулах замаар шинэ теле харилцаа холбооны хамтарсан компанийг санхүүжүүлэх тогтолцоог бүрдүүлжээ. Энэ нь хувьцаа эзэмшигчдийн дургүйдлийг хүргэсэн байна.

Бага хувьцаа эзэмшигчид шүүх хэрэг гаргасан байна. Хэдэн жилийн дараа АНУ-ын Үнэт цаас, арилжааны хороо (ҮЦАХ) болон Мексик улсын эрх бүхий байгууллагуудын зүгээс бага хувьцаа эзэмшигчдийн зардлаар Pliego болон түүний хамтран ажиллагсдын олсон ашиг, гэрээ хэлэлцээрт шалгалт хийж эхэлжээ.

Эцэст нь ҮЦАХ-оос Pliego-г залилан хийсэн гэж үзсэн байна. Түүнд хариуцлага оногдуулахаар болж, гэм буруутай гэж шүүхэд таталгүй торгууль өгчээ. Гэхдээ хожим нь тэрээр компаниудыг биржээс хасахаар шийдвэрлэсэн байна. Мексикийн зохицуулах байгууллагууд нь цөөнхийн хөрөнгө оруулагчдад илүү нээлттэй, мэдээлэлтэй байлгахын тулд компаниудыг шахаж шаардсан хууль тогтоомжоо өөрчлөн шинэчилжээ.

Энэтхэг улсад засгийн газар нь жижиг хувьцаа

эзэмшигчдийг эрх ашгийг компаниуд үл хайхрахаас урьдчилан сэргийлэхийн тулд арга хэмжээ авсан байна. 2012 онд батлагдах Компанийн тухай шинэ хуулийн төслийн дагуу бол компаниуд худалдан авалт, бусад салбарт хөрөнгө оруулалт хийх зэрэг компанитай холбоотой томоохон шийдвэрүүдийг эсэргүүцсэн хувьцаа эзэмшигчдэд хувьцаагаа зарж гарах төлөвлөгөөг санал болгох ёстой гэж заажээ. Одоохондоо хууль болж хэрэгжээгүй ч дээрх хуулийн төсөл нь санал зөрөлдөөнтэй байгаа хувьцаа эзэмшигчдэд хувьцаагаа илүү хялбар байдлаар зарж гарах боломж олгоно. Тухайлбал, компанийн зүгээс хувьцааг эргүүлж авах зэрэг сонголтуудыг хувьцаа эзэмшигчдэд санал болгож болно.

Институционал хөрөнгө оруулагчид нь ихэвчлэн их хэмжээний хувь эзэмшиж байгаа компаниудад мэдрэгдэж байгаа асуудлуудын талаар сэтгүүлчдэд учиг атгуулдаг. Ялангуяа Calpers энэ тал дээр идэвхитэй. 2010 онд тус тэтгэврийн сангийн зүгээс Мексикийн буланд асгарсан газрын тосны хэрэгтэй холбоотойгоор BP plc-ийн удирдлага, чадварыг шүүмжилсэн. BP-ийн 60.6 сая ширхэг хувьцааг эзэмшдэг Calpers-ийн мэдээлсэнээр бол газрын тос асгарахаас өмнө компанийн АНУ дахь үйл ажиллагааг хянаж чадаагүй ажээ.

2011 оны 4 дүгээр сард Calpers BP-ийн хувьцаа эзэмшигчидтэй хамтарч тус компанийн жил бүрийн ээлжит хурлаар тайлан тооцоог нь эсэргүүцсэн байна. Мөн BP-ийн ТУЗ-ийн аюулгүй ажиллагааны хорооны захирал байсан этгээдийг дахин сонгохын эсрэг саналаа өгсөн байна.

Тус компани газрын тос асгарах аюулыг удирдан зохицуулж чадаагүйн улмаас 2012 оны 3 дугаар сарын эхээр 10,000 гаруй хохирогчоос нэхэмжлэл авч 7.8 тэрбум ам.долларын нөхөн төлбөр төлөхөөр болсон байна.

Шинээр хөгжиж буй зах зээлүүдийн хувьд институционал хөрөнгө оруулагчдын хувь эзэмшил ерөнхийдөө бага байдаг. Иймээс сэтгүүлчдийн зүгээс компани доторх болон хувьцаа эзэмшигчдийн дундах хагаралдааны талаарх мэдээ, тайланг нарийвчлан судалж үзнэ гэсэн итгэл найдвар хөрөнгө оруулагчдын

дунд байдаг. Ази болон Африк тивд хувьцаа эзэмшигчдийн холбоод нь илүү нийтлэг бөгөөд идэвхитэй болж байгаа нь маш сайн эх сурвалж болдог.

Жишээлбэл, Малайзын Minority Shareholders' Watchdog Group (MSWG) нь өөрийн вэбсайт (<http://www.mswg.org/my/web>)-тай бөгөөд одоо компанийн засаглалын асуудлууд, компанийн хэлцэл гүйлгээний талаар онцолж долоо хоног бүр электрон зар мэдээг гаргадаг болсон байна. Сингапурын Үнэт цаасны хөрөнгө оруулагчдын холбоо (SIAS) (<http://www.sias.org.sg/>) нь мөн дээрхтэй адил үйл ажиллагааг эрхэлдэг бөгөөд хувьцаа эзэмшигчдийн асуудлыг компаниудын өмнө дэвшүүлэн төлөөлж хэд хэдэн удаа амжилттай ажилласан байна.

Пакистан дахь Карачигийн хувьчлагдсан цахилгаан хангамжийн компанийн хувьцаа эзэмшигчид нь 2011 оны тайландаа дурдсан компанийн нэхэмжлэлүүдийг эсэргүүцсэн байна. Тус тайланд 2010 оноос 2011 он хүртэлх татварын дараах алдагдлыг бууруулж тооцсон байжээ.

Хувьцаа эзэмшигчдийн холбооноос үзэж байгаагаар алдагдлын хэмжээг ийнхүү бууруулсан нь “хэт их ачааллыг далдлан нуусан” алхам ажээ. Өөрөөр хэлбэл эрэлт ихтэй байх үед цахилгааныг таслах буюу “хэтрүүлж төлбөр авах” зүй бус явдлыг тодорхойлж хэрэглэсэн нэр томъёо, ойлголт юм. Түүнчлэн хувьцаа эзэмшигчдийн зүгээс компанийг засгийн газрын эзэмшлийн байх үеэсээ илүү их татаасыг засгийн газраас авч, цахилгаан үйлдвэрлэлийг бууруулсаных нь төлөө шүүмжлэл өрнүүлсэн.



Өөр нэг сайн эх сурвалжийг дурдвал Өмнөд Африкийн хариуцлагатай хөрөнгө оруулалтын хууль юм:
<http://bit.ly/HDK2o1>

Бид Яаж Мэдээ Олж Авдаг вэ

Заримдаа зөвлөж хэлсэн үгнээс ч жижиг хувьцаа эзэмшигчид болон тэдгээрийн тэмцлийн талаарх мэдээг бичиж болно. Компанийн засаглалын зарчмуудын талаарх мэдлэг болон эх сурвалжийн сайн харилцаа холбоо нь мэдээг бичихэд чухал ач холбогдолтой.

Нэг жишээ татвал, Children's Investment Fund (TCI) -ийн ажилчид саяхан хувьчлагдсан Coal India Limited компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн захирлуудыг шүүхэд дуудах төлөвлөгөөний талаар сэтгүүлчдэд мэдээлсэн байна. TCI нь тус компанийн бага хувьцаа эзэмшигч бөгөөд компанийн 90 хувийг Засгийн газар эзэмшдэг байна.

Энэтхэгийн өдөр тутмын Business Standard сонингийн зүгээс энэ мэдээг хэрхэн олж авсан талаар сэтгүүлч N Sundaresha Subramanian онцлон бичихдээ:

TCI-ийн зүгээс бидэнд мэдээлэл өгмөгц надад David-Goliath-ийн хэрэг санаанд орсон юм. Энэ хэрэгт компанийн ердөө 1 хувийг эзэмшдэг этгээд 90 хувийг эзэмшдэг этгээдийг ялсан байдаг. Иймээс мэдээ бэлтгэж болох юм шиг санагдсан. Тэгээд би TCI-ийн танил Oscar Veldhuijzen руу утасдлаа.

Veldhuijzen хэлэхдээ тус сангийн зүгээс компанийн 2010 оны анхдагч зээлийн арилжаагаар хөрөнгө оруулсанаас хойш Coal India-ийн удирдлагад хандаж хүсэлтээ бичсээр байсан гэнэ. Засгийн газрын зүгээс нүүрсний үнийн өсөлтийг өөрчлөх удирдамж гаргасны дараа TCI-аас ийм үйлдэл хийхэд хүргэжээ. Учир нь нүүрсний үнийн өөрчлөлт нь компанийн ашигт ажиллагаанд ноцтойгоор сөрөг нөлөө үзүүлэх боломжтой байлаа.

Veldhuijzen Энэтхэг улсын Мэдээллийн эрхийн тухай

хуулийг ашиглаж нүүрсний үнэтэй холбоотой удирдамжийн нэг хувийг олж авчээ. Тус хуулиар бол иргэдийг засгийн газрын мэдээг ашиглах боломжоор хангасан байдаг. Тэрээр засгийн газрын өндөр албан тушаалтны зүгээс удирдамжийг Coal China-ийн захиралд явуулсаныг баталж харуулсан баримт бичгийн нэг хувийг бидэнд өгсөн юм.

Тус баримт бичгийг тухайн хэрэгт ашиг сонирхолтой нэг талаас өгсөн тул миний бие тухайн ажилтнууд нь үнэхээр ийм албан тушаалыг албан ёсоор эрхэлж байсаныг шалгаж баталгаажуулахын тулд албан ёсны вэбсайттай нь танилцаж, үнэн бодит бхайдлыг нь шалгасан юм.

Түүнчлэн бидэнд мэдээний нөгөө тал хэрэгтэй байсан. Учир нь Coal India-ийн төлөөлөн удирдах зөвлөл нь өөрсдийн итгэл хүлээсэн үүргээ биелүүлж чадаагүй, мөн цөөнхийн хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалж чадаагүй гэж буруутгагдсан. Яам болон компанийн ажилчидтай харилцаа холбоотой байдаг Дели дэх миний хамтран ажиллагч тус компанитай холбогдсон юм. Coal India-ийн зүгээс TCI-ийн албан бичгийг хүлээж авсанаа баталгаажуулахаас татгалзсан. Бид захидлын агуулгын талаар мэдэж байсан бөгөөд сангийн ажилчдаас үүнийг баталгаажуулж байсан юм. Иймээс бид мэдээг бэлтгэхээр болсон.

Энэ бүх үйлдлийг хийхэл хэдэн цаг л зарцуулсан. Бид тухайн шөнө нь өөрийн вэбсайтандаа мэдээг тавьсан бөгөөд дараагийн өдрийн хэвлэлээр нийтлэгдэж цацагдсан юм.

Энэ талаарх мэдээг уншихыг хүсвэл: <http://bit.ly/19kRay>

Хувьцаа эзэмшигчийн асуудлууд: Компаниудын залгамж халааны төлөвлөгөөг шалгах

Хувьцаа эзэмшигч идэвхитнүүд тодорхой асуудлуудад харилцан адилгүй байр суурьтай байх нь түгээмэл байдаг. Гүйцэтгэх удирдлагын зүгээс өөрийн эрүүл мэндийн талаар хир сайн мэдээлж байх ёстой вэ гэсэн асуулт Apple Inc-ийн гүйцэтгэх захирал Steve Jobs-ийн хэрэгтэй адил хэд хэдэн жилийн турш

маргаан дэгдээж ирсэн. Тэрээр өвчний улмаас компанийг орхиж явах болсон боловч энэ талаар олон нийтэд нарийвчлан мэдээлсэн зүйл тун бага байлаа.

Wall Street-ийн сэтгүүлд дурдсанаар Jobs мэс засалд орсоноос хэдэн сарын дараа буюу 2009 онд элэг шилжүүлэн суулгуулсан талаар олж мэдсэн байна. ҮЦАХ-оос бол компаниудаас залгамж халааны төлөвлөгөөг ил тод байлгахыг шаардаг. Сэтгүүлчид ч

гүйцэтгэх удирдлага гэнэт ажилдаа ирэхгүй болсонтой холбоотойгоор энэ талаар асууж тодруулах ёстой боллоо. Гүйцэтгэх захирал гэнэт ажлаа орхих болсон нь эрүүл мэндээс гадна өөр бусад шалтгаантай холбоотой байж болохоор байлаа. Өөрөөр хэлбэл ТУЗ-тай санал зөрөлдсөн, эсвэл өрсөлдөгч компаниас нь ажлын санал тавьсан байж болох шүү дээ.

Компанийг цаашид удирдан манлайлах залгамж халааны төлөвлөгөө нь нэн ялангуяа гэр бүлийн эзэмшлийн компаниудын хувьд чухал (4-р бүлгийг үз). Компанийн үүсгэн байгуулагчийнэ нас ч ирээдүйн залгамж халааны асуудлыг ноцтойгоор сөхөх үндэслэл болох ёстой.

2011 онд Jobs-ийн үйлдэлтэй холбоотойгоор ч юмүү олон хувьцаа эзэмшигчийн зүгээс дараагийн залгамж халааны төлөвлөгөөг төлөөлөн удирдах зөвлөлөөс олон нийтэд зарлахыг шаардаж эхэлсэн. Хэрвээ гүйцэтгэх удирдлагын өвчин компанийн цаашдын чиг хандлага нөлөө үзүүлэхээр бол төлөөлөн удирдах зөвлөлийн зүгээс энэ талаар мэдээлэх үүрэгтэй гэж идэвхитнүүд үзэж байсан юм.

Berkshire Hathaway-ийн гүйцэтгэх захирал Warren Buffett хэлэхдээ дээд түвшний удирдлагын эрүүл мэндийн асуудалтай холбоотой мэдээллийг олон нийтэд зарлах ёстой гэсэн.

“Хэрвээ би ямар нэг ноцтой өвчинтэй байсан бол, эсвэл үүнтэй төстэй байдалд орсон, ажлаа явуулах зэрэг бүх чухал шинж чанараа алдсан бол хамгийн

түрүүнд хийх ёстой зүйл бол энэ талаар Berkshire-ийн хувьцаа эзэмшигчдэд мэдээлэх ёстой гэж бодож байна. Учир нь би хувьцаа эзэмшигчдийн төлөө ажилладаг шүү дээ” гэж тэрээр хэлжээ. Buffett энэ сэдвийн талаар Stanford-ын их сургуулийн Closer Look-д ярилцлага өгсөн байдаг.

Мэдээ олохын тулд жил бүрийн хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох

Зарим сэтгүүлчдийн хувьд жил бүрийн хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох нь цаг завын гарз гэж боддог. Учир нь хурлын өмнө олон чухал ач холбогдолтой асуудлууд шийдэгддэг, мөн зарим тохиолдолд ихэнх хувьцаа эзэмшигчид нь хурлын үр дүнг урьдчилан тодорхойлсон байдаг гэж үздэг. Гэхдээ арвин туршлагатай бизнесийн сэтгүүлч Melissa Preddy хувь нийлүүлэгчдийн хурал бол очих ёстой үнэ цэнэтэй зүйлсийн нэг гэж боддог ажээ.

“Хувь нийлүүлэгчдийн хурал бол компанийн гүйцэтгэх удирдлагуудтай харилцаа холбоо тогтоох, мөн идэвхитэй хувьцаа эзэмшигчид, захирлууд, шинжээчид, блог бичигчид, байгууллагатай холбоотой нийгэмлэгийн удирдагчид болон бусад компаний оролцогчидтой танилцаж танилын хүрээгээ тэлэх сайхан газар” гэж Бизнесийн сэтгүүлзүйд зориулсан Donald W.Reynolds-ийн Үндэсний төвийн вэбсайтанд Preddy блог бичсэн байдаг.



СУРВАЛЖЛАГЧИЙН ТЭМДЭГЛЭЛИЙН ДЭВТЭР

Оросын хуульч бөгөөд нийтлэлч Alexey Navalny Оросын хамгийн том хэд хэдэн компанийн хувьцааг худалдан авч, улмаар эдгээр компанийн арга практикийг судалж эхэлсэн. Тэрээр Оросын шугам хоолойн монополь оператор болох ОАО Transneft компанийг 2009 онд 112 сая ам.долларын буяны хандив өгсөнийг олж мэджээ. Энэ нь хөрөнгө оруулагчдад төлсөн ногдол ашгийн хэмжээнээс бараг найм дахин их үнийн дүн юм.

Буяны хандивыг хэдэн жилийн турш өгсөөр ирсэн бөгөөд 2007 онд 300 сая ам.доллар хүрсэн байна. Энэ хугацаанд ашиг орлого нь өссөн хэдий ч Transneft-ийн зүгээс хувьцаа эзэмшигчдэд өгөх ногдол ашгаа бууруулсан бөгөөд 2003 оноос 2009 он

хүртэл 75 хувиар бууруулсан байх жишээтэй.

Navalny энэхүү буяны хандив мөнгийг хаашаа нь оруулсан талаар харуулсан баримт бичгийг дахин дахин хүссэн боловч компанийн зүгээс татгалзсан хариу өгч байлаа. Үүнээс болж тэрээр ажигласан зүйлээ ярихдаа: “Хэн ч энэхүү буяны мөнгийн үл мөрийг хараагүй. Би хамгийн том гэсэн буяны байгууллагуудын олон ч менежер, ажилчидтай ярилцаж үзлээ. Тэд энэ мөнгийг огт аваагүй гэж хэлсэн” гэжээ. [:http://bloom.bg/HAykpC](http://bloom.bg/HAykpC)

New Yorker’s Julia Ioffe-аар дамжуулж Navalny-ийн танилцуулгыг уншихыг хүсвэл <http://nyr.kr/HGk4Bz>

Түүний нийтлэлийг уншихыг хүсвэл: <http://bit.ly/HPaTwk>

Компанийн жил бүрийн хувь нийлүүлэгчдийн хуралд бэлтгэхийн тулд сэтгүүлчдийн зүгээс компанийн итгэмжлэлийн мэдэгдэл, хөрөнгө оруулагчдад зориулсан мэдэгдэл, саналын хуудас зэрэг хурал болохоос өмнөх 6 орчим долоо хоногт ихэвчлэн гардаг материалуудыг нарийвчлан судлах ёстой. (“Итгэмжлэл” гэдэг үгийн тодорхойлолтыг тайлбар толиноос харна уу.)

Ихэнх улс оронд хөрөнгийн биржүүд, эсвэл үнэт цаасны зохицуулах байгууллагуудын зүгээс шаарддаг итгэмжлэлийн тухай мэдэгдэлд хэд хэдэн асуудлын талаар нарийвчлан тусгасан байх ёстой. Гэхдээ шинээр бий болсон олон хөрөнгийн биржүүд дээр ийм нээлттэй байх шаардлага сул, үүнийг дагаж мөрдөх байдал ч хангалтгүй байдаг. Ямартаа ч гэсэн итгэмжлэлийн мэдэгдлийн хувьд дараах зүйлсийг шалгах нь чухал юм. Үүнд:

- Гүйцэтгэх удирдлага болон захирлуудын цалин хөлсний талаарх нарийвчилсан мэдээлэл, тусгай тэтгэмж болон зээл үүнд хамаарна.
- Жилийн ээлжит хурал дээр санал өгөхөд зориулж танилцуулах асуудлууд, үүнд захирлын сонгон шалгаруулалт орно.
- Захирлын үндсэн үзүүлэлт болон туршлагыг авч үзэх ёстой, ингэснээр хувьцаа эзэмшигчид илүү мэдээлэлтэй шийдвэр гаргах боломжтой болно.
- Хувьцааны опшаний шилжүүлэг
- Одоогийн захирлуудын туршлага болон ТУЗ-ийн бусад гишүүдийн талаарх мэдээлэл

Жил бүрийн ээлжит хурал дээр танилцуулах аливаа санал төлөвлөгөөний талаарх мэдээлэл нь ойлгомжтой, бүрэн дүүрэн байх ёстой. Хэрвээ ийм биш байвал сэтгүүлчид учир шалтгааныг нь тодруулж асуух ёстой.

Түүнчлэн итгэмжлэлийн мэдэгдэлд “холбогдох этгээдтэй хийсэн хэлцэл”-ийн талаарх мэдээллийг тусгаж болно. Үүгээр компаниуд нь өөрсдийн гүйцэтгэх удирдлага болон захирлуудтай хийсэн хэлцлийг илчилж байна гэсэн үг (Холбогдох этгээдтэй хийсэн хэлцлийн талаарх илүү дэлгэрэнгүй мэдээллийг 5 дугаар бүлгээс үзнэ уу).



Итгэмжлэлийн талаарх мэдээг хэрхэн олж авах талаар илүү дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл Melissa Preddy-ийн “Гүйцэтгэх удирдлагын төлбөр болон бусад мэдээнд зориулсан итгэмжлэлийн мэдэгдэлүүд”-ийг үзнэ үү:
<http://bit.ly/J7XjAt>

Жил бүрийн ээлжит хурлаас хэрхэн сайн мэдээлэл олж авах вэ

Сэтгүүлчид нь ихэвчлэн компаниудын жил бүрийн ээлжит хуралд бусад хурал шиг шууд оролцоод байдаггүй. Хэвлэл мэдээллийнхэн зэрэг гадны этгээдүүд хувьцаа эзэмшдэггүй л бол хуралд оролцох хууль ёсны эрхгүй байдаг. Хэрвээ байгууллагууд нь

Авилга хээл хахуулийн түвшин өндөртэй улс орнуудын компаниудын хувьцаа эзэмшигчид болон бизнесийн сурвалжлагчид нь маш их хэмжээгээр нягт нарийн анхаарал хандуулж байх ёстой. Оросын төрийн өмчит компаниуд ийм аюултай арга барилын эсрэг хатуу тэмцэж зогсч байна”

— Alexey Nabalny, Maxim Trudolyubov, Nieman Reports, 2011 оны хавар



зөвшөөрсөн бол эсвэл тухайлан хувьцаа худалдан авахад тулгарч буй асуудлыг ил гаргаж тавьхаар хувьцаа эзэмшигчид нь сурвалжлагчлийг байлцуулах зөвшөөрлийг олгодог байна.

Зарим сэтгүүлчдийн хувьд хурлын үеэр ердийн байдлаар ажиллаж, хурал болж байгаа газрын ойролцоо хувьцаа эзэмшигчид болон бусад хүмүүстэй ярилцлага хийж, эсвэл хурлын дараа утсаар яриа авдаг.

Нэг компани Times-ийн сурвалжлагчийг жил бүрийн ээлжит хуралд оролцохыг нь хориглосны дараа буюу 2005 онд “Нарын гэрэл бол хамгийн сайн халдваргүйжүүлэгч, нуух ямар ч зүйлгүй компаниудын хувьд хэвлэл мэдээллийнхнийг нээлттэй хүлээж авдаг” гэж ажиглагч Corporate Library-ийн редактор Nell Minow New York Times-д ярилцлага өгсөн байдаг.

2001 онд Yahoo Inc компани жил бүрийн ээлжит хуралд сурвалжлагчдыг оролцуулахаас эсэргүүцсэн тул шүүмжлэгчдийн дургүйцлийг хүргэсэн байна. Хувьцаа эзэмшигчдийн хувьд интернетээр хурлын талаар сонсох боломжтой. Гэхдээ ийм хориг нь сэтгүүлчдийн хувьцаа эзэмшигчдэд хүрч очих боломжийг хязгаарлаж, тэднийг хурлын байдлын талаар бүрэн дүүрэн ойлголт авахад саад болдог гэж сэтгүүлчид гомдоллодог.

Сүүлийн жилүүдэд олон компаниуд зөвхөн интернетээр жилийн хурлаа хийдэг болжээ. Шүүмжлэгчдийн үзэж байгаагаар бол энэ нь хувьцаа эзэмшигчдээс өөрсдийг нь тусгаарлах, мөн буруутай үйлдлээ хамгаалах гэсэн өөр нэг арга зам гэнэ. Харин байгууллагын ажилчид онлайн хурал, үүлзалт нь хувьцаа эзэмшигчдийн сонирхлыг илүү их татаж, илүү олон хүмүүсийг хуралд оролцох боломж олгодог гэж үздэг.

Жил бүрийн ээлжит хуралд оролцох өөр нэг шалтгааныг дурдвал жил бүрийн ээлжит хуралд оролцож, өөрсдийн хүссэн асуудал, үндэслэл шалтгаануудаа удирдлага болон төлөөлөн удирдах зөвлөлд тулгаж дарамт үзүүлдэг идэвхитэн буюу “хэнхэг” хувьцаа эзэмшигчдийг барьж авах явдал юм.

Зарим сурвалжлагчид ийм хэнхэг хувьцаа эзэмшигчдээс ичиж зайлсхийж, тэднийг эх сурвалж гэхээсээ илүү хортон шавьжтай адилтган үздэг. Гэхдээ л ийм хувьцаа эзэмшигчид анхаарвал зохих практик болон ТУЗ-ийн алдаа дутагдлын талаарх санааг ихэвчлэн өгдөг.

Компани доторх чухал асуудлын эхний ул суурь нь ийм хувьцаа эзэмшигчийн саналаас гарч ирдэг.

Иймээс бизнесийн сурвалжлагчид дээрх төрлийн хувьцаа эзэмшигчидтэй болгоомжтой хандахын зэрэгцээ нөгөө талаас эх сурвалж болгон ашиглавал зохино.

Хувьцаа эзэмшигчийн эрхийн асуудалд анхаарлаа хандуулах

Байгууллагуудын хэрэг улам мандан гарч ирэх давалгаанаар АНУ-ын моргейжийн зээл ч амжилтгүй болж, дэлхийн санхүүгийн хямралд хүргэсэн. Хувьцаа эзэмшигчид ч компаниудад илүү хүчтэй дуу хоолойгоо хүргэх, хөрөнгө оруулалтаа хамгаалуулахын тулд хэд хэдэн арга хэмжээг санаачилсан байна. Хувьцаа эзэмшигчийн хийсэн мэдэгдэл нь эсэргүүцлийг өдөөн турхирч, мэдээний санааг өгч болно.

Америкийн Нэгдсэн улсад ҮЦАХ-ийн дүрэм журмуудын дагуу компанийн 1 хувь, эсвэл 2,000 ам.доллараас илүү хэмжээний хувьцаа эзэмшдэг аливаа этгээд ийм санал, мэдэгдэл гаргахыг зөвшөөрсөн байдаг (Энэ хязгаар үзүүлэлт нь бусад улс оронд харилцан адилгүй байж болно).

Дүрэм журам болон биелэлт

Зарим зах зээл дээр хувьцаа эзэмшигчид компанийн талаарх хатуу чанга дүрэм журмууд, ялангуяа ил тод байдал, хариуцлагатай байдал, зайлшгүй дагаж мөрдөж биелүүлэх ёстой зүйлсийг шаарддаг. Хувьцаа эзэмшигчдийн зүгээс хийсэн ийм үйл ажиллагаа нь сэтгүүлчдийн анхаарлыг ихэд татдаг бөгөөд сэтгүүлчид нь хөрөнгийн биржээс тавьж байгаа шаардлагуудыг бусад улс орнуудын ижил төстэй дүрэм журмууд, шаардлагуудтай харьцуулж ярих боломж бүрдэнэ.

Компанийн нийгмийн хариуцлага

Хувьцаа эзэмшигчид, компанийн бусад оролцогчид, харилцагчид болон компанийн байгууламжуудын хөрш зэргэлдээх байгууллагууд, бэлтгэн нийлүүлэгчид, засгийн газар нь ихэвчлэн компаниудаас хүрээлэн байгаа орчныг хамгаалах, байгалийн нөөц баялгийг ариг гамтай ашиглах, ажилчидтай шударга харьцахад хариуцлагатай байхыг шаарддаг.

Хөрөнгө оруулагчид нь компанийн нийгмийн хариуцлагатай уялдуулж бизнесийн үйл ажиллагааг анхаарч үздэг. Өөрөөр хэлбэл өрсөлдөгч компаниудаасаа ялгарч илүү өндөр өгөөж өгөх боломжтой компаниудыг харна гэсэн үг. Norway’s зэрэг тэтгэврийн сангууд нь компанийн багц, эсвэл хөрөнгө оруулах талбар нь нийгмийн хариуцлагатай эсэхийг үнэлэхийн тулд удирдамж, дүрэм журмуудыг

МЭДЭЭНИЙ ХЭРЭГСЛИЙН ХАЙРЦАГ

Компанийн хурал уулзалтанд ороцоход хувьцаа эзэмшигчдийн хувьд хир амархан байдаг вэ? Компанийн хурлын өмнө энэ талаар урьдчилан мэдээ бичих хэрэгтэй.

- Санал өгөхөд бэрхшээлтэй зүйлс байна уу?
- Итгэмжлэлийн мэдэгдлийг нотариатаар баталгаажуулах шаардлага, эсвэл итгэмжлэлийг шуудангаар илгээхтэй холбоотой саад бэрхшээл зэрэг хууль зүйн ямарваа хориг, хүндрэл байгаа эсэх?
- Хурлыг нууцаар хийх, тохиромжгүй цаг хугацаанд хол зайдуу газарт хийх зэрэг далд, нууцлаг саад бэрхшээл байгаа эсэх?
- Чухал санаа солилцох, асуулт асуухад хангалттай хэмжээний цаг хугацаа байгаа эсэх?
- Хурлын мэдэгдлүүдийг хэрхэн хүргүүлсэн вэ? Хэн ч унших боломжгүй байдлаар албан мэдээллийн самбарт хууль ёсны зар сурталчилгааг тавьсан уу, имэйлээр илгээсэн үү, эсвэл шуудангаар илгээсэн үү, эсвэл олон нийтийн хэвлэл мэдээллээр нийтэлж гаргасан уу?
- Хэрвээ тус компани нь жил бүрийн ээлжит хурлыг онлайнгаар хийдэг бол хувьцаа эзэмшигчдэд асуулт шууд асуух боломж олгосон уу?
- Компанийн хөрөнгө оруулагчтай харьцах алба хэлтэс нь компанийн талаарх асуултанд хариулт өгдөг үү?

— Эх сурвалж: Компанийн засаглалын тухай хэвлэлийн бага хурлаас тохируулж авч хэрэглэв. Бодлогын харилцааны санаачлага

ашигладаг. 18 триллион ам.долларыг удирдаж байгаа 550 гаруй хөрөнгө оруулалтын сангууд нь өөрсдийн хөрөнгө оруулалтаа чухалчлан үзэж НҮБ-ын Хариуцлагатай хөрөнгө оруулалтын зарчмууд дээр гарын үсэг зурсан байна. Энэ нь олон улсын түвшинд мөрдөж дагадаг цогц зарчмууд юм.

Хөрөнгө оруулагчид, нийгмийн идэвхитнүүд болон компаниудын хоорондох мөргөлдөөн нь сайн мэдээ бичих санаа болно. Энэтхэг улсын Coco-Cola компани нь хэдэн жилийн турш фермерүүдийн усны хомсдолын асуудлыг шийдэж өгөхийг хүссэн дарамтанд орж байлаа. Учир нь тус компани лонхолж савлах үйлдвэр барьсны улмаас ийм нөхцөл байдал үүдэн бий болжээ. Үүнтэй зөрчилдсэн нэг мэдээ гэвэл Хятадын Intel корпорацийн хамааралтай болно.

<http://bloom.bg/HRwPGC>

2011 оноос хойш Bear Greek Mining корпораци нь Перуд 25,000 эсэргүүцэгчидтэй тулгарсан. Ажил хаялт болж, гол гол хурдны замуудыг үхэр чулуугаар хаагдсан. Мөнгөний шинэ уурхайг фермерүүд эсэргүүцэж, өөрсдийн амьдрал ахуйд сөрөг нөлөө үзүүлнэ гэж айж байсан юм. Мөн Chevron Nigeria Limited-ээс эдийн засгийн үр ашиг шаардахын тулд Нигерийн Niger Delta дахь эмэгтэйчүүд газрын тосны байгууламжуудыг бүсэлж байсан түүхтэй.

Түүнчлэн засгийн газруудын зүгээс ч өөрсдийн улс орон бизнесийн үйл ажиллагаа явуулж байгаа компаниудад дарамт шахалт үзүүлдэг. Ялангуяа тухайн бизнесийн үйл ажиллагаа нь улс орны байгалийн нөөц баялагтай холбогдолж байгаа тохиолдолд дээрх дарамт хүчтэй ажиглагддаг. Тухайлбал, Танзани улсад Ерөнхийлөгч Jakaya Kikwete нь орон нутгаас бараа бүтээгдэхүүн, ажил үйлчилгээг худалдаж авч байхыг олборлох салбарынхнаас шаардсан байдаг.

“Энэ нь компаниуд болон компаниудын үйл ажиллагаа явуулж байгаа олон нийтийн дундах харилцаа холбоог сайжруулна. Эс бөгөөс энэ хоёр талын хоорондох дайсагналаас зайлсхийх боломжгүй юм” гэж тэрээр хэлсэн байна.

Төлөөлөн удирдах зөвлөл нь нийгмийн хариуцлагыг анхаарч үзэж байвал компанийн засаглалын бодлогууд, практикууд болон хөрөнгө оруулалтын хандлагыг эерэгээр харах үндэслэл болдог. Эргэн тойрны орчин, олон нийтийг бохирдуулах химийн бодис ашиглавал энэ нь гүн гүнзгий асуудлын дохио болж мэднэ. Ийм хуучирсан үйлдвэрлэлийн технологи нь ашигт ажиллагааг ч бууруулна.

Байгууллагын нийгмийн хариуцлагатай холбоотой асуудлуудын талаар мэдээлж байхдаа сэтгүүлчдийн хувьд асуух ёстой зүйлс гэвэл:

- Компани нь гомдлыг сонсч, шийдвэрлэж байна уу?
- Дээд түвшний удирдлага, эсвэл төлөөлөн удирдах зөвлөлийн аливаа этгээд нь хөдөлмөрийн болон байгаль орчны хамгааллын тухай хуулийг зөрчсөн бэлтгэн нийлүүлэгчдийн ашиг олох боломжийг бүрдүүлэх сонирхлын зөрчилтэй эсэх?
- Компаний бусад оролцогчдоос өгч байгаа шүүмжлэл нь бодитой байна уу?
- Асуудлуудыг засварлахад юу хийх вэ? Үүний шийдлийн өртөг ямар байх вэ?
- Ямар нэг нууж далдалсан зүйл байна уу?

Компанийн нийгмийн хариуцлагыг зөрчсөнөөс үүдэн гарсан хямрал нь удирдлагыг өөрчлөхөд хүргэж, улмаар компанийн нэр хүнд болон ашигт ажиллагаанд аюул учруулж, ажлын байр, байгаль орчны хийгээд бусад хууль журмуудыг мөрдүүлэх засгийн газрын, эсвэл хэвлэл мэдээллийн зохицуулах байгууллагуудад улс төрийн асуудал үүсгэж болох талтай билээ.

Компаниудаас хараат бус байдлаар үнэлгээ хийдэг байгаль орчны бүлгүүд зэрэг төрийн бус байгууллагууд болон институционал хөрөнгө оруулагчид нь ерөнхийдөө компанийн нийгмийн хариуцлагын талаарх мэдээний сайн эх сурвалж болж байдаг.

Компаниуд хамгийн сайн практикуудыг дагаж мөрдөж байгаа эсэхийг илүү сайтар ойлгохын тулд тэдгээрийн үйл ажиллагааг бусад мэргэжлийн байгууллагуудын гаргасан удирдамжуудтай нийцэж байгаа эсэхийг харьцуулан шалга. Тухайлбал, үүнд Азийн компаниудыг жил бүр хянаж шалгадаг CLSA Asia Pacific Markets, Нэгдсэн Үндэсний байгууллагын Олон улсын гэрээ хэлэлцээр, Олон улсын санхүүгийн корпорацийн Эквадорын зарчмууд, дэлхийн хамгийн том тэтгэврийн сангуудын боловсруулсан НҮБ-ын Хариуцлагатай хөрөнгө оруулалтын зарчмууд орно.

Ийм хамгийн сайн практикуудад орох нь:

Дагаж мөрдөх эрхүүд

Томоохон хувьцаа эзэмшигч нь хувиа зарах бол жижиг хувьцаа эзэмшигчийг хамгаална. Энэхүү дүрмийн дагуу компани дүрмийг баталсан л бол жижиг хувьцаа эзэмшигчид нь хэлцэлд оролцож, өөрсдийн хувьцааг зарах эрхтэй байна.

ТУЗ-ийн дарга, гүйцэтгэх захирлыг нэг этгээд гүйцэтгэхийг хориглох

Энэ асуудлаах хэлэлцүүлгийг харахын тулд 2 дугаар бүлгийг үз.

Цалин хөлсний талаар санал хэлэх

Гүйцэтгэх удирдлагын цалин хөлстэй холбоотой заавал үл биелүүлэх саналын эрхийг хувьцаа эзэмшигчдэд өгдөг. Олон улс оронд энэ эрхийг зөвлөх эрх байдлаар хувьцаа эзэмшигчдэд өгдөг байлаа. Сөрөг зөвлөх саналыг биелүүлвэл зохистой, ялангуяа хэдэн жил дараалан ийм санал гарсан тохиолдолд сөрөг саналыг хэрэгжүүлнэ.

Австрали улсын “хоёр цохилт” гэсэн цалин хөлстэй холбоотой бодлогын талаарх мээг харахыг хүсвэл:

<http://bit.ly/HPb2Qv>

Сэжигтэй байж болох хэлцлийг анхаарч үзэх

Хувьцаа эзэмшигчид нь үйлдэл хийсэн эсэхийг үл харгалзан сэтгүүлчид нь хөрөнгө оруулагчдын туйлын ашиг сонирхлын төлөө бус байж болох компанийн үйлдлийг ажиглаж байх ёстой.

Тухайлбал, 2007 онд Хонгконгийн биржид бүртгэлтэй China National Offshore Oil Corporation Ltd (CNOOC) нь гурван жилийн турш өөр нэг төрийн эзэмшлийн компанид мөнгөө хадгалуулахыг хүссэн. Ийм үйлдэл нь хувьцаа эзэмшигчдэд өөрийн эзэмшдэггүй компанийн алдагдлыг хуваалцах эрсдлийг бий болгожээ. Иймд хараат бус хувьцаа эзэмшигчдийн 52 гаруй хувь нь тус мөнгөний хөдөлгөөнийг авч хэлэлцэхийн тулд зарлан хуралдуулсан ээлжит бус хурлаар эсэргүүцэж байгаагаа илэрхийлсэн байна.

2004 онд CNOOC нь үүнтэй төстэй хэлцэл хийсэн болохыг сэтгүүлчдэд мэдэгдсэн байж болох юм. Хувьцаа эзэмшигчид нь тус хэлцлийг баталсан боловч амралтын өдөр болсон хувьцаа эзэмшигчдийн хурлын талаар товч мэдэгдэл хүлээн авчээ. Тухайн үед Блүүмбергийн мэдээнд бичихдээ “Хятадын төрийн өмчит байгууллагууд нь хувьцаа эзэмшигчдэд мэдэгдэлгүйгээр нээлттэй арилжаалагддаг компаниудаас ашиг хүртэж байна” гэж шүүмжлэлтэй хандсан байдаг.

Хожим нь Хонгконгийн зохицуулах байгууллагууд нь 2004 оны дээрх хэлцлийн талаар мэдээлэх ёстой дүрмийг зөрчсөн гэж CNOOC-ийг нийтийн өмнө шүүмжлэн бичсэн байдаг.

Ёсзүйн зөрчлийн талаар анхааралтай байх

Компанийн талаарх мэдлэгээ дээшлүүлэх, эсвэл мэдээ бичих зорилгоор хувьцаа худалдан авч байгаа сэтгүүлчдийн хувд ёсзүйн асуудлуудыг ой ухаандаа тооцож байх ёстой. Хувьцаа худалдан авалт нь хууль журмын дагуу, ил тод байх тусмаа, эсвэл худалдан авсан дүн нь бага, нэг юмуу хоёр хувьцааг авсан бол энэ нь асуудал үүсгэхгүй.

Гэхдээ ямарваа заль мэх ард нь нуугдаж байгаа бол асуудалтай болж мэднэ. Wall Street сэтгүүлийн сурвалжлагч Dennis Berman нь нээлттэй бус технологийн хувьцаат компаниудын арилжааны зах зээл болох SharesPost-аар дамжуулж нийгмийн харилцаа холбооны вэбсайт болох Facebook-ийн хувьцааг худалдан авах зорилгоор өөрийн эмэг эхдээ хүсэлт гаргажээ. Berman-ийн зорилго бол энэ систем нь дүрэм журмуудыг хуурах гэсэн түүний оролдлогыг олж илрүүлэх эсэхийг шалгах явдал байсан юм.

Berman “Бизнесийн үйл ажиллагааг явуулах бүхий л арга замыг шалгах энгийн арга барил хэрэглэх нь хөрөнгө оруулагчид болон зах зээлд чухал сэдвийг илүү ойлгоход тусална” гэж өөрийн үйлдлээ хамгаалан хэлсэн байдаг.

Гэхдээ түүнийг уг үйлдлийг Reuters-ийн нийтлэлч Felix Salmon зэрэг өрсөлдөгч сурвалжлагчид нь өөрийгөө буруу илэрхийлсэн алхам гэж хүчтэй шүүмжилсэн байна. Salmon энэ явдлыг “осолтой үзүүлбэр” гэж нэрлээд Berman-ийн ёсзүйг шүүмжилсэн байна. (Бизнесийн сурвалжлагчдын ёсзүйн талаар илүү дэлгэрүүлж мэдэхийг хүсвэл 7 дугаар бүлгийг үз.)



ТА ЮУ МЭДЭХ ВЭ?

Шуурхай асуулт, хариулт

1. Дагаж мөрдөх эрхүүд гэж:

- A. Олон нийт, иргэд нь компанийн жил бүрийн ээлжит хуралд оролцож болно.
- B. Хэрвээ томоохон хувьцаа эзэмшигч нь хувьцаагаа зарсан бол жижиг хувьцаа эзэмшигчид нь мөн дагаж зарж болно.
- C. Захирлыг нэр дэвшүүлж сонгоход саналаа өгөх арга.

2. Залгамж халааны төлөвлөлт гэдэг нь дараах этгээдийн үүрэг хариуцлага юм.

- A. Хувьцаа эзэмшигчдийн
- B. Одоогийн менежерүүдийн
- C. Төлөөлөн удирдах зөвлөлийн

3. “Цалин хөлсний талаар саналаа хэлэх” гэдэг нь:

- A. Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга нь Гүйцэтгэх захирлын цалин хөлсийг шийддэг
- B. Цалин хөлс, урамшууллын хороо нь шийдвэр гаргадаг.
- C. Хувьцаа эзэмшигчид нь цалин хөлсний асуудлаар зөвлөх дуу хоолойгоо хүргүүлнэ.

Харуулууд: 1. B, 2. C, 3. C

ЭХ СУРВАЛЖУУД БҮЛЭГ 3

Редакторын тэмдэглэл: 3 дугаар бүлгийг бэлтгэхэд зориулж доорх эх сурвалжуудыг авч үзсэн болно. Ямар ч хүн ихэнх вэбсайтууд руу нь орох боломжтой. Wall Street сэтгүүл, Financial Times зэрэг тодорхой эх сурвалжуудын мэдээг үзэхийн тулд нэвтрэх эрх захиалах шаардлагатай. New York Times нь уншигч, үзэгч бүрт зориулж сар бүрд хязгаарлагдмал тооны архивласан материал өгдөг.

НИЙТЛЭЛ, БҮТЭЭЛҮҮД

Dennis Berman, “Facebook-ийн хөрөнгө оруулагч талийгаач эмээтэй уулзсан минь”, Wall Street сэтгүүл, 2011 оны 4 дүгээр сарын 12-ны өдөр. <http://on.wsj.com/HGk9VE>

Maryann Bryant-Rubio, “TV Azteca: Мексикийн компанийн засаглалын кейс судлал”, академик кейс судлал, Колумбийн их сургууль, Нью-Йорк, Олон улсын бизнесийн Chazen Web сэтгүүл, 2005 оны өвөл. <http://bit.ly/IEyn7r>

Jason Corcoran, Henry Meyer, “Ногдол ашиг өндөр байх нь нялхсыг өнчрүүлж, өвчинд хүргэнэ гэж Транснефть хэлэв”, Блүүмберг, 2011 оны 4 дүгээр сарын 19-ний өдөр. <http://bloom.bg/HAykpC>

Maureen Nevin Duffy, “BP-ийн хувьцаа эзэмшигчид жилийн ээлжит хурлаар үгээ хэллээ”, институционал хөрөнгө оруулагч, 2011 оны 4 дүгээр сарын 21-ний өдөр. <http://bit.ly/IOWrBe>

Dan Gillmor, “Яагаад Rupert Murdoch News корпорацийн шинэ зааварчилгааг зарлах ёстой вэ”, Guardian, 2011 оны 10 дугаар сарын 19-ний өдөр. <http://bit.ly/HDUtZ6>

Julia Ioffe, “Цэвэр нөлөөлөл – Нэг эрийн кибер халдлага Оросын авилгалын эсрэг тэмцэв”, New Yorker, 2011 оны 10 дугаар сарын 19-ний өдөр. <http://nyr.kr/HGk4Bz>

Ross Kerber, “Шинжилгээ: Вэбээр хийсэн хувьцаа эзэмшигчдийн хурал эсрэг саналтай дуу хоолойг хориглов”, Royters, 2010 он 9 дүгээр сарын 24-ний өдөр. <http://reut.rs/IPOrln>

CCraig McGuire, “Компанийн хэрхэн хувьцаа эзэмшигч гэж хэн вэ?” Идэвхитэй хувьцаа

эзэмшигч, 2011 оны 11 дүгээр сарын 6-ны өдөр. <http://bit.ly/I9uKVI>

Alexei Navalny, Maxim Trudilyubov, “Оросын сэтгүүлчид авилгал хээл хахуулийг илчлэхэд туслах хэрэгтэй”, Nieman Reports, 2011 оны хавар. <http://hvrd.me/J84PLR>

Melissa Preddy, “Гүйцэтгэх удирдлагын цалин хөлсний итгэмжлэлийн мэдэгдэл болон бусад мэдээг ухах нь”, Бизнесийн сэтгүүлзүйн Donald Reynolds төв, 2011 оны 4 дүгээр сарын 27-ны өдөр. <http://bit.ly/J7XjAt>

Felix Salmon, “Dennis Berman-ийн ёсзүй”, Royters, 2011 оны 4 дүгээр сарын 27-ны өдөр. <http://reut.rs/HGCfVV>

Richard Siklos, “Утасны компани сэтгүүлчдийг жил бүрийн ээлжит хувь нийлүүлэгчдийн хуралд оролцохыг хориглов”, New York Times, 2005 оны 12 дугаар сарын 12-ны өдөр. <http://nyti.ms/HGdWcL>

Walter Stuart, Jessica Mussallem, “Хувьцаа эзэмшигчийн шүүх хэрэг: Та одоохондоо юуг ч хараагүй”, New York Times, 2005 оны 12 дугаар сарын 12-ны өдөр. <http://bit.ly/JT6uFz>

Tim Webb, “Yukos-ийн хувьцаа эзэмшигчид шүүх үйл ажиллагааны эхний шатанд ялалт байгуулав”, Guardian, 2009 оны 11 сарын 30-ны өдөр. <http://bit.ly/HRAOmG>

Xiao Yu, Darren Boey, “CNOOC харьяа компаниуд руугаа шилжүүлэг хийх баталгааг хайж байна”, Блүүмберг, 2004 оны 4 сарын 20-ны өдөр. <http://bloom.bg/HGneVS>

“Мексикийн ууртай хувьцаа эзэмшигчдийн бүлэг”, *Business Week*, 1999 оны 6 дугаар сарын 28-ны өдөр. <http://buswk.co/HxeZqN>

“Apple-ийн Гүйцэтгэх захирал эрүүл мэндийн байдлаа мэдэгдэв: Компанийн, эсвэл хувийн асуудал уу?” *Stanfordknowledgebase, Stanford Business School of Business*, 2011 оны 1 дүгээр сарын 25-ны өдөр. <http://bit.ly/IFkaVo>

“Бизнесийн уламжлалт сэтгэлгээг үл харгалзан Yahoo жил бүрийн ээлжит хуралд сурвалжлагчдыг оролцохыг хориглов”, *Associated Press*, 2001 оны 4 дүгээр сарын 26-ны өдөр. <http://bit.ly/ILSfdi>

“Хэт их төлбөр тооцооноос болж KESC-ийн алдагдал нэмэгдэв”, *Dawn.com, Karachi*, 2011 оны 10 дугаар сарын 14-ний өдөр. <http://bit.ly/Hxaexa>

“Ricardo Salinas Pliego and family,” in “The World’s Billionaires issue,” *Forbes*, Oct. 2010 <http://onforb.es/HGVcWJ>

“Орос улс Yukos Oil компанийн эрх болон Европын шүүхийн дүрмийг зөрчсөн нь”, *Associated Press*, 2011 оны 9 дүгээр сарын 20-ны өдөр. <http://bit.ly/IFkymM>

“Итгэмжлэлийн мэдэгдлийн нууцыг тайлах нь”, *Business-Week*, 2002 оны 3 дугаар сарын 4-ний өдөр. <http://buswk.co/ILLOUC>

“Yukos-ийн хувьцаа эзэмшигчид Стокхольмын арбитрын шүүх үйл ажиллагаанд томоохон ялалт байгуулав”, Хөрөнгө оруулалтын арбитрын шүүхийн сурвалжлагч, 2010 оны 12 сарын 20-ны өдөр. <http://bit.ly/LCLOTD>

Гэр бүлийн болон төрийн өмчит байгууллагуудын эргэн тойронд

Шинээр гарч ирж буй зах зээлтэй улс орнуудад давамгайлж байгаа төрийн болон гэр бүлийн эзэмшилт компаниуд нь сэтгүүлчдийн хувьд нэвтэрч ороход хүндрэлтэй байж болно.

Эдгээр компанийн бүтэц зохион байгуулалт нь төлөөлөн удирдах зөвлөл, үүнтэй төстэй удирдлагын бүтэц, санхүүгийн тайлангуудаа мэдээлдэг, хувьцаа эзэмшигчтэй зэрэг талуудаараа нээлттэй арилжаалагддаг хувьцаат компаниудыг дуурайсан байж болно. Төрийн болон гэр бүлийн эзэмшилтэй олон ч компаниуд хөрөнгийн биржүүдэд бүртгэлтэй байдаг.

Гэхдээ эдгээр компани нь хяналт, тэнцвэржилтийн байдал султай, мөн мэдэгдлийг хязгаарлагдмал хүрээнд хийж үйл ажиллагаа явуулж болно. Энэ нь сэтгүүлчдийн хувьд компанийн нарийн төвөгтэй дотоод үйл ажиллагааны нууцыг тайлахад хүндрэлтэй болгож байдаг.

Олон улсын хяналтын байгууллагууд болон санхүүгийн байгууллагууд нь төрийн өмчит компаниудыг нээлттэй хувьцаат компаниуд шиг ажиллахыг, ялангуяа мэдээллийн нээлттэй байдлыг хангахыг шаардах нь ихэссээр байна.

Гэр бүлийн компаниудын бүтэц, зохион байгуулалт нь төрөл бүрийн хэлбэртэй байж болно.

- Үүсгэн байгуулагчид, эсвэл тэдгээрийн гэр бүл бүхэлд нь эзэмшдэг, удирддаг
- Үүсгэн байгуулагчийн гэр бүл нь хяналтын багц эзэмшдэг, гүйцэтгэх удирдлагад нь чухал үүрэг гүйцэтгэдэг төрийн болон хувийн хэвшлийн компаниуд,
- Гэр бүл нь чухал нөлөө бүхий компаниуд

Тухайлбал, Ойрхи Дорнодод төрийн болон хувийн эзэмшлийн компаниудын нээлттэй байдлыг сайжруулах сонирхол нэмэгдсээр байна. Төрийн болон хувийн эзэмшлийн компаниуд нь эдийн засагт илүү чухал болж, зарим тохиолдолд бүр хангалттай хэмжээний дотоод хяналт, зохих шалгалтгүйгээр үйл ажиллагаа явуулж байгааг санхүүгийн мэргэжилтнүүд ажиглажээ.

“Хувийн болон гэр бүлийн эзэмшлийн компаниуд нь аж ахуйн нэгж салбарын араг ясыг бүрдүүлдэг бөгөөд ажлын байрны маш том орон зайг эзэлж байдаг. Хэрвээ бүс нутгийн зүгээс ажилгүйдлийн хямралыг хязгаарлан барих, ажлын байрыг нэмэгдүүлэхийг хүсвэл энэ салбарыг өсгөж хөгжүүлэх хэрэгтэй юм” гэж Дубай хотын Компанийн засаглалын Hawkamah институтын гүйцэтгэх захирал бөгөөд ахлах эдийн засагч Др.Nasser Saidi хэлсэн байдаг.

Гэр бүлийн бизнесийг ойлгох нь

Family Firm Institute Inc-ийн 2010 оны олон улсын судалгаанд дурдсанаар бол гэр бүлийн компаниуд нь дэлхийн ДНБ-ний 70-90 хувийг жил бүр бүрдүүлж байна гэсэн тооцоо судалгаа байдаг.

Ийм бизнесийн талаарх мэдээ нь ихэвчлэн анхаарал татдаг. Учир нь хүчирхэг, баян чинээлэг, өндөр нууцлалтай гэр бүлийн нэг хэсэг болох онцлог шинж чанарын талаар онцолж ярьдаг. Гэхдээ сэтгүүлчдийн хувьд гэр бүлийн компаниуд нь ил тод байдал дутмаг байдаг тул хүндрэл бэрхшээлүүдтэй тулгарч болно.

“Гэр бүлийн эзэмшлийн” болон “гэр бүлийн хяналттай” гэсэн нэр томъёо нь ихэвчлэн нэг нэгнийгээ орлож хэрэглэгддэг. Гэхдээ ерөнхийдөө гэр бүлийн гишүүд нь гэр бүлийн эзэмшлийн бизнесийн гол хувьцаа эзэмшигчид болдог байхад харин гэр бүлийн удирдаж хянадаг компанийн хувьд гэр бүл нь жижиг хувьцаа эзэмшигч байж болох ч ураг төрлийн хамаарал, удирдлагын үүрэг оролцоо, саналыг

эрхийг эзэмшсэн тусгай зэрэглэлийн хувьцаануудын эзэмшил зэргээрээ дамжуулж компанийн удирдан хянаж байдаг.

Ийм компаниуд нь хэд хэдэн давуу талтай байдаг. Үүнд:

- Шийдвэр гаргалтыг урт хугацаанд хардаг,
- Уян хатан байдал,
- Ирээдүйн залгамж халааныханд зориулсан бизнесийг бий болгох хүсэл тэмүүлэл,
- Компанийн өмнө хүлээсэн гэр бүлийн менежментийн үүрэг амлалт.

Нөгөөтэйгүүр гэр бүлийн компаниуд нь нийтлэг тулгамдсан, бэрхшээлтэй асуудлуудтай байдаг. Үүнд хангалттай хэмжээнд хараат бус төлөөлөн удирдах зөвлөлтэй байх, стратегийн шийдвэр гаргалтуудыг гэр бүлийн гишүүд хийж, төлөөлөн удирдах зөвлөл нь зөвхөн тамга дарах үүрэгтэй, захирлууд болон удирдлагын үүрэг хариуцлагын хооронд будлиан ихтэй, гэр бүлийн хяналт, оролцоо нь нэмэгдэж, өсөх тусам хагарал тэмцэлдээн ихэсдэг байна.

Гэхдээ гол авч үзэх ёстой асуудлуудыг дурдвал:

Гэр бүлийн бизнесүүдийн талаар асуух асуултууд:

- Гэр бүл нь төлөөлөн удирдах зөвлөл болон удирдлагатай харилцаа холбоо тогтоох өөрийн гэсэн удирдах зөвлөлтэй байна уу?
- Төлөөлөн удирдах зөвлөл нь гэр бүлийн бус захирлуудтай юу? Эдгээр захирлууд нь үнэхээр хараат бус уу, эсвэл одоог хүртэл гэр бүлтэй холбоо хамааралтай байна уу?
- Гэр бүлийн хир олон залгамж халаа тус компанийг удирдаж байна вэ? Залгамж халаатай холбоотой тэмцэл, өрсөлдөөн байна уу?
- Компани нь гэр бүлийн ашиг сонирхлын зөрчлийг хянах, шийдэх арга барилтай юу?
- Тэгш бус саналын эрх нь хувьцаа эзэмшигчдийн шийдвэртэй тэнцүү бус үүрэг оролцоог гэр бүлийн гишүүдэд өгч байна уу?

- **Мэргэжлийн бус удирдлага.** Гэр бүлийн гишүүд нь ихэвчлэн зохих мэргэшил чадваргүйгээр удирдлагын албан тушаалд ажиллах нь түгээмэл үзэгдэл юм.

- **Залгамж халааны асуудлууд.** Эдийн засагч Др. Joseph Fan-ийн Азийн зах зээлийн судалгаанд дурдсанаар бол: “Компанийн үүсгэн байгуулагч нь дараагийн залгамж халаадаа жолоогоо өгсөний дараа таван жилийн хугацаанд компаниуд дунджаар 60 орчим хувиар үнэ цэнээ алдаж байжээ”. Шинээр гарч ирж буй зах зээлүүдийн гэр бүлийн бизнесийн үйл ажиллагааны ач холбогдлыг харгалзан үзвэл энэ асуудал нь эдийн засгийн хөгжлийн гол бэрхшээлтэй асуудалд болдог байна.

Гэр бүлийн олон бизнесүүд өөрсдийн ашиг сонирхлыг зохицуулах, гэр бүл, төлөөлөн удирдах зөвлөл болон дээд түвшний удирдлагын хоорондох үндсэн харилцаа холбоог тогтоохын тулд гэр бүлийн зөвлөлийг томилдог. Мөн тус зөвлөл нь төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд нэр дэвшигчдийг санал болгож, гэр бүлийн хөдөлмөр эрхлэлт, цалин хөлс болон хувь эзэмшил зэрэг зүйлүүд дээр бодлого боловсруулдаг.

Гэр бүлийн зөвлөл доторх эх сурвалжуудыг сайжруулах нь мэргэжлийн дээд түвшиндээ очих хүсэлтэй сэтгүүлчдийн хувьд гол түлхүүр нь болно.



Гэр бүлийн бизнесүүд, тэдгээр нь хэрхэн ажилладаг талаар илүү дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл “ОУСК-ийн Бизнесийн засаглалын гарын авлага”-ыг үзнэ үү:
<http://bit.ly/JNjkqO>

Төлөөлөн удирдах зөвлөл дэх гэр бүлийн нөлөөллийг анхаарч үзэх

Мөн сэтгүүлчдэд төлөөлөн удирдах зөвлөл дэх эх сурвалжууд ямагт хэрэгтэй болно. Гэр бүл болон хараат бус захирлуудын аль алинтай нь холбоотой эх сурвалжууд энд хамааралтай.

Энэтхэгийн Satyam Computer Systems Ltd-ийн хэрэг гарсаны дараа төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус байдал нь чухал асуудал болсон.

Компанийн зүгээс анх Satyam-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн дарга бөгөөд үндэслэгч Ramalinga Raju-ийн хүүхдүүдийн удирдаж байгаа хоёр компанийг худалдаж авахын тулд 1.6 тэрбум ам.доллар төлөхийг зөвшөөрсөний дараа Satyam-ийн залилан хэрэг илчлэгдсэн. Raju-ийн гэр бүл Satyam-ийг ажиллуулдаг бөгөөд түүний ах нь ердөө 8 хувийн хувь эзэмшилтэй гүйцэтгэх захирал байсан юм.

Гэхдээ компанийн зүгээс гэр бүлийн эзэмшлийн хоёр компанийг их үнийн дүнгээр худалдаж авах ородлого хийх үед хувьцаа эзэмшигчид нь эсэргүүцэл гаргаж, хувьцааны ханш нь унасан. Улмаар төлөөлөн удирдах зөвлөлөөс дээрх компаниудыг худалдаж авах шийдвэрээсээ буцсан.

Raju сүүлийн жилүүдэд дансны бүртгэлийг буруу хөтөлж, хамгийн сүүлийн улиралд хөрөнгө гэж бүртгэсэн 1.04 тэрбум ам.долларын банкны зээл, бэлэн мөнгө байхгүй байгааг олон нийтэд илчилж захидал бичих ёстой болсон. Эцэст нь тус компани дээрх луйврыг тодорхойлохын тулд 2002 оноос 2008 он хүртэл зургаан жилийн турш үр дүнгээ дахин тооцоолсон байна.

Төлөөлөн удирдах зөвлөл, зохицуулах байгууллагууд болон аудиторчуудын хараа хяналтан дор Raju ийм олон жилийн турш хэрхэн луйвар хийж байсан вэ?

Дээрх хэрэг бүхэлдээ компанитай холбоо хамааралгүй болохыг өмнө нь сэтгүүлчид мэдэх ёстой байсан уу? BusinessWeek-ийн мэдээнд Satyam-ийн нууц улаан тугийг тооцсон байсан:

- Төлөөлөн удирдах зөвлөл нь зургаан менежментийн бус захирлуудтай байсан боловч дөрөв нь эрдэмтэн, нэг нь засгийн газрын танхимын нарийн бичгийн дарга байжээ. Зөвхөн нэг гишүүн нь өмнө нь технологийн компанийн дээд түвшний гүйцэтгэх удирдлагаар ажиллаж байжээ.
- Тус компани нь аудитын хороондоо санхүүгийн мэргэжилтэнгүй байжээ.
- Satyam нь Гүйцэтгэх захирал болон төлөөлөн удирдах зөвлөлийн даргын албан тушаалуудыг тусгаарласан боловч дээрх хоёр албан тушаалыг менежментийн гишүүд байсан, компанийн их хэмжээний хувьцааг эзэмшдэг ах дүүс хашиж байлаа.
- Төлөөлөн удирдах зөвлөлд хараат бус чадварлах захирал байсангүй.

Гэр бүлийн компаниудын бүтэц, зохион байгуулалтыг шалгах

“Пирамид” хэлбэрийн бүтэц, зохион байгуулалт нь гэр бүлийн ноёрхолтой компаниудад нийтлэг тохиолддог. Хуулийн дагуу бол нэг гэр бүл эзэмшлийн харилцаа холбооны гинжин хамаарлаараа дамжуулж хараат бус компаниудыг удирдан хянаж болдог. Компанийн саналын эрхийн хамгийн багадаа 20 хувийг эзэмшдэг хяналтын багц эзэмшигч этгээд нь өөр нэг хувьцаат компанийн эзэмшлээр дамжуулж компанийг хянаж удирддаг.

Ийм компаниуд нь хууль зүй болон ёсзүйн талаасаа үйл ажиллагаа явуулж болно. Гэхдээ 2011 онд Хятадын интернетийн компани болох Renren Inc Нью-Йоркийн хөрөнгийн бирж дээр IPO гаргахад АНУ-ын хөрөнгө оруулагчид маш болгоомжилж дээрх төрлийн бүтэц зохион байгуулалтыг хэрэгжүүлсэн.

Хөрөнгө оруулагчийн вэбсайт болох Motley Fool-ийн онцлон дурдсанаар бол Renren-ийн хувьцааг санал болгож байсан компани нь Кэймэний арлуудад бүртгэлтэй холдинг компани байжээ. Хятад дахь Renren-ний үйл ажиллагаа хариуцсан компани нь угтаа Beijing Qianxiang Tiancheng Technology Development байсан бөгөөд тус компанийн 99 хувийг Renren-ийн гүйцэтгэх захирлын эхнэр болох Хятад гаралтай иргэн эзэмшихээр болж байлаа.

Хоёр зэрэглэлийн хувьцааны бүтэц, зохион байгуулалт гэж байдаг бөгөөд үүнд зарим хувьцаа нь саналын эрхтэй, зарим нь ийм эрхгүй байдаг. Мөн ийм бүтэц, зохион байгуулалттай бол гадны хувьцаа эзэмшигчдийн нөлөөлөл ч хязгаарлагдмал болдог. Энэ бол гэр бүлийн удирдлагатай компаниудад ердийн тохиолдол болно.

Дээр дурдсан болон бусад анхааруулах дохиог үл харгалзан Renren (RENN) нэгж хувьцаагаа 14 ам.доллараар зарж 740 сая ам.доллар татан төвлөрүүлсэн байна.

Энэ IPO амжилттай болсоноос харахад “улаан туг” нь хэт туйлширсан компанийг тодорхойлж өгдөг гэж боддог хөрөнгө оруулагчдыг ч зогсоож саатуулдаггүй байна. Гэхдээ Хятадын компаниудын нягтлан бодох бүртгэлийн практик нь бусад Хятад компаниудтай адил Renren-д хохирол учруулсан гэж хөрөнгө оруулагчид санаа зовниж, тус компанийн хувьцааны үнэ 2012 оны эхээр 4.05 ам.доллар болж унасан.

Дайсагналцсан гэр бүлүүд нь сайн мэдээ өгдөг

Заримдаа гэр бүлийн дотоод дайсагналцал нь шуугиан дэгдээсэн мэдээг бий болгодог. Тухайлбал Мексик улсад Azcarraga-ийн гэр бүл гурван үе дамнан хамгийн том телевиз болох Grupo Televisa S.A-г удирдан хянаж байжээ.

Тус компанийн хуучин захирлын бэлэвсэн эхнэр баривчлагдаж, түүний компанийн томоохон хувь эзэмших нэхэмжлэлээсээ татгалзахыг шаардах хүртэл хэрэг явдал өрнөөгүй. Ажиглагчид ч компани хэрхэн ажиллаж байгаа, төлөөлөн удирдах зөвлөлийн цалин хөлс ямар байгааг нягт нарийн харж эхэлсэн байна. Grupo Televisa-г авах эрхийн төлөө гэр бүлийн зөрчил, дайсагналцал гарах үеэр гол үйл явдал ихэвчлэн өрнөдөг.

Японд байрлалтай олон улсын шар айрагны компани болох Kirin Holdings нь Бразил улсын гэр бүлийн эзэмшлийн шар айраг үйлдвэрлэгч Schincariol Participacoes e Representacoes SA-ийн хяналтын багцыг худалдаж авахаар оролдож байхад нь гэр бүлийн дайсагналцал үүдэж гарсан.

Kirin-ийн худалдаж авахыг сонирхсон Бразилийн компанийн хувьцааны 50 орчим хувийг тус компанийн үүсгэн байгуулагчийн ур удам болох Shincariol-ийн Гүйцэтгэх захирал болон түүний ахын эзэмшиж байгаа нэг компани авсан байлаа. Гэхдээ Shincariol-ийн үлдсэн 49 хувийн хувьцааг дээрх гэр бүлийн хамаатан саднуудын компани эзэмшдэг байв.

Гүйцэтгэх захирал болон түүний ах нь хувьцааг зарахдаа болгоомжтой хандаж байсан ч харин хамаатан саднууд нь үүнийг эсэргүүцэж, шүүхийн хориг шийдвэр гаргуулахаар шүүхэд ханджээ. Японы үндэсний өдөр тутмын сонин болох Asahi Shimbun-ийн мэдээнд гэр бүлийн энэхүү луйврын талаар дэлгэрэнгүй бичсэн байдаг. Энэ мэдээ нь бүр 1950-иад оны үед хамаарах бөгөөд тус компанийн Итали дахь цагаач үүсгэн байгуулагч компанид эзлэх хувиа өөрийн хоёр хүүдээ хувааж өгсөнөөс хэрэг үүджээ. Шар айрагны салбарынхан гэр бүлийн энэхүү хувь хуваалтын талаар ерөнхийдөө мэдэж байснаа мэдэгдсэн боловч Kirin ийм эсэргүүцэл болно гэж таамаглаж байсангүй.

Гэр бүлийн бизнесийн бүхий л мэдээний хувьд тухайн компанийн дотор үйл ажиллагааны талаар бодитой бөгөөд итгэлтэй бичихэд компани доторх сайн эх сурвалж шаардлагатай. Энэ эх сурвалж нь компанийн доторх болон гаднах этгээдүүд, эсвэл гэр бүл доторх этгээд ч байж болно.



Энэ мэдээг сурвалжлагчид хэрхэн бичиж зохицуулсан талаар харахыг хүсвэл “Бразил дахь Kirin-ийн бизнесийн үйл ажиллагааг өргөжүүлэн тэлэх төлөвлөгөө нь гэр бүлийг дайсагналцахад хүргэсэн нь”-ийг үзнэ үү. <http://bit.ly/lhYdK1>

Гэр бүлийн нууцлыг задлахын тулд шүүх үйл ажиллагааг судал

Шүүх үйл ажиллагааны талаар сайтар уншиж судалвал гэр бүлийн компаниудын хөшгийг нээхэд сэтгүүлчдэд тус болно. Учир нь компаниудтай холбоотой маргаан нь шүүхээр эцэслэн шийдвэрлэгддэг бөгөөд их хэмжээний ажил хэрэг болон баримт бичгүүдийг олон нийтэд задалдаг.

Жишээ татвал 2008 онд гэр бүлийн дайсагналцал, маргаантай холбоотой шуугиан тарьсан хэргийг дурдаж болно. Хонконгийн хамгийн баян гэр бүлүүдийн нэгийн эзэмшдэг Хонконгийн хамгийн том үл хөдлөх хөрөнгө хөгжүүлэгч Sun Hung Kai Properties (SHKP) компанийн хэрэг юм.

Компанийн ТУЗ-ийн дарга болон Гүйцэтгэх захирал нь SHKP-ийн ТУЗ-д өөрийн хайрт хүнээ оруулахыг хүссэн тухай мэдээ гарахад хэрэг явдал өрнөж эхэлсэн. Үүнээс болж гүйцэтгэх захирлын хоёр дүү нь ахыгаа шахан зайлуулж, 79 настай ээжийгээ түүний оронд тавьж, төлөөлөн удирдах зөвлөлд эргэлт гаргах үйлдэлд хүргэсэн. Энэ асуудлаар хэд хэдэн удаа шүүх хурал болж, хөөгдсөн гүйцэтгэх захирал нь хоёр дүүгийнхээ эсрэг хэрэг үүсгэсэн байна. Харин дүү нарынх нь зүгээс ахыгаа “худалч” болж, ухаангүй болтлоо гутралд автсан гэж буруутгаж үзэж байсан.

“Гэр бүлийн үнэнч байдал нь эцэстээ дайсагналцал болоход юу тохиолддог вэ? SHKP-ийн хэргийн хувьд тус компанийн зах зээлийн үнэ долоон өдрийн хугацаанд 4.6 тэрбум ам.доллараар унасан” гэж Asia Times Online-ийн сурвалжлагчид тухайн үед мэдээндээ бичсэн байна.

Тус мэдээг уншихыг хүсвэл: <http://bit.ly/ILNhdw>

(Дүү нар нь өөрийн ээжийг орлож 2011 онд SHKP-ийн хамтарсан захирлууд болсон. Харин ах нь гүйцэтгэх бүс захирал хэвээр үлдсэн.)



“Ази тивд бизнесүүдийн 70 гаруй хувь нь гэр бүлийн эзэмшлийн байхад дийлэнх компаниудад нь эдүгээ өөрчлөлт шинэчлэлт орсон байна. Учир нь үүсгэн байгуулагчид нь хөгширчээ. Хэрвээ гэр бүлийн маргаан нь бизнесийн үйл ажиллагаанд хохирол учруулах шийдвэр гаргахад хүргэх юм бол энэ нь илүү өргөн цар хүрээг хамарч эдийн засгийг нь гэмтээж болно...”

— Др. Joseph Fan бол Хонконгийн Хятад судлалын их сургуулийн Санхүү, эдийн засгийн институцийн санхүүгийн профессор бөгөөд хамтарсан захирал юм.

Сэтгүүлчид нь төрийн өмчит компаниудад учирч болзошгүй асуудлын талаар сонор сэрэмжтэй байх ёстой. Эдгээр асуудалд орох нь:

- Засгийн газраас томилоогүй, хараат бус байдлыг хадгалсан захирлууд төлөөлөн удирдах зөвлөлд нь байгаа юу? Эсвэл өмнө нь засгийн газартай харилцаа холбоотой байсан, эсвэл ямар нэг байдлаар харилцаа холбоотой байсан захирлуудаас бүхэлдээ төлөөлөн удирдах зөвлөл бүрдсэн байна уу?
- Төлөөлөн удирдах зөвлөл нь засгийн газрын бодлогууд дээр шууд тамга дардаг системтэй юу?
- Тухайн салбар дахь мэргэжилтнүүд нь компанийн гүйцэтгэх удирдлага болж байна уу, эсвэл улс төрийн үүднээс тэднийг сонгож байна уу?
- Засгийн газар болон компанийн харилцан хамаарлын бүтэц, зохион байгуулалтыг хэрхэн гаргасан байна вэ?
- Удирдлагын шийдвэр гаргалтанд улс төрийн хөндлөнгийн оролцоо байна уу? Тухайлбал, ажлын байрыг цомхотговол ажлын байрыг дээд түвшинд хүртэл нэмэгдүүлэх гэсэн улс төрийн зорилготой зөрчилдсөн тохиолдолд засгийн газрын зүгээс оролцох уу?
- Засгийн газар нь төрийн өмчит байгууллагатай төстэй салбар дотоод болон гадаад өрсөлдөөнийг дэмжиж байна уу, үүнийг үр дүнтэй хэрэгжүүлж байна уу?

Залгамж халааны мэдээнд анхаарах

Гэр бүлийн эзэмшлийн компаниудын залгамж халаа нь нэн ухаан шаардах асуудал болдог. 2011 онд явуулсан олон улсын нэгэн судалгаанд дурдсанаар бол гэр бүлийн бизнесийн 27 хувь нь ирэх таван жилийн хугацаанд өөрчлөгдөхөөр байна гэжээ. Гэхдээ 47 хувь нь ямар ч залгамж халааны төлөвлөгөөгүй байжээ.

Гэр бүлийн компанийн гүйцэтгэх захирал нь гэнэт өвчин тусах, эсвэл ажлын чадваргүй болоход залгамж халаа нь байхгүй бол томоохон асуудал гарч болно. Хамгийн чухал асуудлуудын нэг бол гэр бүл дотор тохирох нэр дэвшигч байна уу, эсвэл гаднаас хүн томилох талаар авч үзэх эсэх юм.

2011 оны “Гэр бүлийн тоглоом” хэмээх PricewaterhouseCoopers-ийн явуулсан судалгаагаар гэр бүлийн бизнес эрхлэгчдийн 38 хувь нь гүйцэтгэх захирлын хүүхдүүд, эсвэл бусад хамаатан садан нь компанийг хангалттай удирдаж авч явах насанд хүрээгүй байхад гүйцэтгэх захирал гэнэт нас барсан тохиолдолд түүнийг орлох этгээдийг томилоогүй байгаа нь тогтоогдсон байна.

Түүнчлэн олон мэргэжилтнүүдийн үзэж байгаагаар бол компанийн зүгээс удирдлагад гадны этгээдийг авах ёстой.

“Гэр бүлийн менежерүүдтэй харьцуулахад илүү олон мэргэжилтэн удирдлага байх тусам компанийн үйл ажиллагаа илүү сайжрах ёстой” гэж Мумбай дахь Ernst & Young-ийн Manesh Patel Financial Times-д ярилцлага өгсөн байдаг.

Төрийн өмчит компаниуд

Сэтгүүлчид нь олон улсын түвшинд ихэвчлэн төрийн эзэмшлийн, эсвэл төрийн хяналттай байгууллагуудын талаар, хааяа хувийн бизнесийн талаар сурвалжилж байдаг гэдгээ мэдэх хэрэгтэй. Энэ нь зөвхөн улс төрийн холбоотойгоор ч төдийгүй мөн ихэвчлэн нууцлагдмал байдаг, өөрсдийн бүртгэл тооцоо, арга практикаа олон нийтэд нээлттэй байлгахад бэлэн бус байдаг зэрэг шалтгааны улмаас онцгой тулгамдсан асуудал үүсгэдэг. Гэхдээ эдгээр компаниуд нь ихэвчлэн улс орны эдийн засгийн араг яс болж байдаг.

Төрийн өмчит компаниуд нь хангалтгүй ажиллавал өрсөлдөөнийг бууруулж, өсөлтөнд саад болно гэж Hawkamah институтийн Др.Saidi хэлсэн байдаг.

Шийдэл нь гэвэл: “Улс төр, эсвэл нийгмийн бодлого болон бизнесийн шийдвэр гаргалтуудыг холихоос зайлсхийж, ийм арга барилыг тодорхойлох, ил тод байдлыг сайжруулах, төрийн өмчит компаниудын төлөөлөн удирдах зөвлөлийг хүчирхэгжүүлэх, тэдгээрийн хариуцлагатай байдлыг нэмэгдүүлэхийн тулд бид тоглоомын талбайг хувийн хэвшлээр тэнцвэржүүлж, төрийн өмчит компаниудын хувь эзэмшлийн үйл ажиллагааг бэхжүүлэх хэрэгтэй” гэж тэрээр нэмж хэлсэн байна.

Төрийн өмчит компаниудаас эх сурвалж олох

Төрийн өмчит компаниудын талаарх сэтгүүлчийн хамгийн сайн эх сурвалжууд бол ихэвчлэн олон нийтэд нээлттэй байгаа баримт бичгүүдээр зөвхөн хязгаарлагддаггүй. Өөрөөр хэлбэл, компанийн дунд шатны менежментийн ажилчид, дотоод мэдээлэл эзэмшигч, гадаадын хөрөнгө оруулагчид, өрсөлдөгчид, засгийн газрын мэдээлэгч, сөрөг намын тэргүүлэгч, бэлтгэн нийлүүлэгчид болон харилцагчид ч үүнд хамааралтай.

2000 онд нэгэн хэджи сангийн менежер Оросын төрийн өмчит Газпром компанийн сэжигтэй байдлын талаар сэтгүүлчдэд мэдээлсэн байдаг. Hermitage сангийн менежер Bill Browder Оросын үнэт цаасны бүртгэлийн мэдээг уншиж судлаад, Газпромын менежерүүд өөрсдийн найз нөхөд, хамаатан саднуудын удирдаж хянадаг байгууллагуудад компанийн хөрөнгийг шилжүүлсэн байгааг олж илрүүлжээ.

Ингээд Financial Times, BusinessWeek, New York Times дээр энэ талаарх мэдээнүүд гарч, эцэст нь Газпромын

гүйцэтгэх захирлыг солих зэрэг өөрчлөлт шинэчлэлт гарч эхлэв. Browder сурвалжлагчдад мэдээлэхдээ Газпромын гүйцэтгэх захирал санхүүгийн сэдэлтэй байсан гэж шууд хэлжээ. Түүнийг тойрсон зөрчилтэй асуудлууд илчлэгдэхэд түүний компанид оруулсан хөрөнгө оруулалт 50 сая ам.доллараас 1.5 тэрбум ам.доллар болж өссөн байна.

Хэджи сангийн менежер нь Газпромын ээдрээ, зөрчилтэй дотоод бүтэц зохион байгуулалтын нууцыг тайлах, компанид юу болж байгааг олж мэдэхэд хангалттай цаг хугацаа, түршлага, эх үүсвэртэй байжээ. Улмаар тэрээр энэхүү мэдээллээ ямар сурвалжлагчдад дамжуулах, ямар хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь компанийн үйл ажиллагааны талаарх илүү сайн мэдээлж нөлөө үзүүлэхүйц байдлаар анхаарал татах вэ гэж бодсон байна.



Газпромын мэдээг

Пеннсилванийн их сургуулийн Wharton сургуулийн Олон

улсын санхүүгийн судалгааны Weiss төвийн ивээн тэтгэж санхүүжүүлсэн хэвлэлийн хурал дээр олон нийтэд хүртээл болгосон байна. Энэ талаар уншихыг хүсвэл: <http://bit.ly/lhYdK1>

Засгийн газрын нөлөөг хянамгай ажиглах

Төрийн өмчит компаниудын үйл ажиллагаанд улс төр гол үүргийг гүйцэтгэдэг.

Тухайлбал компанийн зүгээс ашгаа нэмэгдүүлж, зардлаа бууруулахын тулд баримтлах хамгийн сайн стратеги бол ажлын байрыг цомхотгож, үнээ өсгөх явдал юм. Гэхдээ компанийн эзэн, төр засгаас үүнийг эсэргүүцэж болно. Мөн инфляцийг хөөрөгдөж, ажилгүйдлийг нэмэгдүүлэх бусад аливаа үйлдлийг эсэргүүцэж болно. Зохицуулах байгууллагуудын хувьд ажлын байрны аюулгүй байдлын дүрэм журмуудыг зөрчихийн эсрэг арга хэмжээ авахын оронд бусад арга замыг эрэлхийлж болно.

Засгийн газар нь компанийн гол хувьцаа эзэмшигч биш, эсвэл шууд байдлаар хувь эзэмшдэггүй байлаа ч компанийн үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцож, нөлөө үзүүлэх боломжтой юм.

Дэлхийн хамгийн том төмрийн хүдрийн олборлогч

Бразилийн Vale S.A компани 1997 онд хувьчлагдсан. Гэсэн хэдий ч засгийн газрын зүгээс төрийн салбарын тэтгэврийн сангийн хөрөнгө оруулалтаар дамжуулж компани дахь эрх мэдлээ баталгаажуулж, ноёрхлоо тогтоосон хэвээр байв. 2011 онд тус компанийн гүйцэтгэх захирал Roger Agnelli нь бусад улс орнуудад руу чиглэсэн экспортыг нэмэгдүүлэх стратегийг амжилттай хэрэгжүүлээгүй тул албан тушаалаас нь огцруулах хүртэл дарамт шахалт өгсөн байна.

Улс төрчдийн хувьд 2008 оны санхүүгийн хямралын дараа Agnelli-ийг хөрөнгө оруулалтаа танасан, ажлын байрыг бий болгох, хадгалж үлдэх арга хэмжээ аваагүй гэж буруутгаж хэдэн жилийн турш шүүмжлэл өрнүүлж байсан. Харин Agnelli Бразилд гангийн үйлдвэр бариулах гэсэн улс төрчдийн хүсэлтийг үл тоож, Хятад зэрэг гадаадын ган үйлдвэрлэгч улс орнуудад нийлүүлэх төмрийн хүдрийн экспортоо эргүүлж танасан байна. Эцэст нь тэрээр засгийн газрын дэмжлэггүй болгож компанийг худалдаж авах үнийг төлсөн.

Үүнтэй төстэй нэг хэргийг дурдвал хамтарсан хөрөнгө оруулалттай TNK-BP компанийн гүйцэтгэх захирал Bob Dudley-ыг зайлуулахын тулд Оросын эрх баригчид шургуу ажилласан тухай юм. Лондонд байрлалтай BP PLC-ийн 50 хувийн эзэмшил нь 2008 онд тус компанийг хууль эрхзүй болон зохицуулалтын дарамт шахалтанд оруулсан Оросын эрх баригчдын эрх мэдэлтэй зэрэгцэхгүй болох нь тодорхой болсон юм.

Dudley зэрэг Барууны орны олон менежерүүд Оросын хувьцаа эзэмшигчдийн гомдлын дагуу TNK-BP компанийг орхин явлаа. Өөрөөр хэлбэл засгийн газрын дэмжлэгтэйгээр хувьцаа эзэмшигчдийн зүгээс хууль эрхзүй болон зохицуулалтын дарамт шахалт үзүүлсэн нь хэргийн цаад учиг шалтгаан болж байлаа. Эцэст нь 2009 онд BP бүүлт хийж, төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн тоог 13-аас 6 болгон бууруулж, BP голлох хяналтаа алдаж, шинэ гүйцэтгэх удирдлага томилогдсон байна.

TNK-BP нь шинэ бүрэлдэн тогтсон төлөөлөн удирдах зөвлөлд Германы Канцлер асан Gerhard Schroeder зэрэг хараат бус захирлуудыг оруулж чадсан. Гэвч 2012 оны эхээр Schroeder болон өөр нэг хараат бус захирал нь огцорчээ. Учир нь BP Орос улсын өөр нэг томоохон төрийн мэдлийн эрчим хүчний компани болох Rosneft-тэй нэг талын хэлэлцээр хийх гэж оролдсон гэх асуудлаар шүүхэд дуудагдсан байна.

Vale болон TNK-BP-ийн хэргээс харахад төр засгийн зүгээс компаниудын үйл ажиллагаанд хэрхэн нөлөө үзүүлж болох, зааварчилгааг нь дагаж мөрдөөгүй

гүйцэтгэх удирдлагыг халж сольж, менежментийн түвшинд хөндлөнгөөс оролцож чаддагийг сэтгүүлчид илүү анхаарч мэдээлэх ёстой болох нь тодорхой байна.

Засгийн газрын хяналт удирдлагагүй компаниудад ч улс төр чухал үүрэг гүйцэтгэдэг. Ялангуяа зохицуулалт ихтэй, улс төрийн шаардлага дор байдаг теле харилцаа холбооны томоохон компаниудад ийм тохиолдол их ажиглагддаг.

Өмнөд Африкт хөдөлмөрчний эвлэлийн идэвхитнүүд шүүмжлэл өрнүүлэхдээ “теле харилцаа холбооны Telkom компани Африк дахь хамгийн том оператор Vodacom-д эзэмшиж байгаа хувиа Их Британийн оператор Vodafone-д зарах шийдвэр гаргахад улс төрийн оролцоо их байсан, энэ тендерийн үйл ажиллагаа нь авилгалтай байсан” гэжээ.

Johannesburg-ийн Business Day-д сурвалжлагч Lesley Stones-ийн бичсэн нийтлэлд бичсэнээр бол Telkom компанийн зарим үйл ажиллагааны оутсоурсинг зэрэг янз бүрийн хөдөлгөөн нь улс төрийн дарамт шахалттай холбоотой байсан, компанийн гүйцэтгэх удирдлагууд нь улс төрийн шинэ удирдлага гарч өөрчлөлт хийхээс өмнө “өөрсдийн ирээдүйгээ хамгаалах”-ыг зорьсон гэж Теле харилцаа холбооны ажилчдын нэгдэл, Өмнөд Африкийн харилцаа холбооны нэгдлээс дүгнэсэн байна.

Улс төрийн оролцоо нь ажлын байранд аюул заналхийлэл учруулахад сурвалжлагчдын хувьд хөдөлмөрийн байгууллагууд нь үр өгөөжтэй эх сурвалжууд болно. Гэхдээ эдгээр байгууллагын шүүмжлэлийн үнэн зөв хийгээд бодит байдлын хувийг тэнцүүлсэн байдлаар авч үзэх ёстой.

Сайн талаасаа гэвэл

Гэхдээ бүх төрийн хяналттай компаниудыг буруу удирдлагатай, эсвэл ээдрээтэй хэцүү гэсэн үг биш юм. Нөгөө талаас төрийн өмчит олон компаниуд нь улс орны гол орлогын эх үүсвэр, ажлын байр бүтээгч болж байдаг. Шинээр гарч ирж буй зах зээлтэй үндэстнүүдийн талаарх тусгай тайланд Economist-ийн дурдсанаар бол нөөцийн хэмжээгээрээ дэлхийн хамгийн том арван газрын тос болон хийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг компаниуд нь бүгдээрээ төрийн өмчит байдаг бөгөөд төрийн оролцоо, дэмжлэгтэй компаниуд нь Хятадын хувьцааны зах зээлийн үнийн дүнгийн 80 хувь, Оросын 62 хувийг эзэлж байна.

Энэ талаарх эссеийг уншихыг хүсвэл:

<http://econ.st/HGWktw>

Энэтхэгийн Business Times-т төрийн өмчит компаниудтай холбоотой бэрхшээлтэй асуудлуудыг тодорхойлсон байдаг ч Энэтхэгийн газрын тос, гангийн эрх бүхий байгууллага, Энэтхэгийн төрийн банк зэрэг маш сайн гүйцэтгэлтэй зарим компаниудад төвлөрч авч үзсэн байдаг.

Business Times-д бичихдээ Колкатад байрлалтай Hindustan Copper компанийг анхаарч авч үзсэн байна. Тус компани өмнө нь ихэвчлэн төрийн эзэмшлийн компаниудад тулгардаг олон асуудлуудтай байсан. Маш олон ажилчинтай, эдийн засаг нь сул, суларч байгаа зах зээлээ удирдан зохицуулах чадваргүй байлаа. Харин сайн дурын тэтгэврийн бодлого хэрэгжүүлсэн нь ажиллах хүчнийг 26,000-аас 6,000 болгож бууруулахад тусалсан, мөн үйлдвэрлэлийн аргыг оновчтой болгож, өр зээлээ төлж барагдуулсан. Энэ нь Business Times-ийн хувьд амжилттай гэгдэх мэдээнүүдийн нэгэнд тооцогджээ.

Энэ мэдээг уншихыг хүсвэл: <http://bit.ly/1LSYLF>

МЭДЭЭНИЙ ХЭРЭГСЛИЙН ХАЙРЦАГ

Өөрийн улс орны хэд хэдэн төрийн өмчит компаниудын захирал, менежерүүдийн хувийн болон бизнесийн үндсэн үзүүлэлт, туршлага хийгээд харилцан холбоог шалгаж үзнэ.

Ихэнх тохиолдолд компанийн зүгээс ийм мэдээг олон нийтэд зарладаггүй, эсвэл өөрийн мэдэгдэлдээ тусгадаггүй байна. Өөрөөр хэлбэл компанийн гол гол албан тушаалтнууд бизнесийн үйл ажиллагаанд шаардлагатай туршлага чадвартай эсэх, засгийн газарын болон бусад гол тоглогчидтой хэрхэн холбоо хамааралтай болохыг тодорхойлох, тэдгээрийн намтар түүхийн мэдээллийг олж авахын тулд сэтгүүлчид улам дэлгэрүүлж, сайтар ухаж төнхөх хэрэгтэй гэсэн үг.

Төрийн өмчит компаниудын гол асуудал бол ил, тод байдал

Ерөнхийдөө төрийн өмчит компаниуд нь үйл ажиллагаа, санхүү болон менежментийн бүтэц, зохион байгуулалтын талаарх мэдээллээ гаргахдаа хувьцаат компаниудаас хоцрогдолтой, учир дутагдалтай байдаг.

Ийнхүү ил тод байх үндсэн стандартууд нь хувьцаат компаниудынхтай адил байх ёстой. Төрийн өмчит компаниуд нь ихэвчлэн улсын, эсвэл бус нутгийн биржүүдэд бүртгэлтэй байх боловч заавал ийм шаардлагуудыг дагаж мөрдөх албагүй. Тухайн компани нь жил бүр, эсвэл тогтмол хугацаатайгаар санхүүгийн тайлангуудаа гаргадаг уу? Эдгээр тайлан нь аудитаар шалгагдсан байдаг уу? Хэнээр шалгуулдаг уу? Хувьцаа эзэмшигчид нь жилийн ээлжит хурлын талаар хангалттай мэдээлэл авч, оролцдог уу?



Төрийн өмчит компаниудын ил тод байдал болон мэдэгдлийн талаарх илүү дэлгэрэнгүй хэлэлцүүлгийг харахыг хүсвэл Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага(ЭЗХААБ)-ын “Төрийн өмчит компаниудын засаглалын удирдамж”-ийн 16 дугаар хуудсыг үзнэ үү: <http://bit.ly/1hYVXR>

Оросын төрийн хяналттай газрын тосны компани болох Transneft нь үйл ажиллагааныхаа талаар мэдээлэхээсээ татгалзахад хувьцаа эзэмшигчдийн хувьд тулгарч болох бэрхшээлтэй асуудлуудыг тодруулж авч үзжээ. Тус компани 2003-аас 2009 он хүртэл хувьцаа эзэмшигчиддээ өгөх ногдол ашгшаа 75 хувиар бууруулсан ч 2009 онд буяны хандив болгож 112 сая ам.доллар олгосон байж магадгүй гэж хувьцаа эзэмшигч Alexey Navalny мэдэгдсэн байдаг. (Navalny хувьцаа эзэмшигчдийн өмнөөс компанийн талаар хэрхэн бичсэнийг харахыг хүсвэл Сурвалжлагчийн тэмдэглэл буюу 3 дугаар бүлгийг үзнэ үү.)

Шүүхэд дуудах арга барилыг эс тооцвол Navalny тухайн компаниас өөрийн хандив өгсөн этгээдүүдийн жагсаалтыг өгөхийг шаардах эрхгүй байлаа. Transneft-ийн ашгаас хандивын мөнгө гаргасан ч “нууц” мэдээлэл гэж үзэж байв.



СЭТГҮҮЛЧИЙН ТЭМДЭГЛЭЛ

Financial Times-ийн Kevin Brown гэр бүлийн компаниуд, ялангуяа Ази тивийн компаниудын залгамж халааны төлөвлөлтийн хүндрэл бэрхшээлтэй асуудлуудыг шалгасан. Түүний мэдээнд Индонезийн Bakrie-ийн гэр бүлээс авахуулаад Энэтхэгийн Tata, Stanley Ho-ийн Макаогийн мөрийтэй тоглоомын эзэнт гүрний

төлөөх дотоод тэмцлийг хүртэл хамруулж олон компаниудын жишээг дурдсан байдаг. Ийм төрлийн мэдээ нь гэр бүлийн компаниуд давамгайлан ноёрхож байгаа улс орнуудад тохиромжтой юм.

Энэ талаарх мэдээг уншихыг хүсвэл:

<http://on.ft.com/HxfCjX>

Төрийн өмчит компаниудын засаглал ийм муу байхын үр дагавар маш хүчтэй нөлөө үзүүлж болно. Ерөнхийдөө ийм үр дагавруудаас болж компанийн хувьцааны үнэ маш ихээр унаж, олон нийтэд хор хохирол учруулна. Эцэст нь тухайн компани тогтвортой бизнесийн үйл ажиллагаатай юу, эсвэл засгийн газрын тэтгэмж татаасаас ихээхэн хамааралтай байх ёстой юу гэсэн асуулт сэтгүүлчдийн өмнө гарч ирэх ёстой.

Төрийн өмчит компани нь хамгийн наад зах нь нээлттэй байхын тулд дагаж мөрдөх ёстой зүйлсийг биелүүлж байгаа эсэхийг шалгахын тулд сэтгүүлчид дараах асуултуудыг тавих ёстой. Үүнд:

- Компанийн зорилго зорилтууд зэрэг тусгай зорилтууд нь вэбсайтан дээр нь тодорхой байгаа эсэх?
- Бага өртөгтэй зээл зэрэг тухайн компанид олгосон онцгой ашигтай зүйлсийн талаар олон нийтэд нарийвчлалтай мэдэгдсэн үү?
- Компанийн зүгээс хүлээх ёстой тусгай үүрэг хариуцлагууд (тухайлбал, засгийн газрын ажилчид төрийн онгоцоор үнэгүй зорчиж явах зэрэг) байна уу? Эдгээр үүрэг хариуцлагын талаараа мэдээлж байна уу? Ийм үүрэг хариуцлагуудыг тусгайлан тодорхойлсон байна уу?
- Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг нэр дэвшүүлж, сонгох үйл ажиллагааны талаар мэдэгдсэн байна уу?
- Захирлууд болон удирдлагын талаар олон нийтэд мэдээлсэн байна уу? Эдгээр этгээд нь тухайн салбартай холбоотой туршлага чадвартай байна уу?

Хувьцаа эзэмшигчидтэй хэрхэн харьцаж байгааг ажиглах

Бусад хувьцаат компаниудтай адил төрийн өмчит компаниуд нь бүх хувьцаа эзэмшигчдэд эрх тэгш хандах ёстой. Гэхдээ энэ нь ямагт гэсэн үг биш. Сүүлийн жилүүдэд төрийн өмчит компаниудын талаарх олон ч мэдээ жижиг хувьцаа эзэмшигчдийн эрхийг зөрчсөн.

Төрийн өмчит компаниуд, ялангуяа хувьчлалын эхэн үед Орос болон Зүүн Европын компаниудын зүгээс хувьцаа эзэмшигчдээс хөрөнгийг булааж авахад хэрэглэдэг аргуудын нэг бол “нууц хонгил” юм. Энэ нь компани өөрийн эзэмшлийн бусад компаниуд, эсвэл хувь хүмүүст компанийн хөрөнгийг шилжүүлэхтэй холбоотой үйл ажиллагаа юм. Мөн хөрөнгийг зах зээлийн үнээс доогуур зээлийн баталгаа болгож хямд үнээр худалдах аливаа үйлдэл ч хамаарна.

Түүнчлэн хяналтын багцыг эзэмшигчид цөөнхийн хувьцааны үнийг унагаж, эсвэл цөөнх хувьцаа эзэмшигчдэд илүү санал өгөх замаар компани дахь өөрийн хувьцаа эзэмшлийг нэмэгдүүлэх тохиолдолд “нууц хонгил”-ын арга нь амжилтай хэрэгжих боломжтой.

Хуучны ЗХУ-ын зарим өмч хувьчлалын талаарх мэдээ одоог хүртэл байна. Швейцарын төрийн прокурорын алба нь саяхан зургаан Чех иргэн болон нэг Бельги иргэнийг мөнгө угаасан хэргээр ял оногдуулсан. Мөн 1999 онд Чехийн нэгэн уул уурхайн компанийн хяналтыг авахын тулд компанийн бэлэн мөнгийг ашигласан болох нь батлагдсан.

Сүүлийн үеийн нэгэн академик судалгааны бүтээлд эдүгээ Хятадын компаниуд “нууц хонгил”-ын аргатай төстэй үйл ажиллагааг хэрэгжүүлж байж болзошгүйг дурдсан байна. Энэ тохиолдолд төрийн биш, харин хувийн хэвшлийн хяналт бүхий хувьцаа эзэмшигчид, эзэд нар ард нь байгаа гэж судлаачид үзжээ.



ТА ЮУ МЭДЭХ ВЭ?

Шуурхай асуулт, хариулт

1. Нууц хонгил гэж юу вэ?

- A. Менежментийн үүрэг оролцоог үйл ажиллагаагаар нь салгаж ангилах
- B. Компаний ашигийг ногдол ашиг байдлаар хувиарлахаас илүүтэй компанийн үйл ажиллагаанд зориулах
- C. Хувьцаа эзэмшигчдийн хөрөнгийг авахын тулд компанийн хөрөнгийг шилжүүлэх

2. Гэр бүлийн зонхилсон компанийн “пирамид” хэлбэрийн бүтэц, зохион байгуулалт гэдэг нь:

- A. Үүсгэн байгуулагч нь ТУЗ-ийн дарга, харин бусад хамаатан саднууд нь дээд түвшний удирдлага байна.
- B. Гэр бүл нь ТУЗ-д давамгайлж оролцоно.
- C. Нэг гэр бүл нь бие даасан хэд хэдэн компанийг удирдан хянадаг.

3. Гэр бүлийн бизнесийн үйл ажиллагаанд нийтлэг тохиолдох хоёрдугаар зэрэглэлийн хувьцааны бүтэц гэж:

- A. Нэгдүгээр зэрэглэлийн хувьцаанууд нь илүү эрх мэдэл, ялангуяа санал өгөх эрхийг олгодог
- B. Зарим хувьцаа эзэмшигчдийг өөрийн хувьцаагаа урамшуулалттай зарахыг зөвшөөрдөг
- C. Зөвхөн ногдол ашигт хамааралтай.

Харуулах: 1. C, 2. C, 3. A

ЭХ СУРВАЛЖУУД БҮЛЭГ 4

Редакторын тэмдэглэл: 4 бүлгийг бэлтгэхэд зориулж доорх эх сурвалжуудыг авч үзсэн болно. Ямар ч хүн ихэнх вэбсайтууд руу нь орох боломжтой. Wall Street сэтгүүл, Financial Times зэрэг тодорхой эх сурвалжуудын мэдээг үзэхийн тулд нэвтрэх эрх захиалах шаардлагатай. New York Times нь уншигч, үзэгч бүрт зориулж сар бүрд хязгаарлагдмал тооны архивласан материал өгдөг.

НИЙТЛЭЛ, БҮТЭЭЛҮҮД

Beverly Behan, “Энэтхэгийн Satyam-ийн талаарх засаглалын хичээлүүд”, BusinessWeek, 2009 оны 1 дүгээр сарын 16-ны өдөр.
<http://buswk.co/НМу6Ро>

Kevin Brown, “Залгамж халаатай холбоотой бэрхшээлтэй асуудал нь гэр бүл төлөвлөлтийг чухал болгож байна”, Financial Times, 2011 оны 10 дугаар сарын 11-ний өдөр.
<http://on.ft.com/HxfCjX>

Jason Corcoran, Henry Meyer, “Ногдол ашиг өндөр байх нь нялхсыг өнчрүүлж, өвчинд хүргэнэ гэж Транснефть хэлэв”, Блүүмберг, 2011 оны 4 дүгээр сарын 19-ний өдөр. <http://bloom.bg/HAykpC>

Samnath Disgupta, “Hindustan Copper, элемент нь авч үзвэл”, India Times, 2011 оны 8 дугаар сарын 21-ний өдөр. <http://bit.ly/IISYLF>

Nathaniel Parish Flannery, судлаач шинжээч, Governance Metrics International (GMI), “Tele-novela: Мексикийн Televisa-ийн ТУЗ-ийн хариуцлагатай байдлын асуудлууд”, Forbes, 2011 оны 6 дугаар сарын 9-ний өдөр.
<http://onforb.es/IOMgNe>

Owen Fletcher, Denny McMahon, “Хятад улс хөрөнгө оруулагчдыг айлгав”, Wall Street сэтгүүл,

2011 оны 10 дугаар сарын 1-ний өдөр.

<http://on.wsj.com/HE0cOQ>

Gaurav Ghose, “Мэдэгдэлд тавигдах хэм хэмжээ нэмэгдүүлэхийг уриалах нь”, *Gulfnews.com*, 2011 оны 10 дугаар сарын 29-ний өдөр.

<http://bit.ly/ILOAch>

Emily Godson, “TNK-BP-ийн захирлууд шүүх үйл ажиллагааны саналын дагуу огцров”, *Telegraph*, 2012 оны 1 дүгээр сарын 14-ний өдөр.

<http://tgr.ph/ITgId>

Samantha Pearson, “Бразил улс Vale-д дарамт шахалт үзүүлэв”, *Financial Times*, 2011 оны 3 дугаар сарын 23-ний өдөр.

<http://on.ft.com/ITjOi>

Lesley Stones, “South Africa: Telkom Not Picking Up on Corruption Claims,” *Business Day*, Dec. 9, 2008.

<http://bit.ly/HDSW0D>

Lesley Stones, “Өмнөд Африк: Telkom авилгалын хэргээр дуудагдахгүй”, *Business Day*, 2008 оны 12 дугаар сарын 9-ний өдөр. <http://on.ft.com/I9zSZR>

Jonathan Wheatley, “Албан ёсны: Agnelli Vale-ээс гарах нь”, *Financial Times*, 2011 оны 4 дүгээр сарын 1-ний өдөр.

<http://on.ft.com/HJ9mWl>

“Шинээр хөгжиж гарч буй зах зээлтэй улс орнууд: Төрийн хөрөнгөжилт өсөн нэмэгдсэн нь”, *Economist*, 2012 оны 1 дүгээр сарын 19-ний өдөр.

<http://econ.st/HGWktw>

“Олон улсын мэдээг үзэх нь”, *Family Firm Institute Inc.*, 2010 он.

<http://bit.ly/HRCTyV>

“Муу хэвлэл мэдээллийн талаарх сайн мэдээ: Компанийн засаглалын асуудал, Доромжлол дуусав”, 2007 он, *Knowledge@Wharton*.

<http://bit.ly/IGn8Nh>

“Хятадын Facebook Renren 740 сая ам.долларыг татан төвлөрүүлэв...”, *Wired*, 2011 оны 5 дугаар сарын 4-ний өдөр. <http://bit.ly/HADyIb>

“Швейцарийн зальт этгээд Чехийн нүүрс олборлогч MUS-д “нууц хонгил”-ын арга ашигласан байж магадгүй”, *Czechposition.com*, 2011 оны 10 дугаар сарын 24-ний өдөр.

<http://bit.ly/HGoTKX>

“Та Хятадын Facebook-ийг худалдаж авах уу?” *Motley Fool*, 2011 оны 4 дүгээр сарын 28-ний өдөр.

<http://bit.ly/IEIOIk>

НОМ, СУДАЛГАА

“Компанийн засаглал/Төрийн болон хувийн хэвшлийн өөрчлөлт шинэчлэлийн уулзаврын цэг”, 2009 он, Олон улсын хувийн хэвшлийн компаниудын төв. <http://bit.ly/JssrvA>

“Гэр бүлийн тоглоом”, PwC-ийн гэр бүлийн бизнесийн судалгаа, 2010-2011 он.

<http://bit.ly/HGgZ4B>

“Төрийн эзэмшлийн компаниудын засаглалын тухай удирдамж”, Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (ЭЗХАХБ), 2005 он. <http://bit.ly/lhYVXR>

“Халуун сэдэв: Компанийн засаглалын тренд - Бид урагшаа харсан шигээ хойшоо харах ёстой”, 2011 оны 6 дугаар сар, *Deloitte Development*.

“Байгууллага хоорондын зээлээр дамжуулж “нууц хонгил” татах нь: Хятадын туршлага”, Guo-hua Jiang, Charles M.C.Lee, Heng Yue, 2009 оны 11 дүгээр сарын 2-ны өдөр.

Шугамыг дагах нь: дүрэм журмууд болон мэдээлэх зарчим

Сүүлийн хорь гаруй жилийн хугацаанд компанийн засаглалтай холбоотой хамгийн том зарим хэргүүд нь урьдаас төлөвлөсөн луйвартай холбоотой байжээ.

Хууль эрхзүйн хүрээнд хийсэн санхүүгийн болон санхүүгийн бус мэдэгдлүүдийн алдаа дутагдлыг тодорхойлох нь эрэн сурвалжлах бизнесийн сурвалжлагчдын хийх ёстой ажил юм. Өөрөөр хэлбэл жижиг мэдээллийг ч уншиж, санхүүгийн мэдээлэл болон техникийн хэлийг ойлгохыг хичээх хэрэгтэй гэсэн үг юм.

Санхүүгийн хэрэгжүүлэлт, үнэт цаасны зохицуулах агентлагууд болон хөрөнгийн биржүүд нь луйврыг илчилж, мөрдлөг шалгалтыг эхлүүлэх ёстой. Гэхдээ ийм зүйлийг байнга хийнэ гэсэн үг биш л дээ. АНУ-ын Үнэт цаас, арилжааны хороо(ҮЦАХ)-оос Enron корпорацийн талаар олон улирлын турш нууцаар мэдээлж, үүний дараа шалгалтын газрууд мөрдлөг хяналтаа эхлүүлсэн байна.

Сүүлийн хорь гаруй жилийн хугацаанд олон улсын түвшинд томоохон компаниудын үйлдсэн гэмт хэргүүдийн дийлэнх нь зохицуулах байгууллагууд, аудиторууд, банкууд болон бусад санхүүгийн байгууллагуудын хамар дор нь бараг явагдаж байсан. Захирлууд болон хувьцаа эзэмшигчдэд юу ч мэдэгдэлгүйгээр луйврын хэргүүд гарч байлаа.

Луйвар, гэмт хэргээс хэрхэн ангид байх вэ?

Түүхэнд байсан хамгийн том хэргүүдийн жишээнээс харахад удаа дараалан давтагдах шинж чанар ажиглагдаж байлаа. 1990-иад оны сүүлээр Солонгосын Daewoo группын менежерүүд 15.3 тэрбум ам.долларын луйвар хийхийн тулд нягтлан бодох бүртгэлийн манёврыг ашигласан. Ингэхдээ компанийн хувьцааны үнийг 32 тэрбум ам.доллараар хөөрөгдсөн байна. Тус хэрэгт компанийн олон ажилтнууд оролцоноос хэд хэдэн этгээд шоронд

явж, их хэмжээний торгууль шийтгэл авсан байна.

Компанийг үндэслэн байгуулагч, захирал нь гэмт хэргийн шинж чанартай үйлдэл хийсэн гэж буруутгагдаж, 10 жилийн турш хоригдох ял авч, 22 тэрбум ам.долларын нөхөн төлбөр төлөхөөр болжээ. Энэ мөнгөний ихэнх хэсгийг өөр улс орон руу шилжүүлсэн байна.

Энэхүү Удирдамжид тусгасан ихэнх хэргүүдийн хувьд сэтгүүлчид нь үйл явдлын өмнө биш харин дараа нь хэргийн талаар бичсэн байдаг. Хэвлэл мэдээллийн зорилго бол аливаа хэрэг үүдэн гарахаас өмнө сэжиг бүхий нэхэмжлэл, зөрчлийн талаар мэдээлж, мэдээг түрүүлж бичих явдал юм. Ийм боломж байгаа юу?

“Daewoo-ийн мэдээг болгоомж хянамгай байдлаар судалсан ямар ч хүн тухайн хэргийн зөрчлийг илрүүлж чадах байсан” гэж Солонгос улсын ерөнхийлөгчийн эдийн засгийн зөвлөх асан Lee Dong Gull 2011 онд BusinessWeek-д ярьсан байдаг. (Нягтлан бодох бүртгэлийн тодорхой нарийн төвөгтэй асуудлын талаар хэрхэн мэдэх талаар зөвлөгөө авахыг хүсвэл 6 дугаар бүлгийн “арга заль” гэж тодорхойлж бичсэн хэсгийг үзнэ үү.)

Тэрээр нэмж хэлэхдээ ийм луйварын төлөө хариуцлага хүлээх этгээдүүдэд “тухайн байдлыг ажиглаж шалгасан нягтлан бодох бүртгэлийн компаниуд болон зохицуулах байгууллагын ажилчид” хамаарах ётой гэсэн байна.

Хөрөнгийн биржүүд болон зохицуулах байгууллагууд нь ийм зөрчилтэй зүйсийн талаар мэдээлэх, ялангуяа мэдэгдэл гаргах, мэдээлэх зэрэгт тавигдах шаардлагуудыг чанд мөрдөн сахиулж байх хэрэгтэй. Гэсэн хэдий ч дараах хэд хэдэн шалтгааны улмаас энэ нь зохих ёсоор хэрэгждэггүй. Үүнд:

- Шинээр гарч буй ирж зах зээлтэй улс орнуудын хөрөнгийн биржүүд болон зохицуулах агентлагууд нь сул дүрэм журмуудтай, хязгаарлагдмал нөөцтэй, эсвэл

ийм цогц хууль тогтоомжуудыг чиглүүлж явах чадваргүй байдаг.

- Шаардлага мөрдөн сахиж биелүүлэх нь сул, эсвэл огт ийм зүйл байдаггүй.
- Компани доторх менежерүүд болон санхүүгийн мэргэжилтнүүд нь өөрсдийн хэлцэл, үйл ажиллагааг нууцлахдаа мэргэжилтэн болсон байдаг.
- Хэвлэл мэдээллийнхэн нь санхүүгийн болон бусад мэдэгдлийн талаар уншиж, сурвалжлахдаа хичээл зүтгэл муу, эсвэл тухайн цаг үед нь компаниудын талаар бичдэггүй, чухал мэдээллийг орхигдуулдаг.

Үнэт цаасны зохицуулах байгууллагуудын зүгээс шаардлагуудыг дагаж мөрдөхийг шахааж шаардаж байгаа бөгөөд энэ шахалт нь зарим нөлөөтэй байдаг. 2011 онд Вьетнамын зах зээлийн зохицуулах байгууллага болох Төрийн үнэт цаасны хороо (ТҮЦХ)-ны зүгээс санхүүгийн тайлангуудыг сүүлд мэдээлсэн гэх үндсэн шалтгаанаар мэдэгдэлтэй холбоотой шаардлагуудыг дагаж биелүүлээгүй, мөрдөөгүй гэж 14 хувьцаат компанийн нэрсийн жагсаалтыг гаргасан.

ТҮЦХ-ны хатуу чанга шаардлагын дагуу Ho Chi Minh-ийн хөрөнгийн биржид бүртгэлтэй байсан Vien Dong Pharmaceutical (DVD) компани санхүүгийн тайлангуудаа нийтэд зарласан. Үүний дараа хувьцаа эзэмшигчид болон зохицуулах байгууллагын зүгээс тус компанийг их хэмжээний өр зээлтэй болохыг тогтоож хүчээр татан буулгахад хүргэсэн юм. Гэхдээ шүүмжлэгчдийн үздэгээр бол зах зээлийг өөрчилж шинэчлэхэд ийм анхааруулга, торгууль болон арилжааг нь зогсоох арга хэмжээ авахад ч хангалтгүй ажээ. Тэдний үзэж байгаагаар бол зохицуулах

байгууллагуудын зүгээс зөрчилтэй компаниудыг бүртгэлээс хасах арга хэмжээ нь ил тод байдлыг сайжруулж чадах юм байна.

Үүнийг амжилттай хэрэгжүүлсэн түүхийн хамгийн сонгодог жишээ бол Бразилийн Novo Mercado буюу компанийн засаглалын сайн арга барил, удирдамжийг сайн дураар ажигладаг тусгай зах зээл юм. Тус зах зээлийг 2000 онд Бразилийн хөрөнгийн бирж Bovespa байгуулсан бөгөөд тус улсдаа компанийн засаглалын стандартуудыг сайжруулж чадсанаараа нэр хүндтэй болсон. Өөрөөр хэлбэл, бусад шинээр гарч ирж буй зах зээлийн хөрөнгийн биржүүдэд үлгэр жишээ болсон байна.

Novo Mercado-г ажилуулж эхлүүлэхээс өмнө дотоодын болон олон улсын хөрөнгө оруулагчдын аль аль нь Бразилийн компаниудад итгэдэггүй, шинээр олон нийтэд хувьцааг санал болгох IPO ч ховор байжээ. Novo Mercado-ийн үйл ажиллагаа удаан эхэлсэн ч одоо 100 гаруй хувьцаат компанитай, байн байна IPO хийдэг болжээ.

Novo Mercado-ийн ачаар компанийн засаглал сайжирч, 2008-2009 оны олон улсын санхүүгийн хямралыг амжилттай даван туулахад тус болсон бөгөөд Бразилийн хөрөнгө оруулагчидтай харилцах холбооны гүйцэтгэх удирдлага ч нэр хүнд олж авсан байна.



Novo Mercado-ийн нөлөөний талаар уншихыг хүсвэл: <http://bit.ly/IFrv7o>

Novo Mercado-ийн гарал үүслийн талаарх илүү дэлгэрүүлж уншихыг хүсвэл: <http://bit.ly/HGhfRh>

Холбогдох этгээдийн ажил гүйлгээ нь хуурмаг биш байж болох ч компаниудын зүгээс эдгээр ажил гүйлгээг санхүүгийн тайлангууд дээрх борлуулалтыг нэмэгдүүлэх, зардлыг бууруулах, ашгийг өндөр харагдуулахын тулд ашигласан байж болно.



Олон улсын зохицуулах байгууллагууд болон хөрөнгийн биржүүдээс шаарддаг үндсэн баримт бичгүүд нь АНУ-ын Үнэт цаас, арилжааны хороо(ҮЦАХ)-ноос шаарддагтай ижил төстэй байдаг.

Аудит хийгээгүй тогтмол хугацаатай санхүүгийн тайлангууд (Загвар 10-Q).

Харах нь:

- Орлого, ашиг, зардал, мөнгөн урсгал, хөрөнгө болон эх үүсвэрт огцом өөрчлөлт орсон байна уу? Энэ өөрчлөлтийг юу авчрав?
- Хувьцаа худалдан авалт - Компанийн зүгээс өөрийн хувьцаа худалдан авах хэмжээгээ нэмэгдүүлсэн үү, эсвэл бууруулсан үү? Яагаад?
- Одоогийн шүүх маргааны асуудал - Ямарваа шинэ зарга, шүүх үйл ажиллагаа байна уу? Болзошгүй хохирлыг барагдуулах бэлэн мөнгөний нөөцтэй байна уу? Хэрвээ тийм бол таамаглаж байгаа алдагдлын мөн чанар юу вэ?
- Зарлагын төлөвлөгөө - Удалгүй хийх том хэмжээний худалдан авалтууд байна уу?
- Нэгтгэл, худалдан авалтын талаарх шинэ мэдээ - Сүүлийн үеийн нэгтгэл, эсвэл худалдан авалтын нөлөө нь юу вэ? Орлого, ашигт ажиллагаанд өөрчлөлт орсон талаар нарийвчилсан тайлбар байна уу?

Аудит хийсэн жил бүрийн санхүүгийн тайлангууд (Маягт 10-K). Дээр жагсаан бичсэн бүх зүйлс нь мөн 10-K маягт дээр байна.

Хувьцаа эзэмшигчдийн мэдэх ёстой гол гол үйл явдлууд зэрэг сүүлийн үеийн мэдээлэл (8-K маягт), орох нь:

- Гол захирал, эсвэл ТУЗ-ийн гишүүн нь өвчтэй, эсвэл байхгүй эсэх
- Аудитын компанийн өөрчлөлт
- Гол гол худалдан авалт, худалдаа
- Санхүүгийн жилийн өөрчлөлт
- Компанийн хувьцааг бүртгэлээс хасах
- Хууль зохицуулалтын арга хэмжээ
- Дампуурал, хөрөнгө хүлээн авалт

Жил бүрийн итгэмжлэлийн мэдэгдэл (14A төлөвлөгөө), гүйцэтгэх удирдлагын цалин

хөлсний талаарх мэдээтэй хамт захирлуудын сонгон шалгаруулалт зэрэг хувьцаа эзэмшигчийн саналд тавих асуултуудыг авч үздэг.

Бүртгэлийн тайлангууд, хувьцаа санал болгосон танилцуулгууд хамаарна (Нээлттэй хувьцаат компани болж байгаа гадаадын хаалттай компаниудад зориулсан S-1 маягт, эсвэл F-1 маягт).

Дотоод мэдээлэл эзэмшигчдийн хувьцаа эзэмшил, ажил гүйлгээ (3, 4 болон 5 дугаар маягтууд), компанийн гүйцэтгэх удирдлагуудын анхны байдлаарх хувьцаа эзэмшил, хувь эзэмшилд гарсан өөрчлөлт, худалдан авалт, эсвэл борлуулалт

ҮЦАХ-ны үнэ төлбөргүй EDGAR (Электрон мэдээ цуглуулалт, шинжилгээ, хайлт)-ын мэдээллийн сангаас компаниудын тайлан мэдээг хэрхэн олох, мөн тайлан мэдээ бүрт тавигдах шаардлагын нарийвчилсан тайлбарыг харахыг хүсвэл:

<http://1.usa.gov/lvpgae>

(Тогтмол хугацаатай болон жил бүрийн санхүүгийн тайлан мэдээний тоон үзүүлэлтүүдийг хэрхэн уншиж ойлгох талаарх илүү дэлгэрэнгүй мэдээллийг авахыг хүсвэл 6 дугаар бүлгийг үзнэ үү. Итгэмжлэлийн мэдэгдлийн талаарх тайлбарыг 3 дугаар бүлгээс үз.)

Хаанаас юуг харах вэ

Шалгаж үзэх ёстой гол гол зүйлсийн нэг нь холбогдох этгээдийн ажил гүйлгээ юм. Энэ нь тусгай харилцаа холбоогоор нэгдсэн хоёр талын дундаж бизнесийн үйл ажиллагаа, хэлцлийг илэрхийлнэ. Мөн гол хувьцаа эзэмшигч, байгууллага, эсвэл дээд түвшний удирдлага, захирал болон байгууллагын хоорондох хэлцэл ч байж болно.

Бүртгэлтэй компаниуд нь жил бүрийн тайландаа ийм харилцаа холбооны талаар мэдээлэх шаардлагатай бөгөөд бүх компаниуд нь хувьцаа эзэмшигчдэд холбогдох этгээдийн харилцаа холбоог мэдэгдэх ёстой.

Холбогдох этгээдийн ажил гүйлгээ нь хуурмаг биш байж болох ч компаниудын зүгээс эдгээр ажил

гүйлгээг санхүүгийн тайлангууд дээрх борлуулалтыг нэмэгдүүлэх, зардлыг бууруулах, ашгийг өндөр харагдуулахын тулд ашигласан байж болно. Түүнчлэн олон нийтийн эзэмшиж байгаа бизнесээс хөрөнгө, мөнгийг хувийн эзэмшлийн компаниудыг удирддаг, эсвэл эзэмшдэг дотоод мэдээлэл ашигладаг этгээдүүд рүү шилжүүлэхэд ийм ажил гүйлгээг ашиглаж ч болно (4 дүгээр бүлгийн “нууц хонгил”-ын аргыг үз).

Сэтгүүлчдийн хувьд анхаарах ёстой зүйлс бол төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд болон бэлтгэн нийлүүлэгчид болох бусад компаниудын хоорондох уялдаа холбоо, компани дахь гол гол албан тушаалуудыг хашиж байгаа гэр бүлийн гишүүдийн бусад компанитай хийж байгаа бизнесийн үйл ажиллагаа, бараа бүтээгдэхүүн болон ажил үйлчилгээний нийлүүлэлтийн хувь тэнцүү бус өндөр зардал юм.

Төлөөлөн удирдах зөвлөлийн ширүүн тэмцэлдээн нь мөн холбогдох этгээдүүдийн сэжигтэй ажил гүйлгээний нууц мэдээлэл болно. Нэг жишээ татвал Кенийн Cooper Motor Corporation (CMC) бөгөөд компанийн удирдах захирлын баталж байгаагаар хоёр захирал нь гадны дансуудад хөрөнгө мөнгийг шилжүүлэхийн тулд хамтран ажиллаж байжээ. Кенийн Хөрөнгийн зах зээлийн эрх бүхий байгууллагын захирлын мэдээлсэнээр бол зохицуулах байгууллагууд энэ талаар хэвлэл мэдээллийнхнээс анх сонссон бөгөөд төлөөлөн удирдах зөвлөл нь зохицуулах байгууллагын маягт зааварчилгааны дагуу санхүүгийн байдлаа бүрэн дүүрэн илчилж мэдэгдээгүй байна.

Зохицуулах байгууллагууд янз бүрийн дотоод баримт нотолгоог шалгаж үзэж байхдаа төлөөлөн удидах зөвлөлийн гишүүн байсан нэг этгээд үйлчилгээ үзүүлсэнийхээ төлөө компаниас илүү их төлбөр авсан болох нь батлагдаж, тус компанийн хувьцааны арилжааг зогсоох хүртэл арга хэмжээг авсан байна. Ашиг сонирхлын ийм зөрчил нь төлөөлөн удирдах зөвлөл дотор дайн дэгдээсэн гэж Найробигийн Daily Nation-ийн CMC-ийн нөхцөл байдал болон төсөөллийн шинжилгээнд дурдсан байдаг.

Энэ мэдээг уншихыг хүсвэл: <http://bit.ly/HDSWOD>

Гүйцэтгэх захирал нь Olympus-ийн луйврыг илчлэв

Японы камер болон дуран үйлдвэрлэгч Olympus корпораци нь Британийн гүйцэтгэх захирлаа гэнэт зайлуулсаны дараа 2011 оны 11 дүгээр сарын

хоёрдугаар улирлын орлого үр дүнгийн тайлангаа мэдээлэхээ хойшуулсаар байсан. Тус захирал нь өмнө нь залгамж халаагаа хурдан авсаны дараа хоёр анхаарал татсан асуудал үүсгэжээ. Тэрээр хамаагүй үнээр компанид олон сая ам.долларын төлбөрийн дарамт учруулсан өмнөх худалдан авалтуудын талаар олон асуулт тавьж, эдгээр асуултаа олон нийтэд нээлттэй зарласан байна.

Бүр хэдэн жилийн өмнө болсон эдгээр хэлцэл нь сүүлийн хорь гаруй жилийн турш хөрөнгө оруулалтын алдагдалтай байснаа нуухад ашиглагдсан байжээ. Компанийн захирал, ерөнхийлөгч болон дотоод аудитор гээд дээд түвшний ажилтнууд энэ хэрэгт хамрагдсан болох нь батлагдсан байна.

Olympus-ийн худалдаж авсан компаниуд бүр эртнээс сэжиг татаж болох байсан тул сайтар судалж шинжлэх хэрэгтэй байсан. Төлөөлөн удирах зөвлөлөөс томилсон хэсгийн удаа дараалсан шалгалтаар зарим тохиолдолд компаниудыг худалдаж авах төлбөр нь худалдан авалтын дүнгээс гурав гаруй дахин өссөн байжээ. Гэхдээ эдгээр манёврын талаар олон жилийн турш илчлээгүй байлаа.

Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга огцорч, тусгай зөвлөл нь худалдан авалтыг судлахаар томилогдсоны дараа Токиогийн хөрөнгийн бирж (ТХБ)-ээс Olympus-ийг илүү мэдээлэл өгөхийг шаардаж, хувьцааны үнийг хүчтэй унахад хүргэсэн хөрөнгө оруулагчийн сэтгэл зовоосон асуудалд удаан хариу үйлдэл үзүүлж байгааг шүүмжилжээ. Улмаар ТХБ-ээс Olympus-ийг биржийн бүртгэлээс хасахаар заналхийлсэн байна.

Гэхдээ ийм үйлдэл нь хувьцаа эзэмшигчдэд зайлшгүй сайн зүйл биш болно. Азийн Компанийн Засаглалын холбоо нь Olympus-ийг биржийн бүртгэлээс хасахгүй байхыг ТХБ-ээс хүсч, “бүртгэлээс хасах нь менежерүүдэд хариуцлага оногдуулж байгаатай адил хувьцаа эзэмшигчдийг ч шийтгэх тул үнэт цаасанд ерөнхийдөө ийм торгууль шийтгэл өгөхгүй байх нь зүйтэй” гэжээ.

Түүнчлэн Азийн Компанийн Засаглалын холбоо онцлон тэмдэглэхдээ өндөр хөгжилтэй улс орнуудын биржүүд дээр Olympus зэрэг компанийг бүртгэлээс хасч болохгүй, учир нь “боломжийн бизнестэй компаниудад ийм айдас үлдэнэ” гэсэн байна.

Сэжигтэй нэхэмжлэлийг харах

Сэтгүүлчид зөрлийг илрүүлэхийн тулд цаасан тайлан, мэдэгдлийг нарийн ухаж, гадаргуугийн доод хэсгийг

МЭДЭЭНИЙ ХЭРЭГСЛИЙН ХАЙРЦАГ

Мэдээний санаа: Хувьцаа нь өсч, мөн буурч байж болох тохиолдлуудын талаар судалж мэдээг бичихдээ томоохон хөрөнгө оруулагчдын хувьцааны арилжааг шалгаж үзээрэй.

Жишээ: Варрен Ваффеттын Беркшир Хэйтвэй шиг томоохон хөрөнгө оруулагчийн хийсэн хувьцаа аливаа арилжаа нь хэвлэл мэдээллийн анхаарлыг татдаг. Ваффет технологийн салбарын хувьцаанд урт хугацаанд хөрөнгө оруулдаггүй ч гэсэн 2011 онд IBM, Intel-ийн хувьцааг унахад худалдаж авсаныг сэтгүүлчид онцлон бичиж байсан.
<http://aol.it/HEaj6c>

сайтар ажиглаж болно.

Канадын Globe and Mail, судалгааны компани болох Muddy Waters-ийн сурвалжлагчид 2011 оны намар батлан бичихдээ “Хятадын компани болох Sino-Forest корпораци болон Канадын банзны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг хамгийн том нээлттэй хувьцаат компани Хятадын Юннан муж дахь банзны хувь эзэмшлийн үнийн дүн болон хэмжээг өсгөн тооцсон” гэжээ. (Сэтгүүлчид энэхүү зөрүүг хэрхэн шалгасан болохыг харахын тулд энэхүү бүлгийн Сурвалжлагчийн тэмдэглэлийг үз.)

Sino-Forest нь дээрх нотолгоог няцаасан боловч эргэлзээ сэжиг газар авсаар Онтариагийн үнэт цаасны хорооноос тус компанийг орлогоо буруу танилцуулж, банзны хувь эзэмшлээ хэтрүүлж мэдээлсэн гэж буруутгасан байна. Тус хороо компанийн хувьцааны арилжааг түр зогсоож, мөн захирал/гүйцэтгэх захирал болон хэд хэдэн захирлыг огцрохыг шаарджээ. Royal Canadian Mounted Police-аас мөн энэ хэрэгт оролцож, луйврын баталгаа нотолгоогоор гэмт хэргийн мөрдлөг явуулж эхэлсэн байна.



Аудиторуудын санал болон хөрөнгө оруулалтын судалгааны компаниудын хооронд заримдаа тохиолддог зөрчлийн талаарх баганыг харахыг хүсвэл:
<http://nyti.ms/HAEPZC>

Ихэнх улс орнуудад компанийн үнийн дүнд “материаллаг”, эсвэл “чухал” нөлөөтэй мэдээллийг зарлаагүй бол торгууль оногдуулдаг. Түүнчлэн ийм мэдэгдэл, зарлал нь цаг хугацаандаа байх ёстой. Хэрвээ цаг хугацаандаа биш байвал сэтгүүлчид болон зохицуулах байгууллагуудын хувьд анхаарлын бай болно.

Сэтгүүлчид компаниудын мэдэгдлүүдийг ажиглан хянаж мэдээг хэрхэн олж авах вэ? Доор зарим зөвлөмжийг өгсөн байна. Үүнд:

1. Хууль, зохицуулах байгууллагын шаардлагуудын талаар мэдэж байх

Компаниуд хууль ёсны дагуу, хувьцаа эзэмшигчдийн туйлын ашиг сонирхлын төлөө ажиллаж байгаа эсэхийг баталгаажуулахад хөрөнгийн биржүүд болон үнэт цаасны зохицуулах байгууллагуудын гүйцэтгэх үүрэг оролцоо нь ялангуяа зохицуулалт, түүний биелэлт сул байх хандлагатай шинээр гарч ирж буй зах зээлүүдэд чухал байдаг. Гэхдээ ийм шаардлагууд нь нилээд харилцан адилгүй зөрүүтэй байдаг тул биелэлт нь хүртэл ийм байдаг.

Сэтгүүлчид өөрсдийн мэдээлж байгаа биржүүдийн бүртгэлийн болон бүртгэлээс хасах дүрэм журмуудын талаар мэдэж, улмаар биелэлтийг нь зохих ёсоор хянах ёстой. Ингэхдээ компаниуд санхүүгийн тайлангуудаа цаг хугацаандаа мэдээлж байгаа эсэх зэрэг үндсэн үзүүлэлтүүдэд ч анхаарал хандуулах ёстой. Бүртгэх болон бүртгэлээс хасах тухай дүрэм журмуудыг хөрөнгийн биржүүд нь өөрсдөө, эсвэл үнэт цаасны зохицуулах байгууллагууд нь ихэвчлийн вэбсайтууд дээрээ зарлаж гаргадаг.

Ийнхүү мэдэгдээгүй бол ихэвчлэн ямар нэг асуудалтай зүйл байгааг илэрхийлнэ. Малайзын тээвэр хүргэлтийн оператор Transmile Групп 2007 оны жилийн тайланг хэдэн сарын турш мэдэгдэхээ хойшлуулсан. Эцэст нь мэдээг гаргахад компанийн

зүгээс 36.05 сая ам.долларын алдагдлыг шинээр хүлээсэн. Тус компани 2004, 2005 онуудад орлогоо хэтрүүлж тооцсон болохоо сүүлийн тайлан мэдэгдэлдээ дүрджээ.

Энэ хэргийн улмаас хожим нь Transmile-ийн аудитын хорооны хоёр хараат бус захирал нь шоронд орох ял авч, компанийн улирлын тайланг Bursa Malaysia-д буруу мэдээлсэн гэх хэргээр шийтгэл хүлээсэн байдаг.

Тайлан мэдээг хоцруулахтай холбоотой алдагдал, эсвэл буруу мэдэгдэл байхгүй байж болох ч ийм байдал нь тухайн компанийн санхүүгийн үйл ажиллагаанд хангалттай хэмжээний эх үүсвэр байхгүй, эсвэл бүрэн төгс биш болохыг илэрхийлж болно.

Эсрэгээрээ засаглал сайжирч, дүрэм журмуудыг дагаж мөрдөх нь ихэсвэл компанийн нэр хүндэд эерэг нөлөө үзүүлж болох юм. 2012 онд Standard & Poor's (S&P), Renaissance Capital (RenCap) онцлон хэлэхдээ Нигерийн банкны салбар, ялангуяа эрсдлийн удирдлага болон засаглалын чиглэлээр сайжирч байгаа гэсэн байна.

“Нигери бол одоо цөөхөн боловч чанартай томоохон банкуудтай, засаглал ч сайн, хууль эрхзүйн хараа хяналт ч сайжирсан” гэж S&P өөрийн тайландаа дүрджээ.

Сэтгүүлчид нь өөрийн мэдээлж буй салбарууд, тухайлбал банк, түүхий эд, үйлдвэрлэл болон

Зохицуулах байгууллагууд юу хийж чадах вэ? Тухайн улс орны хууль тогтоомж, хууль болон зохицуулалтын орчин нөхцөлөөс шалтгаалж:

- Компанийн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрлийг буцаан татах
- Хувьцааны арилжааг нь зогсоох
- Компанийн “нэр болон шившиг”-ийг дурдсан мэдэгдлүүд хийх
- Санхүүгийн торгууль оногдуулах
- Шүүхийн хориг тавих
- Компанийн хөрөнгийг зарцаахыг шүүхээс хүсэх
- Захирлуудын эсрэг шүүхийн хориг тавих, шийтгэх, торгох, яллах

бусад чиглэлээр хууль эрхзүйн зохицуулалтын талаар мэдлэгтэй байвал зохицуулах байгууллагаас гаргасан хэвлэлийн мэдээ, эсвэл энэ хэргийн хувьд үнэлгээний агентлагуудын тайлангаас чухал мэдээг боловсруулахад асуудалгүй болно гэж Лагосын This Day-д бичсэн байна.

Энэ мэдээг харахыг хүсвэл: <http://bit.ly/Hxh6Lg>



СУРВАЛЖЛАГЧИЙН ТЭМДЭГЛЭЛ

Заримдаа компанийн мэдэгдэл, тайлангийн үнэн зөв байдлыг батлахад тоон үзүүлэлтүүдийг шалгаж, цаасан баримт бичгүүдийг судлахаас илүү зүйл хийх шаардлагатай болно.

2011 оны намар Канадын Globe and Mail-ийн сурвалжлагчид Канадын хөрөнгийн биржэд бүртгэлтэй банзны хамгийн том үйлдвэр болох Sino-Forest корпорацийг мөрдөж шалгахын тулд Хятадад очиж, хоёр долоо хоногийн турш газар дээр нь ажилласан байна.

Анх Muddy Waters ХХК-ийн судлаачид тус

компанийг банзны хувь эзэмшлийн дүнгээ хөөргөж луйврын гэмт хэрэг хийж байсан болохыг баталж анхааруулга өгсөн билээ.

Юннан мужид сурвалжлагчид хоёр долоо хоногийг зарцуулж, орон нутгийн засаг захиргааны ажилчид, ойн мэргэжилтнүүд, бизнесийн операторууд болон брокеруудтай ярилцаж, Muddy Waters-ийн анхааруулгыг дахин баталсан мэдээг бэлтгэсэн байна. Гэвч компанийн зүгээс энэ баталгаа нотолгоог дахин няцаасаар байлаа.

Globe and Mail-ийн мэдээг уншихыг хүсвэл: <http://bit.ly/HAF1rW>

2. Дотоод мэдээлэл эзэмшигчийн хувьцааны арилжаанд анхаарал хандуулах

Зарим хүмүүс “дотоод мэдээлэл эзэмшигчийн арилжаа” гэсэн нэр томъёог хууль бус үйл ажиллагаатай холбон авч үздэг. Гэхдээ компанийн гүйцэтгэх удирдлагууд болон төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд нь мэдэгдэл, тайлантай холбоотой дүрэм журмуудыг дагаж мөрдөж, арилжааны талаарх компанийн дотоод бодлогуудыг чандлан баримтлахын зэрэгцээ компанийн хувьцааг худалдаж, худалдан авч болно.

Аливаа дотоод мэдээлэл эзэмшигч нь хувьцааны арилжаа хийх зорилгоор онцгой мэдлэг буюу дотоод мэдээлэл ашиглах нь хууль бус юм. Мөн хувьцааны үнэ ханшийг хүчтэй өсгөж, унагах шалтгаан болдог мэдээг “материаллаг мэдээ” ч гэж нэрлэгддэг мэдээг найз нөхөд, хамаатан саднууддаа өгч, зөвлөхийг ч хориглоно.

Дотоод мэдээлэл эзэмшигч нь зөвхөн компанийн дээд түвшний удирдлага, захирлууд байгаад зогсохгүй мөн тэдгээрийн найз нөхөд, гэр бүл болон дотоод мэдээллийг ашиглах боломжтой хувь нийлүүлэгч, зөвлөхүүд ч байх боломжтой.

Дотоод мэдээлэл эзэмшигчийн хувьцааны арилжаанд оролцоход өөрийгөө мэдэгдэж илчлэхэд тавигдах шаардлагууд нь тухайн биржээсээ шалтгаалж нилээд харилцан адилгүй байдаг бөгөөд шинээр гарч ирж буй зах зээлүүдэд эдгээр шаардлага нь бага байдаг. Гэхдээ ийм мэдэгдэл, баталгааг шаардсан ямар ч орчин нөхцөлд сэтгүүлчид компанийн хувь эзэмшлийн өөрчлөлт, арилжаа болон арилжааны хэв маягийг ажиглаж байх ёстой. Захирлууд болон менежерүүдийн арилжааны талаар сар бүр тогтмол мэдээ бичиж байх нь ач холбогдолтой юм.

Өнөөдрийг хүртэл хамгийн том дотоод мэдээлэл ашиглаж арилжаанд оролцсон гэмт хэрэг бол дэлхийн хамгийн том хэджи сангуудын нэг болох Galeon групыг удирдаж байсан хөрөнгө оруулагч Raj Rajaratnam-тай холбоотой. Тэрээр 50 гаруй сая ам.долларын ашиг олохын тулд компанийн дотоод мэдээлэл эзэмшигчдийн өгсөн мэдээлэлд тулгуурлаж арилжаанд оролцсоныхоо төлөө 2011 онд 10 сая ам.долларын торгууль, мөн 11 жил шоронд орох ял авсан байна. Дараа нь ҮЦАХ-ноос Rajaratnam-д 92.8 сая ам.долларын торгууль оногдуулсан нь дотоод мэдээлэл эзэмшиж арилжаанд оролцсон этгээдэд оногдуулсан хамгийн их дүнтэй торгууль боллоо.

Хэдий гэмт хэргийн шинж чанартай биш ч гэсэн дотоод мэдээлэл эзэмшигчийн хувьцааг худалдах,

2011 оны 11 сарын 3-ны өдөр хэвлэл мэдээллийн цацаж явуулсанаар бол Google инк-ийн хамтран үүсгэн байгуулагч, захирал Сергей Брин 11 дүгээр сарын 1-ний өдөр компанийн 83,334 ширхэг хувьцааг худалдсан байна. Энэ нь тухайн хугацаанд Брин болон Ларри Пейж нарын зарим хувь эзэмшлээ худалдах, компанийг хянаж удирдах гол эрхээсээ татгалзах гэсэн төлөвлөгөө, стратегийн нэг хэсэг байжээ. Энэ талаар мэдээлсэн дотоод мэдээлэл эзэмшигчийн арилжааны талаарх уншихыг хүсвэл: <http://yhoo.it/LOIC8P>

худалдан авах шийдвэрүүд нь ихэвчлэн бусад хувьцаа эзэмшигчдэд дохио өгч, хөрөнгө оруулагчдын хувьд үнэ цэнэтэй мэдээлэл болдог.

Тухайлбал, утсан харилцаа холбооны тухай шинэ хууль 2006 онд хүчин төгөлдөр болсоны дараа ердөө гурван өдрийн дотор Тайландын томоохон харилцаа холбооны Shin корпорацийн 49.6 хувийн хувьцааг тус улсын нэгэн алдартай гэр бүл худалдсан байна. Тэд уг хэлцлээс 1.88 орчим тэрбум ам.долларын ашиг олжээ. Мэдээж ийм мэдээг олж мэдэж авах нь бусад хөрөнгө оруулагчид болон хувьцаа эзэмшигчдэд чухал байсан нь тодорхой.



Дотоод мэдээлэл эзэмшигчийн арилжааг хэрхэн шалгах талаар дэлгэрүүлж уншихыг хүсвэл:
<http://bit.ly/ISulrE>

3. Хувьцааны манифуляцийг анхааралтай ажиглах

Үнийн гойд хэлбэлзэл, хувьцааны худалдан авалтын онцгой өөрчлөлтийг мэдэрдэг брокер, шинжээч эсвэл зохицуулах байгууллагуудын зүгээс мэдээлэхгүй л бол энэ талаар олж мэдээлэхэд сэтгүүлчдийн хувьд бэрхшээлтэй байж болно.

Сөрөг мэдээ явуулж хувьцааны ханшинд нөлөөлсөн гэж компаниудын зүгээс сэтгүүлчдийг буруутгах тохиолдлууд ч байдаг. Гэхдээ мэдээ нь үнэн зөв, бодитой л бол сэтгүүлчид хувьцааны үнийн талаар мэдээлсэнийхээ төлөө ямар ч үүрэг хариуцлага хүлээхгүй болно.

Хувьцааны манифуляцийн нэг хэргийг дурдвал 2012 оны 2 дугаар сарын Өмнөд Солонгосын гэмт хэргийн мөрдөн шалгах үйл ажиллагаа юм. Засгийн газрын удирдах түвшний албан хаагч байсан нэгэн этгээд Камерунд алмазны олборлолтын төсөл хэрэгжүүлдэг Өмнөд Солонгосын CNK International компанийн үйл ажиллагааны талаар буруу мэдээлсэн гэх шалтгаанаар буруутгагдсан байна.

Гадаад хэргийн яамны дэд сайд байсан тэрээр дээрх уул уурхайн компанид зөвлөхөөр ажиллаж байсан бөгөөд CNK Камерун дахь төслөөсөө 420 орчим сая крат алмаз олборлосон тухай хэвлэлийн мэдээлэл гаргажээ.

Гадаад хэргийн яамнаас тус мэдээг гаргасан бөгөөд энэ нь компанийн хувьцааны ханшийг богино хугацаанд хүчтэй өсгөх шалтгаан болжээ. Cho Jung-ruo хэмээх нэртэй тэрээр энэ үйл ажиллагаанаасаа 1 тэрбум гаруй ам.долларын ашиг хийсэн болох нь тогтоогджээ. Шүүгчдийн үзэж байгаагаар засгийн газрын бусад ажилчид ч мөн ийм хэрэгт орооцолдсон байж болох юм.

4. Аудиторуудын тайланг шалгах

Энэхүү Удирдамжид дурдсан компанитай холбоотой

бараг бүх хэргүүдийг авч үзвэл аудитын компаниуд луйвар, зөрчлийг илрүүлж чадаагүй гэж буруутгагдаж байсан ч зарим нь бүр гэмт хэрэгт холбогдож байжээ.

Аудиторын үндсэн үүрэг нь санхүүгийн тайлангуудыг нягтлан бодох бүртгэлийн дүрэм журмууд, зарчмуудын дагуу бэлтгэсэн эсэхийг тодорхойлох явдал юм. Аудиторууд мэдэгдэхдээ тэд компанийн удирдлагаас өгсөн мэдээлэлд л зөвхөн үндэслэж ажилладаг гэдэг. Өөрөөр хэлбэл тухайн компани нягтлан бодох бүртгэлийн дүрэм журмууд, зарчмуудыг дагаж мөрдсөн эсэхийг баталж нотлох аудиторуудын үйл ажиллагаа хязгаарлагдмал байдаг.

АНУ-д Arthur Andersen Enron компанийн бүх хэлцэл дээр гарын үсэг зурсаныхаа төлөө компаниас их хэмжээний төлбөр авч байсан. Хэдий аудитын үйл ажиллагааны хувьд буруутгагдаагүй ч АНУ-ын Хууль зүйн яамнаас үүнийг гэмт хэргийн сэдэлтэй гэж үзэж арга хэмжээ авсан байдаг. Итали улсад ч Parmalat SpA-ийн аудиторууд, Grant Thornton, Deloitte Touche Tohmatsu-ыг татан буулгасан, нэр хүндийг нь унагасан хэргүүд компанийн бүртгэл тооцооны алдаа, зөрчлийг илрүүлж чадаагүйтэй холбогдож байлаа. Эдгээр компани эцэст нь хувьцаа эзэмшигчдэд 15 сая ам.долларын шийтгэл төлөхөөр болсон байдаг.

Компанийн жилийн тайлангууд болон санхүүгийн тайлангуудын талаар бичиж байгаа сурвалжлагчид нь аудитын олон төрлийн дүгнэлтийн талаар ойлгодог байх шаардлагатай.

Аудитын тайланд бие даасан аудитын компани нь компанийн санхүүгийн тайлангуудын талаарх мэргэжлийн дүгнэлтээ илэрхийлсэн байдаг. Аудитын дүгнэлт нь зохих байдлын талаар бичдэг бөгөөд тайлангуудыг “материал” шинж чанарын хувьд алдаа дутагдалгүй болохыг дүгнэдэг болохоос биш баталгаа өгөх зорилгогүй юм.

Зөрчилгүй дүгнэлт — Санхүүгийн тайлангуудыг үнэн зөв илэрхийлсэн.

Зөрчилтэй дүгнэлт — Аудитор нь одоогийн нягтлан бодох бүртгэлийн хэрэглээний тодорхой зарчмуудыг эсэргүүцсэн, эсвэл материаллаг тодорхойгүй байдлын болзошгүй үр дүнг тогтоож чадаагүй.

Дүгнэлт өгөхөөс татгалзсан — Аудитор нь

хангалттай баталгаа нотолгоог олж авахад хангалттай мэдээлэл байгаагүй, эсвэл санхүүгийн тайлангуудын талаар дүгнэлт гаргах боломжгүй.

Сөрөг дүгнэлт — Аудитор нь санхүүгийн тайлангуудад компанийн санхүүгийн байдал, үйл ажиллагааны үр дүн, санхүүгийн байдлын өөрчлөлтийг нийтээр хүлээн зөвшөөрсөн нягтлан бодох бүртгэлийн зарчмуудын дагуу танилцуулаагүй гэж дүгнэсэн.

Сэтгүүлчид “асуудлыг тодруулах нь” гэсэн аудиторын тайлангийн өөр нэг хэсгийг үзэж байх ёстой. Энд аудитор нь захирлуудын тайлангуудад өгсөн тодорхой мэдэгдлүүд байдаг бөгөөд зарим шинжээчдийн хувьд хамгийн чухал хэсэг ч болж өгдөг. Тодруулга хэсгийн мэдэгдлүүдийг ихэвчлэн компанийн хувьд “санаа зовоосон”, үйл ажиллагаанд нөлөөлөх тодорхойгүй байдлын талаар бичсэн байдаг. “Санаа зовоосон” гэдэг нь ирээдүйд компани бизнесийн үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх боловч тухайн хугацаанд өр төлбөрөө төлж чадах эсэх тал дээр ихээхэн эргэлзээ байгааг илэрхийлсэн утга санаа юм

Бодит байдал дээр хамгийн том дөрвөн аудитын компаниуд бүгд харилцагчтайгаа хамт нэг буюу түүнээс дээш удаа гэмт хэрэгт холбогдсон байх жишээтэй. Энэтхэг улсын Satyam Computer Systems компанийн хэрэгтэй холбоотойгоор Pricewaterhouse Coopers-ийн хоёр ч түнш гэмт хэргийн ял авч байсан. Хөгжих компанийг нягтлан бодох бүртгэлээ булзааруулах боломж олгосон гэх хэргээр YЦАХ-ны зүгээс KPMG-д ял оногдуулсан байдаг. KPMG буруутай үйл ажиллагаагаа хүлээн зөвшөөрөлгүйгээр 2005 онд дээрх хэрэгтэй холбоотой гомдлыг барагдуулсан байна.

Компанийн аудиторрууд, аудитын үйл ажиллагааны талаар сурвалжлагчдын асуух ёстой асуултуудад орох нь:

- Гадны аудитор нь мэргэшсэн, найдвартай, хараат бус, хууль эрхзүй болон зохицуулалтын зөрчил гаргаж байгаагүй эсэх?
- Аудиторын дүгнэлтийн хязгаарлалт нь юу вэ?
- Санхүүгийн тайлангуудыг шалгаж баталгаажуулахад ямар арга барил хэрэглэсэн вэ?
- Аудитын тайлан нь компанийн санхүүгийн тайлангуудын талаар юу гэж дурдсан байна вэ?
- Аудитын үйлчилгээг эс тооцвол тухайн аудитын компани аудит хийлгэж байгаа компанитай ямар төрлийн бизнесийн харилцаа холбоотой вэ? Сонирхлын аливаа зөрчилтэй эсэх?
- Аудитын баг нь харилцагчийнхаа бизнесийн талаар мэдэх боломжтой байсан уу?
- Удирдлага нь аудиторруудтай хамтран ажиллагааг эсэх?

Компаниудын хэргээс болж ихэвчлэн хатуу дүрэм журмууд, чанга сахиж мөрдөх шаардлага бий

болдог. Enron болон WorldCom-ийн хэрэг гарсаны дараах 2002 оны Sarbanes-Oxley-ийн хуульд аудит, аудитын компаниуд, аудитын хороодтой холбоотой шинэ заалтууд, мөн тайлан тэнцлээс гадуурх ажил гүйлгээний талаар мэдээлэх шаардлага болон бусад шинэ дүрэм журмуудыг тусгасан байна. Мөн тус шинэ хуулиар ТУЗ-ийн дарга, гүйцэтгэх захирал болон санхүү хариуцсан захирал нь аудиторын ажлыг хянахдаа илүү анхааралтай хандаж, санхүүгийн тайлангуудын өмнөөс биечлэн хариуцлага хүлээхээр болсон байна.

5. Санхүүгийн ертөнц дэх олон эх сурвалжуудыг боловсруулах

Хэджи сангийн менежерүүд, богино хугацааны арилжаанд оролцогчид, шинжээчид болон судлаачид нь сэтгүүлчдийн хувьд үнэ цэнэтэй эх сурвалж байж болно. Учир нь тэд компанийн санхүүгийн болон санхүүгийн бус мэдээллийг илүү нарийн ухаж дөнхөж, харилцагчиддаа зориулж өргөн цар хүрээний урьдчилсан судалгаа хийдэг.

2011 онд богино хугацааны арилжааны судалгааны компани болох Muddy Waters ХКК АНУ-д бүртгэлтэй Хятадын компаниуд хөрөнгө болон орлогоо хэтрүүлэн тооцсон болохыг буруушаан шүүмжилсэн. (Гэхдээ сэтгүүлчдэд өгөх анхааруулга нь: ихэнх тохиолдолд компаниудын өөрдийн хийсэн дотоод шалгалт судалгаа нь гадны бусад баталгаа нотолгоотой зөрчилдөж байдаг.)

Гэвч Muddy Waters-ийн зүгээс Хятадын компаниудыг хангалтгүй хянаж байгаа PricewaterhouseCoopers, Deloitte Touche Tohmatsu, KPMG болон Ernst & Young зэрэг дөрвөн томоохон нягтлан бодох бүртгэлийн компаниудын алдаа гэж үзсээр байлаа.

Түүнчлэн компанийн үйл ажиллагаа явуулж байгаа салбар дахь зохицуулах байгууллагууд нь сайн эх сурвалжууд болох боломжтой.

(Сэтгүүлчдэд боломжтой байдаг эх сурвалжуудын талаар дэлгэрүүлж уншихыг хүсвэл 7 дугаар бүлгийг үз.)



ТА ЮУ МЭДЭХ ВЭ?

Шуурхай асуулт, хариулт

1. Дараах санхүүгийн мэдэгдэл, тайлангуудын зөвхөн нэгийг нь аудитаар баталгаажуулах ёстой. Аль нь вэ?

- A. Тогтмол хугацаатай орлогын тайлан
- B. Жил бүрийн санхүүгийн тайлан
- C. Итгэмжлэлийн мэдэгдэл

2. Аудитор нь компанийн санхүүгийн тайлангуудын талаар “тайлбаргүй” санал, дүгнэлтийг өгсөн бол энэ нь юу гэсэн үг вэ?

- A. Аудитор нь тайлангуудыг баталгаажуулаагүй
- B. Тайлангуудад компанийн санхүүгийн төлөв байдлыг үнэн зөв тусгасан талаар аудитор нь зохих баталгаа нотолгоотой юм.
- C. Аудитор нь дүгнэлт өгөхөөс татгалзсан.

3. Дараах тохиолдолд дотоод мэдээлэл эзэмшигчийн арилжаа нь хууль бус болно.

- A. Хувьцааны тоо нь хөрөнгө оруулагчийн хувь эзэмшлийн 10 хувиас хэтэрсэн.
- B. Хөрөнгө оруулагч нь дотоод эх сурвалжаас олж авсан компанийн талаарх нууц, материаллаг (чухал), олон нийтэд нээлттэй бус мэдээлэлтэй бөгөөд тус мэдээллээр арилжаанд оролцсон.
- C. Худалдагч, эсвэл худалдан авагч нь компанийн дотоод мэдээлэл эзэмшигчтэй холбоотой.

Харуултууд: 1. B, 2. B, 3. B

ЭХ СУРВАЛЖУУД БҮЛЭГ 5

Редакторын тэмдэглэл: 5 дугаар бүлгийг бэлтгэхэд зориулж доорх эх сурвалжуудыг авч үзсэн болно. Ямар ч хүн ихэнх вэбсайтууд руу нь орох боломжтой. Wall Street сэтгүүл, Financial Times зэрэг тодорхой эх сурвалжуудын мэдээг үзэхийн тулд нэвтрэх эрх захиалах шаардлагатай. New York Times нь уншигч, үзэгч бүрт зориулж сар бүрд хязгаарлагдмал тооны архивласан материал өгдөг.

НИЙТЛЭЛ, БҮТЭЭЛҮҮД

Jamie Allen, “Ази тив дэх компанийн засаглалын бүтэлгүйдэл: Захирлууд болон байгууллагын зөвлөх нь эрсдлийг удирдан зохицуулахад хэрхэн туслах вэ?” Азийн компанийн засаглалын холбоо (АКЗХ)-ны танилцуулга, 2009 оны 5 дугаар сарын 6-ны өдөр. <http://bit.ly/lidfPV>

Catherine Belton, Neil Buckley, “Оросын банкууд: Барьцаа хөрөнгийн хохирол”, Financial Times, 2011 оны 9 дүгээр сарын 22-ны өдөр. <http://on.ft.com/INw0Pe>

Joseph Bonyo, “Кени: Төлөөлөн удирдах зөвлөлийн дайн CMA-ийн нууц хэсгийг илчлэв”, Daily Nation, Nairobi, 2011 оны 9 дүгээр сарын 19-ний өдөр. <http://bit.ly/HDSW0D>

Obinna Chima, “Нигери: S&P - Банкууд одоо компанийн засаглалд илүү сайн болов”, 2012 оны 3 сарын 1-ний өдөр, This Day, Лагос, Нигери. <http://bit.ly/Hxh6Lg>

Hans Christianson, Alissa Koldertsova, “Хөрөнгийн биржүүдийн компанийн засаглалд гүйцэтгэх үүрэг оролцоо”, Financial Market Trends, ЭЗХАХБ, 2008 он. <http://bit.ly/lvwX07>

Sleve Eder, Amy Or, “Менежер ногоон уулыг дэлбэлэв”, Wall Street сэтгүүл, 2011 оны 10 дугаар сарын 18-ны өдөр. <http://on.wsj.com/IFBj18>

Nathaniel Parish Flannery, “судлаач, GovernanceMetricsInternational (GMI),” Шинэ хөгжил: Менежментийн зовлон хийгээд гадаадад

бүртгэлтэй компаниудын эрсдэл, 2011 оны 8 сарын 26-ний өдөр. <http://onforb.es/HH3App>

Moon Ilwahn, “Ким Даewoo-ийн албан тушаалаас ангижрав”, BusinessWeek, 2011 оны 2 дугаар сарын 19-ний өдөр. <http://buswk.co/HDXVCV>

Kana Inagaki, “TSE Pressure on Olympus Intensifies,” The Wall Street Journal, Oct. 31, 2011. <http://on.wsj.com/lvxnDx>

Peter Lattman, “Rajaratnam 92.8 сая ам.долларын торгууль төлөхөөр болов”, New York Times, 2011 оны 11 дүгээр сарын 8-ны өдөр. <http://nyti.ms/HH3JZG>

Dinny McMahon, “Гарын үсэг нь Хятадын аудитыг баталж чадах уу?” Wall Street сэтгүүл, 2011 оны 10 сарын 22-ны өдөр. <http://on.wsj.com/HPnLCO>

Mark MacKinnon, Andy Hoffman, “Sino-Forest-ийн хэрэгт гол түнш нь эргэлзээ төрүүлэв”, Globe and Mail, 2011 оны 6 сарын 18-ны өдөр. <http://bit.ly/HAF1rW>

Duncan Mavin, Ken Brown, “Muddy Waters-ийн эсрэг Sino-Forest тэмцэл өрнүүлэв”, Wall Street сэтгүүл, 2011 оны 11 дүгээр сарын 16-ны өдөр. <http://on.wsj.com/HDYaOq>

Rick Aristotle Munarriz, “Warren Buffett худалдан авч байгаа 5 шинэ хувьцаа”, Motley Fool, 2011 оны 11 дүгээр сарын 18-ны өдөр. <http://aol.it/HEaj6c>

Floyd Norris, “Аудитын асуудалтай дүгнэлт”, New York Times, 2011 оны 6 сарын 9. <http://nyti.ms/HRM52T>

Kate O’Keefe, “Хонгконг дотоод мэдээллээр хэлцэл хийсэн гүйцэтгэх удирдлагад хариуцлага оногдуулав”, Wall Street сэтгүүл, 2011 оны 8 дугаар сарын 26-ны өдөр. <http://on.wsj.com/HH41js>

Chris Roush, “ҮЦАХ-ны тайлангуудыг компаниудын талаар мэдээлэл бэлтгэхэд хэрхэн ашиглах вэ”, Сэтгүүлчийн эх сурвалж, Харвардын Shorenstein

төв болон Carnegie-Knight, 2011 оны 3 дугаар сарын 17-ны өдөр. <http://bit.ly/IEU0oo>

Neil Stewart, “Бразилийн компаниуд Novo Mercado-ийн ачаар хөгжиж цэцэглэв”, Дотоод мэдээлэл эзэмшигч хөрөнгө оруулагчийн харилцаа, 2010 оны 3 дугаар сарын 1-ний өдөр. <http://bit.ly/lvzXth>

“Компанийн нягтлан бодох бүртгэлийн асуудлаар онцлох зүйл”, accountingweb.co.uk, 2009 оны 6 дугаар сарын 5-ны өдөр. <http://bit.ly/HRlnpB>

“Шүүх прокурор гадаад хэргийн дэд сайд асан этгээдийг хувьцааны манифуляци хийсэн хэргээр зарлан дуудав”, Yonhap News, 2012 оны 2 дугаар сарын 28-ны өдөр. <http://bit.ly/HGKv8m>

Shincorp-ийн хэлцэл, 2006 оны 10 дугаар сарын 18-ны өдөр. <http://bit.ly/HDZctB>

“Дотоод мэдээлэл эзэмшигчийн арилжаанаас хөрөнгө оруулагчид юуг мэдэж болох вэ?”, Investopedia, 2011 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр. <http://bit.ly/ISulrE>

“Google-ийн хамтран үүсгэн байгуулагчид хувьцаагаа зарсан нь”, BBC News, 2010 оны 1 дүгээр сарын 24-ний өдөр. <http://bbc.in/HGwklT>

“Сергей Брин Google-ийн 48.4 сая ам.долларын (GOOG) хувьцааг зарсан нь”, Marketbrief.com, 2011 оны 11 дүгээр сарын 3-ны өдөр. <http://bit.ly/HJfJJK>

“Raj Rajaratnam- Galleon группын үүсгэн байгуулагч дотоод мэдээлэл ашиглаж арилжаанд оролцсон хэргээр буруутгагдав”, New York Times, 2011 оны 10 дугаар сарын 26-ны өдөр. <http://nyti.ms/HPpR5x>

“Ил тод байдлын цаг хугацаа: Ойрхи Дорнодод компанийн засаглалыг сайжруулахын тулд ямар арга хэмжээ авах вэ?” knowledge@wharton, Wharton сургууль, Пеннисилванийн их сургууль, 2009 оны 3 дугаар сарын 11-ний өдөр. <http://bit.ly/HRNEOP>

Тоон үзүүлэлтийн цаадах мэдээг олж харах

Ихэнх нь ня-бо биш бөгөөд санхүүгийн нарийн мэдлэг багатай сэтгүүлчид яаж компаний удирдах ажилтнуудын санхүү бүртгэлийн нарийн төвөгтэй башир арга залиг олж тогтоон худал хуурмаг зүйл хийн мэхлэж байгааг илрүүлэн гаргаж сурах вэ?

Нягтлан бодохын курст суух албагүй ч гэсэн сэтгүүлчид компаний санхүүгийн тайланд ашиглагддаг нэр томъёонуудыг өөрсдөө судлан тоонуудыг хэрхэн тайлбарлахыг ойлгоод авчихаж чадна.

- Олон тооны номнуудыг оролцуулан / Хавсралтанд байгаа сонгон авсан номнуудын жагсаалтыг үз/ сэтгүүлчдэд санхүүгийн мэдлэгээ сайжруулах олон янзын хэрэгслүүд байдаг юм. Санхүүгийн вэб сайтууд дээр үнэ төлбөргүй хичээлүүд болон өгүүллүүд байдаг / Энэхүү бүлгийн линкүүд болон энэхүү бүлгийн төгсгөлд байгаа номын жагсаалтуудыг үз/.
- Аризонагийн улсын их сургуулийн Дональд Рэйнолдзын бизнесийн сэтгүүл зүйн үндэсний төвөөс бизнесийн чиглэлээр ажилладаг сэтгүүлчдэд зориулан тусгайлан боловсруулсан санхүүгийн тайлангууд хэрхэн уншиж ойлгох талаарх онлайн аргаар үнэ төлбөргүй өөрийнхөө дуртай үед суралцах боломжтой курс бий: <http://bit.ly/HRNlxk>
- Бас нэг туслалцаа авч болох эх сурвалж бол 2010 оны 10 сард АНУ-ын аудитын чанарын төвөөс гаргасан “Санхүүгийн тайлагналтын луйварыг илрүүлэн таслан зогсоох арга хэмжээний тухай” хэмээх баримт бичиг бөгөөд түүнийг <http://thecaq.org> сайтаас үзэж болно.

Бусад ашигтай зөвлөлгөөг доор өгүүлэв:

1. Компаний вэб сайтаас эхлэх нь

Тухайн компаний вэб хуудсыг үз; тухайн компани бүртгэгдсэн хөрөнгийн биржийг нягтлаад үз; мөн тухайн салбартай холбоотой блогууд болон

шинжээчдийн вэб сайтуудыг хайх хэрэгтэй. Зохицуулах байгууллагуудын сайтуудаар орж үзэж байнга шалгаж байх хэрэгтэй.

Вэб сайтууд дээрх мэдээлэлд дараах зүйлс багтсан байдаг:

- Орлого, ашиг болон хувьцааны байдал
- Тухайн компаний гол статистик
- Нээлттэй хувьцаат компаний тайлагнасан санхүүгийн мэдээллүүд
- Салбарын хэмжээнд тухайн компанитай өрсөлдөгчдийн талаарх товч тойм
- Тухайн компани, түүний стратеги болон түүний хувьцааны үнийн хэтийн төлөвийн талаар товч мэдээллүүд
- Тухайн компаний гол хувьцаа эзэмшигчид, ажилтнууд болон ахлах удирдлагын ажилтнуудын цалин хөлсний талаарх мэдээлэл
- Сүүлийн үеийн үйл явдлуудын талаар хэвлэлд нийтэлсэн мэдээнүүдийг оролцуулан тухайн компаний талаарх өнөөгийн мэдээ мэдээлэл
- Тухайн компаний талаарх мэдээлэл бүхий санхүүгийн чиглэлийн блогууд
- Тухайн компаний түүх, стратеги болон гол гол үйл явдлуудыг багтаасан компаний танилцуулга

2. Санхүүгийн тайлангийн бүрдэл

Санхүүгийн тайлан нь ерөнхийдөө дараах зүйлсээс бүрддэг:

- Тайлан тэнцэл
- Орлогын тайлан
- Бэлэн мөнгөн урсгалын тайлан
- Хувьцаа эзэмшигчдийн капитал

- Санхүүгийн тайлангийн тайлбарууд

Тайлан тэнцэл: Тайлан тэнцэл гэдэг нь тодорхой хугацааны буюу ихэвчлэн санхүүгийн жилийн сүүлчийн өдрийн байдлаарх тухайн компаний санхүүгийн тайлангийн “дүр зураг” гэж голдуу тодорхойлдог. Тайлан тэнцэл нь тухайн компаний санхүүгийн тайлангийн гол хэсэг бөгөөд үйл ажиллагаануудаа явуулах ямар хөрөнгө байгаа болон төлөгдөөгүй өр төлбөр ямархуу байгааг нь харуулдаг.

Хилийн чанадад байгуулагдсан компаниудыг хэрхэн судлах талаар та мэдэх үү?

Энэ талаарх мэдээллийн эх сурвалжуудыг олж авах, мэдээлэл солилцох болон шинэ арга хэрэгслүүдийг сурч авах үүднээс мөшгөн сурвалжлагчдад зориулагдсан вэбд тулгуурласан төв болох “Мөрдөлтийн хянах самбартай” харьцах хэрэгтэй. Техникийн туслалцааг Сэтгүүлчдийн олон улсын төв өгдөг. <http://www.datatracker.org/>

Тайлан тэнцэл нь хөрөнгө /тухайн компани юу өмчилж байна/ болон өр төлбөрийн /компани ямар өртэй вэ/ харилцааг илэрхийлдэг. Үлдэж байгаа нь “компаний цэвэр үнэ цэнэ” эсвэл “балансаарх үнэ” / “бүртгэлийн үнэ”/ гэж нэрлэгддэг хувьцаа эзэмшигчдийн капитал юм. Энэ нь хувьцааны хөрөнгө дээр хуримтлагдсан ашгийг нэмээд компани өөрөө эргүүлэн худалдаж авсан хувьцааг хассантай тэнцүү буюу дараах томъёогоор илэрхийлэгдэнэ. Үүнд:

$$\text{Хувьцаа эзэмшигчдийн хөрөнгө} = \text{нийт хөрөнгө} - \text{нийт өр төлбөр} \\ \text{ЭСВЭЛ}$$

$$\text{Хувьцаа эзэмшигчдийн хөрөнгө} = \text{хувьцааны хөрөнгө} + \text{хуримтлагдсан ашиг} - \text{эргүүлэн худалдаж авсан хувьцаа}$$

Богино хугацаат өр төлбөр гэдэгт бусад зүйлсээс гадна өглөгийн данс, богино хугацааны өр, урт хугацааны өрийн өнөөгийн төлөх ёстой хэсэг багтана. **Богино хугацаат бус өр төлбөр гэдэгт** ихээхэн хэмжээний мэдээлэл агуулж болох хувьцаа эзэмшигчдэд төлөх ёстой өрийн бичиг болон бондууд, урт хугацааны өр болон тэтгэвэр болон тэтгэвэрт гарсны дараах тэтгэлэг олгох үүргүүд

багтана.

Балансын гадуурх хөрөнгө эсвэл өр нь алдагдлыг нуух эсвэл худал ашиг бий болгоход ашиглагддаг. Балансын гадуурх хөрөнгө эсвэл өрийн талаарх танилцуулга болох сүүлийн жилүүдийн санхүү бүртгэлийн луйврийн скандалуудын заль мэхүүдийн талаар: <http://bit.ly/lvAFGS> сайтыг үзнэ үү.



Тайлан балансийг хэрхэн тайлбарлах талаар илүү дэлгэрэнгүй мэдээллийг <http://bit.ly/IFGGxw> вэб сайтаас үзнэ үү:

Ашгийн тайлан: Үүнийг мөн “орлогын тайлан” эсвэл “үйл ажиллагааны үр дүнгийн тайлан” ч гэж нэрлэдэг талтай. Энэ тайлан нь ихэнхдээ нэг жилийн тайлант хугацааны хүрээнд тухайн компаний олсон орлогууд болон гаргасан зардлуудыг харуулдаг бөгөөд өнгөрсөн оны ашгийн тайлантай харьцуулбал орлого хэр өссөн талаарх хэрэгтэй мэдээллээр хангадаг. Мөн нийт ашиг /орлого/, нийт зардал болон цэвэр ашгийн өөрчлөлтүүдийг харуулдаг.

Үйл ажиллагааны зардлууд нь тухайн компани үндсэн үйл ажиллагаануудаа явуулахад гарсан ердийн зардлууд юм. **Үйл ажиллагааны бус зардлууд** гэдэг нь тухайн компаний санхүүжилт болон хөрөнгө оруулалтын үйл ажиллагаануудтай холбоотой зардлуудыг хэлнэ.

Ашгийн тайлан нь тухайн компаний бэлэн мөнгөний урсгалыг бус ашигт байдлыг хэмждэг /Доорхийг үз/. Ашгийн тайланд ашиглагдсан үндсэн дүн шинжилгээ, ашгийн тайланд ашиглагдсан нэр томъёонууд болон ашгийн тайлангийн загварыг <http://bit.ly/IFH5jj> сайтаас үзнэ үү.

Бэлэн мөнгөний урсгалын тайлан:

Олон шинжээчид болон хөрөнгө оруулагчид бэлэн мөнгөний урсгалыг компаний санхүүгийн тайлангийн хамгийн чухал зүйл гэж үздэг. Ихэнх хөрөнгийн биржүүд нээлттэй хувьцаат компаниудыг явагдаж буй үйл ажиллагаануудынхаа бүх бэлэн мөнгөний орох урсгалууд, хөрөнгө оруулалтууд, санхүүжилтийн үйл ажиллагаанууд болон бэлэн мөнгөний гадагш урсгалуудыг тайлагнаж байхыг шаарддаг.

Бэлэн мөнгөний орох гарах урсгалууд нь нэг жилийн хугацаанд тухайн компаний бэлэн мөнгө нь хаанаас

орж ирж хэрхэн зарцуулагдаж байгааг харуулдаг.

Тухайн компани ашиггүй ажиллаж байсан ч гэсэн бэлэн мөнгөний урсгал эерэг байж болно. Бэлэн мөнгөний урсгал нь хөрөнгө, өр төлбөр, өглөгийн данс эсвэл авлагын данс зэргийг харуулдаггүй. Компаний эрүүл мэнд ямархуу байгааг иж бүрэн харуулахын тулд бэлэн мөнгөний урсгалыг санхүүгийн бусад тайлангуудтай холбон авч үзэж шинжлэх шаардлагатай.

“Энрон корпорацийн түүхийг ирээдүйд дахин давтахаас зайлсхийх тухай” /2001 онд дампуурсан АНУ-ын корпораци/ нэртэй өгүүлэлдээ сэтгүүлчид ашгийн тайлан дахь орлого болон ашигт анхаарах хандлагатай болсон гэж Колумбия Журнализм Ревью /КЖР/ сэтгүүл тэмдэглэжээ.

“Гэвч ялангуяа үйл ажиллагаанаас орсон бэлэн мөнгөний урсгалын өгөгдлүүдийг судлах нь тухайн хугацаанд хэр их мөнгө компаниас орж гарч байгааг илүү тод харуулдаг бөгөөд илүү сайн илчлэх боломж олгодог” гэж КЖР сэтгүүлд бичсэн өгүүлэлдээ Аня Шиффрин бичсэн байна.

Үйл ажиллагаануудаас олсон бэлэн мөнгөний урсгал сөрөг байсан ч компани ашигтай ажиллаж байж болдог. Үүний нэг шалтгаан нь борлуулалтыг зээлээр хийсэн байж болох бөгөөд бэлэн мөнгө авах нь хожим төлбөрөө хэр найдвартай хийснээс хамаарна. Үйл ажиллагаануудаас орох мөнгөн урсгалууд сөрөг хэвээр үргэлжлээд байвал улаан дарцаг тавин анхааруулах хэрэгтэй болно. Бэлэн мөнгөгүйгээр компани ажиллагсдынхаа цалин тавьж эсвэл бусад үйл ажиллагаа явуулах зардлаа нөхөх боломжгүй болно.

Үйл ажиллагааны бэлэн мөнгөний урсгалын сөрөг утга дахин дахин давтагдаад байх нь тухайн компани өөрийн үйл ажиллагаануудаас цэвэр бэлэн мөнгө олж чадахгүй байгааг харуулсан муу шинж тэмдэг юм. Хэрэв тэр хэвээр үргэлжлээд байвал тухайн компани ойрын ирээдүйд санхүүгийн хямралд орох магадлал өндөр болно.

Төлбөрүүдийг сунгаж эсвэл саатуулж буй компани үйл ажиллагааны мөнгөн урсгалыг хиймлээр нэмэгдүүлж болно. Энэ нь бэлэн мөнгөний урсгалын тайлан дээр үйл ажиллагааны бэлэн мөнгөний гарах урсгалын бууралт байдлаар харагдана. Гэвч тухайн компанид зээл олгогчид төлбөрийг цаг тухайд нь хийхийг шаардан шахалт үзүүлэх учраас уг бууралтыг тогтвортой хадгалах боломжгүй. Үүнийг тайлан баланс дээрх “үйл ажиллагааны гарах мөнгөн урсгалыг” “өглөгийн данстай” харьцуулсан харьцаа харуулдаг.



Бэлэн мөнгөний урсгалын тухай тайлбар болон бэлэн мөнгөний урсгалын тайлангийн загварыг <http://bit.ly/HRM3eE> сайтаас үзнэ үү:

3. Жилийн тайлангууд болон тогтмол хугацаанд гаргадаг тайлангуудаас өгүүлэл бичих санаа хайх нь

Жилийн санхүүгийн тайланг багтаасан жилийн тайлан нь ихэвчлэн сэтгүүлчдэд өгүүлэл бичихэд хэрэгтэй олон сайхан санаанууд агуулж байдаг бөгөөд өмнөх жилд тухайн компаний авч явуулсан стратеги

Санхүүгийн боловсролын вэб сайт болох Инвестпедиа нь жилийн тайлангийн “Санхүү бүртгэлийн чухал бодлогуудын товч тойм” мэтийн хэсгүүдэд ихэвчлэн оруулдаг ногоон, шар, улаан дарцагнуудыг ямар үед тавьдаг болохыг мэдэж авах боломжийг хөрөнгө оруулагчдад өгнө.





СУРВАЛЖЛАГЧИЙН ТЭМДЭГЛЭЛИЙН ДЭВТЭР

Сэтгүүлчид тоон өгөгдлүүдийг ойлгох нь чухал болох талаар:

“...үнэндээ маш цөөн тооны сурвалжлагчид үнэ ба ашиг хоёрын ялгааг ойлгож байгаа нь хачирхалтай. Хэрэг дээрээ санхүүжилтын асуудлыг мэдээллэж буй бизнесийн сэтгүүлч бараг байхгүй байна. Компаний талаар сурвалжилж байх үед зээл авах өртөг нь 100-аас /суурь түвшин/ 250 эсвэл 300 түүнээс их [эрсдэл ихээхэн нэмэгдсэн гэж хөрөнгө оруулагчид

үзэж байгаа гэсэн үг] болтол нэмэгдээд байхад ямар ч сурвалжлагч тэр талаар асуухгүй л байна. Тийм зүйл тохиолдоод байхад хэн ч асуухгүй байгаа нь асуудал болоод байна. Бидний мэргэжлийнхэнд сургалтын асуудал ноцтой болж байгаа гэж би бодож байна. Бид буутай байлдаанд хутгатай оролцож байна шүү дээ.” гэж Блүмберг Ньюсын сурвалжлагч асан Марк Питман хэлжээ.

Эх сурвалж: Аудитын талаарх ярилцлага, Рян Читтум, КЖР

эсвэл үйл ажиллагаануудын талаар шинэ мэдээлэл харуулдаг. Ихэвчлэн компаний тогтмол хугацаанд гаргадаг орлогын тайлангуудаас жилийн тайлан нь илүү их мэдээлэл олгохоор байдаг учир нь салбарын зохицуулах байгууллага илүү мэдээлэл шаарддаг.

Тайланг бүхэлд нь уншихаас гадна сурвалжлагчид жилийн эцсийн санхүүгийн тайланд онцгойлон анхаарах шаардлагатай.

Тайлан дахь тоон өгөгдлүүд нь сонирхолтой зүйл өгүүлэх нь ховор ч гэсэн ямар ч төрлийн тайлангийн хувьд тоон өгөгдлүүд нь өгүүлэл бичих шинэ санаа өгөх шинэ мэдээлэл, компаний стратеги болон үйл ажиллагааны зохих өөрчлөлтүүдийг харуулдаг.

- Тайланд багтсан бүх тоон өгөгдлүүдээс нэг жилээс нөгөө жилд гарсан өөрчлөлтүүдийг хай; процентийн өөрчлөлтүүд ихээхэн үнэ цэнэтэй мэдээлэл агуулдаг.
- Өнөөгийн эдийн засгийн орчинд тухайн өөрчлөлтүүд учир утгатай эсэхийг асуу;
- Өгүүлэл бичих санаа олох үүднээс эрсдлийн хүчин зүйлсийг судлаж үз; Эрсдлийг зохих ёсоор үнэлж түүнд бэлтгэлтэй байж чадаж үү? Жишээлбэл, 2007 оны жилийн тайландаа Кока Кола компани усны хомсдол, усны чанар муутай байдал болон кока коланы ашиг байдалд тэдгээрийн үзүүлж болох нөлөөллийн талаар дурьдсан байна.
- Хуудасны эсвэл бүлгийн төгсгөлд өгсөн тайлбаруудыг унш; Тэдгээр нь ихэвчлэн цаашдын санаанууд төрүүлж байдаг. КЖР сэтгүүл “Энрон корпорацийн түүхийг

ирээдүйд дахин давтахаас зайлсхийх тухай” гэсэн өгүүлэлдээ тэмдэглэсэнчлэн Энрон корпорацийн санхүүгийн тайлангуудын тайлбаруудыг анхааралтай уншсанаар балансын гадуурх түншлэлүүд болон ашиг сонирхлын зөрчлүүдийн хэр хэмжээний талаарх асуултууд тавихад хүргэсэн ажээ. Бас нэг улаан дарцаг тавих боломжтой зүйл бол харилцагчид болон нийлүүлэгчидтэйгээ харьцах компаний харилцаанууд байдаг бөгөөд тэдгээрийн талаар ихэвчлэн хуудасны эсвэл бүлгийн төгсгөлийн тайлбаруудад бичсэн байдаг.

- Санхүүгийн боловсролын вэб сайт болох Инвестпедиа нь жилийн тайлангийн “Санхүү бүртгэлийн чухал бодлогуудын товч тойм” мэтийн хэсгүүдэд ихэвчлэн оруулдаг ногоон, шар, улаан дарцагнуудыг ямар үед тавьдаг болохыг мэдэж авах боломжийг хөрөнгө оруулагчдад өгнө. Тэдгээрийг мэдэж авахын тулд дараах сайтыг үз: <http://bit.ly/HJg8vC>
- Дараагийн жил болон түүнээс цааш төлөх ёстой өрийн хэмжээг хайж олоод тухайн компани түүнийг төлөх ямар хөрөнгийн эх үүсвэртэй болохыг авч үз.
- Зарга заалхай болон бусад хуулийн асуудлаарх хэсгийг судлах хэрэгтэй. Заримдаа хувьцаа эзэмшигчид зарга мэдүүлдэг боловч ханган нийлүүлэгчид, харилцагчид болон өрсөлдөгчдийн гаргасан заргууд нь сэжигтэй байж болох практикууд байгааг эсвэл наад зах нь тухайн компанид сэтгэл дундуур байгааг харуулдаг.

ӨГҮҮЛЭЛ БИЧИХ АРГА ХЭРЭГСЭЛ

Нээлттэй хувьцаат компаний амжиргаагаа залгуулдаг тогтмол орлогын талаарх өгүүлэл бичихдээ тухайн компани нийтэд мэдээллэсэн мэдээндээ өөрийн гүйцэтгэлд хийсэн дүн шинжилгээг нь санхүүгийн бодит тайланд тусгагдсан тоон өгөгдлүүд болон тэдгээр тоон өгөгдлүүдийг тайлагнахдаа хийсэн компаний тайлбаруудтай нь харьцуулж үзэх хэрэгтэй.

Нийтэд мэдээллэсэн мэдээ нь тодорхой тоонуудтай холбоотой эерэг зүйлсийг дөвийлгөн гаргаад арай өөр зүйл харуулсан бусад тоонуудыг орхигдуулах хандлагатай байдаг.

Жилийн тайлан ч мөн адил тийм байдаг талтай: гялтганасан гэрэл зурагнууд болон оптимистик дүн шинжилгээнүүд нь заримдаа санхүүгийн тайлан дахь тоонуудтайгаа зөрчилддөг. Тиймээс худлаа дөвийлгөсөн зүйлсээр тархиа угаалгалгүйгээр тоонуудыг нь судлан илрүүлэх ёстой зүйлсийг илрүүлэх нь сэтгүүлчийн ажил байх ёстой.

- Өмнөх жилийн компаний тооцоо болон ирээдүйн стратегийн талаарх ярилцлага нь ихэнхдээ аль хэдийнээ мэдэгдэж буй мэдээлэлд эерэг өнгө аяс оруулдаг ч гэсэн заримдаа ийм ярилцлагуудад өгүүлэл бичих санаа нуугдаж байдаг талтай.
- Зарим үнэт цаасны зохицуулах байгууллагуудын шаарддагчлан ихэнх жилийн тайланд орсон байдаг “менежментийн ярилцлага болон дүн шинжилгээ” нь өнгөрсөн үйл явдлуудыг тайлбарлах өсөж дэвжих төлөвлөгөөнүүдийг гаргах боломжийг менежментэд олгодог. Энэ хэсэг нь

менежментийн стилийг ойлгоход тус болдог. Энэ хэсгийн мэдээлэлд аудит хийгддэггүй.

- Компаний гол борлуулалт эсвэл худалдан авалтуудыг бодитоор үнэлсэн үү?

Жишээлбэл, 2011 оны 9 сард Фортис Хэлзкэр Индия компани өөрийн гэр бүлийн өмчлөгчид болон Малвиндор болон Шивиндер Сингхийн гадаад дахь эрүүл мэндийн бизнес эрхэлдэг компанийг худалдан авах гэж буйгаа зарласан. Тэгснийхээ дараахан группын дотоодын 665 сая ам. долларын уг гүйлгээ нь хөрөнгийн биржид бүртгэлтэй уг компаний хувьцаа эзэмшигчдийн хувьд шударга болж чадсан эсэх талаар хөрөнгө оруулалтын шинжээчид санаа зовж байгаагаа илэрхийлсэн байдаг. Энэтхэгийн Экономик Таймз сонингийн явуулсан дүн шинжилгээгээр тухайн бизнесийн төлөө уг компани 20 хувь хүртэл шимтгэл төлсөн байдаг. Уг сонин зохицуулах байгууллагын файлууд, компаний танилцуулгууд болон хэвлэлд өгсөн мэдээллүүдийг ашиглан тийм дүгнэлтэнд хүрсэн байдаг.

Бизнесийн чиглэлээр сурвалжилдаг олон сэтгүүлчид компаниудын тогтмол гаргадаг санхүүгийн тайлагнууд эсвэл ашиг орлогын талаар хэлбэрийн төдий өгүүлүүд бичдэг боловч санхүүгийн тайлангуудыг илүү шүүмжлэлтэйгээр уншвал илүү нарийн ширийн зүйлсийг илчилсэн овсгоотой өгүүлэлүүд бичих боломж олгодог.

Компаний данснууд эсвэл шийдвэрүүдэд байгаа ноцтой асуудлуудыг гаргаж ирж сурах нь сайн өгүүлэл бичих зам руу хөтөлдөг.

4. Тааламжгүй асуултууд асуух

Сэтгүүлчид өөрсдөө луйварчин наймаачдын явуулдсан луйврын үйл ажиллагаануудыг илрүүлэх магадлал муутай ч банкнууд болон хөрөнгө оруулалтын пүүсүүдээс тэдгээрийн эрсдлийн менежментийн бодлогууд, ахлах гүйцэтгэлийн ажилтнууд болон ТУЗ-ийн гишүүдийнх нь эрсдлийн менежмент хийх чадварын талаарх болон зөвшөөрөлгүй наймаа хийхээс хамгаалах тогтолцоо ба бодлогууд банк санхүүгийн байгууллагуудад байдаг эсэх талаарх асуултуудыг асууж лавлаж болно.



“Сурвалжилж буй компаниудад байгаа ноцтой асуудлуудыг олж тогтоох арван зөвлөмжүүдийг”

<http://bit.ly/HGol8e> сайтаас харж болно.



Та юу мэдэх вэ?

Асуулт хариултууд:

1. Энэ тайлан нь тодорхой хугацаан дахь тухайн компаний санхүүгийн байдлын талаарх мэдээлэл өгдөг.

- A. Ашиг орлогын талаарх тогтмол тайлан
- B. Тайлан баланс
- B. Бэлэн мөнгөний үрсгалын тайлан

2. Үйл ажиллагааны бус зардлууд нь:

- A. Санхүүжүүлэлт болон хөрөнгө оруулалтын үйл ажиллагаатай холбоотой зардлууд
- B. Ердийн бизнесийн үйл ажиллагаануудтай холбоотой зардлууд
- B. Санаандгүй гэнэтийн зардлууд

3. Компаний нийт хөрөнгийн бүтээмжээс өр төлбөрийн хасвал юу гарах вэ?

- A. Цэвэр ашиг
- B. Богино хугацааны өр
- B. Хувьцаа эзэмшигчдийн капитал

Харуултууд: 1. Т. В. 2. А, 3. С

Хэдийгээр сүүлийн жилүүдэд гарсан компаний олон скандалуудыг өндөр албан тушаалын гүйцэтгэх ажилтнууд зохион байгуулсан байдаг ч зарим сэжигтэй наймаануудыг луйварчин ажиллагсад хийчихээд хэтэрхий оройттол ахлах албан тушаалтнуудаасаа нууж чадсан байдаг.

Английн Барингс Банкны наймаачин Ник Лисон 1990-ээд оны эхээр тус банкны жилийн нийт орлогын 10 хувийг шамшигдуулсан байдаг. Дараа нь Азийн санхүүгийн хямрал эхэлж алдагдалд орж эхэлсэн байна. Лисон нууц дансанд 800 сая фунт стерлинг нууж чадсан байдаг. Түүний дарга нар нь 1995 онд явуулсан аудитын шалгалтаар нууц наймааг нь

илрүүлж эхэлсэн бөгөөд тэр үед уг банкны хөрөнгө болон ирээдүй нь аль хэдийнээ хүнд байдалд орчихсон байсан. Яваандаа хэрэг бишдэж Лисон шоронд орж Баринс банк худалдагдсан юм.

Лисонгийн хэрэг явдал сургамж болсоор байтал Францийн том банк болох Социати Женерал банкны бас нэгэн луйварчин ажилтан олон жилийн дараа буюу 2008 онд ижил төстэй хэрэг тарьсан байдаг. Жероме кевиелийн хэрэг 7 тэрбум фунт стерлинг хүрсэн байдаг.

Мөн онд Швейцарийн UBS AG банкны ажилтан Квеку Адоболи өөрийн наймааны алдагдлыг нууцалж эхэлсэн байдаг бөгөөд түүний учруулсан алдагдал 2011 онд 2 тэрбум доллар хүрч байжээ.

Адоболи залилан болон хуурамч бүртгэл тооцоо хийсэн хэрэгт орж төрийн кспертүүд уг банкны эрсдлийн менежмент хяналт тааруу болохыг тогтоож эхэлсэн байдаг. Тус банкны гүйцэтгэх захирал Освальд Грюебел хэлэхдээ USB банк тухайн салбартаа л хамгийн шилдэг эрсдлийн менежментийн нэгжтэй гэж эхэлж хэлээд удалгүй огцорсон бөгөөд тэдний банкны ажилтан зөвшөөрөлгүй наймаа хийж олон тэрбум долларын алдагдал учруулсанд үнэхээр гайхаж байсан гэдэг.

5. “Залиланг” хэрхэн илрүүлэх талаарх зөвлөмжүүд

Нягтлан бодох бүртгэлийн заль мэхүүдийг илрүүлэх нь сонирхогчдын хийдэг ажил биш хэдий ч ня-бо бүртгэлийн профессор Ховарл М. Шилит сэжигтэй заль мэхүүдийг илрүүлэхэд хялбархан болгох оролдлого хийсэн байдаг. “Санхүүгийн залилангууд” хэмээх түүний ном анх 1993 онд хэвлэгдсэн бөгөөд саяхан 2010 онд шинэчлэгдэн хэвлэгдсэн байдаг /энэхүү бүлгийн төгсгөлд байгаа эх сурвалжууд гэсэн хэсгийг үз/.

Зөвшөөрлийг авч байж ашигласан дараах диаграмууд нь санхүүгийн тайлангуудад заль мэх луйвар хаана байж болохыг харуулсан байна.

Хоёр диаграмуудын аль алиныг 2010 онд хэвлэсэн Ховард Шилит болон Жерми Перлер нарын “Санхүүгийн залилан-санхүүгийн тайлан дахь заль мэх луйвыг хэрхэн илрүүлэх вэ” номын гуравдах нийтлэлээс авсан болно.

Санхүүгийн залилан

Ашиг орлоготой холбоотой ов мэх

- Орлогыг хэт хурдан бүртгэх
- Хуурамч орлого бүртгэх
- Нэг удаагийн эсвэл тогтворгүй үйл ажиллагаануудыг ашиглан ашгийг өсгөх
- Өнөөгийн гарсан зардлуудыг хожуу үе рүү шилжүүлэх
- Зардлуудыг нуух бусад арга техникүүд ашиглах
- Өнөөгийн орлогыг хожуу үе рүү шилжүүлэх
- Ирээдүйд гарах зардлуудыг өмнөх үе рүү нь шилжүүлэх

Бэлэн мөнгөний урсгалтай холбоотой залилан

- Санхүүжилтийн бэлэн мөнгөний орох урсгалыг үйл ажиллагааны хэсэг рүү шилжүүлэх
- Ердийн үйл ажиллагааны бэлэн мөнгөний гарах урсгалыг хөрөнгө оруулалтын хэсэг рүү шилжүүлэх
- Худалдан авалтууд эсвэл зарцуулалтуудыг ашиглан үйл ажиллагааны бэлэн мөнгөний урсгалыг хөөрөгдөх /инфляц үүсгэх/
- Тогтворгүй үйл ажиллагаанууд ашиглан үйл ажиллагааны бэлэн мөнгөний урсгалыг ихэсгэх

Залиланг харуулдаг гол үзүүлэлтүүд

- Гүйцэтгэлийг илэрхий өсгөж төөрөгдөлд оруулхуйц үзүүлэлтүүд харуулах
- Уналт доройтлыг харуулхаас зайлсхийхийн тулд тайлан балансийн гуйвуулсан үзүүлэлтүүд гаргах

Анхааруулгын тэмдэгүүд:

Залилан хийх үндэс суурийг тавих

- Ахлах удирдлагынхан дотор шалгах тэнцвэржүүлэх ажиллагаа алдагдах
- Вол Стритын шинжээчдын тооцоолж байснаас байнга давж гарсан үзүүлэлтүүдтэй байх
- Компаний удирдлага, өмчлөл болон захирлуудын зөвлөлд нэг гэр бүл ноёрхох
- Хамааралтай талын гүйлгээнүүд хийгдэх
- Санхүүгийн тайлагналтыг идэвхтэй явуулахыг дэмжсэн зохисгүй нөхөн олговрын структуртай байх
- ТУЗ-ын гишүүдийг зохисгүй сонгох
- Компани болон ТУЗ-ийн гишүүдийн хоорондын зохисгүй харилцаа
- Чадвар муутай аудитын компаниар аудит хийлгэх
- Үнэн зөвөөр дүгнэх чадваргүй бие даасан байдалгүй аудитор авч ажиллуулах
- Компаний менежмент нь зохицуулах байгууллагын эсвэл эрх зүйн шинжилгээ судалгаанаас зайлсхийх оролдлого гаргах

Эх сурвалжууд БҮЛЭГ 6

Редакторын тэмдэглэл: 6-р бүлгийг бэлтгэх үүднээс дараах эх сурвалжуудыг ашигласан болно. Доорх вэб сайтүүдийн ихэнх нь аливаа уншигч чөлөөтэй нэвтрэх бололцоотой сайтүүд байгаа. Вол Стрит Журнал, Файнаншиал Таймз мэтийн тодорхой хэвлэлүүдийн өгүүлүүдийг уншихын тулд захиалга хийх шаардлага гарч болно. Нью Йорк Таймз сэтгүүл бол уншигч бүртээ сард тодорхой хэмжээний хязгаарлалт бүхий архивын материал үзэх боломж олгодог.

ӨГҮҮЛЛҮҮД БОЛОН ИЛТГЭЛҮҮД

Гайлез Брүүм, “2.3 тэрбум долларын алдагдалд орсныхоо дараа UBS банкны гүйцэтгэх захирал Грюебел огцорсон нь” Блүүмберг, 2011 оны 9 сарын 24.
<http://bloom.bg/HDZPmQ>

Лилиан Чью “Зөвхө ганц хүн биш: Хэрхэн Лисон Бариггз банкыг дампууруулсан тухай болон Лисоноос үүдсэн сургамж” хэмээх судалгаа, Олон улсын санхүүгийн эрсдлийн хүрээлэн.
<http://riskinstitute.ch/137550.htm>

Линдси Фортадо ба Бен Мошински, UBS банкны худалдаачин Адоболи луйверын хэрэгт холбогдсон нь, 2008 он хүртэлх ня-бо бүртгэл”, Блүүмберг, 2011 оны 9 сарын 17.

Ричард Лот, “Санхүүгийн тайлангийн талаар таны мэдэж байх ёстой 12 зүйлс” Инвестпедиа, 2011 оны 4 сарын 1. <http://bit.ly/ISLPUQ>

Ричард Лот, “Ашгийн тайлангийн талаарх ойлголт”, Инвестпедиа, 2011 оны 10 сарын 10.
<http://bit.ly/HRMANT>

Касси Мклин, “Сурвалжилж буй компанидаа болж буй асуудлыг илрүүлэх 10 зөвлөмж” Талкинг бизнес ньус, 2012 оны 3 сарын 18.
<http://bit.ly/HGol8e>

Megan Murphy and Haig Simonian, “Banking: Lightening Strikes Twice,” Financial Times, Oct. 2, 2011.
<http://on.ft.com/HGoBUP>

Брент Радклифф, “Компаний ашиг орлогын тайлангуудын нууцлалыг хэрхэн тайлах вэ”, Инвестпедиа, 2010 оны 11 сарын 19.
<http://bit.ly/HxlLg2>

Крис Рауш, Санхүүгийн тайлангуудын тухай ойлголт”, Сэтгүүлчийн ресурс сэтгүүл, Харвардын Шоренштайны Төв ба Карнеги Кнайт, 2011 оны 4 сарын 7.
<http://bit.ly/IEU0oo>

Жон Самуел, “Фортис Хэлзкэр компани хэрхэн төрийн асуудалтай хутгалдан Группынхээ дотоодын гүйлгээ хийснээс хойш хувьцааных нь үнэ 25% буурав”, Индиан Экономик Таймз сэтгүүл, 2011 оны 12 сарын 12. <http://bit.ly/HRMNAU>

Аня Шиффрин, “Энроны асуудал давтагдахаас зайлхийх нь” Коламбиа Журнализм Рювью сэтгүүл, 2002 он.

Лиза Смит, “Тайлан балансын гадуурх зүйлс: танилцуулга” Инвестпедиа, 2011 оны 1 сарын 14. <http://bit.ly/J8Dmtm>

Жил Треанор, Саймон Боуерс болон Сэм Жоунс, “Луйварчин Квеку Адоболи 2008 он хүртэл хийсэн хэрэгийнхээ төлөө ял сонслоо” Гуардиан, 2008 оны 9 сарын 17. <http://bit.ly/IFIPJD>

Жил Треанор, “наймааны тактик: Социати Женералын Жероме Кервейл болон UBS банкны Квеку Адоболи” Гуардиан, 2011 оны 9 сарын 15. <http://bit.ly/IEXJIF>

Жил Треанор, “UBS банк дотоод хяналт алдсанаа хүлээлээ”, Гуардиан, 2011 оны 10 сарын 25. <http://bit.ly/HxITML>

Рик Вэйман, Хөрөнгө оруулагчдад өгөх сануулга” Инвестпедиа, 2008 оны 2 сарын 22. <http://bit.ly/HJgwKF>

Рик Вэйман, “Санхүүгийн тайлангийн тайлбаруудаас хөрөнгө оруулагчийн шалгах зүйлсийн жагсаалт” Инвестпедиа, 2008 оны 2 сарын 22. <http://bit.ly/IFbjm>

“Компаний бэлэн мөнгөний урсгалын талаар мэдэх шаардлагатай чухал зүйлс” Интестпедиа,

2011 оны 3 сарын 14. <http://bit.ly/HRMANT>

Аризонагийн улсын их сургуулийн Бизнесийн сэтгүүл зүйн үндэсний төвийн Дональд В. Рэйнольдсын бэлтгэсэн Санхүүгийн тайлангийн талаарх үнэ төлбөргүй бие даасан курс. <http://bit.ly/HRNixk>

АНУ-ын үнэт цаасны солилцооны комиссын “Санхүүгийн тайлангийн талаарх эхлэн суралцагчдын зааварчилгаа”. <http://1.usa.gov/HEfOBP>

“Лисон хэрхэн банкыг дампууруулсан вэ?” Би Би Си Ньюс, 1999 оны 6 сарын 22. <http://bbc.in/NAKsqR>

“Си Эй Өү компаний тохиолдол төрийн өмчийн компаниудад зориулагдсан “гашуун эм”, Синхуа Ньюс Аженси, 2004 оны 12 сарын 20. <http://bit.ly/HRNiL1>

НОМУУД БОЛОН СУДАЛГААНЫ АЖЛУУД

Роберт А. Г. Монкс, Александра Рид Лажоукс, “Портфолио хөрөнгө оруулалтын талаарх компаний үнэлгээ”, Нью Йорк: Блүүмберг Пресс, 2011

2010 онд хэвлэсэн Ховард Шилит болон Жереми Перлер нарын “Санхүүгийн залилан-санхүүгийн тайлан дахь заль мэх луйврыг хэрхэн илрүүлэх вэ” номын гуравдах нийтлэл

Луйврын тухай өгүүлэл бичих талаарх зөвлөмжүүд

“Би таныг болон танай гэр бүлийг удаанаар тарчлан үхэхийг хүсч байна”

— *Италийн Пармалат Эс Пи Эй компаний санхүүгийн захирал асан Фаусто Тоннаг цагдаа нар шүүх рүү авч явж байх үед сэтгүүлчдэд хэлсэн үг.*

Хэвлэл мэдээллийнхэн олж илрүүлсэн скандалуудын үр дүнд карьер нь будаа болж шоронд орсон луйварчдаас сэтгүүлчид талархлын үг сонсоно гэж бараг байдаггүй.

Зарим гүйцэтгэх албан тушаалтан захирлууд сэтгүүлчдийг зах зээлд эсвэл хөрөнгө оруулагчдад үйлчлэх үүрэгтэй гэж үздэг. Ихэнх сэтгүүлчид өөрсдөө хэвлэл мэдээллийнхэн бол луйвар хулгайг хянаж байдаг хүмүүсийн бүлэг бөгөөд компаний хууль бус үйлдлийг оролцуулан компаний үйл ажиллагаануудыг илчлэн бичиж байх мэргэжлийн үүрэгтэй улс гэж үздэг.

КЖР сэтгүүлд зориулагдсан бизнесийн хэвлэл мэдээллийн тухай блог болох Аудит блогд Дин Старкман бичихдээ “өнөөгийн хямрал нь зээлийн санхүүжилтийн салбарт байгаа системтэй буруу үйлдлүүдийн талаарх анхаарал татсан, харанга дэлдсэн, луйврыг илчилсэн, хөрөнгө оруулагчид илэрхий мэдэхгүй байгаа чухал үрт хугацааны анхаарах зүйлсийг нь хэлж өгсөн тийм нийтлэлүүдийн жишээг харуулсаар байна” гэжээ.

Компаний засаглалын асуудлууд хэрхэн энэхүү хянагчийн үүрэг хариуцлагатай нийцэж байна вэ? Хариулт нь юу вэ гэвэл ихэнхдээ компаний засаглалын зарчмуудыг үл ойшоосон байдал нь компаниуд дээр буруу үйл явдлууд явагдах үндэс суурь нь болоод байна. Скандалууд гараад ирэхээр хөрөнгө оруулагчид болон зохицуулах байгууллагууд нэн даруй “ТУЗ нь хаачсан юм вэ?” гэсэн нэг л гол асуулт асууцгааж эхэлдэг.

Японы камер болон дурангийн үйлдвэрлэгч Олимпс Корпорацид 2011 онд болсон цуврал үйл явдлууд нь тус компаний Англи гүйцэтгэх захирал болон түүний Япон ТУЗ-ийн хоорондын соёлын зөрчлөөс эхэлсэн

юм шиг байдаг. Үгүйдээ л гүйцэтгэх захирал Майкль Вүүдвардыг хөөн зайлуулах болсон шалтгаанаа Олимпсусын ТУЗ-ийн захирал Цүёоши Кикүкава тийнхүү тайлбарласан байдаг юм билээ.

Ихээхэн хэмжээний алдагдлуудыг нуун дарагдуулах зорилго бүхий цуврал сэжигтэй гүйлгээнүүдийн төлөө хүлээх хариуцлагыг ТУЗ болон өмнөх гүйцэтгэх захиралд ноогдуулах оролдлого Вүүдвард гаргасан нь түүний халагдах болсон жинхэнэ шалтгаан болохыг хэдийгээр Вүүдвардаас мэдээлэл авсан ч гэсэн сэтгүүлчид урд өмнө нь олж тогтоосон байдаг. Хувьцаа эзэмшигчид зарга мэдүүлж зохицуулах байгууллага шалгалт хийн Кикүкава ТУЗ-ийн даргын үүрэгт ажлаа өгөхөд хүрсэн нь ТУЗ-ийн хэлж байсанчлан Англи гүйцэтгэх захирал болон Япон ТУЗ-ын хоорондын соёлын зөрчил биш харин Олимпс компаний ТУЗ-ийн буруутай үйлдлүүд олны анхаарлын төвд орж ирсэн байдаг.

Компаний засаглалын зөрчлийг хэрхэн илрүүлэх вэ?

Гүйцэтгэх захирал ажлаасаа гэнэт хөөгдсөн, ТУЗ-ийн дарга “тэтгэвэрт гарсан” эсвэл гэнэтхэн стратегийн өөрчлөлт хийх болсон зэрэг ноцтой мэдээний ард нуугдаж буй компаний засаглалын асуудлуудыг сэтгүүлчид хэрхэн илрүүлэх вэ?

Ихэвчлэн тийм үйл явдлууд нь гол худалдан авалт хийх, өргөтгөл хийх эсвэл уналтанд орох зэрэг тухайн компанид томоохон өөрчлөлт хийх үетэй нэг цаг үед тохиолддог. 5 болон 6-р бүлгүүдэд дурьдсан зохицуулалтын болон санхүүгийн асуудлуудаас гадна дараах зарим бусад боломжит асуудлууд байж болно. Үүнд:

Сэтгүүлчид заримдаа бизнесийн талаар өдөр тутмын аар саар зүйлд хэт автаж хүмүүс болон тэдгээрийн харилцааны талаарх хамгийн сайн өгүүлүүд бичихээ мартаж орхих нь бий.

- Компаниудыг худалдан авах эсвэл өөрөө худалдагдах гэж байгаа тухайгаа зарлах
- Салбарууд, брэндүүд эсвэл байгууламжуудаа худалдах
- ТУЗ-ын захирлууд өөр компанийн ТУЗ-д орох, компаниас гарах эсвэл хувьцаагаа зарах алхмууд
- Хувьцаа эзэмшигч хувь хүн эсвэл байгууллагууд компанийн бодлого, практикуудын талаар

шүүмжлэлтэй хандах анхмууд хийх

Гүйцэтгэх захирлын хувь хүний шинж чанартай холбоотой асуудлууд, ТУЗ болон компаний удирдлагын хоорондын зөрчил, зохицуулах байгууллага болон компаний албан тушаалтнуудыг хооронд эсвэл ажиллагсад ба удирдлагын хооронд үл тохиролцох зүйлс гарах болон хувьцаа эзэмшигчдийн дэмжигчид санаа зовж эхлэх зэрэг нь олны анхаарлыг ихээхэн татаж ноцтой мэдээ байж болох боломжтой байдаг.

Компаний засаглалын талаарх өгүүллээ сэтгүүлийн эхний нүүрэн дээр тавих нь

Үйл явдлыг ухан мэдээлэл олж авахаас гадна өгүүллээ редакторт “борлуулж” тухайн өгүүлэл олны өмнө ил тавигдах ёстой гэж редакторыг сэнхрүүлж чадах нь бас сурвалжлагч нарын хийх ёстой ажил байдаг.

Эцэст нь таны чулуудсан өгүүлэл үнэхээр чухал мэдээлэл байх ёстой.

Ихэнх сэтгүүлчид дараах найман элементүүд редакторуудын анхаарлыг татах, түүнээс ч чухал нь уншигчдыг байлдан дагуулахад чухал гэж үздэг.Үүнд:

Нэн даруй мэдээлж байх: ТУЗ-ийн шийдвэр эсвэл компаний үйлдэл өнөөдөр гарсан уу эсвэл гарах хуваарьтай байгаа юу гэдгийг хойшлуулалгүй нэн даруй мэдээлэх

Уншигчдад ойр дотно байх: Тухайн компаний засаглалын асуудал хэрхэн тухайн олон нийт, бүс нутаг эсвэл улс оронд нөлөөлөх вэ? Хэрэв тухайн улс оронд компаниудын засаглал ерөнхийдөө тааруу байдаг бол эдийн засаг нь урт хугацаанд тогтвортойгоор өсч чадах уу?

Алдар хүндтэй байдал: Тухайн ТУЗ-ийн дарга эсвэл гүйцэтгэх захирал, ТУЗ-ийн гишүүнийг олон түмэн сайн мэддэг үү?

Хачирхалтай байдал: Тухайн компаний гол

бизнес нь компьютерын үйлдвэрлэл байхад ТУЗ нь наранд шарлагын газартай амралтын газар худалдан авах шийдвэр гаргасан уу?

Зөрчил: ТУЗ-ын гишүүд, хөрөнгө оруулагчид, бусад хувьцаа эзэмшигчид, засгийн газар эсвэл ахлах менежментийн дунд санал зөрөлдөөнтэй асуудлууд байгаа юу?

Тодорхой бус байдал: жишээлбэл, бизнесээ явуулхын тулд шинэ зээлүүд авах нь санхүүгийн хувьд зөв зүйтэй болохыг компани харуулан нотлох тодорхой хугацаа зааж өгсөн үү?

Мэдрэмж, сэтгэл хөдлөл: мэдээллийн энэхүү элементийг хүний сонирхол гэж нийтлэгээр нэрлэдэг бөгөөд хүний сэтгэл зүйн болон биет суурь хэрэгцээг хүлээн зөвшөөрч байгааг хөндсөн өгүүлүүд багтана.

Үр дагавар: хэрэв ашиг сонирхлын зөрчил нь ТУЗ болон ахлах менежментийг муу шийдвэр гаргахад хүргэсэн бол тухайн компани бизнесээ үргэлжлүүлэн явуулж чадах уу? Хөрөнгө оруулагчид болон зах зээл нь тийм ашиг сонирхлын зөрчлүүдийн талаар хангалттай мэдээлэл авч чадсан уу? Үр дагавруудыг нь тэд компаний хувьцааны үнэ цэнээр нөхөхөөр тооцсон үү??

— Эх сурвалж: “Тоонуудын цаана байгаа бизнесийн талаар мэдээлэх нь: Компаний засаглал дах сайн, муу болон үзэшгүй муухай зүйлсийг олж тогтоох тухай” Компаний засаглалын глобал форум <http://bit.ly/I9LEmZ>

Хамгийн зөв эх сурвалжуудаа хэрхэн олох вэ?

Компаний засаглалын асуудлаар бичдэг олон сэтгүүлчид аливаа асуудлуудын талаар тэдэнд мэдээлэл өгч компаниудын үйл явдлуудын талаарх санаа оноогоо өгөх хүсэлтэй байдаг мэргэжилтнүүдэд бараалхагддаг. Тийм мэргэжилтнүүдэд компаний засаглалын талаар судалгаа шинжилгээ хийдэг байгууллагуудын мэргэжилтнүүд, уг сэдвээр голчлон судалдаг эрдэмтэд болон томоохон бизнесийн чиглэлийн сургуулиудын компаний засаглалын хүрээлэнгүүдийн гишүүд багтдаг. /Хавсралтанд өгөгдсөн эх сурвалжууд гэсэн хэсгээс харилцах хаяг болон вэб сайтуудыг нь үзэж болно/.

Их сургуулиудын компаний засаглалын хөтөлбөрүүдэд хамрагдсан тэнхимүүд болон эрдэм шинжилгээний ажилтнуудын явуулсан эрдэм шинжилгээний судалгаанууд нь өгүүлэл бичих ашигтай зөвлөмжүүд болон маш сайн санаа өгч болно. Цөөхнийг нэрлэхэд Мексикийн ТВ Азтека, Энэтхэгийн Сатям Компьютер Системс Лимитэд, Италийн Пармалат Эс Пи Эй болон АНУ-ын Энрон корпорац мэтийн компаниудад болсон үйл явдлуудыг судалсан олон тооны эрдэм шинжилгээ судалгааны ажлуудын талаар энэхүү Зааварчилгаанд иш татсан байгаа /Энэхүү хэсгийн төгсгөлд байгаа эх сурвалжуудын хэсэг болон Сонгон авсан эх сурвалжууд хэмээх хавсралтыг үзнэ үү/.

Зөвхөн Харвардын их сургуулийн компаний засаглалын талаарх вэб хуудсанд байдаг ажлын баримт бичгүүдэд 2011 оны эцсээр авч үзсэн сэдвүүд л гэхэд бусад зүйлсээс гадна нэмэлт цалин олгоход гаргасан зардлыг татвар өсгөх замаар нөхсөн хэрэг явдлууд, цөмийн эрчим хүчний станцуудын эрсдэл үүрэх чадвар болон алмайруулсан ТУЗ-үүдийн талаарх сонирхолтой судалгаанууд багтсан байдаг.

5 ба 6-р бүлгүүдэд тайлбарласанчлан ня-бо бүртгэлийн тайлангуудын зүүлт тайлбарууд, хавсралтууд болон ерөнхий тайлбарууд болон зохицуулах байгууллагад бүртгэгдсэн файлуудын нарийн ширийн зүйлсийг хичээнгүйлэн судлах нь компаниудын талаар ноцтой мэдээлэл бичих гол арга зам болдог.

Компаниудын гадна дотно талын бусад эх сурвалжууд ч мөн чухал. Олон компаний дунд шатны менежментийн ажилтнууд, ялангуяа санхүүгийн хэлтсийн ажилтнууд, ихэнхдээ их тус дэм болж

чаддаг талтай. Ихэвчлэн маш чухал үйл явдлыг илрүүлэх арга зам болдог матаачид, мэдээлэгчдийн юу ярихыг сонсохдоо сэтгүүлч бүр дуртай байдаг. Гэхдээ матаачдаас мэдээлэл авах нь сул талтай байдаг учир нь тэдгээр нь хувийн өшөө хонзон авах сонирхолтой ч юмуу заримдаа компаний үйл ажиллагаануудын талаарх үзэл бодол нь хязгаарлагдмал, баримтуудыг нарийн сайн шалгаж нотлоогүй байдалтай байх нь бий.

Портфолио менежерүүд, хөрөнгө оруулагчид болон шинжээчид ч мөн мэдээллийн маш сайн эх сурвалжууд болж чадна. Хэдж-сангийн буюу ирээдүйд оруулах хөрөнгө оруулалтын сангийн менежерүүд болон борлуулагчид нь бизнесийн чиглэлээр сурвалжлага хийдэг дундаж түвшингийн сурвалжлагчид олж тогтоож чадахааргүй нарийн төвөгтэй санхүүгийн маневрууд болон ня-бо бүртгэлийн практикуудын тадаар ойлголт өгөхөд тус болдог.

Үйлдвэрчний эвлэлийн тэргүүн лидерүүд, боловсон хүчний зөвлөхүүд, компаний нөхөн төлбөрийн мэргэжилтнүүд болон боловсон хүчин олж авахад зуучилдаг пүүсүүд мөн зөвлөмж экспертизээр туслах боломжтой байдаг.

Хуйвалдаануудыг олж тогтоох нь

Сэтгүүлчид заримдаа бизнесийн талаар өдөр тутмын аар саар зүйлд хэт автаж хүмүүс болон тэдгээрийн харилцааны талаарх хамгийн сайн өгүүлүүд бичихээ мартаж орхих нь бий.

4-р бүлэгт дэлгэрэнгүй дурьдсан гэр бүлийн хэрүүл маргаан өш хонзонгоос үзэхэд компаний засаглалын олон түүхүүд ах дүү нар нэг нэгнийхээ эсрэг, дагавар хүүхдүүд нь хойд авгай нартай нь тэмцэх, үе залгамжлагчид болон ирээдүйн үе залгамжлагчдын хооронд болсон тэмцлүүдтэй холбоотой байдаг.

Шүүхийн файлуудад нэвтрэх нь тийм түүхүүдийг олж тогтоох нэг арга зам байдаг бөгөөд заримдаа сэтгүүлчдэд гэр бүлийн харилцаануудын талаар гүн гүнзгий мэдээлэл олж авах боломж олгодог. Макаугийн мөрийтэй тоглоомын хаан Станли Хогийн хэдэн авгай нар болон хүүхдүүд нь түүний эзэнт улсыг өмчлөхын тулд шүүх дээр тэмцэлдсэн байдаг бөгөөд энэхүү гунигт түүхийн талаар нэлээд дэлгэрэнгүй нарийн ширийн зүйлсийг шүүхийн файлуудаас мэдэж болдог байна.

Мэргэжлийн этгээд хэллэгээс зайлсхийх

Тоонууд, этгээд мэргэжлийн хэллэгүүдээр дүүрэн авцалдаагүй өгүүлбэрүүдтэй бизнесийн чиглэлийн өгүүлүүд уншигчдыг төөрөгдөлд оруулдаг. Мэргэжлийн этгээд хэллэг хэрэглэхээс зайлсхийх нэг арга бол нэр томъёонуудын тодорхойлолтуудыг өгөх явдал юм. Заримдаа техникийн хэллэг хэрэглэхгүй байх боломжгүй байдаг. “Collateralized debt obligations (CDOs)” барьцаат өр төлөх үүргүүд гэдэг хэллэг нь төлбөрийн чадвар тааруу зээлдэгчдэд өгсөн өндөр хүүтэй моргижийн зээлээс үүдэлтэй эдийн засгийн хямралын үед ихээхэн түгээмэл хэрэглэгдэх болсон үгс юм. Нью Йорк Таймс сэтгүүл маш товч бөгөөд тодорхой тайлбарласан байдаг: “Барьцаат зээл төлөх үүргүүд гэдэг нь бонд мэтийн бусдаар ямарч холбоо хамааралгүй зээлийн хэрэгслүүдийг нэгтгэн фонд болгоод тэр фондынхоо хувьцааг хөрөнгө оруулагчдад худалдах замаар банкууд бий болгосон зүйл юм”.

Аливаа өгүүлэл бичихдээ үндэслэлийг нь судлаад, тухайн салбарын мэргэжилтнүүдээс асууж лавлаж байгаад маш тодорхой өгүүлэл бичвэл уншигчдын анхаарлыг татаж чадах болно.

- Эхний дүрэм: та юун тухай бичиж байгаагаа маш сайн ойлгож байх хэрэгтэй
- Өөрийнхөө мэдэж байгаагаас илүү зүйл мэдэж байгаа юм шиг дүр эсгэн “залилах” гэж оролдох хэрэггүй
- Өгүүлбэрүүд, цэг таслал, цэгтэй таслалуудын тоог тоолох хэрэгтэй. Хялбар болгох замаар бичилтээ оновчтой болгохыг хичээх хэрэгтэй.

Тухайн үйл явдлыг маш сайн мэдэж байгаа сэтгүүлч маш тодорхой бөгөөд уншигчдын хамгийн их сонирхсон зүйлсэд түлхүү анхаарч чадсан өгүүлэл бичих боломж илүүтэй байдаг.

Редакторт өгөх зөвлөмжүүд

Бизнесийн чиглэлээрх байнга бичдэг өгүүлүүддээ компаний засаглалын чухал асуудлуудыг олж тогтоож сурахад нь сурвалжлагч нарт редакторууд туслаж чадна.

Ердийн бизнесийн үйл явдлуудын цаана байгаа асуудлуудыг шаламгай олж тогтоодог байх хэрэгтэй. Тэдгээр нь ихэвчлэн компаний засаглалын илүү гүн гүнзгий асуудлуудаас урган гарсан байдаг. /Эдгээр сэдвүүдийг энэхүү Зааварчилгааны өмнөх бүлгүүдэд илүү дэлгэрэнгүй авч үзсэн билээ/.

- Өндөр албан тушаалын гүйцэтгэх ажилтнууд эсвэл ТУЗ-ийн гишүүдийг томилох, халах
- Компаний өмчлөлд ихээхэн өөрчлөлт орох /хувьцаа гаргалт, буцааж хувьцаагаа худалдан авалт, хөрөнгө оруулагч байгууллагуудыг оролцуулан томоохон өмчлөгчид; хувьцааны ангилалууд болон өмчлөлийн бүтэц эсвэл хуваарилалтын бусад өөрчлөлтүүд; компаниудын нэгдэлт худалдан авалт; тархсан өмчлөл дэх гэр бүлийн өмчлөл эсвэл хувьчлалт/
- Өндөр албан тушаалтнуудын эсвэл ТУЗ-ийн гишүүдийн цалин урамшуулал, нөхөн олговорт орсон өөрчлөлтүүд

- Тухайн компанийг сайн удирдаж байгааг харуулсан эсвэл ня-бо бүртгэл эсвэл санхүүгийн тайлагналтын скандалуудыг илчилсэн ашиг орлого гүйцэтгэлийн ер бусын хөдөлгөөнүүд
- Шинэ зах зээлд нэвтрэх эсвэл шинэ бүтээгдэхүүний шугам нэвтрүүлэх мэтээр компаний стратегийн шинэ чиглэл бий болох
- Компанийг хэрхэн хүнд байдлаас гаргах вэ гэдэг талаар менежмент болон ТУЗ-ийн хоорондох зөрчлүүдийг хурцатгасан уналт эсвэл ноцтой асуудлууд тулгарсан
- Компаний хөрөнгийг хулгайлсан, буруугаар ашиглан шамшигдуулсан эсвэл хээл хахуулийн асуудлууд
- Хувьцаа эзэмшигчид нь ТУЗ болон компаний менежменттэй зөрчилдсөн
- Бусад зүйлсээс гадна байгаль орчин, ажлын байр, нийтийн эрүүл мэндийн асуудлуудаар орон нутгийн олон нийтийн лидерүүд, сонирхогч бүлгүүд, үйлдвэрлэгчид эсвэл хөдөлмөрчидтэй хэл амаа ололцохгүй байдал үүссэн
- Хөрөнгийн биржид бүртгүүлэх журамд гарсан өөрчлөлтүүд. Юунаас үүдсэн яагаад?

Бараг бүх бизнесийн чиглэлийн өгүүллийн хэвлэн нийтэлсэн эсвэл вэб сайт дээр тавьсан хувилбараас гадна видео, аудио материал ашиглан сайжруулж болдог. Бизнесийн чиглэлийн сурвалжлагчийн хувьд нэгдүгээр асуулт нь: видео клип, тайлбар текст бүхий гэрэл зураг эсвэл цуврал гэрэл зургууд эсвэл аудио бичлэг зэрэг мэдээллийн хэрэгслийн ямараар нь өгүүлэл чинь хамгийн сайн борлогдох вэ?



Өгүүллийнхээ форматыг хэрхэн сонгох вэ?

Компаний засаглалын талаарх өгүүлүүд бичих тодорхой томъёолол байхгүй. Тэдгээр нь ихэнхдээ хувь хүний шинж чанарын зөрчил, эрх мэдлийн төлөө тэмцэл, шунал, айдас, нийгэмд эзлэх байр суурь эрх мэдэлтэй холбоотой хүмүүсийн драма байдаг. Тухайн өгүүллийн шинж чанар нь мэдээ, бүрэн хэмжээний өгүүлэл, мэдээ-бүрэн хэмжээний өгүүлэл, профиль, сурвалжлага гэх мэт ямар форматтай байхыг хэлээд өгнө.

Форматыг сонгохдоо өөрөөсөө гурван асуулт асуух хэрэгтэй:

- Уг үйл явдлыг яаж өгүүлвэл уншигчдын сонирхлыг төрүүлж өөртөө татаж чадах хамгийн сайн арга зам байхаар байна вэ?
- Тухайн өгүүллийн материалд ямар формат илүү зохимжтой вэ?
- Яагаад уншигч уг өгүүллийг сонирхох ёстой юм?

Янз бүрийн өгүүллийн хэлбэрүүдийн зарим ерөнхий тодорхойлолтуудыг доор дурьдав. Үүнд:

Мэдээ

Хэрэв тухайн өгүүлэл нь болж өнгөрсөн эсвэл болох гэж буй ямар нэгэн зүйлийн талаар урьд өмнө нь сурвалжилж мэдээлэж байгаагүй шинэ

мэдээнүүд байвал уламжлалт мэдээний формат илүү тохиромжтой. Тухайн мэдээ нь уншигчдад хамгийн чухал мэдээллийг юуны өмнө өгөөд бусад мэдээллийг хөмөрсөн пирамид байдлаар доош нь цувуулан өгүүлсэн байна.

Бизнесийн чиглэлийн өгүүлэлд эхлээд хэлэх гол тоонуудыг маш болгоомжтой сонгох хэрэгтэй бөгөөд эхний өгүүлбэрт хэт олон тоонууд оруулахаас зайлсхийх нь чухал. *Жишээлбэл, компаний гол гүйцэтгэх ажилтан ажлаас гарсан буюу түүнийг халсан тухай өгүүлээд, дараа нь гол худалдан авалтууд эсвэл бизнесийн шугамыг зарсан тухай болон хувьцаа эзэмшигчдийн санаачлагуудын талаар өгүүлэх нь зүйтэй.*

Бүрэн хэмжээний өгүүлэл

Нэг их хүчтэй цаг хугацааны элемент байхгүй, ерөнхий сэдэвтэй, мэдээ болгон хүргэж буй өгүүллийг тодорхой өнцгөөс харуулсан тийм өгүүллийг бүрэн хэмжээний өгүүлэл гэнэ. Жишээлбэл, Хюлет Пакард компани гүйцэтгэх захирлаа халснаас хойш хэдхэн хоногийн дараа гарсан уг компаний ТУЗ-ын тухай өгүүлэл байдаг. *Жишээлбэл, компаний стратеги чиглэлд гарсан өөрчлөлтүүд, гүйцэтгэх захирлыг орлож болох хүний тухай, ялангуяа гэр бүлийн бизнесийн хувьд өв залгамжлахтай холбоотой асуудлууд байж болно.*

Мэдээ-бүрэн хэмжээний өгүүлэл

Зарим өгүүлэлүүд нь мэдээнүүд болон бүрэн хэмжээний өгүүллийн хоорондох завсарт багтаж

болно. Сэдэв нь өнөөгийн үйл явдал эсвэл мэдээнд багтаж буй хүний тухай байж болох боловч өгүүлэл нь илүү өргөн цар хүрээтэй бөгөөд тухайн өгүүлэлд багтааж болох тайзны цаадах нарийн ширийн зүйлсийг түлхүү оруулсан байж болно. *Жишээлбэл, Шинэ захирлууд нь хэрхэн компаний бодлого болон шийдвэр гаргалтанд нөлөөлсөн тухай; ня-бо бүртгэлийн скандалууд эсвэл хувьцааны үнийн уналтын дараа компани хэрхэн эргэн сэргэж хөл дээрээ босч байгаа тухай байж болно.*

Профиль

Профиль буюу богино хэмжээний намтарчилсан өгүүлэл нь нэг хүний тухай голчлон өгүүлэх бөгөөд тухайн хүний иж бүрэн намтар төрхийг гаргахыг оролддог. Энэ нь тухайн хүнтэй хийсэн ярилцлагад тулгуурласан байж болох боловч хамран ажиллагсад, гэр бүл, найз нөхөд, бүр өрсөлдөгчид зэрэг бусад эх сурвалжуудыг мөн оруулсан байна. Профиль нь мөн тодорхой бизнес буюу компанид төвлөрсөн байж болох бөгөөд тухайн компаний хувьд ямар нэгэн ялгаатай мэдээлэх шаардлагатай гэж үзэхүйц зүйл байвал тийнхүү оруулж болно. *Жишээлбэл, гэр бүлийн бизнесийн залуу гишүүдийн тухай; компаний бодлого чиглэлийг шүүмжилж байгаа томоохон хувьцаа эзэмшигчийн тухай ч байж болно.*

Мөрдөн сурвалжлах сэтгүүл зүй

Мөрдөн сурвалжилсан сурвалжлага нь мэдээ болон бүрэн хэмжээний өгүүллийн аль алиных нь элементүүдийг агуулсан байдаг бөгөөд аль ч хэлбэрээр үр ашигтайгаар бичиж болдог. Мөрдөн сурвалжилсан сурвалжлага гэж тооцохын тулд тухайн өгүүлэл нь ямар нэгэн буруу зүйлийг илрүүлэн анх удаа нийтэд мэдээллэж байх ёстой. Энэ нь мэдээ эсвэл бүрэн хэмжээний өгүүлээс илүү урт байх бөгөөд олон хоногийн үйл явдлуудын цувралуудыг танилцуулсан гол текстэндээ нэмэлт болж өгөхүйц хүрээлсэн хэлбэртэй тайлбаруудтай байж болно. Тийм тайлбарууд нь гол текстээсээ жижигхэн байх бөгөөд тус бүр нь тухайн текстэнд орсон дэд-сэдэвүүдэд чиглэсэн илүү дэлгэрэнгүй эсвэл суурь мэдээлэл өгч байдаг.

Жишээлбэл, компаний тухай дэлгэрэнгүй өгүүлэл нь сэжиг бүхий эсвэл хууль бус маневруудыг илчилсэн шинжтэй байвал сурвалжлага гэж үзэж болно. Нэг сайн жишээ бол Глоб энд Мэйлсийн бичсэн Хятадын ойн аж ахуйн корпорацийн Хятадад эзэмшдэг мод бэлтгэх аж ахуйн талаарх өгүүллийг уншиж болно /бүлэг 5/.

Үзэл бодлоо илэрхийлэх багана

Сэтгүүлчид тухайн компаний стратегийн талаар асууж менежмент болон ТУЗ-ийг нь шүүмжилж болдог бөгөөд шууд баримттай мэдээнүүдээс илүү нөмөр нөөлөгтэй вэбсайтны баганануудаар үзэл бодлоо илэрхийлдэг байна. India's Livemint.com вэбсайт дээрх энэхүү багананд Тамал Бандедапхия хэмээх сэтгүүлч Ражастхам Банкны хяналтын алдах дарамтанд ороод байгаа Правал Кумар Таяалын албан тушаалын талаар асуултууд хэрхэн асууж чадсаныг анзааран харж болно. <http://bit.ly/19LOuC>

Өгүүллийн бүтцийг найруулахдаа эдгээр хэрэгслүүдийг ашиглаж болно

Компаний засаглалын талаарх өгүүлүүд бичихдээ нарийн төвөгтэй мэдээллийг илүү жижигхэн хэсгүүдэд залдах нь уншигчдад илүү аятайхан байдаг.

Жагсаах арга техник

Ихэнхдээ төсвийн талаарх өгүүлүүдэд ашиглагддаг энэхүү аргыг мөн гол үйл явдлуудын тойм эсвэл чухал зүйлсийг харуулахад ашиглаж болдог. Энэхүү арга нь уламжлалт мэдээний эхний өгүүлбэрээр эхлэн араас нь нэмэлт мэдээллийн цөөн хэдэн параграфууд яваад ардаас нь туслах мэдээллүүдийг жагсаадаг.

Тик ток

Энэхүү хар ярианы нэр томъёо нь /тик ток гэдэг нь цаган дээрх минут секундын зүүний гаргах дууг хэлсэн хэрэг/ мэдээллийн гол гол үйл явдлууд гол тоглогчдын үзэж буйгаар хэрхэн өрнөсөн болох ул мөрийг хронологийн буюу цаг хугацааны дарааллаар харуулдаг.

Хэсгүүдэд хуваах арга техник

Энэ нь өгүүллийг номын бүлгүүд мэт хэд хэдэн хэсгүүдэд хуваан уншигчдын анхаарлыг янз бүрийн гол зүйлсэд хандуулахад тусладаг визуал хэрэгсэл юм. Эдгээр хэсгүүд нь том цэг эсвэл том үсэг эсвэл дэд бүлэг/ гарчиг/ мэтийн график хэрэгслүүдээр тусгаарлагддаг.

Болл Стрит Журналын формула

Энэхүү арга техникийг түүнийг анх боловсруулан сайжруулсан сонин газрын нэрээр нэрлэсэн бөгөөд ихэвчлэн бүрэн хэмжээний өгүүлүүд болон мэдээ-бүрэн хэмжээний өгүүлүүд бичихэд ашиглагддаг. Энэ нь тухайн хүн, үйл явдал болсон газар эсвэл



СУРВАЛЖЛАГЧИЙН ТЭМДЭГЛЭЛИЙН ДЭВТЭР

Нэг хэсэг сэтгүүлчид зөвлөмж туслалцаа авахын тулд шинжээчдэд ихээхэн найдлага тавьдаг байсан. Гэхдээ Энрон корпорац

будаа болсноос хойш тэр үе өөрчлөгдсөн. Ихэнх шинжээчид Энроны талаар шүүмжлэлтэй хандаагүй бөгөөд бүр сэтгэл нь ч хөдлөөгүй гэхэд болно. Шинжээчдийн олон компаниуд Энронтой гэрээтэй ажиллаж төлбөр авдаг байсан нь мэдэгдсэн. Тийм шинжээчид бие дааж ажиллах боломжгүй бөгөөд эерэг мэдээлэл өгөх хандлагатай байдаг.

“Энроны илчлэгдээгүй түүхийг илрүүлсэн нь “ хэмээх КЖР сэтгүүлд 2002 онд гарсан өгүүлэлдээ Нью Йорк Таймсын сэтгүүлч Гретчен Моргенсон “Бизнесийн чиглэлээр бичдэг сурвалжлагчид одоо шинжээчдийн үгийг иш татах хэрэггүй болсон байх” гэжээ.

Тэрээр цаашаа бичихдээ “ хэрэв тэд цаашид иш

татвал наад зах нь тухайн шинжээчийн фирмийн нэр болон тухайн яригдаж буй компанитай ямар харьцаатайг нь ядаж тодорхой бичих шаардлагатай” гэжээ.

2012 онд Моргенсон бичихдээ “ялангуяа том хөрөнгө оруулалтын банкнуудын олон шинжээчид хөрөнгө оруулагчдаас хөрөнгө босгох, өөр компанитай нэгдэх худалдан авах зэрэг асуудлуудаар зөвлөлгөө авдаг байсан бизнесийн харилцаатай компаниудын талаар эерэг зүйлс бичигдээдэг нь тодорхой болсон. Энэхүү зөрчилтэй байр суурь нь интернетийн компаниуд цэцэглэн хөгжсөнөөс хойш олны анхааралд хүрэх болсон бөгөөд шинжээчдийн ажлуудад хийсэн шалгалтаар хөрөнгө оруулагчдад тухайн шинжээчид өөрсдөө зөвлөж байсан компаниудаа ч басамжлан доромжилсон дотоод имэйлүүд шидэлцэж байсан нь илэрсэн байдаг” гэжээ.

Бизнесийн чиглэлээр бичдэг сурвалжлагчдын ёс зүйн асуудлууд нь улс төр, спорт болон аливаа бусад чиглэлээр бичдэг сурвалжлагчдынхаас ялгаатай зүйл бараг байхгүй боловч зарим онцгой асуудлууд байдаг бөгөөд ашиг сонирхолын зөрчлүүд үүсэх боломж магадгүй илүү өндөр байдаг байж болно.

үйл явдлыг харуулсан гарчигаар эхэлдэг. Өгүүлэл нь онцгой зүйлээс эхлэн дараа нь ерөнхий зүйл рүү үргэлжилдэг. Гуравдах эсвэл дөрөвдөх параграфтаа тухайн өгүүллийн гол сэдвийг илэрхийлсэн тусгай үсгээр бичсэн параграфтай байна.

Малтимедиа ашиглан өгүүллэгээ сайжруулах нь

Бараг бүх бизнесийн чиглэлийн өгүүллийн хэвлэн нийтэлсэн эсвэл вэб сайт дээр тавьсан хувилбараас гадна видео, аудио материал ашиглан хүний дуу дүрс нэмж сайжруулж болдог. Бизнесийн чиглэлийн сурвалжлагчийн хувьд нэгдүгээр асуулт нь: видео клип, тайлбар текст бүхий гэрэл зураг эсвэл цуврал

гэрэл зургууд эсвэл аудио бичлэг зэрэг мэдээллийн хэрэгслийн ямараар нь өгүүлэл чинь хамгийн сайн борлогдох вэ?

Шийдвэр нь тухайн өгүүлэлд оруулчихаар ямар визуал материал бэлэн байгаагаас хамаарна. Сурвалжилж буй хүнтэйгээ хийсэн ярилцлагыг камераар аван видео болгож болно. Эсвэл аудио интервью байдлаар бичлэг хийгээд вэб сайтаас хүмүүс татаж аваад компьютерээр эсвэл MP3 плэйр ашиглан сонсох бололцтой болгож болно. Аудио тайлбартай цуврал гэрэл зурагнуудыг слайдшоу байдлаар оруулж өгөх нь нарийн төвөгтэй технологиудыг тайлбарлахад хялбар болгодог талтай.

Олон мэдээний өрөөнүүд одоо үед өөрийн гэсэн

ӨГҮҮЛЭЛ БИЧИХ АРГА ХЭРЭГСЭЛ

Өгүүлэл бичих санааг хаанаас олж авч болох вэ?

Нийгмийн мэдээллийн хэрэгсэл нь байнга санхүүгийн блогуудыг шалгаж, “Tweets” болон Фэйсбүүк мэтийн нийгмийн сүлжээнүүдийг үзэж байдаг сэтгүүлчдэд хамгийн сайн эх сурвалж болж өгдөг.

Ройтерд зориулагдсан Феликс Салмоны санхүүгийн блог болох “Хийжүүлсэн ундаа дахь лимоны хэрчим” нэртэй блог нь компаний үйл явдлууд болон менежментийн өөрчлөлтүүдийн талаарх ноцтой мэдээнүүд байнга гаргадаг.

<http://blogs.reuters.com/felix-salmon/>

Зеро Хэдж хэмээх бас нэг блог нь өдөр тутмын гол сэтгүүл зүйд хамаарахгүй ч бусад сэтгүүлчдэд санаа авах сайн эх үүсвэр болохуйц заримдаа таагдашгүй санхүүгийн асуудлууд руу сэтгүүлчдийн анхаардлыг гүн хандуулдаг блог юм.

<http://www.zerohedge.com/>

Салмон болон Зеро Хэдж блогуудын аль аль нь үнэн зөв найдвартай мэдээлэл гаргадгаараа нэр хүндтэй болж чадсан хэдий ч сэтгүүлчид нийгмийн сүлжээнүүд болон блогуудыг шалгахдаа болгоомжтой хандах шаардлагатай.

дижитал мэдээллийн технологиор тоноглогдсон байдаг бөгөөд хэрэв та тийм орчинд ажиллах азтай бол танай редактор чинь видео зурагчин, дууны техникч зэргийг таньтай цуг томилолтоор явуулах бизээ. Гэхдээ олон сурвалжлагчид онлайнгаар өөрсдийн гэсэн дижитал материалууд цуглуулах

боломжтой болох үүднээс энгийн бөгөөд үнэтэй бус видеокамерууд эсвэл видео бичлэгийн хэрэгсэл худалдан авах болсон.

Зарим сурвалжлага эр зориг шаарддаг

Компаний санхүү болон үйл ажиллагаануудыг ухаж байгаад буруу үйлдлүүд илрүүлдэг сэтгүүлчид том корпорацууд болон баян бизнесийн хүмүүсээс даралт шахалт хүлээх нь байдаг.

Тэр бүү хэл өөрсдийнх нь редакторууд эсвэл хэвлэн нийтлэгчид ноцтой сурвалжлагуудаас зайлхийн том реклам гаргагч компаниуд, нөлөөтэй бизнесийнхэн, хүчирхэг улс төрчдийг гомдоохоос айдаг болохыг олж тогтоосон байдаг. Хэвлэн нийтлүүлэхэд хүндрэл учирч болох ч тухайн өгүүлэх гээд байгаа зүйлсээ маш нарийвчлан судалж үзсэн бөгөөд хэлэн нийтлэх нь бүх талуудад шударга зүйл болно гэдгийг харуулж чадсан сэтгүүлчид л дээд боссүүддаа тухайн өгүүллээ нийтлүүлэх нь зөв болохыг итгүүлж чаддаг.

Хэвлэн нийтлүүлэхийг нь таслан зогсоох, айлган сүрдүүлэх оролдлогуудтай тэмцэх хамгийн сайн хамгаалалт бол хөдөлшгүй үнэн байх явдал юм. Гэвч заримдаа хөдөлшгүй үнэн байх ч хангалтгүй байх нь бий.

Индонез дахь хүчирхэг бизнесмэнтэй холбоотой өгүүлэл нь тэр үед Индонезийн хамгийн том мэдээллийн сэтгүүл болох Темпогийн ерөнхий редактор байсан Бамбанг Харумуртид том цохилт болсон. Уг өгүүлэлд 2003 онд Жакарта хотын зах дээр гарсан сэжиг бүхий гал түймэрт тухайн талбайд өндөр үнэтэй худалдааны төв барьж байгуулах гэсэн компаний төлөвлөгөөтэй холбоотой байж болох юм гэж буруутгасан байдаг.

Уг төслийн ард байгаа бизнесмэн болох Томи Вината Харимурт болон түүний хоёр хамтрагчдыг шүүхэд өгч нэр төрийг нь гутаасан гэж заалдсан. Дараа нь засгийн газар оролцож хүний нэр төр гутаасан эрүүгийн хэрэг тулган сэтгүүлчдийг хоёр жил хорих ял оноохыг шаардсан Энэ ял нь дэлхий даяарх сэтгүүлчдийн дургүйцлыг төрүүлсэн бөгөөд уг сэтгүүлийн ажилтнуудыг хэвлэлийн тухай хуулиар биш эрүүгийн хуулиар шийтгэж байгаа нь Индонез улсан ардчилал хэвлэлийн эрх чөлөө байхгүй болсныг харуулж байна гэж эсэргүүцэл илэрхийлсэн.

Харимуртид бизнесмэн хүний нэр төр гутаасан хэргээр буруутган нэг жил хорих ял оноосон. Хоёр

сурвалжлагчид нь цагаатгагдсан боловч дээд шүүх нь доод шатны шүүхийн шийдвэрийг цуцлан тэдгээр сэтгүүлчдийг хэвлэлийн тухай хуулийн дагуу шийтгэх ёстой гэж үзсэн.

Шүүхийн заргууд сэтгүүлчдэд гол аюул занал учруулдаг боловч корпорацууд болон олон нийттэй харьцах төлөөлөгчдийн үзүүлэх дарамт нь хавьгүй илүү их тохиолддог. Срөг өгүүлүүдийн субъект нь томоохон зар сурталчилгааны компани байвал тийм өгүүлэл нэн даруй хариу арга хэмжээтэй учирдаг. Тийм дарамт шахалтын үед редакторууд болон сонинны газрын эзний дэмжлэг маш чухал байдаг.

Хэрэг мөрдөн сурвалжилсан сэтгүүл зүйг дэмжин эх үүсвэрээр хангадаг хэд хэдэн байгууллагууд байдаг. Тэд хэрэг мөрдөн сурвалжлах сэтгүүл зүйн холбогдолтой хичээл, бие даасан курсууд болон жишээнүүдээр хангадаг. Тэдгээр байгууллагуудын дунд дараах байгууллагууд багтдаг:

Хэрэг мөрдөн сурвалжлах төв: <http://cironline.org/>

Мөрдөн сурвалжилдаг сурвалжлагчид болон редакторууд: <http://www.ire.org/>

Эрэн сурвалжлах самбар: <http://www.datatracker.org/>

Олон улсын сэтгүүлзүйн төв:
<http://www.icfj.org/>

Олон улсын сэтгүүлзүйн сүлжээ: <http://ijnnet.org/>

Олон улсын эрэн сурвалжлах сэтгүүлзүйн консорциум: <http://www.publicintegrity.org/investigations/icij/pages/resources/>

Пойнтерын институт: <http://www.poynter.org/>

Филиппины эрэн сурвалжлах сэтгүүлзүйн төв:
<http://pcij.org/>

Ёс зүйн саад бэрхшээлүүдийг даван туулах нь

Бизнесийн чиглэлээр бичдэг сурвалжлагчдын ёс зүйн асуудлууд нь улс төр, спорт болон аливаа бусад чиглэлээр бичдэг сурвалжлагчдынхаас ялгаатай зүйл бараг байхгүй боловч зарим онцгой асуудлууд байдаг бөгөөд ашиг сонирхолын зөрчлүүд үүсэх боломж

магадгүй илүү өндөр байдаг байж болно.

Компаниуд эерэг сурвалжлага хийлгэхийн тулд бүтээгдэхүүн бэлэглэх нь олонтоо байдаг. Сэтгүүлчид тухайн бүтээгдэхүүнийг нь туршиж шалгах зориулалтаар бүтээгдэхүүнийг нь зээлээр авахыг зөвшөөрч болох ч тухайн бүтээгдэхүүнийг нь компанид нь буцааж өгөх шаардлагатай. Компьютер, хөдөлгөөнт хэрэгсэл гэх мэтийг бэлгэнд авах нь сэтгүүлчид бодитой сурвалжлага хийхэд саад учруулж ашиг сонирхлын зөрчил бий болгодог.

Олон орнуудад сэтгүүлчид заримдаа зардлаа нөхөх гэж мөнгөтэй дугуй авдаг уламжлалтай байдаг. Ихэнх олон улсын байгууллагууд өөрсдийн ажилтнуудад тийм бэлэг авахыг хориглосон байдаг. Гэвч сурвалжлагчид нь бага цалинтай бөгөөд бэлгийг орлогынхоо нэмэлт эх үүсвэр болгодог компаниудад тийм уламжлал хадгалагдсаар байдаг.

Бэлэг сэлтээс татгалздаг сэтгүүлчид уншигчдынхаа итгэлийг хүлээж сайн сэтгүүлч болохоо харуулах боломж илүү байдаг.

Ихэнх томоохон мэдээллийн байгууллагууд бизнесийн чиглэлийн сурвалжлагчид болон тэдний гэр бүлийнхнийг сурвалжилж буй эсвэл ирээдүйд сурвалжлах компанийхаа хувьцааг худалдан авахыг нь хориглодог. Компаниудад сурвалжлага хийж байхдаа олж авсан мэдээллийг хөрөнгө оруулагчид, шинжээч эсвэл өөр хэн ч байсан тухайн компанид тодорхой ашиг сонирхолтой байгаа бусад хүнд задруулахгүй байх ёстой.

Мэдээнүүдээс үүдэн эсвэл сургаар хувьцааны үнэ дээш доош болох нь байдаг учраас сэтгүүлчид бүх мэдээллийг нарийн чанд шалгаж байх талаар анхааралтай хандах ёстой байдаг. Хэрэглэгчдийн сэтгэгдэл, хөрөнгө оруулагчдын үйлдэл, менежерүүд болон захирлуудын нэр хүндэд мэдээллийн хэрэгсэл дээр байгаа мэдээлэл нөлөөлж болно. Гэхдээ тэглээ гээд сэтгүүлчид хэт болгоомжтой байх ёстой гэсэн үг биш харин бичих мэдээлэл хийхдээ хамгийн өндөр мэргэжлийн стандартууд дагаж мөрдөж ажиллах ёстой гэсэн үг юм.

Энэ нь бүх талуудыг адилхан хангалттай хамарсан шударга тэнцвэртэй өгүүлүүд бичихийн чухлыг харуулж байгаа хэрэг болно.



ТА ЮУ МЭДЭХ ВЭ?

Таавар

1. Бизнесийн чиглэлийн сурвалжлагч томоохон гангийн үйлдвэрийг байнга сурвалжилдаг байжээ. Түүний эцэг эх нь тус компаний тодорхой хувьцааг эзэмшдэг. Тухайн компаний хувьцааны үнийг ихээхэн бууруулхаар зарим хүндрэлүүд тус компанид учирсныг тэр мэдэж байвал яах ёстой вэ?

- А. Эцэг эхийнхээ хувьцааны талаар редактортаа хэлээд тус компанийг сурвалжлахаа болих
- Б. Редакторт хэлэх шаардлагагүй. Тус компаний талаар аль болох шударгаар сурвалжилсан хэвээр байх
- В. Эцэг эхийгээ хувьцаагаа нэн даруй худалдаж мөнгө болгохыг зөвлөх

2. Гол үйл явдлын үндэс суурийг цаг хугацааны дарааллаар харуулдаг

төрлийн өгүүллийг нэрлэдэг аман ярианы нэр томъёог юу гэдэг вэ?

- А. Инвестигатив
- Б. Тик ток
- В. Хэсэгчлэн хуваах арга

3. Зарим сурвалжлагчдын үзэж байгаагаар сурвалжлагчид шинжээчдийг эх сурвалж болгохдоо ямар нэгэн байдлаар эргэлзээтэй хандах ёстой гэж үздэг. Яагаад:

- А. Шинжээчид нь судлаж буй компаниудаасаа бие даасан байх шаардлагагүй
- Б. Шинжээчид мэдлэггүй
- В. Олон шинжээчид олон нийтэд мэдэгдэхгүй албан бусаар мэдээлэл хийх дуртай.

Харуултууд: 1. А, 2. В, 3. А

ЭХ СУРВАЛЖУУД БҮЛЭГ 7

Редакторын тэмдэглэл: 7 дугаар бүлгийг бэлтгэхэд дараах эх сурвалжуудыг авч ашиглав. Ихэнх вэбсайтуудад нь дурын уншигч нэвтрэх орох боломжтой. Wall Street сэтгүүл, Financial Times зэрэг тодорхой хэвлэл мэдээлэлийн хувьд нэвтрэх захиалга өгөх шаардлагатай. New York Times нь сар бүр үзэгчдэд зориулж хязгаартай тооны архивласан материал өгдөг.

НИЙТЛЭЛ, БҮТЭЭЛҮҮД

Tamal Vandyoradhuay, “Компанийн засаглал болон Ражастханы банк”, LiveMint.com, 2011 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр. <http://bit.ly/l9LOuC>

Anne Molyneux, “Компанийн засаглал: Эрэн сурвалжлах бизнесийн сэтгүүл”, танилцуулга, 2011 оны 5 дугаар сар, Ханой. Ивээн тэтгэгч: Дэлхийн компанийн засаглалын форум.

Takashi Nakamichi, Atsuko Fukase, “Японы төв банкир Олимпын хэрэгт харамсаа”, Wall Street сэтгүүл, 2011 оны 11 дүгээр сарын 16-ний өдөр. <http://on.wsj.com/IM8VhF>

Dean Starkman, “Санхүүгийн сэтгүүлзүй юунд зориулагдсан вэ?” Аудит, Колумбийн сэтгүүлзүйн тойм, 2009 оны 1 дүгээр сарын 13-ний өдөр. <http://bit.ly/HDZts0>

Mark Tran, “Parmalat-ийн санхүүгийн захирал асан сэтгүүлчдийг зодов”, Guardian, 2004 оны 1 дүгээр сарын 5-ний өдөр. <http://bit.ly/IEZAH1>

Paul Wolfowitz, “Эрх чөлөөний эхний төсөл”, New York Times, 2004 оны 9 дүгээр сарын 16-ны өдөр. <http://nyti.ms/ISPbr0>

Ben Worhen, Joann S.Lublin, “Хямрал HP-ийн захирлыг дайрав”, Wall Street сэтгүүл, 2011 оны 9 дүгээр сарын 22-ны өдөр. <http://on.wsj.com/HEhew9>

“Индонезийн редактор Libel-ээс болж хоригдов”, BBC News, 2004 оны 9 дүгээр сарын 16-ны өдөр. <http://bbc.in/J8GEga>

“Дээд шүүхээс Bambang Hartumurti-д нэг жилийн ял оноов”, Хил хязгааргүй сэтгүүлчид, 2006 оны 3 дугаар сарын 8-ны өдөр. <http://bit.ly/IFMmr9>

НОМ, СУДАЛГАА

“Тооны цаадах бизнесийн сурвалжлага: Корпорацийн засаглалын сайн, муу, харгис гурвыг олох нь,” 2009 оны 10 дугаар сард сурсан хичээл, Дэлхийн компанийн засаглалын форум болон Олон улсын санхүүгийн корпораци, Дэлхийн банк групп.

Компанийн засаглалд улам гүн нэвтэрч орохыг хүссэн сэтгүүлчид нь их хэмжээний эх сурвалжуудыг онлайнаар олж болно. Танай улс, эсвэл бүс нутагт Компанийн засаглалын институт, захирлууд (заримыг нь жагсаан бичсэн) нь сургалт, семинар санал болгохын зэрэгцээ үндсэн материал, бусад эх сурвалжаар хангаж болно. Доор зарим эх сурвалжийг сонгосон бөгөөд ихэнхийнх нь загвар, дээж боломжтой байгаа. Түүнчлэн эрэн сурвалжлах сэтгүүл зүйн мэдээлэл, эх сурвалжаар сэтгүүлчдэд тусалдаг тусгай байгууллагуудыг үзнэ үү.

■ КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН ТОЙМ

Олон улсын байгууллагууд

СФА институт

<http://www.cfainstitute.org>

Мэргэшсэн санхүүгийн шинжээч болох шалгалтуудыг давсан хөрөнгө оруулалтын мэргэжилтнүүдийн дэлхий хамгийн том холбооноос бүрдүүлсэн олон улсын, ашгийн төлөө бүс байгууллага. Дэлхийн хэмжээний мэргэжилтнүүдтэй нэгдэхийг санал болгож, нягтлан бодох бүртгэл, аудит, компанийн засаглал (Бүртгэлтэй компаниудын компанийн засаглал: Хөрөнгө оруулагчдын гарын авлага, хоёрдугаар хэвлэл) болон бусад хөрөнгө оруулалтын сэдэв()-ээр үндсэн материал, академик судалгааг хэвлэж гаргадаг.

Дэлхийн компанийн засаглалын форум

<http://www.gcgf.org/>

Шинээр гарч ирж буй зах зээлүүд болон хөгжиж буй улс орнуудын компанийн засаглалын өөрчлөлт шинэчлэлтийн төлөөх тус Форум нь компанийн засаглалын талаарх сургалтын материалаар хангаж, компанийн засаглалын асуудлаар судалгаа нийтэлж, үйл ажиллагааны талаараа дэлхий даяар тогтмол тайлан гаргадаг.

Олон улсын санхүүжилтийн корпораци

www.ifc.org/corporategovernance

Дэлхийн банкны группын гишүүн ОУСК нь хөгжиж буй улс орнуудын хувийн хэвшлийн салбарт төвлөрсөн дэлхийн хамгийн томоохон хөгжлийн институт юм. Вэбсайтаараа дамжуулж дэлхийн дахины компанийн засаглал, ялангуяа гэр бүлийн эзэмшилтэй болон төрийн өмчит компаниудын талаар өргөн хэмжээний эх сурвалжаар хангадаг.

Олон улсын худалдааны танхим

<http://www.iccwbo.org>

ОУХТ-ын үйл ажиллагаа нь арбитрын үйл ажиллагаа, маргаан шийдвэрлэхээс авахуулаад худалдааны гэмт хэрэгтэй тэмцэх, авилгалтай тэмцэх, бизнесийн өөрийгөө удирдах, зах зээлийн эдийн засгийн систем, чөлөөт худалдааны жишгийг тогтоох зэргээр өргөн цар хүрээнд хамаардаг.

Олон улсын компанийн засаглалын сүлжээ

<http://www.icgn.org>

Дэлхийн даяар компанийн засаглалын стандартыг сайжруулахаар 50 улс оронд үйл ажиллагаа явуулж буй олон

улсын гишүүнчлэлтэй байгууллага юм. ОУКЗС нь компанийн засаглалын асуудлаарх шийдэл, үзэл баримтлалыг эрэлхийлдэг. Мэдээний хэсэг дээрээ компанийн засаглалын мэдээнүүдийн чиг хандлагын талаар илүү сайн авч үздэг.

Олон улсын нэгдсэн тайлагналын зөвлөл

<http://www.theiirc.org/>

Корпораци, хөрөнгө оруулалт, нягтлан бодох бүртгэл, үнэт цаас, хууль эрхзүй, академик болон стандарт тогтоох салбарууд, иргэний нийгэмлэгийн удирдагчдаас бүрдсэн. Тайлангууд гаргадаг.

Исламын санхүүгийн үйлчилгээний зөвлөл

<http://www.ifsb.org/>

Банк, хөрөнгийн зах зээл болон даатгалын салбарын зарчмуудыг гаргаж, олон улсын стандартыг тогтоох замаар Исламын санхүүгийн үйлчилгээний салбарын тогтвортой байдлыг дэмждэг.

Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (ЭЗХАХБ)

http://www.oecd.org/topic/0,3699,en_2649_37439_1_1_1_1_37439,00.html

Францад байрлалтай, 34 гишүүн улс оронтой. ЭЗХАХБ-ийн Компанийн засаглалын зарчмууд нь дэлхийн компанийн засаглалын хууль тогтоомж, шилдэг арга практикийн үндэс суурь болдог. Өөр эх сурвалжуудад компанийн засаглалын талаарх статистик мэдээ, судалгаа, ном бүтээл болон олон улсын мэдээ ордог.

Transparency International

<http://www.transparency.org>

Бус нутагт үүссэн байгуулагдсан 90 гаруй үндэсний бүлэгтэй, бүлгийн зохион байгуулалтаараа дамжуулж авилгалын эсрэг тэмцдэг олон улсын иргэний нийгэмлэгийн байгууллага.

Стандарт, кодуудыг дагаж мөрдөх тухай Дэлхийн банкны тайлангууд

<http://www.worldbank.org/ifa/roscc.html>

Эдгээр тайлангууд нь хямралд бага өртөх, илүү бат бөх дэлхийн эдийн засагт хувь нэмрээ оруулах, зах зээлийн үр ашиг болон эмх журмыг сайжруулах, эдийн засгийн хийгээд санхүүгийн хүндрэлд нөлөөлж болох сул талуудыг илүү сайтар тодорхойлоход тусалдаг.

БҮС НУТГИЙН БАЙГУУЛЛАГУУД

Африк (Дэд Сахаар)

Нигери – Санхүүгийн институтуудын сургалтын төв

<http://www.ftc-ng.com/index.asp>

Ерөнхий менежмент, манлайлалыг хөгжүүлэх, банк болон санхүү чиглэлээр сургалтын хөтөлбөрүүдийг боловсруулж хүргэдэг.

Захирлуудын институт – Өмнөд Африк

<http://www.iodsa.co.za/>

Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн захирлыг бэлтгэх, боловсролын хөтөлбөрүүдээр дамжуулж хөгжил, урт хугацааны сургалтын үйл ажиллагааг зохион байгуулахыг зорьдог.

Ази, Номхой Далай

Азийн компанийн засаглалын холбоо

<http://www.acga-asia.org/>

Ази тив дэх үр ашигтай компанийн засаглалын арга барилын талаар хөрөнгө оруулагчид, компаниуд болон зохицуулах байгууллагуудтай хамтран ажилладаг бие даасан, ашгийн төлөө бус гишүүнчлэлтэй байгууллага.

Бангладешийн байгууллагын институт

<http://www.bei-bd.org/>

Хувийн салбарт чухал нөлөө бүхий асуудлуудыг дэмжиж, зах зээлд чиглэсэн эдийн засгийг хөгжүүлэх бодлогод нөлөө үзүүлэхийг зорьдог ашгийн төлөө бус, улс төрийн бус судалгааны төв.

Энэтхэгийн компанийн нарийн бичгийн дарга нарын институт

<http://www.icsi.edu/>

Энэтхэг дэх компанийн нарийн бичгийн дарга нарын мэргэжлийг хөгжүүлэх, зохицуулах хүлээн зөвшөөрөгдсөн цорын ганц мэргэжлийн байгууллага.

Компанийн засаглалын Пакистаны институт

<http://www.picg.org.pk/index.php>

Пакистан дахь компанийн засаглалын зөв арга барилыг дэмжих төр-хувийн хэвшлийн нөхөрлөл.

Европ

Европын Сэргээн босголт, хөгжлийн банк

<http://www.ebrd.com/pages/homepage.shtml>

Төв Европоос төв Азийг хүртэлх 29 улс орны төслийг дэмждэг олон улсын санхүүгийн байгууллага. Нээлттэй, ардчилсан зах зээлтэй эдийн засгийн төлөөх шилжилтийг дэмжиж, байгууллагын үйл ажиллагааг дэмждэг.

Европын Захирлуудын холбоодын эвсэл

<http://www.ecoda.org/about.html>

Захирлуудын үр чадвар, мэргэжил болон нийгэмд үзүүлэх нөлөөг дэмжих зорилготой.

Европын компанийн засаглалын институт

<http://www.ecgi.org/index.htm>

Компанийн засаглалын үндсэн асуудалд тулгуурлаж мэргэжилтнүүд, хууль тогтоогчид болон хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн дунд хэлэлцүүлэг, харилцан яриа өрнүүлэх форум болдог.

Компанийн засаглалын Балтик институт

<http://www.corporategovernance.lt/>

Балтикийн олон нийтийн, хувийн, төрийн болон орон нутгийн эзэмшлийн компаниудыг компанийн засаглалаар дамжуулж дэлхийн хэмжээнд ил тод, өрсөлдөхүйц байдлыг бүрдүүлдэг.

Их Британийн Захирлуудын институт

<http://www.iod.com/home/default.aspx>

Компанийн захирлуудын стандартуудыг дэмжиж, төлөөлж, тогтоодог.

Словянийн Захирлуудын холбоо

<http://www.zdruzenje-ni.si/zcnswweb/vsebina.asp?s=381&n=1>

Хяналтын зөвлөлийн төлөөлөл бүхий Словянийн гишүүнчлэл бүхий цорын ганц байгууллага. Гишүүдэд боловсрол, гэрчилгээ, судалгаа, мэргэжлийн стандартууд, хэвлэл мэдээлэл болон зөвлөх үйлчилгээг үзүүлдэг.

Латин Америк, Карибын тэнгис

Компанийн засаглалын Бразилийн институт

<http://www.ibgc.org.br/Home.aspx>

Бразилд компанийн засаглал, шилдэг арга барилыг нэвтрүүлэх, дамжуулах төв форум.

Компанийн засаглалын зөв арга барилын төв

<http://ols.uas.mx/cegc/>

Мексик дэх компанийн засаглалын зөв арга барилыг дэмжих ашгийн төлөө бус байгууллага. Компанийн засаглалын шинэ арга барил, хэрэгслийг хангах хөтөлбөрүүдийг ивээн тэтгэдэг.

Компанийн засаглал болон хөрөнгийн зах зээлийн төв

<http://www.cgchile.cl/>

Чили дэх компанийн засаглалын зөв арга барилыг дэмжих иргэний нийгэмлэг, мэргэжилтнүүд болон хувийн хэвшлийн төлөөллийг багтаадаг.

IGCLA.net

<http://igcla.wordpress.com/>

ЭЗХАХБ болон Олон улсын компанийн засаглалын форумаас зохион байгуулдаг компанийн засаглалын дугуй ширээний ярилцлагаар үүсгэн байгуулсан Латин Америкийн компанийн засаглалын институтуудын албан бус холбоо.

Ямайкын хувийн хэвшлийн байгууллага

<http://www.psoj.org/>

Компанийн засаглалын хороо нь бизнесийн байгууллагуудын манлайлагч нарт шилдэг арга барилыг дэмжиж ажиллахыг зорьдог.

Хөрөнгийн зах зээлийг дэмжих холбоо

<http://www.procapitales.org/>

Перугийн хөрөнгийн зах зээлийн агентлагуудын мэргэжлийн холбоо, компанийн засаглалын зөв арга барилыг дэмждэг.

Ойрхи Дорнод ба Хойд Африк

Компанийн засаглалын хариуцлагын форум

http://www.cgrforum.com/Public/Main_English.aspx?site_id=1&page_id=308

Ойрхи Дорнод, Хойд Африкийн бүс нутаг дахь бизнесийн тэргүүлэгчидтэй хамт компанийн засаглал болон хариуцлагын чиглэлээрх олон улсын мэргэжилтнүүдийг нэгтгэн үзлүүлэх зорилгоор тогтмол арга хэмжээ зохион байгуулдаг.

Компанийн засаглалын Хавкамах институт

<http://www.hawkamah.org/>

Компанийн засаглалыг хөгжүүлэхэд Ойрхи Дорнод, Хойд Африкийн бүс нутаг дахь улс орнуудад туслах, компанийн салбарын өөрчлөлт шинэчлэлт хийгээд сайн засаглалыг хөгжүүлэх зорилготой.

Либаны ил тод байдлын холбоо

<http://www.transparency-lebanon.org/>

Сайн засаглалын зарчмуудыг дэмжих, авилгалыг хязгаарлахад чиглэсэн Либаны анхны ТББ.

Хойд Америк

Компанийн захирлуудын үндэсний холбоо

<http://www.nacdonline.org/>

Захирлуудад үлгэр жишээ болох манлайллыг хөгжүүлэх зорилготой. ТУЗ-ийн гишүүдийн хэрэгцээ шаардлагыг хангах, захирлуудыг илүү үр дүнтэй, үр ашигтай ажлаа гүйцэтгэхэд туслах тал дээр илүү чиглэдэг.

Институционал хөрөнгө оруулагчдын зөвлөл

www.cii.org

тэтгэврийн сан болон ажилчдын нөхөн олговрын бусад сангууд, халамжийн сан, хандивын сан зэргээс бүрдсэн (3 триллион ам.доллараас давсан хөрөнгөтэй) ашгийн төлөө бус, нам бус холбоо бөгөөд компанийн засаглалын талаар илүү сайн судлахад ном хэвлэл, саналын бичиг болон бусад эх сурвалжаар хангадаг.

■ АКАДЕМИК ИНСТИТУТ, БАЙГУУЛЛАГУУД

Олон их сургуулиуд компанийн засаглалд зориулж судалгааны төвүүд байгуулсан байдаг. Эдгээр вэбсайтууд нь судалгааны материал хэвлэж, олон нийтийн форум болон бусад арга хэмжээг ивээн тэтгэж, бусад вэбсайтуудыг зөвлөдөг. Эдгээр институт нь сэтгүүлчдэд шинжилгээ, материал хангахын тулд экспертүүдээр хангадаг.

Компанийн засаглалын төв Бизнесийн Түк сургууль, Дармоут

<http://mba.tuck.dartmouth.edu/ccg/>

Олон улсын зах зээл, эзэмшлийн бүтэц, хуулийн уламжлал дахь олон улсын ялгаа нь санхүүгийн гэрээ контрактыг сайн боловсруулахад хэрхэн нөлөөлдөг болох талаарх ойлголтонд чиглэж судалгаагаа явуулдаг. Түүнчлэн тус төв нь хувьцаа эзэмшигчид (компанийн эзэд) болон компанийн бусад бүрэлдэхүүнийн хоорондох болзошгүй зөрчлийг шалгадаг.

Компанийн засаглалын төв, Лондон бизнесийн

сургууль <http://www.london.edu/facultyandresearch/researchactivities/centreforcorporategovernance.html>

Мэдээ шинэчлэх зорилгоор факультад нэвтэрч, судалгааг хянадаг.

Мельбурний их сургууль, Компанийн хууль болон үнэт цаасны зохицуулалтын төв

<http://cclsr.law.unimelb.edu.au>

Компанийн хууль болон үнэт цаасны хууль тогтоомжийн талаар судалгаа явуулж, дэмжлэг үзүүлдэг. Компанийн засаглалын олон улсын вэбсайтуудын холбоосыг өгдөг.

INSEAD компанийн засаглалын санаачлага

http://www.insead.edu/facultyresearch/centres/governance_initiative/

Олон улсын хэмжээнд ТУЗ-ийн гишүүдэд тулгарч буй хэрэгцээ шаардлагад нийцсэн чухал судалгаа, заах арга барилыг ивээн тэтгэдэг. Кейс судалгаагаар хангаж, мэргэжилтнүүд болон төгсөгчдөд туслалцаа үзүүлдэг.

Knowledge@Wharton

<http://knowledge.wharton.upenn.edu/>

Бизнесийн сургуулийн факультатаас эдийн засагт нөлөөлж болох мэдээний үйл явдалд шинжилгээ хийх.

Сингапурын засаглал болон ил тод байдлын индексийн үндэсний сургууль

<http://bschool.nus.edu/CGIO/OurProjects/GovernanceTransparencyIndex.aspx>

Тус индекс нь Ази тив дэх 700 гаруй компанийн засаглал болон ил тод байдлын чанарыг үнэлдэг. Засаглал нь ТУЗ-ийн асуудал, цалин хөлс, хариуцлагатай байдал болон аудитын асуудлыг хамардаг. Ил тод байдлын хэмжүүр нь компаниуд хувьцаа эзэмшигчидтэй хэрхэн харилцаж байгаа асуудалд чиглэдэг.

Компанийн нэр хүндийн кейс судлалын Оксфордын их сургуулийн төв

<http://www.sbs.ox.ac.uk/centres/reputation/research/Pages/CaseStudies.aspx>

Сэтгүүлчид болон компанийн шийдвэр гаргагчдын хоорондох харилцаа холбоо зэрэг компанийн зан төлөв, нэр хүндийн үр дагаврын асуудлаар судалгаа, шинжилгээ хийдэг.

Туркийн компанийн засаглалын форумын Сабанчи их сургууль

<http://cgft.sabanciuniv.edu/about/background>

Компанийн засаглалын цар хүрээ, арга практикийг шинжлэх ухааны судалгаагаар сайжруулахад хувь нэмэр оруулах, идэвхитэй үйл ажиллагаагаар бодлого хөгжүүлэх процессыг

дэмжих, эрдэмтэд болон мэргэжилтнүүдийн хооронд харилцан хэлэлцүүлэг өрнүүлэх, судалгаагаар хангах.

Дилаверийн их сургууль, Компанийн засаглалын Вейнбергийн төв

<http://www.delawarecorporategovernance-blog.com/>

Бизнесийн тэргүүлэгчид, байгууллагын ТУЗ-ийн гишүүд, хуулийн нийгэмлэг, академик, мэргэжилтнүүд, бакалавр болон магистрийн оюутнууд, компанийн засаглалыг сонирхож байгаа бусад этгээдийг уулзуулах, хамтран ажиллуулах, сургах, заах чиглэлд анхаарч, форум хийдэг.

Ейлийн менежментийн сургууль Компанийн засаглалын Миллстейний төв

<http://millstein.som.yale.edu/>

Компаниуд нь нийгэмд хариуцлагатай, ёсзүйтэй, ил тод байдлаар үйлчлэх ёстой гэсэн нөхцлийг судлах олон улсын томоохон эх сурвалж. Ашиг хүртэгчийн сонирхлыг хооронд нь хослуулж, стратеги болон эрсдэлтэй харьцахын тулд дэлхийн хэмжээнд байгууллагууд, институционал хөрөнгө оруулагчдын чадварыг ойлгохтой шууд холбогдож ажиллана.

■ ТУСГАЙ СЭДВҮҮД

Нягтлан бодох бүртгэл, аудит

Нягтлан бодох бүртгэл, аудитын компаниуд нь компанийн засаглалын талаарх суурь мэдээллээр хангаж, компаниудын тулгамдаж байгаа асуудлуудын талаар ихэвчлэн судалгаа явуулдаг. Доорх вэбсайтуудад одоогийн, эсвэл ирээдүйн бүх харилцагчдын бүлэгт анхаарал хандуулдаг бөгөөд тэдгээрийн шинэчлэл, шинжилгээ чухал байж болно. Мэргэжлийн гурпууд нь судалгааг санал болгож, хэлэлцүүлэг хийх форум болж болно. Мөн тэд сэтгүүлчдийг нягтлан болох бүртгэл, аудитын мэргэжилтнүүдийг олж уулзахад туслах боломжтой.

Компанийн засаглалын төлөөх Делойттын төв

<http://www.corpgov.deloitte.com/site/us/template.PAGE/>

Эрнст энд Янг – Засаглал, тайлагнал

<http://www.ey.com/US/en/Issues/Governance-and-reporting>

Англи, Уэльсийн мэргэшсэн нягтлан бодогчдын институт

<http://www.icaew.com/>

Олон улсын хэмжээнд 138,000 гаруй мэргэшсэн нягтлан бодогчдыг дэмжих мэргэжлийн гишүүнчлэлтэй байгууллага. Нягтлан бодох бүртгэл, засаглалын асуудлаар тайлан, нийтлэл бичиж, вэбсайт ажиллуулдаг. Мэдээгээ шинэчилж гаргадаг.

Нягтлан бодогчдын олон улсын холбоо

<http://www.ifac.org>

127 улс орон, шүүхийн харъяаллын 2.5 сая гишүүний төлөө олог нийтийн ашиг сонирхлын асуудлын талаар ярьж,

шилдэг арга барилыг дэмждэг. Хууль эрхзүй, зохицуулалтын санал, төлөвлөгөөний талаар тайлан гаргаж, санал бичдэг.

KPMG-ийн аудитын хорооны институт

<http://www.kpmginstitutes.com/aci/>

PricewaterhouseCoopers (PwC)-ийн ТУЗ-ийн засаглалын төв

<http://www.pwc.com/us/en/corporate-governance>

Компанийн мэдэгдлүүд дээрх компанийн засаглалын бодлогууд

Компаниуд нь өөрсдийн вэбсайтдаа компанийн засаглалын бодлогуудын талаар нийтэлж, жилийн тайлангуудад мэдэгдэл оруулна. Институционал хөрөнгө оруулагчид хувьцааг нь эзэмшиж байгаа компаниудаас бичгээр мэдэгдэх ёстой засаглалын дүрэм журам, бодлогуудыг өгөхийг шаарддаг. Доорх жишээнүүд компанийн мэдэгдлүүдэд олдож болох компанийн засаглалын бодлогуудыг харуулав. Энэ мэдээлэл нь зөвхөн заах зорилготой байх бөгөөд дор жагсаасан компаниудын засаглалын тодорхой стандартуудыг илэрхийлж, баталгаа олгохгүй болохыг анхаарна уу.

Нэвтрэх хориотой

<http://www.accessbankplc.com/Pages/page.aspx?value=45#>

Их Британи болон Африкийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг Нигерид байрлалтай томоохон санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч.

BHP Billiton

www.bhpbilliton.com

Австралид байрлалтай дэлхийн хамгийн том бие даасан уул уурхай, газрын тос, хийн компаниудын нэг.

Hysan Development Company Limited

http://www.hysan.com.hk/eng/index_company.html

Хонгконгт байрлалтай үл хөдлөх хөрөнгийн хөрөнгө оруулалт, менежмент болон хөгжлийн тэргүүлэх компани.

Натура

<http://www.natura.net>

Засаглал болон бараа бүтээгдэхүүний тогтвортой байдлыг онцолдог Бразилийн томоохон гоо сайхны компани.

Petronas

<http://www.petronas.com.my/Pages/default.aspx>

Малайзын засгийн газраас бүрэн эзэмшилтэй олон улсын газрын тос, хийн нэгдсэн компани.

Тата групп

<http://www.tata.com>

Энэхүү Энэтхэгийн нэр хүнд бүхий компанийн ёсзүйн дүрэм нь дэлхийн долоон бизнесийн салбарт үйл ажиллагаа явуулж байгаа 100 гаруй компаниудыг хамруулж үздэг.

Turkcel

<http://www.turkcell.com.tr/site/en/turkcellhakkinda/Sayfalar/genel.aspx>

Түркийн гар утасны харилцаа холбооны олон улсын нэр хүнд бүхий компани.

Маргаан шийдвэрлэлт

Үр дүнтэй маргаан шийдвэрлэх төв

<http://www.cedr.com>

CEDR нь зөрчилтэй холбоотой зардлыг бууруулах, маргаанаас урьдчилан сэргийлэх, маргаан шийдвэрлэх сонголт, чадавхийг бий болгох зорилго бүхий бие даасан, ашгийн бүс байгууллага юм. CEDR нь зуучлах, зөвлөх болон сургалтын үйлчилгээг үзүүлдэг.

Ёсзүй

Өмнөд Африкийн ёсзүйн институт

<http://www.ethicsa.com>

Судалгаа явуулж, сургалт ба зөвлөх үйлчилгээ үзүүлдэг, үнэлгээ болон баталгаажуулалт өгдөг ашгийн бүс байгууллага. Судалгааг онлайнгаар авах боломжтой бөгөөд нөөцийн төв нь зөвхөн биеэр очиж үзэх боломжтой ном зохиол хийгээд бусад материалтай байна.

Ethisphere

<http://ethisphere.com>

Бизнесийн ёсзүй, байгууллагын нийгмийн хариуцлага, авилгалын эсрэг болон тогтвортой байдлын чиглэлээр шалгарсан арга барилыг бий болгох, хөгжүүлэх, хуваалцах зорилготой олон улсын байгууллага. Хэвлэл мэдээллийн танилцуулга зэрэг арга хэмжээг зохион байгуулж, зэрэглэл өгч, үндсэн материал хэвлэн гаргадаг.

Globethics.net

www.globethics.net

Женевт байрлах олон улсын ёсзүйн сүлжээ бөгөөд ёс суртахууны тусгал, үйлдлийн электрон тавцан болж өгдөг. Онлайн номын сангаараа дамжуулж сэтгүүл, нэвтэрхий толь, электрон ном болон бусад материал чөлөөтэй тараадаг. Сэтгүүлчид ийм сүлжээний боломжийг эдэлж харилцаа холбоогоо тэлэх боломжтой.

Хэрэглээний ёсзүйн Марккула төв

<http://www.scu.edu/ethics>

Санта Кларагийн их сургуулийн төв нь ёсзүйн асуудлаар судалгаа явуулж, форум зохион байгуулдаг.

Бизнесийн практикуудын талаарх Рио Тинтогийн мэдэгдэл

http://procurement.riotinto.com/ENG/supplierregistration/34_the_way_we_work.asp

Тогтвортой байдлын стандарт хандлага

<http://www.standardchartered.com/en/sustainability/our-approach/>

Тривентийн Санхүүгийн ёсзүйн дүрэм

<https://www.thrivent.com/aboutus/privacy/conduct.html>

Институционал хөрөнгө оруулагчид

Aberdeen

www.aberdeen-asset.com

Bradesco

<http://www.bradesco.com.br/site/conteudo/governanca/default.aspx?secaold=730>

CalPERS

<http://www.calpers-governance.org/>

Hermes

http://www.hermes.co.uk/Portals/8/The_Hermes_Ownership_Principles_US.pdf

Зэрэглэл

Хэд хэдэн байгууллагууд мэдээний үндсэн дээр бий болж болох компанийн засаглалыг компани дагаж мөрдөж байгаа эсэх талаар бие даасан үнэлгээ хийдэг. .

CLSA

<https://www.clsa.com/index.php>

Бие даасан брокер, хөрөнгө оруулалтын банк нь Азийн компанийн засаглалын холбоотой хамтарч Ази тивийн компанийн засаглалын гүйцэтгэл, асуудлууд болон чиг хандлагын талаар хамгийн цогц үнэлгээг хийж танилцуулдаг.

GovernanceMetrics International

<http://www2.gmiratings.com/>

АНУ-д байрлалтай, дэлхийн 20,000 гаруй компанийг хамардаг. Шинжилгээ, тайлан, судалгаа болон зэрэглэл гаргадаг. Шинэ мэдээ авахыг хүсвэл FeedBurner блогт захиалгаа өгнө үү.

Компанийн нийгмийн хариуцлага, тогтвортой байдал

Хөрөнгө оруулагчид, ашиг сонирхлын бүлгүүд болон засгийн газар нь компанийн урт хугацааны тогтвортой байдлыг баталгаажуулж, нийгэм болон байгаль орчинд үзүүлэх нөлөөг бууруулах бодлого, арга барилуудыг батлахыг шаардаж шахдаг. Доорх байгууллагууд нь нийгмийн хариуцлагын талаар компаниудыг зарим талаараа үнэлж, тус асуудлаар мэдээлэл өгч болно.

Caux Round Table

<http://www.cauxroundtable.org/>

Ёсзүйн капитализмыг дэмжиж ажилладаг олон улсын бизнесийн тэргүүлэгчдийн сүлжээ. CRT-ийн зарчмууд нь бизнесийн шийдвэр гаргалтанд ёсзүйн үндсэн хэм хэмжээг хэрэглэдэг.

Олон улсын хувийн хэвшлийн байгууллагуудын төв

<http://www.cipe.org>

Тус төв нь ардчилсан нийгэмд чухал иргэний институтуудыг бүтээн байгуулахад бизнесийн тэргүүлэгчид, бодлого тогтоогчид болон сэтгүүлчидтэй хамтарч ажилладаг.

Хөтөлбөрийн гол чиглэлүүд нь авилгалтай тэмцэх, сурталчилгаа, бизнесийн холбоод, компанийн засаглал, ардчилсан засаглал, мэдээлэлд хандах, албан ёсны бус салбар, өмчийн эрх, эмэгтэйчүүд болон залуус юм.

Экваторын зарчмууд

www.equator-principles.com

ОУСК болон Дэлхийн банкны стандартуудад суурилсан эдгээр зарчмууд нь төслийн санхүүжилтийн ажил гүйлгээнд байгаль орчны хийгээд нийгмийн эрсдлийг тодорхойлох, үнэлэх, удирдахад зориулсан зээлийн эрсдлийн менежментийн бүтцийг бий болгосон.

Олборлох салбарын ил тод байдлын санаачлага

<http://eiti.org/>

Улс орны олборлох салбарын орлогын хариуцлагатай, ил тод байдлыг баталгаажуулах дэлхийн стандартыг тогтоодог.

Олон улсын тайлагналын санаачлага

<http://www.globalreporting.org/>

Эдийн засаг, байгаль орчин болон нийгмийн тогтвортой байдлыг дэмждэг ашгийн төлөө бус байгууллага. Тус газар нь дэлхий даяар хэрэглэгдэж буй тогтвортой байдлын тайлагналын цогц бүтцээр бүх компани, байгууллагуудыг хангадаг.

Байгаль орчин болон хөгжлийн олон улсын институт, оролцооны сургалт болон үйлдлийн цуврал

www.iied.org

Тус институт нь сэтгүүлчдэд янз бүрийн үзэгчидтэй холбогдож байгаль орчин болон хөгжлийн хоорондох хамаарлын талаар тогтмол бөгөөд илүү нарийн мэдээлэх, хэвлэл мэдээллийн өргөн цар хүрээг хамруулахад туслалцаа үзүүлдэг.

Хариуцлагатай хөрөнгө оруулагч

<http://www.responsible-investor.com/>

Хариуцлагатай хөрөнгө оруулалт, байгаль орчин, нийгэм, засаглал болон олон улсын институционал хөрөнгө оруулагчдын тогтвортой санхүүжилтийн асуудал сэдвээр хариуцлагатай мэдээлэл хүргэх цорын ганц найдвартай үйлчилгээ. Тус сайт нь цөөн тооны нийтлэл, бүтээлийг үнэгүй үзэх боломж олгодог.

Тогтвортой байдал

www.sustainability.com

1987 онд үүсгэн байгуулагдсан. Хэрэглээ, ил тод байдал, хувьцаа эзэмшигчийн оролцоо, шинэ санаачлага болон шилжилтийн стратеги зэрэг асуудлуудад бизнесийн болон нийгмийн үнэ цэнийг бий болгох, илүү сайн ойлгуулахад харилцагчид хийгээд түншүүдэд туслалцаа үзүүлдэг.

НҮБ-ын Олон улсын хэлэлцээр

<http://www.unglobalcompact.org/>

Энэ нь хүний эрх, хөдөлмөр, байгаль орчин болон авилгалтай тэмцэх зэрэг салбаруудад дэлхий даяар хүлээн зөвшөөрсөн арван зарчмын дагуу бизнесүүдэд өөрсдийн үйл ажиллагаа, стратегиудыг нийцүүлэн үйл ажиллагаа явуулах стратегийн бодлогын санаачлага юм.

■ ОНЛАЙН НОМЫН САН

Нэвтрэхэд чөлөөтэй текстэн архив

<http://archive.org/details/texts>

Дижитал хэлбэрээрх ном, нийтлэл болон бусад материалын интернет номын сан. Түүнчлэн олон улсын ашгийн төлөө бус байгууллагууд, их дээд сургуулиуд болон бусад этгээдийн байгуулсан олон онлайн номын сангуудын өргөн цар хүрээний холбоосыг олгож өгдөг.

Нэр томъёонуудыг Компаний засаглалын талаарх практик зааварчилгаа, Эдийн засгийн хамтын ажиллагаа хөгжлийн байгууллага, businessdictionary.com investpedia.com зэрэг хэд хэдэн эх сурвалжуудаас цуглуулан авсан болно.

А

Accountability (хариуцлага, тайлагнах үүрэг): Компаний засаглалын хувьд энэ нь компаний гүйцэтгэл ба компаний үйлдлүүдийн талаар хувьцаа эзэмшигчид болон сонирхогч талуудын өмнө ТУЗ-ийн хүлээх хариуцлагыг хэлнэ. Энэ нь компаний удирдлагын гүйцэтгэсэн бүх үйлдлүүдийн талаар хариуцлага хүлээх, мэдээллийг сонирхогч талуудад тайлагнадаг байх тухай үзэл баримтлал юм. Мөн энэ нь тухайн бизнесийг удирдан явуулахдаа компаний удирдлага авч явуулсан үйлдлүүдийнхээ төлөө ТУЗ-ийн өмнө хүлээх хариуцлага, тайлагнах үүргийг хэлж байгаа хэрэг болно.

Accounting standards (ня-бо бүртгэлийн стандартууд): Санхүүгийн гүйлгээнүүд болон мэдээллийг бүртгэх, талагнах талаар ня-бо бүртгэлийн стандарт тогтоогч байгууллагуудаас тогтоосон нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн журмууд, конвенцүүд, стандартууд болон процедуруудын иж бүрдлийг хэлнэ.

Acquisition (өөр компани худалдан авалт): Хувьцааг нь худалдан авах эсвэл солилцох замаар өөр компаний ханалтыг гартаа авах. Ийм худалдан авалт нь дайсагнасан эсвэл нөхөрсөг шинжтэй байж болно.

Agency conflict (агенттай үүссэн зөрчлүүд): захирал нь агентад эрх мэдэл шийдвэр гаргах эрх олгон өөрийн нэрийн өмнөөс ажиллуулхаар агент хөлслөн авснаас үүдэн гарах хүндрэлтэй асуудлууд /проблемууд/

Agency cost (Агентын өртөг зардал): компаний удирдлага-хувьцаа эзэмшигчийн янз бүрийн зорилтуудтай холбоотой проблемуудыг шийдвэрлэхэд тухайн компанид учирсан зардлууд. Зардлууд нь хоёр гол эх сурвалжаас бүрддэг: агент ашигласантай холбоотой зардлууд /жишээлбэл, агентууд нь тухайн компаний эх үүсвэрүүдийг өөрийн ашиг сонирхолд ашиглах эрсдэл/ болон агент ашигласантай холбоотой проблемуудыг арилгахад ашигласан арга техникүүдийн зардлууд /жишээлбэл, санхүүгийн тайлангууд боловсруулах эсвэл гүйцэтгэх ажилтнуудын ашиг сонирхлыг хувьцаа эзэмшигчдийн ашиг сонирхолтой нийцүүлэх үүднээс хувьцааны опционууд ашигласан зардлууд/

Agency theory (Агентын тухай онол): өөрийнхөө нэрийн өмнөөс ажиллуулхаар хоёрдогч тал буюу агентыг хөлслөн авч буй захирал болон агентын хоорондын эрх мэдэл ашиг сонирхолын харилцааг харуулахад ашиглагддаг онолын тогтолцоо.

American Depositary Receipt (Америкийн итгэмжлэгдсэн хадгалагчийн гаргасан баримт бичиг): Америкийн зах зээл дээр гадаадын хувьцаануудыг арилжаалах асуудлыг

хөнгөвчлөх зорилгоор Америкийн банканд итгэмжлэн хадгалуулсан гадаадын хувьцаануудын оронд тухайн банкнаас гаргасан үнэт цаас.

Annual general meeting (Shareholders' Assembly) (Хувьцаа эзэмшигчдийн жил бүр болдог ерөнхий хурал/ чуулган): санхүүгийн жил дууссаны дараахан жил бүр хуралддаг хувьцаа эзэмшигчдийн хурал бөгөөд түүн дээр хувьцаа эзэмшигчид ТУЗ-ийн гишүүд болон компаний удирдлага өмнөх жилийн ажлаа дүгнэн ярилцаж, санхүүгийн тайлангууд болон ирээдүйн хэтийн төлөвийн талаар хэлэлцдэг. Уг хурлаар ТУЗ-ийн гишүүдийг сонгодог бөгөөд хувьцаа эзэмшигчдийн санаа зовж бусад асуудлуудыг хэлэлцдэг. Энэхүү хурал нь хувьцаа эзэмшигчдэд компаний ТУЗ-ийн гишүүдээс шууд асуултуудаа асууж санал хураах, шийдвэр гаргах эрх мэдлээ хэрэгжүүлэх гол боломж нь байдаг.

Annual report (Жилийн тайлан): компаниуд жил бүр хувьцаа эзэмшигчиддээ гаргаж өгдөг баримт бичиг. Түүнд өмнөх жилийн санхүүгийн үр дүнгүүд болон ерөнхий гүйцэтгэл, ирээдүйн хэтийн төлөвийн талаарх commentууд багтсан байдаг. Жилийн тайланд компаний засаглалын тайлан болон гүйцэтгэх захирлын тайлан мэтийн бусад тайлангууд мөн багтсан байна.

Auditor's opinion (Аудиторын дүгнэлт): Тухайн компаний санхүүгийн тайлангууд бүртгэлүүдэд аудит хийсэн бие даасан аудитор санхүүгийн тайлангуудыг дагалдуулан гаргасан аудиторын дүгнэлт. Уг дүгнэлт нь тухайн компаний санхүүгийн тайлангууд нь түүний санхүүгийн нөхцөл байдлыг үнэн зөв харуулж чадсан эсэхийг харуулдаг.

Audit (Аудит): түүхэн санхүүгийн тайлангуудыг нягтлан шалгаж тэдгээрт итгэх итгэлийн түвшинг сайжруулах зорилго бүхий шалгалт. Бие даасан мэргэжлийн чадварлаг гадны аудиторүүд компаний санхүүгийн болон ня-бо бүртгэл ба бусад дагалдах баримт бичгүүдийг шалган магадлах нь тэдгээр баримт бичгүүд холбогдох тайлагналт ня-бо бүртгэлийн стандартын шаардлагуудын дагуу хийгдсэн бөгөөд луйвар эсвэл алдаанаас үүдсэн материаллагаар буруу тайлагнасан зүйлс байхгүй компаний санхүүгийн бодит байдлыг үнэн зөв харуулсан болохыг уншигчдад баталгаажуулж өгдөг.

Audit Committee (аудитын хороо): ТУЗ-ийн байгуулсан хороо бөгөөд сонирхогч талуудад гарган өгч тайлагнаж буй компаний санхүүгийн болон санхүүгийн бус мэдээллүүдийг хянах үүрэгтэй. Уг хороо нь ТУЗ/ хувьцаа эзэмшигчдээр батлуулахаар тухайн компанид аудит хийх пүүсийг сонгон санал болгох асуудлыг хариуцдаг. Хэрэв ТУЗ-ийн бие даасан эрсдийн үнэлгээний хороо гэж байхгүй бол, уг аудитын

хороо нь компаний удирдлагын орчин болон эрсдлийн хяналтыг мөн хариуцдаг.

B

Board of Directors: (ТУЗ): Компанийг удирдан чиглүүлж хянаж байх үүднээс хувьцаа эзэмшигчдийн сонгосон хувь хүмүүсийн бүлгийг хэлнэ. Тэд компаний хэтийн зорилго, эрхэм зорилгыг тодорхойлж, стратегийг нь тогтоон менежментэд нь хяналт тавьдаг. ТУЗ нь гүйцэтгэх захирлыг сонгох, гүйцэтгэх ажилтнуудын цаоин урамшуулал нөхөн олговрын багцийг тодорхойлох, компаний урт хугацааны зорилтуудыг тогтоон эрсдэл болон дүрэм журмын мөрдөлтийг хянах үүрэгтэй.

Board statutes (or Board charter) (ТУЗ-ийн дүрэм): ТУЗ болон түүний хороодын үүрэг, хариуцлага, бүрэлдэхүүн болон үйл ажиллагааг тодорхойлсон баримт бичиг.

By-laws (компаний дотоод журам): ТУЗ эсвэл хувьцаа эзэмшигчдийн баталсан компаний дотоод засаглалын дүрэм журмыг тодорхойлсон бичшээр үйлдсэн баримт бичиг бөгөөд захирлуудыг томилох, ажилтнуудын ажил үүрэг болон хувьцааг хэрхэн шилжүүлэх гэх мэтийн сэдвүүдийг багтаасан байдаг.

C

Cash flow rights (Ашгийн хувь авах эрх): Компаний ашгийн тодорхой хувийг авах эрх. Хувьцаа эзэмшигчдийн ноогдол ашиг авах эрхийг оруулсан хөрөнгө оруулалт болон тусгай ангиллын хувьцааны өмчлөлд нь тулгуурлан компани тогтоодог.

Chairman of Board (ТУЗ-ийн дарга): ТУЗ-ийн хамгийн өндөр албан тушаалтай гишүүн. ТУЗ-ийн дарга нь ТУЗ-ийг удирдах, мэдээлэлтэй байж шийдвэр гаргадаг байхын тулд шаардлагатай бүх мэдээллээ авч чаддаг байхаар ТУЗ-ийн ажиллагааны үр ашигтай байдлыг хангах, ТУЗ-ийн хурлаар хэлэлцэх асуудлуудыг боловсруулах, ТУЗ-ийн ажиллагааг хувьцаа эзэмшигчдийн ашиг сонирхолд нийцүүлэн явуулах асуудлыг хангах үүрэгтэй.

Company Charter (Компаний дүрэм): Тухайн компани байгуулагдсан улс орны холбогдох төрийн эрх бүхий байгууллагад бүртгүүлсэн компаний албан ёсны баримт бичиг. Компаний дүрэм нь түүний зорилго, хуулиар хүлээх эрхүүд, гаргахыг зөвшөөрсөн хувьцааны ангилалууд, хувьцаа эзэмшигчид ба ТУЗ-ийн гишүүдийн эрх үүргүүдийг тодорхой заасан байна.

Chief executive officer (гүйцэтгэх захирал): ТУЗ-д ажлаа тайлагнадаг компаний хамгийн өндөр албан тушаалтай удирдах ажилтан. Гүйцэтгэх захирал нь богино хугацааны шийдвэрүүд гаргах, ажиллагсдыг удирдах, стратегийг хэрэгжүүлэх, эрсдлийн менежмент хийх, менежментийг

хянах үүрэгтэй.

Classified Board (Дэс дараалалтай сонгогддог ТУЗ): Жил бүр ТУЗ-ийн гишүүдийн тодорхой хэсгийг хэдэн жилийн хугацаатайгаар сонгож байдаг бүтэц бүхий ТУЗ-ийг хэлнэ.

Codes of conduct/ ethics (Ёс зүйн дүрэм): Хэрхэн зохистойгоор биеэ авч явах, холбогдох нарийн төвөгтэй асуудлаар зохистой үйлдлүүд хэрхэн хийхийг тодорхойлж тухайн байгууллага боловсруулан баталсан ёс зүйн дүрэм. Энэ нь компани хэрхэн өөрийн зорилгуудаа хүрэх, бизнесээ хэрхэн явуулах вэ гэдгийг харуулдаг.

Committees of the Board (ТУЗ-ийн хороод): Зөвхөн ТУЗ-ийн гишүүдээс бүрдсэн хороод нь ТУЗ-ийн байнгийн хуралдаануудаас гадуур тодорхой чиглэлүүдээр дүн шинжилгээ хийхэд нь ТУЗ-д туслах зорилгоор байгуулагддаг. Аудитын, цалин урамшууллын болон нэр дэмшүүлэх хороод зэрэг нийтлэг хороод байдаг.

Common shares (энгийн хувьцаа): Компаний өмчлөлийг төлөөлж эзэмшигчдээ санал хураах эрх, ноогдол ашиг эсвэл хөрөнгийн хуваарилалтаар компаний үлдэгдэл ашгаас хувь хүртэх эрх олгодог үнэт цаас.

Compliance (дүрэм журам мөрдөлт): Дүрэм журам мөрдөж ажиллахыг зөвшөөрөх. Ерөнхийдөө бол энэ нь тодорхой тогтоогдсон спецификациуд, гадаад дотоод бодлого, стандартууд болон хуулиудыг дагаж мөрдөн нийцүүлэн ажиллах гэсэн санаа болно.

Concentrated ownership (төвлөрсөн өмчлөл): ганцхан хувьцаа эзэмшигч /эсвэл хувьцаа эзэмшигчдийн жижигхэн бүлэг/ компаний санал хураах эрхтэй хувьцааны ихэнх хувийг эзэмшдэг өмчлөлийн хэлбэр.

Conflict of interest (Ашиг сонирхлын зөрчил): энэ нь үнэнч байдал, ашиг сонирхол болон ажил үүрэг зөрчилдөж байгаа эрх зүйн болон / эсвэл ёс зүйн нөхцөл байдлын аль алиныг харуулдаг. Хувь хүний хувийн ашиг сонирхол болон мэргэжлийн эсвэл нийтийн ашиг сонирхолын хооронд зөрчил гарах боломжоос үүдэн тухайн хүний үнэнч шударга байдлыг доройтуулах боломжтой нөхцөл байдал хамаарна. Үүнд мөн нэг этгээдийн хоёрдогч талын өмнө хүлээсэн хариуцлага нь түүний гуравдагч талын өмнө хүлээсэн хариуцлагаа биелүүлэх боломжийг нь хязгаарлаад байгаа нөхцөл байдал бас орно. ТУЗ-ийн гишүүд ашиг сонирхолын зөрчлөөс зайлсхийх үүрэгтэй байдаг бөгөөд үргэлж компани болон хувьцаа эзэмшигчдийн ашиг тусын тулд чадах бүхнээ хийх ёстой байдаг.

Control block (хяналтын багц): компаний санал хураах эрхтэй хувьцаануудын ихэнхийг төлөөлсөн хувьцаануудын нийлмэл багц

Controlled companies (Тодорхой хувьцаа эзэмшигчийн хяналтанд байдаг компаниуд): хувь хүн эсвэл хэд хэдэн хоорондоо холбоотой хувь хүмүүсийн бүлэг эсвэл нэг

хуулийн этгээд санал хураах эрхтэй хувьцааных нь ихэнх хувийг өмчилдөг компаниуд

Controlling shareholders (давуу эрхтэй хувьцаа эзэмшигчид): ТУЗ-ийн бүрэлдэхүүнийг хянахад хангалттай хэмжээний санал хураах эрхтэй хувьцаа эзэмшигчид, ихэнхдээ энэ нь 30 хувь эсвэл түүнээс дээш байх бөгөөд тийм хувьцаа эзэмшигч нь ихэвчлэн гэр бүл эсвэл улс байдаг.

Cost of capital (капиталын өртөг): тодорхой хөрөнгө оруулалтанд зориулан хөрөнгө оруулагчдыг татахад шаардагдах тухайн зах зээлийн хөрөнгө оруулалтаа нөхөн төлөх коэффициент / өгөөжийн хэмжээ эсвэл ашгийн норм гэж бас нэрлэдэг/

Cost of debt (өрийн өртөг): өнөөгийн зах зээлийн хүүгээр зээлсэн хөрөнгийн өртөг

Cost of equity (хөрөнгө оруулалтын өртөг): хөрөнгө оруулалтынх нь өгөөжийг саатуулсны төлөө болон эрсдэл үүрсний төлөөх нөхөн олговор байдлаар өмчлөгчдөд санал болгож буй тухайн компаний хамгийн бага хөрөнгө оруулалтаа нөхөн төлөх коэффициент

Cumulative voting (Кумулятив санал хураалт): хувьцаа эзэмшигчид ТУЗ-ийн гишүүний суудал тус бүрт өөр өөр нэр дэвшигчийн төлөө санал өгөх эсвэл хэд хэдэн нэр дэвшигчдийн хооронд саналуудаа хуваарилах ёстой ердийн эсвэл хуулиар тогтоогдсон санал хураалтын зарчмаар биш харин жижиг хувьцаа эзэмшигчдэд бүх саналуудаа ганцхан нэр дэвшигчид өгөх боломж олгох замаар жижигхэн хувьцаа эзэмшигчдэд илүү эрх мэдэл олгодог санал хураалтын тогтолцоо

Current ratio (current assets/ current liabilities) (хөрвөх чадварын коэффициент / эргэлийн хөрөнгө болон богино хугацаат өр зээлийн харьцаа): тухайн компаний богино хугацааны өр зээлээ төлөх чадварыг хэмждэг харьцаа

D

Daily volume of shares traded (хоногт арилжаалагдсан хувьцааны хэмжээ): хөрөнгийн бирж дээр өдөр бүр арилжаалагдсан тухайн хувьцааны хэмжээ

Debt ratio (current + long term financial debt/ total assets) (Өрийн харьцаа/зээлсэн капиталын хувийн жин (өнөөгийн + урт хугацааны санхүүгийн өр төлбөрийг нийт хөрөнгөд харьцуулсан харьцаа)): Тухайн компаний урт хугацааны санхүүгийн хараат байдлыг харуулдаг харьцаа

Dividend yield (Ноогдол ашгийн гарц): жилийн ноогдол ашгийг хувьцааны үнэтэй харьцуулсан харьцаа. Ноогдол ашгийн гарцийг хувьцааны ашиг өгөөжийг хэмжихэд өргөнөөр ашигладаг.

Disclosure (Мэдээлэл өгөх үүрэг): энэ нь зохицуулах

байгууллагууд болон олон нийтийг оролцуулан хэд хэдэн талуудын шаардлагуудын дагуу эсвэл ня-бо бүртгэлийн стандартууд мэтийн стандартууд болон гэрээнүүдийн дагуу материал, зах зээлийн нөлөөллийн мэдээллийг өгч байх компаний үүргийг хэлнэ. Мэдээлэл өгөх үүрэг нь компаний засаглалын гол зарчмуудын нэг болох ил тод байдлыг бий болгоход хувь нэмэр оруулдаг.

Dispersed ownership (тархай өмчлөлийн бүтэц): энэхүү өмчлөлийн бүтэц нь хяналтын багц атгадаг хувьцаа эзэмшигчид байхгүй бүтэц юм. Хувьцаануудыг нь маш олон хувьцаа эзэмшигчид өмчилдөг бөгөөд хувьцаа эзэмшигч бүр багахан хувийн хувьцаа эзэмшдэг учраас хэн нь ч дангаараа компаний асуудлаар шийдвэр гаргах, шийдвэрт нөлөөлөх боломжгүй байдаг.

Dual-class shares (хос ангилалтай хувьцаа): нэг ангилал нь санал хураах эрхтэй нөгөөх нь тийм эрхгүй байдаг А ангиллын болон Б ангиллын хувьцаанууд мэтийн өөр өөр эрхүүд бүхий хувьцааг хэлнэ.

E

EBITDA Margin (EBITDA/ operational revenues) (хүү, татвар, элэгдэл хорогдол тооцохоос өмнөх орлогын өгөөж) компаний орлогын өгөөжийн хязгаарыг харуулдаг ашигтай байдлын хэмжүүр.

Economic profit (residual profit) (эдийн засгийн ашиг/ үлдэгдэл ашиг): бүх оруулсан хөрөнгийн өртгийг суутгасны дараах ашиг. Эдийн засгийн ашиг нь татварын дараах ашиглалтын орлогоос оруулсан хөрөнгийн өртгийг хассантай тэнцүү байна.

Economic value added (эдийн засгийн нэмэгдсэн үнэ цэнэ): хувьцаагаар оруулсан хөрөнгийн өртгийг суутган засвар/ тодотгол хийсний дараах жинхэнэ эдийн засгийн ашгийг тооцдог санхүүгийн хэмжүүр. Уг хэмжүүр нь компаний хувьцаа эзэмшигчдэд шаардлагатай өгөөжийн хэмжээнээс гадна бий болсон нэмэгдсэн үнэ цэнийг харуулдаг.

Executive session (ТУЗ-ийн хаалттай хуралдаан): гүйцэтгэх захирал болон бусад гүйцэтгэх ажилтнуудыг оролцуулалгүй ТУЗ-ын хуралдааны хаалттай явуулдаг хэсэг.

F

Family constitution (гэр бүлийн үндсэн журам): хөрөнгө оруулсан компаниудтай нь хамааралтай гэр бүлийн эх үүсвэрүүдийг хуваах гэр бүлийн гишүүдийн эрх үүргүүдийг заасан удирдамж

Family council (гэр бүлийн зөвлөл): гэр бүлийнхээ бизнесийн өнөөгийн болон ирээдүйн байдлын талаар ярилцахаар гэр бүлийн гишүүд цугладаг зохион

байгуулалттай хуралдаан. Гэр бүлийн гишүүд нь тухайн компанийхаа өдөр тутмын үйл ажиллагаанд оролцож ч болно үгүй ч байж болно. Гэр бүлийн зөвлөл нь гэр бүлийн чиглүүлэгч зарчмуудыг хуваалцах замаар гэр бүлийн нэгдмэл байдлыг бий болгох компанийхаа мэргэжлийн менежментийн асуудлуудыг гэр бүлийн асуудалтай хутгахгүй тусд нь байлгах арга юм. Энэ нь ихэвчлэн аливаа асуудлаар тухайн гэр бүр хэрхэн санал өгөхөө тодорхойлдог хурал юм.

Family office (Гэр бүлийн оффис): Маш том нарийн төвөгтэй хөрөнгүүдтэй гэр бүлүүдэд туслах үйлчилгээ үзүүлэхэд зориулагдсан бүлэг. Тийм үйлчилгээнүүдэд ихэвчлэн санхүүгийн, эрх зүйн болон хөрөнгө оруулалтын банкингийн чиглэлээр туслалцаа үзүүлэх үйлчилгээнүүд ордог. Гэр бүлийн оффис нь хувь хүмүүсийн баялаг эд хөрөнгийн оновчтой менежмент хийн иж бүрэн зохицуулалт хийх хэрэгсэл байх зориулалттай. Гэр бүлийн оффис нь мөн илүү өргөн хүрээтэй өв залгамжлал, манлайлал болон гэр бүлийн засаглалын төлөвлөгөөнүүдийг хэрэгжүүлэх арга хэрэгсэл болдог.

Family owned business (гэр бүлийн өмчлөлийн бизнес): хяналтын хувьцааг нэг л гэр бүл /тухайн гэр бүлийн гишүүд болон бусад хамаатнууд оролцсон/ эсвэл гэр бүлүүдийн бүлэг өмчилдөг компани эсвэл төслийг хэлнэ.

Fairness (Шударга байдал): бүх хувьцаа эзэмшигчид болон сонирхогч талуудын эрхийг хүндэтгэн дээдлэх явдал. Компаний засаглалын зарчмуудын нэг бөгөөд бүх хувьцаа эзэмшигчидтэйгээ адил тэгш хандаж сонирхогч талуудын хууль ёсны эрхийг анхаарах асуудлыг хангах зарчим юм.

Financial statements (санхүүгийн тайлангууд): санхүүгийн тайлангуудын иж бүрдэлд тайлан баланс, ашгийн тайлан, хөрөнгийн өмчлөлд орсон өөрчлөлтийн тайлан, бэлэн мөнгөний урсгалын тайлан болон тайлбарууд багтдаг. Тэдгээр нь хамтдаа тухайн байгууллагын тодорхой цаг үеийн эдийн засгийн эх үүсвэрүүд болон үүргүүдийг эсвэл тайлангийн хугацаанд тэдгээрт гарсан өөрчлөлтүүдийг харуулдаг.

Free-float (чөлөөт хувьцаа): Хувьцаануудад хөрвөх чадвар олгодог зах зээл дээр арилжаалхаар хэлэлцээр хийгдэж буй хувьцааны хэсэг. Эдгээр хувьцааг томоохон өмчлөгчид эзэмшдэггүй бөгөөд компани өөрөө өмчилөөгүй хувьцаанууд

FSA: зах зээлийн зохицуулалт хяналт хариуцсан Английн Санхүүгийн үйлчилгээний байгууллага

G

Generally accepted accounting principles (нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн ня-бо бүртгэлийн зарчмууд): Тухайн орны тайлагналтын шаардлаг ня-бо бүртгэлийн стандартууд тогтоодог байгууллагуудаас тогтоосон компаниудад зориулагдсан ня-бо бүртгэлийн журмууд, дүрэм болон

стандартууд. Улс болгон өөр орныхоос арай өөр өөрийн гэсэн ийм зарчмуудтай байдаг. Жишээлбэл, US GAAP бол АНУ-д бүртгэлтэй компаниудад хэрэглэдэг санхүү бүртгэлийн бодлогууд бөгөөд тэдгээрийг Financial Accounting Standards Board гэдэг байгууллага гаргадаг. Тэдгээр нь Европ болон бусад олон оронд хэрэглэдэг Олон улсын санхүүгийн бүртгэлийн стандартын зөвлөлөөс баталдаг Олон улсын санхүүгийн тайлагналтын стандартуудаас ялгаатай байдаг.

H

Hostile takeover (дайсагнасан худалдан авалт): худалдан авах гэж буй компанийх нь ТУЗ худалдан авах саналыг нь зөвшөөрөлгүй буцаачаад байхад тухайн компанийг худалдан авахаар үргэлжлүүлэн хөөцөлдөж байж худалдан авах эсвэл худалдан авах гэж буй компанийхаа ТУЗ-д урьдчилан мэдэгдэлгүйгээр худалдан авах санал гаргах нөхцөл энд багтана.

I

Independent auditors (бие даасан аудиторрууд): санхүүгийн тайлангуудад аудитын шалгалт хийх үүрэг хүлээсэн гадны аудитын пүүсийн мэргэжилтгүүдийг хэлнэ. Аудитыг жилээр, хагас жилээр эсвэл улирал болгон хийлгэх шаардлагатай байж болно. Ихэнх орнуудад бие даасан аудиторрууд нь жилийн тайлангийн аудит хийдэг. Тэд тухайн компаний санхүүгийн тайлангуудад ямар нэгэн хувийн сонирхолгүй байх ёстой байдаг бөгөөд санхүүгийн тайлангуудыг боловсруулахад ямар нэгэн үүрэг гүйцэтгээгүй байх ёстой. Тухайн компаний санхүүгийн тайлангууд болон санхүүгийн бүртгэлүүд нь компаний санхүүгийн байдлыг шударга үнэнээр харуулсан бөгөөд аливаа материаллаг алдаагүй болохыг ямар нэгэн сонирхолгүйгээр батлаж өгөх ёстой байдаг.

Independent director (ТУЗ-ийн бие даасан захирал): тухайн компани, түүний ТУЗ-ийн дарга, гүйцэтгэх захирал эсвэл аливаа бусад гүйцэтгэх ажилтантай зөвхөн ТУЗ-ийн гишүүний хувиар харьцахаас бусад ямар нэгэн мэргэжлийн, гэр бүлийн, хувийн эсвэл санхүүгийн холбоо байхгүй хүнийг хэлнэ. Бие даасан ТУЗ-ийн гишүүн нь тухайн компаний бүхий л шийдвэрүүдэд үнэн зөв бодитой үнэлэлт дүгнэлт өгч чаддаг байх ёстой.

Insider trading (Компаний дотоодын этгээд үнэт цаас арилжаалах): тухайн компанитай холбоотой эсвэл тухайн компаний талаар тусгай мэдлэгтэй хүн үнэт цаасыг нь арилжаалах асуудал. Компаний дотоодын этгээд хэдийд арилжаа хийхээс хамааран тийнхүү арилжаа хийх нь хууль бус эсвэл хууль ёсны байж болдог. Тухайн үнэт цаасны талаарх материаллаг мэдээллийг олон нийтэд тараагаагүй бөгөөд тийм мэдээлэл нь тухайн компаний хувьцааны үнэнд нөлөөлөх бололцоотой байвал тийм арилжаа хийхийг хууль бусд тооцно.

Institutional investor (хөрөнгө оруулагч байгууллагууд):

хадгаламж эзэмшигч хувь хүн эсвэл тэтгэврийн сангийн гишүүд мэтийн ашиг хүртэгчийн нэрийн өмнөөс үйл ажиллагаа явуулдаг мэргэжлийн хөрөнгө оруулагчдийг хэлнэ. Хөрөнгө оруулагч байгууллага буюу хувьцаа эзэмшигч нь олон хүмүүсийн хадгаламжийн мөнгөнүүдийг эсвэл тэдний хөрөнгийн менежерүүддээ итгэмжилсэн хөрөнгийг нь цуглуулаад хамтран хувьцаа худалдан авч хөрөнгө оруулалт хийдэг.

Internal audit (дотоод аудит): аливаа байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, үнэ цэнийг нь нэмэгдүүлэх зорилготой бие даасан зөвлөх үйлчилгээ. Энэ нь эрсдлийн менежмент, удирдлага болон засаглалын үйл явцуудыг үнэлж үр ашгийг нь дээшлүүлэх дэг журамтэй системтэй хандлагыг бий болгох замаар тухайн байгууллагад тавьсан зорилтоо биелүүлэхэд нь туслалцаа үзүүлдэг.

Investor relations (хөрөнгө оруулагчидтай харилцах харилцаанууд): компаний асуудлаар харилцах хэлтэс үүнийг хариуцдаг. Энэ хэлтэс нь хөрөнгө оруулагчидтай харилцаж хувийн болон улсын компаниудын талаарх мэдээлэл түгээх ажлын менежментийг хариуцдаг.

L

Lead director (ТУЗ-ийн тэргүүлэх гишүүн): АНУ-д ашигладаг энэхүү нэр томъёо нь ТУЗ-ийн бие даасан гишүүнийг хэлж байгаа хэрэг бөгөөд ийм гишүүн нь ТУЗ-д болон гүйцэтгэх захиралд нөлөөлөх аливаа хяналтын хувьцаа эзэмшигчийн төлөөлөгчийн эрх мэдлийн эсрэг тэнцвэржүүлэгчийн үүрэг гүйцэтгэдэг. Тэргүүлэх гишүүн нь ТУЗ-ийн хэд хэдэн гишүүдийн ахлагч байдаг бөгөөд ТУЗ-ийн хяналтын үүрэг хариуцлагыг гүйцэтгэх асуудлыг хангадаг. Түүний гол үүрэг хариуцлага нь хурлын хэлэлцэх асуудал бэлтгэхэд оролцох, хаалттай хуралдаанууд даргалах, хаалттай хуралдааны дараа гүйцэтгэх захиралд мэдээлэх, ТУЗ-ийн хурлын танхимын динамикуыг хангахад туслах явдал байдаг.

Liquidity index (хөрвөх чадварын индекс): энэхүү индексийг хөрөнгийн биржүүд бий болгосон бөгөөд тухайн хугацаанд арилжаалагдсан бүх хувьцаануудын нийт хэмжээтэй тухайн компаний хувьцааны хэмжээний арилжаалагдсан хувийг харьцуулан харуулдаг.

M

Market capitalization (зах зээлийн капитализац): Зарагдаагүй үлдсэн хувьцааны тоог тухайн хувьцааны зах зээлийн үнээр үржүүлэн тогтоодог тухайн компаний зах зээлийн үнэ цэнэ

Minority shareholders (жижиг хувьцаа эзэмшигчид): гол хувьцаа эзэмшигчид хяналтын хувьцааг нь эзэмшдэг компаний жижигхэн буюу ихэнхдээ 5%-иас бага хувьцаа эзэмшигчид. Гэхдээ улс бүр “жижиг хувьцаа эзэмшигчийн”

хувьцааны хувь хэмжээг өөр өөрөөр тогтоож болно.

N

Non-voting shares (санал хураах эрхгүй хувьцаа) : энэ ангиллын хувьцаа эзэмшигч нь зарим үнэхээрийн онцгой тохиолдлоос бусад тохиолдолд хувьцаа эзэмшигчдийн хурал дээр санал хураах эрхгүй байдаг. Санал хураах эрхгүй хувьцаа эзэмшигчид ихэнхдээ ноогдол ашиг авахдаа давуу эрх эдэлдэг.

O

One-tier board (нэг үе шаттай ТУЗ): Гүйцэтгэх болон гүйцэтгэх бус гишүүдээс бүрдсэн ТУЗ-ийг хэлнэ. Ийм ТУЗ нь өдөр тутмын бизнесийг менежментийн багт даалгадаг. АНУ, Англи, Хамтын нөхөрлөлийн орнуудад ийм ТУЗ-тэй компаниуд байдаг.

Ownership structure (өмчлөлийн бүтэц): компаний хувьцаанууд хувьцаа эзэмшигчдийн дунд хуваарилагдсан хэлбэрийг хэлнэ.

P

Payout index (dividend per share/ earnings per share) (ноогдол ашгийн индекс буюу нэгж хувьцаанд ноогдох ноогдол ашгийг нэгж хувьцаанаас олсон цэвэр ашигт харьцуулсан харьцаа): цэвэр ашигт үндэслэн компаний төлж буй ноогдол ашгийг харуулсан хэмжүүр

Price / earnings ratio (үнэ ба ашгийн харьцаа): өнөөгийн байгаа хувьцааны үнийг нэгж хувьцаанаас олохоор тооцсон ашигт хуваан тогтоодог тухайн компаний харьцуулсан үнэлгээ хийх хэмжүүр

Present book value (Өнөөгийн балансын үнэ): өнөөгийн байгаа хувьцааны үнийг хувьцааны балансын үнэнд хувааж гаргасан компаний харьцуулсан үнэлгээ хийх хэмжүүр

Poison pill (хорны эсрэг эм): буцаах хатуу нөхцөлтэй давуу эрхтэй шинэ хувьцаанууд гаргах эсвэл ахлах гүйцэтгэх ажилтнуудад тэтгэвэрт гарахад нь тусгай урамшуулал олгох заалт бүхий бусад механизм нэвтрүүлэх замаар хувьцаа худалдан авах өртгийг нэмэгдүүлж дайсагнасан шинжтэй худалдан авалтаас урьдчилан сэргийлэх арга хэрэгсэл.

Preferred shares (Давуу эрхтэй хувьцаа): ноогдол ашиг төлөлт болон татан буугдах үед хөрөнгө хуваарилахтай холбоотойгоор бусад ангиллын хувьцаанаас давуу эрх эдлэх компаний өмчлөлийн хувьцаанууд. Давуу эрхтэй хувьцаанууд нь голдуу санал хураах эрхгүй байдаг.

Proxy (итгэмжлэл): компаний засаглалын хувьд итгэмжлэл гэдэг нь өөр талын нэрийн өмнөөс үйл ажиллагаа явуулах

хууль ёсны эрхтэй этгээл эсвэл агентыг хэлнэ. Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох боломжгүй хувьцаа эзэмшигчид ихэнхлэн итгэмжлэл гарган шийдвэр гаргалтанд оролцох сонголт хийдэг. Итгэмжлэгдсэн төлөөлөгч нь тухайн хувьцаа эзэмшигчийн нэрийн өмнөөс холбогдох асуудлаар саналаа өгдөг. Ихэнх компаниуд хувьцаа эзэмшигчдийн жилийн хуралдаанаа зарлах мэдэгдэлдээ итгэмжлэгдсэн этгээдэд өгөх мэдэглүүдийг багтаан оруулдаг. Энэ итгэмжлэгдсэн этгээдэд өгөх мэдэгдэл гэдэг нь тухайн хурал дээр санал хураах ямар асуудлууд байгаа талаарх мэдээлэл агуулсан мэдэгдэл байдаг. Энэхүү мэдэгдэл нь хувьцаа эзэмшигчдэд өөрийн итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр дамжуулан тодорхой мэдээлэлтэйгээр тухайн асуудлаар шийдвэрээ гаргах боломж олгодог.

Pulverized / dispersed ownership (тархмал өмчлөл): хяналтын хувьцаа эзэмшдэг хувьцаа эзэмшигч байхгүй өмчлөлийн бүтэц.

Pyramidal structure (пирамид бүтэц): гэр бүл ноёрхсон компаниудад нийтлэг байдаг зохион байгуулалтын бүтэц. Эрх зүйн хувьд бие даасан компаниудыг нэг гэр бүл өмчлөхдөө өмчлөлийн харилцааны сүлжээ ашигладаг.

R

Related party (холбоотой тал): хэрэв аливаа тал өөр байгууллагыг шууд ба шууд бусаар хянаж байдаг эсвэл бусад талуудаар дамжуулан хянаж байдаг бол тухайн талыг тэр байгууллагад холбоотой тал гэж үзнэ. Мөн талууд нэг газрын нийтлэг хяналтанд байдаг бол мөн холбоотой талууд болно. Холбоотой талууд нь ихэвчлэн компанийн санхүүгийн эсвэл ашиглалтын бодлогуудаар дамжуулан нөлөөлөх хандлагатай байдаг бөгөөд нөгөө талын үйлддэлд нөлөөлөх эрх мэдэлтэй байдаг. Холбоотой тал гэдэг нь гэр бүлийн гишүүн /эцэг эх, эхнэр нөхөр, хүүхдүүд, бусад хамаатнуудыг оролцуулан/, байгууллагынх нь гол менежер /түүний гэр бүлийн гишүүд/ эсвэл тухайн байгууллагын хараат компаниуд, эцэг компани, хамтарсан компаниуд байж болно.

Return on equity (хувьцааны хөрөнгийн өгөөж): цэвэр ашиг/ хувьцааны дансаарх үнэ. Энэ нь хувьцаа эзэмшигчийн оруулсан хөрөнгийн өгөөжийн хувийг харуулсан ашигтай байдлыг заадаг хэмжүүр.

Risk management (эрсдлийн менежмент): компанид учрах эрсдлийг тогтоох, шинжлэх, менежмент хийх, хянах, тийм эрсдлээс зайлсхийх оновчтой аргыг тогтоох үйл явц.

S

Sarbanes-Oxley Act (Сарбанез Окслигийн хууль): Компаний санхүүгийн тайлагналтыг чангалж холбооны санхүү бүртгэлийн хяналтын зөвлөлийг байгуулж, санхүүгийн бүртгэлийг хуурамчаар янзалсан албан тушаалтнуудад

эрүүгийн хариуцлага хүлээлэгдэг болгосон АНУ-ын хууль

Say on pay (компаний гүйцэтгэх ажилтнуудын цалин урамшууллын талаар саналаа өгөх эрх): компаний ахлах удирдлагын гүйцэтгэх ажилтнуудын цалин урамшуулал ямар байх талаар саналаа хэлэх хувьцаа эзэмшигчийн эрх. Компаний хуулиар хувьцаа эзэмшигчид ийм эрх эдэлдэг.

Securities and Exchange Commission (SEC) (Үнэт цаас хөрөнгийн биржүүдийн комисс): АНУ-ын санхүүгийн зах зээлийг зохицуулан хөрөнгө оруулагчдыг хамгаалдаг АНУ-ын агентлаг. АНУ-ын хөрөнгийн биржүүдэд бүртгэлтэй бүх компаниуд SEC-ийн дүрэм журмуудыг мөрдөх ёстой.

Shareholders (хувьцаа эзэмшигч): компаниудын гаргасан хувьцааг эзэмшигчид

Shareholders' agreement (хувьцаа эзэмшигчдийн гэрээ): хувьцаа эзэмшигчдийн хоорондын харилцааг зохицуулдаг бөгөөд компанийг хэрхэн удирдаж хянаж байгаа тодорхойлсон гэрээг хэлнэ. Энэхүү гэрээ нь жижиг хувьцаа эзэмшигчдийн ашиг сонирхлыг хамгаалах, нийтлэг эрх ашгийг хангах асуудлыг хяналтын хувьцаа эзэмшигчдийн зорилтуудтай уялдуулахад тусладаг.

Shareholders rights (хувьцаа эзэмшигчдийн эрх): компанийн хувьцааг өмчлөх болсноор бий болсон компанитай байгуулсан гэрээгээр олгогдсон хууль ёсны эрхүүд болон бусад эрхүүдэд үндэслэсэн эрхүүдийг хэлнэ. Хувьцаа эзэмшигчийн үндсэн эрхүүдэд компанийн талаарх мэдээлэл авах, хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох, ТУЗ-ийн гишүүдийг сонгох, гадны аудиторыг томилох, санал хураах эрх болон ноогдол ашиг хүртэх эрх зэрэг багтана.

Standard & Poor's 500 index (S&P500) (Стандард энд Пүүр компанийн 500 индекс): Нью Йоркын хөрөнгийн бирж дээр бүртгэгдсэн бүх хувьцаануудын долларын үнэ цэнийн 85%-ийг бүрдүүлдэг АНУ-ын 500 компаниудын индекс. Уг индекс нь АНУ-ын хөрөнгийн зах зээлийн ерөнхий гүйцэтгэлийн ерөнхий хэмжүүр болдог.

Solvency ratio (EBITA/ Interest expense) (компаний авсан зээлийн хөрөнгөтэй нь харьцуулсан төлбөрийн чадварын үзүүлэлт) Тухайн хугацаанд өрөө төлөх компанийн төлбөрийн чадварийг харуулсан хэмжүүр

Staggered board (Дэс дараалалтай сонгогддог ТУЗ): Жил бүр ТУЗ-ийн гишүүдийн тодорхой хэсгийг хэдэн жилийн хугацаатайгаар сонгож байдаг бүтэц бүхий ТУЗ-ийг хэлнэ. Classified board гэдэгтэй адилхан

Stakeholders (сонирхогч тал): аливаа төсөл эсвэл компанийг хууль ёсны дагуу сонирхож буй этгээд эсвэл байгууллага. Илүү ерөнхий авч үзвэл бэлтгэн нийлүүлэгчид, зээлдүүлэгчид, харилцагчид, ажиллагсад, орон нутгийн олон нийт гэх мэт тухайн компанийн үйл ажиллагаа шууд нөлөөлөх бүх этгээдүүдийг хэлнэ

Share multiple (share ratios) (хувьцааны харьцаа):

компаний ашиг /нэгж хувьцаанд ноогдох бэлэн мөнгөний урсгал/ болон хөрөнгөтэй /нэгж хувьцааны дансаарх үнэ/ холбоотой хувьцаа эзэмшигчийн нэхэмжлэлд ашиглагддаг харьцаанууд

Share option (Хувьцааны опцион): тодорхой хугацаанаас өмнө, тодорхой үнээр тодорхой хувьцаа эсвэл хөрөнгийг худалдан авах эсвэл худалдах эрх олгосон гэрээ эсвэл давуу эрхийг хэлнэ. Хамгийн их нийтлэг байдаг хувьцааны опционууд: тодорхой тооны хувьцааг тогтоосон үнээр хүчингүй болох өдөр нь эсвэл түүнээс өмнө худалдан авах эрх болон тодорхой тооны хувьцааг тогтоосон үнээр хүчингүй болох өдөр нь эсвэл түүнээс өмнө худалдах эрх

T

Tag-along rights (дагалдах эрх): хэрэв томоохон хувьцаа эзэмшигчид хувьцаагаа зарвал жижиг хувьцаа эзэмшигчид том хувьцаа эзэмшигчдийн зарсан хугацаа нөхцлүүдээр хувьцаагаа зарах эрхтэй гэсэн үг. Энэхүү эрх нь жижиг хувьцаа эзэмшигчдийг хамгаалдаг бөгөөд хувьцаа эзэмшигчдийн гэрээнд стандарт заалт болж ордог.

Takeover (компани худалдан авалт): нийтэд нээлттэй арилжаалагдаж буй компанийг өөр компани /худалдан авагч, тендерт оролцогч/ худалдан авах үйл явц

Tobins' Q (Тобинс Кю): гэдэг нь онолын ном зохиолуудад нийтлэг хэрэглэдэг компаний зах зээлийн үнэ цэнэ гэсэн үг. Үүнийг тооцоходоо компаний хөрөнгийн зах зээлийн үнэ цэнийг компаний хөрөнгийг өөрчлөх өртөгт хувааж гаргадаг. Энэ үзүүлэлтийг бий болгосон Нобелийн шагналт эдийн засагч Yale University сургуулийн Жэймс Тобины нэрээр түүнийг нэрлэсэн байна.

Trading policy (арилжаалах бодлого): компаний захирлууд болон ажилтнууд компанийхаа хувьцааг арилжаалахад тавигдах хугацаа нөхцлүүдийг харуулсан бодлого. Тэд хувьцаа арилжиж болохгүй хугацаа буюу “хаалттай хугацааг” зааж өгсөн байдаг.

Transparency (ил тод байдал): сонирхогч талуудын ашиг сонирхолтой холбоотой мэдээлэл болон бүх хувьцааны үнэд нөлөөлж болох материаллаг асуудлуудын талаарх мэдээллүүдийг нийтлэн хувьцаа эзэмшигчдэд өгч байх компаний засаглалын зарчим.

Tunneling (хөрөнгө шамшигдуулах луйвар): томоохон

хувьцаа эзэмшигч эсвэл компаний өндөр албан тушаалын ажилтан өөрсдийн хувийн ашгийн төлөө компаний хөрөнгө эсвэл ирээдүйн бизнесийг ашиглах хууль бус бизнесийн практик

Two-tier board (хоёр үе шаттай ТУЗ): Хяналтын болон менежментийн ажил үүргүүдийг хоёр тусдаа хэсэг болгон хуваадаг ТУЗ-ийг хэлнэ. Хяналтын зөвлөл нь ТУЗ-ийн гишүүдээс бүрдсэн байх бөгөөд гүйцэтгэх захирлуудаас бүрдсэн менежментийн зөвлөлийг удирдан хянаж ажилладаг. Франц, Герман, Зүүн Европт түгээмэл байдаг. Хоёр үе шаттай ТУЗ-ийн бүх төрлүүд хоорондоо адилхан биш байдаг.

V

Value based management (хувьцааны үнэ цэнэд суурилсан менежмент): компанийг хувьцааны үнэ цэнэтэй нийцүүлэн хувьцааны үнэ цэнийг хамгийн их байлгах асуудлыг хангаж ажиллах менежментийн хандлагыг хэлнэ. Хувьцааны үнэ цэнэд суурилсан менежментийн гурван үндсэн элементүүд нь : үнэ цэнийг бий болгох – компани хэрхэн ирээдүйн цэнэ нэмэгдүүлэн хамгийн их болгох вэ? стратегитэй төстэй; үнэ цэнийн менежмент хийх – засаглал, менежментийн өөрчлөлт, байгууллагын соёл, харилцаа, манлайлал; болон үнэ цэнийг хэмжих – үнэлгээ.

Voting rights (санал хураах эрх): компанид чухал асуудлуудаар хувьцаа эзэмшигчдийн хурал дээр саналаа өгөх эрх.

Voting shares (санал хураах эрхтэй хувьцаа): ТУЗ-ийн гишүүдийг сонгохыг оролцуулан компаний бодлогын асуудлуудаар саналаа өгөх эрхийг хувьцаа эзэмшигчдээ олгодог хувьцаа.

W

Weighted average cost of capital (капиталын жинлэсэн дундаж өртөг) : оруулах боломжтой хөрөнгө оруулалтын өгөөжийг хэмжих хэмжүүр. Энэ үзүүлэлтэнд нийт санхүүжилт болон холбогдох хүү эсвэл ноогдол ашгийн төлбөрүүдийн өртөгтэй пропорционалаар нийт өртөгт оруулж буй харьцангуй хувиар нь жигнэсэн өрийн болон хөрөнгийн өртөгийг багтаасан байдаг.

Форумын тухай

Олон улсын компанийн засаглалын форум нь шинээр гарч ирж буй зах зээл болон хөгжиж буй улс орнуудын компанийн засаглалын өөрчлөлт шинэчлэлттэй холбоотой мэдлэг, чадварыг бэхжүүлэх томоохон талбар юм. Тус Форум нь хөгжилтэй, хөгжиж буй улс орнуудын компанийн засаглалын үндсэн асуудлуудад хосгүй үр чадвар, түршлага болон шийдлүүдийг санал болгодог.

Форумын үндсэн үйл ажиллагаа нь хувийн хэвшлийн салбарын хөгжлийн хөдөлгүүр болгон дэмжих, санхүүгийн хямралтай үед хөгжиж буй болон шинээр гарч ирж буй зах зээлүүдийн өртөмтгий байдлыг бууруулах, компаниудыг ил тод, тогтвортой, нийгэмд хариуцлагатай байдлаар үр дүнтэй хөрөнгө оруулалт хийх, үйл ажиллагаа явуулахад туслалцаа үзүүлэх явдал юм. Үүний тулд тус Форум нь олон улсын хувийн хэвшлийн тэргүүлэгчидтэй сүлжээ тогтоож, олон улсын, бүс нутгийн хийгээд орон нутгийн институтуудтай хамтарч ажилладаг.

Тус форумыг 1999 онд Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага болон Дэлхийн банк хамтран байгуулсан, ОУСК-ын дотор байрлах олон ивээн тэтгэгчтэй сангийн компани юм.



Global
Corporate
Governance
Forum

2121 Pennsylvania Avenue, NW
Washington, DC 20433 USA

Утас: +1 (202) 458 1857
Факс: +1 (202) 522 7588

www.gcgf.org
cgsecretariat@ifc.org

БИДНИЙ ХАРИЛЦАГЧИД

